


# “ПАРЛАМЕНТ”

*(Судалгааны эмхэтгэл)*



## ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Нийгэм
- Эрх зүй, төрийн байгуулал


UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXX боть)- ийг  
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Д.Бадамдаш  
Д.Халиун

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Баатар



## ГАРЧИГ

### **I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ**

- 1.1 Санхүүгийн зах зээлийг зохицуулж байгаа тогтолцооны талаарх олон улсын туршлага  
*Г.Билгээ, О.Нарантуяа, Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*
- 1.2 БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны үйл ажиллагаа, бүтэц, чиг үүрэг  
*Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа*

### **II БҮЛЭГ. НИЙГЭМ**

- 2.1 Гадаадын зарим орны хотын нийтийн аж ахуйн үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалт  
*Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*
- 2.2 “Бурхан багшийн их дүйчин өдрийг тэмдэглэдэг гадаадын зарим орнуудын талаарх мэдээлэл, лавлагаа”  
*Д.Жигваагүнсэл*
- 2.3 Коронавирус ба зарим улс орнуудын хариу арга хэмжээний талаарх мэдээлэл (2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар)  
*Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа, Э.Энхтүвшин, Д.Халиун*
- 2.4 Гадаадын зарим орны мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зарим зохицуулалт  
*Г.Алтан-Оч (Ph.D), Р.Нургүл*

### **III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ**

- 3.1 Гадаадын зарим орны үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг зохицуулах байгууллагын чиг үүрэг  
*Д.Халиун, Р.Оргилмаа*
- 3.2 Гадаадын зарим орны Парламентын судалгааны албаны орон тооны талаарх мэдээлэл, лавлагаа  
*Г.Билгээ, О.Нарантуяа*
- 3.3 Монгол Улсын болон гадаадын зарим орны хууль тогтоомжоор парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй болон хаалттай дэгийг зохицуулсан байдал  
*Г.Билгээ, О.Нарантуяа*
- 3.4 Улсын Их Хурлын гишүүдийн чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанд оролцсон байдлын талаарх судалгаа (2012-2016 он, 2016-2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар)  
*Г.Билгээ, Р.Нургүл*
- 3.5 1992 оноос хойш байгуулагдсан Улсын Их Хурлын Байнгын хорооны бүтэц, бүрэлдэхүүн  
*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл,*

*Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

- 3.6** Гадаадын зарим орны парламентад намын бүлэг байгуулах гишүүдийн тооны хязгаар

*Г.Билгээ*

- 3.7** Гадаадын зарим орны парламентын хууль тогтоох бүрэн эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт

*Г.Билгээ*

- 3.8** Парламентын мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах талаар бусад орны парламентын дэгийн хуульд зохицуулсан байдал

*Г.Билгээ*

- 3.9** Монгол Улс болон гадаадын зарим орны парламентын ажлын албаны дүрэм

*Р.Нургүл, Р.Өнөрсайхан*

- 3.10** Гадаадын зарим орны парламентын ажлын албаны цалингийн систем, нийгмийн баталгаа, хүний нөөцийн бодлого, хөтөлбөрүүдийн талаарх харьцуулсан судалгаа

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл,  
О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа, Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*

- 3.11** Коронавирусийн халдварын дэгдэлтийн үе дэх гадаадын зарим улсын парламентын ажиллагаа, хуралдааныг зайнаас явуулж санал хураах талаарх туршлага (2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)

*Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
Р.Нургүл, Р.Оргилмаа, Д.Халиун*

- 3.12** Гадаадын зарим орны парламентын Байнгын хороодын талаарх мэдээлэл

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
О.Нарантуяа, Р.Оргилмаа*

- 3.13** Батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн статистик үзүүлэлт /2012-2016 он, 2016-2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар/

*Г.Билгээ*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# 1 БҮЛЭГ

---

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, О.Нарантуяа  
Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*

## ГАРЧИГ

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

#### САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

##### 1.Институцийн уламжлалт буюу силос загвар

1.1.БНХАУ

1.2.Мексик

1.3.Хонконг

##### 2.Функциональ загвар

2.1.Итали

2.2.Франц

##### 3.Хослуулсан буюу нэгтгэсэн загвар

3.1.Япон

3.2.Сингапур

3.3.Герман

##### 4.Хосолмол зохицуулалттай загвар

4.1.Австрали

4.2.Швейцар

4.3.Катар

4.4.Испани

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Олон улсын хэмжээнд санхүүгийн зохицуулах тогтолцоог ерөнхийд нь 4 загварт хуваан авч үздэг байна. Судалгаанд эдгээр дөрвөн загварын талаар, загвар тус бүрээс нь санхүүгийн зохицуулах тогтолцоог амжилттай хэрэгжүүлж байгаа 11 орныг төлөөлөл болгон хамруулсан бөгөөд тэдгээрийн давуу болон сул талуудыг авч үзлээ. Үүнд:

1. институцийн уламжлалт загвар: БНХАУ, Мексик, Хонконг;
2. функциональ загвар: Итали болон Франц;
3. хосолсон буюу нэгтгэсэн загвар: Япон, Сингапур, Герман;
4. хосолмол зохицуулалттай загвар: Швейцар, Катар, Испани, Австрали.

Судалгаанаас үзэхэд, **институцийн уламжлалт буюу “Силос” загвар** нь зохицуулагдаж байгаа хуулийн этгээдийн хэлбэрт анхаарах ба тусгай зохицуулагчийг томилдог байна. Санхүүгийн системийн зохицуулалтын энэхүү загварын төлөөлөл болгон Хятад, Мексик, Хонконгийг судалгаанд хамруулав.

**Функциональ загвар нь** хуулийн этгээдийн хэлбэрийг үл харгалзан, харин санхүүгийн зохицуулалтанд хамрагдаж байгаа бүтээгдэхүүн, гүйлгээний төрлүүдэд чиглэгддэг. Иймээс олон төрлийн гүйлгээг эрхэлдэг хуулийн этгээд маш олон төрлийн зохицуулалтад хамаардаг байна. Санхүүгийн зохицуулагч бүр нь хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хариуцах бөгөөд зохицуулагчийн үйл ажиллагаа, эрх мэдлийн хүрээгээр тодорхойлогдсон бүтээгдэхүүний төрөл бүрт хамаарна. Энэхүү загварыг одоогоор Итали, Франц, Бразил улсууд хэрэглэж байна.

**Хосолсон буюу нэгтгэсэн загварт** санхүүгийн зах зээлийн аюулгүй болон найдвартай байдал, үйл ажиллагааны хяналтыг зохицуулалтын нэг байгууллага хариуцдаг тогтолцоо хамаарагддаг байна. Судалгаанд энэхүү загварын төлөөлөл болгон Япон, Сингапур, Герман улсыг хамрууллаа. Ялангуяа олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чадвартай гэдгээр нь Сингапурын туршлагыг сүүлийн үед үнэлж байгаа ажээ. Үүний дотор Сингапурын амжилтыг онцгойлон авч үзсэн бөгөөд энэ нь зохистой зохицуулалтыг зөв хийх шийдэл гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд зохицуулалтын бүтэц нь дангаараа хангалтгүй гэдгийг харуулах зорилготой юм.

Мөн Герман Улсын банкны секторын ач холбогдол өндөр учраас тус улсын санхүүгийн зохицуулах тогтолцоог судалгаанд орууллаа.

**“Twin Peaks” буюу хосолмол зохицуулалттай загвар** нь хоёр зохицуулагчаас бүрддэг бөгөөд тэдгээрийн зорилго нь системийн тогтвортой байдал, алтернатив сонголт болон зах зээлийг удирдах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

2008 оны дэлхийн санхүүгийн хямралын (GFC) дараа санхүүгийн зохицуулалт алдагдаж, тухайн үед мөрдөгдөж байсан санхүүгийн зохицуулалтын олон хэлбэрийн тогтолцоонуудад анхаарал хандуулах болов. Тухайн үед ашиглаж байсан санхүүгийн зохицуулалтын тогтолцооны дээрх дөрвөн загвараас хосолмол зохицуулалттай загвар нь хамгийн их анхаарал татаж, олонд хүлээн зөвшөөрөгдөх

болсон.

Учир нь энэхүү загварыг хэрэгжүүлж байсан Австрали Улс санхүүгийн хямралыг амжилттай туулж гарснаараа тодорхой жишээ болж чадсан байна. Австрали Улсын Санхүүгийн зохицуулах зөвлөл нь агентлаг хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, хянах зорилготой бөгөөд санхүүгийн зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллага нь чухамдаа хямралын үед санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюулын эсрэг хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга болсон гэж үздэг юм байна.

Санхүүгийн хосолмол зохицуулалттай загварт системийн үр дүнтэй олон элементүүд байдаг бөгөөд тэдгээрийн дор эдийн засгийн хяналт, зах зээлийн бие даасан зохицуулагчид байдаг. Эдгээр нь зохицуулагч тус бүрийн хоорондын зорилго, чиг үүрэг болон хариуцлагыг тодорхой хуваарилах; зохицуулагч хоорондын үр дүнтэй уялдаа холбоо; ил тод байдал, хариуцлага; хяналт болон албадлагын эрх мэдлийг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хараат бус байдал (гүйцэтгэх засаглалын хувьд); засаглалын зохистой тогтолцоо, хангалттай нөөц боломжтой байх асуудал багтдаг.

Хослуулсан буюу нэгтгэсэн загвар нь “Twin Peaks” загвараас ялгаатай: энэхүү загвар нь тогтвортой ажиллагаа болон хяналтыг хослуулж зохицуулдаг бол “Twin Peaks” загвар нь энэ хоёр асуудлыг салгаж зохицуулдаг байна. Энэ нь зохицуулагчийн соёл, агентлаг хоорондын зохион байгуулалт, зохицуулалтын философийн функцтэй холбоотой юм.

Судалгаанд хосолмол зохицуулалттай загварын төлөөлөл болгон Швейцар, Катар, Испани, Австрали улсуудын хамруулав.



## **САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

Дэлхийн улс оронд одоогоор ашиглагдаж байгаа санхүүгийн системийн зохицуулалтын дөрвөн загвар, тэдгээрийн давуу болон сул талуудыг Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Мексикийн Нэгдсэн Улс, Хонконг, Бүгд Найрамдах Итали Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Швейцарын Холбооны Улс, Катар Улс, Испанийн Вант Улс, Австралийн Холбооны Улсын туршлага дээр харьцуулан судалсан болно.

Санхүүгийн зохицуулалтын дөрвөн загварыг авч үзвэл:

1. институцийн уламжлалт буюу силос загвар: БНХАУ, Мексик, Хонконг;
2. функциональ загвар: Итали болон Франц;
3. хосолсон буюу нэгтгэсэн загвар: Япон, Сингапур, Герман;
4. хосолмол зохицуулалттай загвар: Швейцар, Катар, Испани, Австрали.

### **Нэг.ИНСТИТУЦИЙН УЛАМЖЛАЛТ БУЮУ СИЛОС ЗАГВАР**

Энэ загвар нь зохицуулагдаж байгаа хуулийн этгээдийн хэлбэрт анхаарах ба тусгай зохицуулагчийг томилдог байна. Санхүүгийн системийн зохицуулалтын энэхүү загварыг Хятад, Мексик ба Хонконг зэрэг улсад ашигладаг.

#### **1.1. Бүгд Найрамдах Хятад Улс**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд банкны секторын үндсэн хяналт нь Хятадын ардын банк (Хятадын төв банк)-наас (China's National Central Bank (BoC)) Хятадын банкны зохицуулах хороонд (CBRC) 2003 онд шилжсэн байна.

**Хятадын Банкны зохицуулах хорооны** зохицуулалтанд банк, санхүүгийн хөрөнгийн менежер, сангууд, хөрөнгө оруулалтын компаниуд болон бусад хадгаламжийн сангийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагууд ордог.

Хятадын Банкны зохицуулах хорооны үүрэг нь банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, дүрмийг батлах, комплаенсийн хяналт тавих явдал юм. Хятадын ардын банк нь зөвхөн мөнгөний бодлого батлах, банкуудад банк хоорондын зах зээл дээр ажиллахад шаардлагатай санхүүжилтийг олгох үүрэгтэй. Мөн хөрөнгийн болон фьючерс зах зээлийг зохицуулж, хяналт тавьж, хориг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

Хятадын санхүүгийн байгууллагууд хоорондоо ижил төстэй бүтээгдэхүүнийг гаргаж, салбар хоорондын ялгаа арилж байгаа тул цаашид хяналт тавих, хэрэгжүүлэх асуудал улам бүр гарах, зөрчил үүсэх нөхцөл нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

#### **1.2. Мексик Улс**

Мексикт Институтийн загвар хүчтэй бөгөөд үүнийг “Силос” загвар гэж нэрлэдэг. Мексик улсад санхүүгийн байгууллагуудад зохицуулалт хийх болон хяналт тавих үүргийг Үндэсний Банк, Үнэт Цаасны Комисс (CNBV) гэх тус улсын Сангийн яамны

харьяа, төвлөрсөн бус нэгж байгууллага гүйцэтгэдэг.

**Үндэсний банк, Үнэт цаасны комисс** нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах үүрэгтэй бөгөөд банк, банк бус санхүүгийн байгууллага, брокер, дундын сан зэрэг санхүүгийн бүх байгууллагуудад хяналт тавьдаг байна. Харин Үндэсний даатгал, Бондын компаниудын комисс (CNSF) нь даатгал, баталгаа бондын зах зээлд зохицуулалт хийх үүрэгтэй.

Харин **Тэтгэврийн хадгаламжийн системийн үндэсний комисс** (CONSAR) нь Мексикийн тэтгэврийн системийг зохицуулах, хянах үүрэг гүйцэтгэдэг. Тус байгууллагын гол зорилго нь тэтгэврийн сангийн удирдлага, хөрөнгө оруулалтыг хариуцдаг хувийн санхүүгийн институтыг зохицуулах явдал юм. Нэгдсэн хяналт, санхүүгийн группуудын ерөнхий хянагч гэж байдаггүй.

**Санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчдийг хамгаалах үндэсний комисс** (CONDUSEF) нь санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчдийн эрхийг хамгаалах ажлыг хариуцна. Гол зорилго нь “Мексик Улсад үйл ажиллагаа явуулж буй институтын санал болгосон санхүүгийн үйлчилгээг ашигладаг хүмүүсийн эрхийг хамгаалах, дэмжих зөвлөгөө өгдөг” ажээ.

Тус комисс нь Санхүү зээлийн газрын харьяанд ажиллах ба Мексик Улс дахь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үндсэн байгууллага юм. Мөн Хадгаламжийн даатгалын агентлаг (IPAB) хадгаламжийн даатгалыг хариуцдаг. Хадгаламжийн Даатгалын Агентлаг нь үндсэн дөрвөн үүрэг хүлээдэг нь: 400,000 Хөрөнгө Оруулалтын Нэгж (UDIs) хүртэлх дүнтэй хадгаламжид баталгаа олгодог; хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төлбөрийн чадваргүй болсон банкуудад шийдвэр гүйцэтгэх арга хэмжээ авдаг; төлбөрийн чадваргүй болсон банкнуудын хөрөнгийг хүлээн авагч, татан буулгагчийн үүрэг гүйцэтгэдэг; мөн Хадгаламжийн Хамгаалалтын Бонд гаргах зэрэг замаар өөрийн өр төлбөрийг удирдана.

### 1.3. Хонконг Улс

Хонконгийн хувьд валютын болон банкны тогтвортой байдлыг хангах үүрэг бүхий төрийн байгууллага нь **Хонконгийн Мөнгөний бодлогын газар** (HKMA) юм. Тус газрын үндсэн үүрэг нь санхүүгийн систем, банкны системийн нэгдмэл, тогтвортой байдлыг хангах, олон улсын санхүүгийн төв болох статусыг хадгалах, хөрөнгийн санг удирдах, мөн Хонконгийн санхүүгийн дэд бүтцийг хөгжүүлэх явдал юм. Тус байгууллага нь Хонконгийн төв банкны үүргийг гүйцэтгэдэг.

Хонконгийн Мөнгөний бодлогын газар нь хуулиар дамжуулан хариуцлага хүлээнэ. Санхүүгийн Нарийн бичгийн дарга нь Хөрөнгийн санг удирдахдаа Хөрөнгийн Сангийн зөвлөх хорооны зөвлөгөөг авдаг байна.

**Хонконгийн Үнэт цаас, фьючерс гэрээний комисс** нь “үнэт цаас, фьючерс зах зээлийн эмх цэгцтэй үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, Хонконгийг олон улсын санхүүгийн төв, Хятадын санхүүгийн гол зах зээл болгох” зорилгоор үнэт цаас болон фьючерс гэрээнүүдийг зохицуулах үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь бие даасан, хууль ёсны байгууллага юм.

Санхүүгийн системийг зохицуулах Институтийн загвар нь зохицуулалтын орчинг тархай бутархай болгож, банк-даатгал хосолсон үйл ажиллагааг явуулдаг санхүүгийн байгууллагуудтай харилцахад төвөгтэй нөхцөлийг үүсгэж байна. Иймэрхүү хосолсон үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад зохицуулалт давхардах, хоорондоо зөрчилдөх нөхцөл байдлууд үүсдэг. Энэ тохиолдолд зохицуулагч агентлаг санхүүгийн системийн тогтвортой байдал, зах зээлийн нөхцөл болон хэрэглэгчдийг хамгаалах чиглэлээр хариуцлага хүлээх ёстой.

Хуулийн этгээдийн хэлбэр дээр үндэслэн ямар төрлийн үйл ажиллагаа явуулах, ямар төрлийн бүтээгдэхүүн санал болгодгийг нь тогтоож болох ч санхүүгийн фирмүүдийн хувьд өөрсдийн санал болгох бүтээгдэхүүний төрлүүд дээр хийгддэг зохицуулалтыг өөрчлөхөд шинэ бүтээгдэхүүн санал болгохыг эрхэмлэдэг. Орчин үед эрх баригчид эдгээр шинэ бүтээгдэхүүнүүдийг удирдах өөрсдийн зохицуулалтын хүрээг өргөтгөх чиглэлээр анхаарч байна.

### **Хоёр.ФУНКЦИОНАЛЬ ЗАГВАР**

Функциональ арга нь хуулийн этгээдийн хэлбэрийг үл харгалзан, харин санхүүгийн зохицуулалтанд хамрагдаж байгаа бүтээгдэхүүн, гүйлгээний төрлүүдэд чиглэгддэг. Иймээс олон төрлийн гүйлгээг эрхэлдэг хуулийн этгээд маш олон төрлийн зохицуулалтад хамаардаг байна. Санхүүгийн зохицуулагч бүр нь хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хариуцах бөгөөд зохицуулагчийн үйл ажиллагаа, эрх мэдлийн хүрээгээр тодорхойлогдсон бүтээгдэхүүний төрөл бүрт хамаарна. Энэхүү загварыг одоогоор Итали, Франц, Бразил улсууд хэрэглэж байна.

#### **2.1.Итали Улс**

Итали Улсад банк, хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, даатгалын тогтолцоо нь хяналт, шалгалт, дүрэм журам тогтоосон эрх зүйн зохицуулалтад үндэслэнэ. Италийн төв банк нь мөнгөний бодлогыг тодорхойлдог бөгөөд Европын Төв банкуудын системийн гишүүн байна. Төв банк нь зохицуулалт, хяналт шалгалтын чиг үүргийг гүйцэтгэхээс гадна санхүүгийн системийн тогтвортой байдлыг хариуцна. Холбогдох журам батлах, хяналт шалгалтын чиг үүргээс гадна холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох, оролцох, татан буулгах зэргээр өргөн хүрээний хариуцлага тооцох зохицуулалтыг мөн хэрэгжүүлдэг.

**Хуулийн этгээд, хөрөнгийн биржийн хороо** нь хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагааны удирдлагын асуудлыг чиглүүлэн ажилладаг.

Хороо нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах, санхүүгийн зах зээлийн оролцогчдын ил тод, зөв зан үйлийг хангах, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас олон нийтийг бүрэн дүүрэн, үнэн зөв мэдээллээр хангаж буй эсэх, олон нийтэд санал болгож буй үнэт цаасны хэтийн төлөв, бодит байдлыг хангах, тусгай эрх бүхий аудитуудын шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх болон дотоод худалдаа, зах зээлийн залилан мэхлэхтэй холбоотой зөрчлүүдэд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

## 2.2.Франц Улс

Франц Улсад мөн функциональ зохицуулалтын загварыг ашигладаг байна. 2010 онд Францын төв банкны дэргэд байгуулагдсан **Францын хяналт шалгалтын газар** (Autorité de contrôle prudentiel et de résolution) (ACPR) нь бие даасан, хараат бус захиргааны байгууллага бөгөөд банк, даатгалын компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг явуулдаг.

Тус байгууллага нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хариуцаж, холбогдох хэм хэмжээний хэрэгжилтийг хангах, хянах, зохицуулах чиглэлээр ажиллана.

Тус газраас гадна Autorité des Marchés Financiers (AMF) буюу хөрөнгө оруулагчид ил тод бодитой мэдээлэл хүлээн авах боломжийг хангах болон санхүүгийн зах зээлийн цэгцтэй байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг хамгаалах үүрэгтэй бие даасан байгууллага ажилладаг.

Функциональ аргын дутагдалтай тал нь санхүүгийн зохицуулагч нар тухайн үүссэн нөхцөл байдал, хуулийн этгээд, санхүүгийн системд учраад буй аюулыг өөр өөр өнцгөөр буюу харилцан адилгүй авч үзэх, үнэлэх явдал юм. Цаашилбал, асуудал аль санхүүгийн зохицуулагч байгууллагад хамаарах харьяаллыг тогтоохын тулд зохицуулагдаж буй үйл ажиллагааны төрлийг нарийн тодорхой тогтоох шаардлагатай байна.

Санхүүгийн зохицуулалтын энэхүү загвар нь зохицуулагч байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа өндөр түвшинд байгаа тохиолдолд нийтлэг бөгөөд үр дүнтэй байх боломжтой.

Мөн нэг дутагдалтай тал нь хайбрид буюу эрлийз санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой гэж үзэж байна.

Нэмж дурдахад, энэ арга нь сүүдрийн банкуудын өсөлт, ач холбогдол, болзошгүй аюулыг зохих ёсоор хангаж чадах эсэх нь эргэлзээтэй байна.

### Гурав.ХОСЛУУЛСАН БУЮУ НЭГТГЭСЭН ЗАГВАР

Энэхүү загварт санхүүгийн зах зээлийн аюулгүй болон найдвартай байдал, үйл ажиллагааны хяналтыг зохицуулалтын нэг байгууллага хариуцдаг тогтолцоо хамаарах ба энэ загварыг одоогоор Япон, Сингапур, Герман, Скандинавын орнуудад ашиглаж байна. Хослуулсан буюу нэгтгэсэн загвар нь судалгаанд хожим дэлгэрэнгүй өгүүлэх “Twin Peaks” загвараас ялгаатай: энэ загвар нь тогтвортой ажиллагаа болон хяналтыг хослуулан зохицуулдаг бол “Twin Peaks” загвар нь энэ хоёр асуудлыг салгаж зохицуулдаг байна.

## 3.1.Япон Улс

Японд **Санхүүгийн үйлчилгээ эрхлэх агентлаг** (Financial Services Agency) нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банк, үнэт цаас, валют арилжаа, даатгалын үйл ажиллагааг хянах үүрэгтэй. Мөн хадгаламж эзэмшигчид, даатгалын бодлого эзэмшигч (insurance policy holders), үнэт цаасны хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа болон үнэт цаасны гүйлгээнд хяналт тавих үүрэгтэй.

Тус агентлаг нь Японы Сайд нарын танхимд хамаарахгүй. Агентлагийг комиссар (Commissioner) удирдаж, Сангийн сайдад үйл ажиллагаагаа тайлагнана. Үнэт цаас, биржид хяналт тавих хороо (Securities and Exchange Surveillance Commission, SESC) болон Мэргэшсэн нягтлан бодогч, аудитын хяналтын зөвлөл (Certified Public Accountants and Auditing Oversight Board) нь тус агентлагт хамаарна.

Санхүүгийн үйлчилгээ эрхлэх агентлагын зорилго нь санхүүгийн шударга, ил тод зах зээлийг хадгалах, санхүүгийн системийн хэрэглэгчдийг хамгаалах, хэрэглэгчдийн тав тухыг нэмэгдүүлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг бий болгоход оршино.

### **3.2. Сингапур Улс**

1970 онд Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газрын эрх зүйн байдлын тухай хууль (Monetary Authority of Singapore Act, 1970) батлагдаж 1971 онд Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газар (Monetary Authority of Singapore, MAS) тус улсын санхүүгийн үйлчилгээний салбарыг зохицуулахаар байгуулагдсан байна.

Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газар нь Сингапурын төв банк бөгөөд санхүүгийн нэгдсэн зохицуулагчийн хувьд мөнгө, банк санхүү, даатгал, үнэт цаас, санхүүгийн салбарыг удирдах ба 2002 оноос Валютын Комиссаруудын Зөвлөлтэй нэгтгэсний дараа валютын гүйлгээний үүргийг гүйцэтгэж байна.

Санхүүгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж байгаагийн хувьд Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газар нь тус улсын бүх санхүүгийн байгууллагууд болох банкууд, даатгуулагчид, хөрөнгийн зах зээлийн зуучлагчид, санхүүгийн зөвлөхүүд, хөрөнгийн биржүүдийн санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн тогтвортой байдалд нэгдсэн хяналтыг тавина. Мөн тус байгууллага нь жижиг хөрөнгө оруулагчдын боловсролыг хариуцаж ажилладаг.

Сингапур Улс нь санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлийн менежментийн тогтолцоог боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чадвартай гэдгээрээ үнэлэгддэг. Тус улсын амжилттай хэрэгжиж байгаа энэхүү зохицуулалт нь буруутай үйлдлийг нотлох биш, харин эрсдэлийн талаарх мэдээлэл болон төрийн албадлагын механизмыг хослуулсан явдал юм. Энэ нь Сингапурын банкны салбарт “мэргэжлийн шударга байдал”-ыг тууштай барьдаг баталгаанд тулгуурлаж байна. Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газраас явуулж байгаа хяналт шалгалт, өгсөн сануулга бол маш ноцтой асуудал болох бөгөөд хэрэв хууль, дүрмийг зөрчсөн тохиолдолд их хэмжээний торгууль ногдуулах, эсхүл хорих ялаар шийтгүүлдэг байна. 2011 онд Сингапурын Хөгжлийн банк (Development Bank of Singapore)-ны бэлэн мөнгөний машинууд 7 цагийн турш (өглөөний 3 цагаас 10 цаг хүртэл) түр зогсолт хийсэн бөгөөд үүнээс ойролцоогоор 1 цаг 30 минут нь ажлын цагаар доголдсон буюу ажиллаагүй байна. Үүний улмаас Сингапурын Мөнгөний асуудал эрхлэх газраас тус банканд үйл ажиллагааны эрсдэлийн хөрөнгийг 230 сая сингапур доллараар нэмэгдүүлэх, уг хөрөнгийг дараа оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд хадгалах шаардлагыг тавьсан байна.



### 3.3.Герман улс

Тус улсад Германы Бундесбанк (Deutsche Bundesbank, DB) болон Холбооны санхүүгийн хяналтын газар (BaFin) нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хяналт тавих үүрэгтэй. Германы Бундесбанкийн зохицуулалтын үндсэн зарчим нь хадгалуулагчийн төдийгүй, мөн зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангадаг байна.

Хяналт нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хэлбэр, цар хүрээ, эрсдэл зэргээс хамаарна. Үүнтэй холбогдуулан зохицуулагч байгууллага нь тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар нь шаардлага хангасан эсэх, эрсдэлээ хянах механизмтай эсэх дээр анхаарлаа хандуулдаг байна.

Холбооны санхүүгийн хяналтын газар нь хяналт тавих дээд байгууллага, харин Германы Бундесбанк нь макро эдийн засгийн хяналтыг хариуцна. Холбооны санхүүгийн хяналтын газрын хяналтын зарчмыг Бундесбанктай зөвшилцсөний үндсэн дээр гаргасан бөгөөд тэдгээрийн хоорондын ажиллагааг Банкны үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулна.

Хяналтын зарчим нь эрх мэдлийн давхцалаас урьдчилан сэргийлэх зорилгоор түүний хүрээг нь нарийвчлан тогтоосон байна. Банкны үйл ажиллагааны тухай хуулийн 7(1)-д заасны дагуу тогтоосон хүрээнд Германы Бундесбанк нь хяналтыг тогтмол хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус банк нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримт, нотолгоонууд олж авах, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодит байдал болон болзошгүй эрсдэл, аудитын үр дүнг үнэлнэ.

Германы Бундесбанк нь хяналтын энэ чиг үүргээ Санхүүгийн тогтвортой байдлын тухай хууль (Gesetz zur Überwachung der Finanzstabilität (FinStabG))-ийн дагуу хэрэгжүүлнэ.

Холбооны санхүүгийн хяналтын газар (BaFin)-ын хувьд тухайн байгууллагын хүлээсэн эрсдлийн бодлого нь түүний үйл ажиллагааны бодлого, стратеги, журам, механизм зэрэгт нийцэж байгаа эсэх, мөн эрсдэлийн зохистой менежментийг хангасан эсэх, зохих хөрөнгөнд нийцсэн эсэх талаар хяналт, үнэлгээний эцсийн шийдвэр, тайлбарыг гаргана. Тус газар нь эцсийн шийдвэр, тайлбарыг гаргахдаа Германы Бундесбанкийн зөвлөмжид тулгуурлана.

#### **Дөрөв.TWIN PEAKS БУЮУ ХОСОЛМОЛ ЗОХИЦУУЛАГЧ**

Энэ загвар нь объектив эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогддог. Энэхүү зохицуулалт нь хоёр зохицуулагчаас бүрддэг бөгөөд тэдгээрийн зорилго нь системийн тогтвортой байдал, алтернатив сонголтыг санал болгох болон зах зээлийг удирдах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах явдал юм. Ийм зохицуулалттай орнуудад Австрали, Нидерланд Швейцар, Катар болон Испани улсууд орно. Итали, Франц, АНУ зэрэг орнууд санхүүгийн зохицуулалтын энэ аргыг ашиглах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.

Санхүүгийн зохицуулалтын "Twin Peaks"-ийн загварт системийн үр дүнтэй олон элементүүд байдаг бөгөөд тэдгээрийн дор эдийн засгийн хяналт, зах зээлийн бие даасан зохицуулагчид байдаг. Эдгээр нь зохицуулагч тус бүрийн хоорондын зорилго, чиг үүрэг болон хариуцлагыг тодорхой хуваарилах; зохицуулагч

хоорондын үр дүнтэй уялдаа холбоо; ил тод байдал, хариуцлага; хяналт болон албадлагын эрх мэдлийг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хараат бус байдал (гүйцэтгэх засаглалын хувьд); засаглалын зохистой тогтолцоо, хангалттай нөөц боломжтой байх асуудал багтдаг. Гэсэн хэдий ч эдгээр бүх шалгуурыг харгалзсан “Twin Peaks” зохицуулалтын систем нь санхүүгийн хямралаас хамгаалах баталгаа болж чадахгүй.

“Twin Peaks” нь хамгийн сайн эхлэл, хамгийн оновчтой зохицуулалтын бүтэц, хамгийн сайн баталгаа, нотолгоог санал болгодог загвар гэж үздэг. Санхүүгийн хямралаас зайлхийх нь тус загварыг ашигладаг улс орны манлайлал, соёл, тулгадмсан асуудал, томоохон ашиг сонирхлын асуудлыг хэрхэн шийдвэрлэхээс хамаарна. Энэ нь эргээд улс төрчдийн санхүүгийн салбарт хийх дайралт, Засгийн газраас зохицуулагчдын төсөв санхүүг хэрхэн хангахаас хамаардаг байна.

Энэхүү загварын талаар Уинстон Черчилл “Twin Peaks” бол төгсгөлийн эхлэл биш юм. Энэ нь зөвхөн эхлэлийн төгсгөл юм<sup>1</sup>. гэж бичжээ.

#### 4.1.Австрали Улс

Тус улс “Twin Peaks” загварыг 1997 онд Уэоллисийн судалгааны хорооны дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлсэн. Австралийн загварыг гурван зохицуулагчтай загвар гэж тодорхойлдог. Эдгээр зохицуулагч бүр бие даасан, хууль ёсны байгууллага юм.

Австрали Улсын хувьд зах зээлийн үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага болох Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын комисс (ASIC), Австралийн зохицуулах байгууллага (APRA) болон Төв банк гэсэн гурван байгууллагаас бүрддэг.

**Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын комисс (ASIC)**<sup>2</sup> нь зах зээлийн үйл ажиллагаа, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан, хараат бус байгууллага юм. Үйл ажиллагаагаа жил бүр Холбооны парламентад тайлагнадаг. 2001 онд Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын комиссын тухай хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаандаа Корпорацийн тухай хуулийг дагаж мөрддөг.

Дараах чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- Санхүүгийн систем болон түүнтэй холбоотой аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, сайжруулах;
- Хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийн санхүүгийн системд итгэх итгэл, оролцоог дээшлүүлэх;
- Хууль тогтоомжийг хамгийн бага процедураар үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Мэдээллийг хурдан шуурхай хүлээж авах, боловсруулах, хадгалах гэх мэт.

**Австралийн зохицуулах байгууллага (APRA)**<sup>3</sup> нь Австралийн санхүүгийн системийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, банкны хөндлөнгийн хяналт хийх чиг үүрэгтэй бие даасан, хараат бус байгууллага юм. Тус байгууллага нь 1998 онд

<sup>1</sup> The four methods of financial system regulation: An international comparative survey, page 172

<sup>2</sup> <https://asic.gov.au> Australian Securities and Investment Commission (ASIC)

<sup>3</sup> <https://www.apra.gov.au> Australian Prudential Regulation Authority (APRA)

байгуулагдсан, жил бүр тайлангаа Холбооны парламентад тайлагнадаг.

Австралийн зохицуулах байгууллагын тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг.

Тус байгууллага нь санхүүгийн байгууллагууд хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг хангах үүрэгтэй. Энэ нь хадгаламж эзэмшигч байгууллагууд, амь нас болон ерөнхий даатгалын компаниуд, томоохон хэмжээний тэтгэврийн сангуудын аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлдэг.

Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын комисс (ASIC)-той 2016 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

**Төв банк** (Reserve Bank of Australia (RBA))<sup>4</sup> Австралийн нөөцийн банк нь Австралийн төв банк юм. Мөнгө, санхүү болон төлбөрийн системийн бодлого, үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргах болон бусад асуудлыг хариуцдаг бие даасан төв банк юм.

Тус банк нь 1959 оны Нөөцийн банкны тухай хууль болон Парламентын хуулийн дагуу байгуулагдсан. 2013 онд батлагдсан Төрийн удирдлага, гүйцэтгэл, хариуцлагын тухай хуулийн дагуу төр болон Төв банк хоорондын харилцааг зохицуулдаг.

**Санхүүгийн зохицуулах зөвлөл** (Council of Financial Regulators, CFR)<sup>5</sup> нь агентлаг хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, хянах зорилготой бөгөөд Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын комисс, Австралийн зохицуулах байгууллага, Төв банк болон Австралийн нөөцийн сан гэсэн 4 гишүүнтэй, хараат бус байгууллага. Санхүүгийн зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Зөвлөлийн уулзалтыг Төв банкны нарийн бичгийн даргын дэмжлэгтэйгээр Төв банкны ерөнхийлөгч удирддаг. Зөвлөлийн уулзалт улиралд нэг удаа болдог бөгөөд шаардлагатай тохиолдолд зарлан хуралддаг. Хурлаар дараах асуудлыг хэлэлцдэг. Үүнд:

- санхүүгийн систем дэх чухал шаардлагатай асуудлыг тодорхойлох, түүнд нөлөөлж болзошгүй асуудлыг тодорхойлох;
- санхүүгийн тогтвортой байдлын асуудал;
- нөхцөл байдалд тохирсон хариу арга хэмжээний талаар;
- санхүүгийн тогтворгүй байдлын талаар;
- гишүүдийн чиг үүргийн давхардлыг шийдвэрлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Тус байгууллага нь байгуулагдсанаасаа хойш амжилттай ажиллаж ирсэн бөгөөд ялангуяа хямралын үед санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюулын эсрэг хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга болсон гэж үздэг.

#### 4.2.Швейцар Улс

Швейцар Улсын хувьд Үндэсний банк нь санхүүгийн тогтвортой байдлыг хариуцдаг.

<sup>4</sup> <https://www.rba.gov.au/about-rba/> Reserve Bank of Australia (RBA)

<sup>5</sup> <https://www.rba.gov.au/fin-stability/reg-framework/cfr.html> Council of Financial Regulators (CFR)



Төлбөр болон үнэт цаасны төлбөр тооцооны системийг хянах ажлыг Швейцарын Үндэсний банк хариуцдаг. Үүнтэй холбогдуулан Үндэсний банк нь Швейцарын Санхүүгийн зах зээлийн хяналтын газар (FINMA)-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж хоёр байгууллагын бие даасан эрх мэдлийг тодорхойлж, хамтран ажилладаг. Харилцан ойлголцлын санамж бичгээр хамтын ажиллагааг зохицуулдаг.

Швейцарын Үндэсний банк нь зах зээлийн үйл ажиллагаагаа дахин санхүүжүүлэх боломжгүй болсон дотоодын банкуудад хөрвөх чадварын туслалцаа үзүүлэх болон зээл олгох асуудлыг хариуцдаг.

Банкны салбар дахь хяналт шалгалтыг Швейцарын **Санхүүгийн зах зээлийн хяналтын газар** (FINMA) хариуцдаг. Тус газар нь банкууд, даатгалын компаниуд, хөрөнгийн биржүүд, үнэт цаасны дилерүүд, хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо, дистрибьютерүүд болон даатгалын зуучлагч нарыг удирдана. Зөвшөөрөл олгох болон мөнгө угаахтай тэмцэх үүрэгтэй. Мөн хариуцлага ногдуулах, шаардлагатай бол бүтцийн өөрчлөлт хийх болон дампуурлын хэрэг үүсгэх үйл ажиллагаа явуулна.

#### 4.3.Катар Улс

**Катарын Санхүүгийн зах зээлийн газар** (QFMA) нь санхүүгийн зах зээл болон үнэт цаасны компаниудыг хянах зорилгоор байгуулагдсан бие даасан зохицуулагч байгууллага юм. Хөрөнгийн зах зээл дээр дүрэм журмыг мөрдүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй. Үүний зорилго нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах, санхүүгийн зах зээлийн үр ашигтай, шударга байдлыг хангах, санхүүгийн бүрэн бүтэн, ил тод байдлыг сайжруулах болон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төөрөгдөлд оруулах, хууран мэхлэхээс урьдчилан сэргийлэх юм.

**Катарын Санхүүгийн төв зохицуулах газар** нь санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг иргэд, компаниудад зөвшөөрөл олгох болон зохицуулах чиг үүрэг бүхий зарчимд суурилсан бие даасан зохицуулах байгууллага юм. Зорилго нь үр ашигтай, ил тод, бүрэн бүтэн байдал болон итгэл үнэмшилд туслалцаа, дэмжлэг үзүүлэх түүнчлэн системийн эрсдлийг бууруулах болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад туслалцаа үзүүлэх явдал юм. Мөн үйлчлүүлэгчид болон хөрөнгө оруулагчдыг хамгаалах болон санхүүгийн мэдлэгийг хөгжүүлэхэд оршино.

Катарын санхүүгийн төв байгууллагууд болон тэдгээрийн түншүүдийн хоорондох маргааныг шийдвэрлэх, арбитр болон иргэний маргааны албан ёсны шийдвэр гаргах зорилготой Иргэний болон худалдааны шүүхийг байгуулсан. Мөн Катарын санхүүгийн төв зохицуулах байгууллагын гаргасан шийдвэрийн эсрэг аж ахуйн нэгж, хувь хүний давж заалдах хүсэлтийг хянан шийдвэрлэх Катарын санхүүгийн төвийн Зохицуулах шүүхийг байгуулсан.

#### 4.4.Испани Улс

Испанийн загварт Испанийн банк, үнэт цаасны зах зээлийн үндэсний комисс, Даатгал, тэтгэврийн сангийн ерөнхий газар багтдаг.

**Испанийн банк** нь хяналт, зохицуулалтыг хариуцдаг. Банкны хяналт шалгалтын үйл ажиллагааны зорилго нь ирээдүйн банкны хямралыг урьдчилан харах, урьдчилан сэргийлэх замаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, чадавхжуулах зорилгоор байгууллага бүрийн эрсдэлийн төрлийг тодорхойлох явдал юм.


Испанийн банкны ашигладаг аргыг "Эрсдэлийн хандлагаар банкны үйл ажиллагааг хянах (SABER)" гэж нэрлэдэг бөгөөд энэ нь үнэлгээний нэгдсэн тогтолцоог хангах зорилготой юм. SABER нь ирээдүйд аль институтад илүү бэрхшээл үүсэх магадлалтайг тодорхойлох зорилготой. Тодорхой үнэлгээнээс дээш эрсдэлийн хяналтын түвшин бүхий институтэд онцгой анхаарал хандуулдаг. Өөр өөр институтын хяналт шалгалтын хамрах хүрээ нь эрсдлийн хяналтын түвшин болон институтын системд эзлэх байр сууринаас хамаардаг. Хамрах хүрээг шаардлагатай тохиолдолд шинэчилж болох бөгөөд энэ нь жилд нэг удаа байна.

**Испанийн үнэт цаасны зах зээлийн үндэсний комисс** нь Испанийн хөрөнгийн зах зээл, түүнд оролцогчдын үйл ажиллагааг хянах, зах зээл дэх ил тод байдлыг хангах, үнэ тогтоох болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй. Мөн зарим тохиолдолд хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг.

Комисс нь олон нийтэд үнэт цаас гаргах, үнэт цаасны хоёрдогч зах зээл болон хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхэлдэг компаниудыг хариуцдаг. Мөн хоёрдогч зах зээл болон хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхэлдэг компанийн гүйлгээний аюулгүй байдал, төлбөрийн чадварыг баталгаажуулах зорилгоор хяналт, шалгалт хийх эрхтэй.

**Испанийн даатгал, тэтгэврийн сангийн Ерөнхий газар** нь хувийн даатгал ба давхар даатгал, даатгалын брокер, тэтгэврийн асуудлыг хянаж, зохицуулдаг. Энэ нь гомдол гаргах үйл явцаар дамжуулан бодлого боловсруулагч, тэтгэмж авагч, гуравдагч этгээд, тэтгэврийн асуудалд оролцогчдыг хамгаалдаг.

Даатгал, тэтгэврийн сангийн ерөнхий газар нь хөрөнгө болон өр төлбөрийн үнэлгээг шалгаж, дагаж мөрдөх байдлын ерөнхий үнэлгээ хийж, эрсдэл, төлбөрийн чадварын үнэлгээг хийдэг. Үүнээс гадна зах зээлийн үйл ажиллагааг хянах үүрэгтэй.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- The four methods of financial system regulation An international comparative survey. <https://www.researchgate.net/publication/290434254>
- Australian Prudential Regulation Authority (APRA) <https://www.apra.gov.au>
- Australian Securities and Investment Commission (ASIC) <https://asic.gov.au>
- Reserve Bank of Australia (RBA) <https://www.rba.gov.au/about-rba/>
- Council of Financial Regulators (CFR) <https://www.rba.gov.au/fin-stability/reg-framework/cfr.html>



**БНХАУ-ЫН ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ХОРООНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ**

(Мэдээлэл, лавлагаа)

*Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

1. Ерөнхий мэдээлэл
2. Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны дотоод бүтэц, зохион байгуулалт
3. Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг
4. Үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт
5. Хавсралт



## БНХАУ-ЫН ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

**Ерөнхий мэдээлэл:** БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо <sup>6</sup> нь (National Development and Reform Commission of the People's Republic of China (NDRC), (国家发展和改革委员会)) Төрийн зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг макро эдийн засгийн удирдлагын газар бөгөөд эдийн засагт захиргааны болон төлөвлөлтийн хяналт тавьдаг байгууллага юм.

Тус хороо нь өмнө нь Улсын төлөвлөлтийн комисс (1952-1998), Улсын хөгжлийн төлөвлөлтийн комисс (1998-2003), Үндэсний бүтээн байгуулалт, шинэчлэлийн хороо (2003-2008), Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо (2008 оноос “Институт байгуулах тухай Төрийн зөвлөлийн мэдэгдэл”-ийн дагуу улсын эдийн засгийн орчин, төлөвлөлтийг сайжруулах, нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн зөвлөлийн бүрэлдэхүүн хэлтэс болсон), Үндэсний хөгжил, шинэчлэлийн комисс (2013-2018) нэртэй байсан.

Хятад улс Төрийн зөвлөлийн институцийн шинэчлэлийг Үндсэн хууль болон Төрийн зөвлөлийн Органик хуульд <sup>8</sup> нийцүүлэн 8 удаа хийсэн бөгөөд энэхүү өөрчлөлтөөр (1982, 1988, 1993, 1998, 2003, 2008, 2013, 2018 <sup>9</sup> онд болсон) Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны нэр болон бүтэц, чиг үүргийг тухай бүр өөрчлөн зохион байгуулсаар иржээ.

Хамгийн сүүлд 2018 оны 3-р сард Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн 13-р Их хурлын анхдугаар хуралдаанаар батлагдсан Төрийн зөвлөлийн институцийн шинэчлэлийн төлөвлөгөөний <sup>10</sup> дагуу Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны бүтэц, чиг үүргийг дахин шинэчлэн баталж, өмнө нь 26 байсан хэлтсийн тоог 24 болгон багасган зарим чиг үүрэг, үйл ажиллагааг бусад газарт шилжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Монополийн эсрэг хууль болон үнийн удирдлагыг шинээр байгуулагдсан Зах зээлийг зохицуулах улсын захиргаанд;
- ✓ бүсүүдийг тогтоон байгуулах үүргийг шинээр байгуулагдсан Байгалийн баялгийн яаманд;
- ✓ хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтын төслүүдэд зөвшөөрөл олгох үүргийг Хөдөө аж ахуй ба хөдөө орон нутгийн хэргийн яаманд;
- ✓ Цаг агаарын өөрчлөлт хариуцсан нэгж нь Хүрээлэн буй орчны яаманд;
- ✓ эрүүл мэндийн үйлчилгээний үнэ тогтоох үүрэг шинээр байгуулагдсан Улсын эрүүл мэндийн хороонд;
- ✓ улс үндэстний гол томоохон төслүүдийг хянах үүрэг Улсын аудитын албанд тус тус шилжсэн <sup>11</sup>.

<sup>6</sup> <http://en.ndrc.gov.cn/>

<sup>7</sup> <http://politics.people.com.cn/GB/1026/7163969.html>

<sup>8</sup> Organic Law of the State Council of the People's Republic of China  
[http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/13/content\\_1384048.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/13/content_1384048.htm)

<sup>9</sup> [http://www.xinhuanet.com/politics/2018lh/2018-03/17/c\\_1122552185.htm](http://www.xinhuanet.com/politics/2018lh/2018-03/17/c_1122552185.htm)


<sup>10</sup> <https://baike.baidu.com/item/国务院机构改革方案>

<sup>11</sup> <https://www.uschina.org/policy/national-development-and-reform-commission>

## **Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны дотоод бүтэц, зохион байгуулалт<sup>12</sup>**

2018 оны шинэчлэлээр Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо (ҮХШХ) нь үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг 24 хэлтэс<sup>13</sup>, шууд харьяаны 5 хороо, товчоо, захиргаа бүхий дараах бүтэцтэй болжээ. Үүнд:

Схем зураг



<sup>12</sup> <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/jgsz/>

<sup>13</sup> <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/znbm/>

## **Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг<sup>14</sup>**

Тус хороо нь Төрийн зөвлөлийн институцийн шинэчлэлийн төлөвлөгөөний дагуу дараах 15 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Улсын эдийн засаг нийгмийн хөгжлийн стратеги, жилийн төлөвлөгөө, хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулах; эдийн засаг болон нийгмийн хөгжлийг зохицуулах; дотоод гадаадын эдийн засгийн нөхцөл байдлын судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх; улсын эдийн засгийн хөгжилтэй холбоотой зорилтууд болон бодлогын, мөн ерөнхий үнийн түвшний зохицуулалт, үндсэн эдийн засгийн бүтцүүдийг оновчтой зохицуулах талаар санал дэвшүүлэх, улмаар олон хувилбарт эдийн засгийн арга хэрэгсэл, бодлогууд хэрэгжүүлэхийг санал зөвлөмж болгох; улсын эдийн засаг, хөгжлийн төлөвлөгөөг Төрийн зөвлөлийн нэрийн өмнөөс Үндэсний ардын хуралд өргөн барих.

2. Макро эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг хянаж, урьдчилсан прогноз, сэрэмжлүүлэг болон мэдээллийн удирдамжаар хангах; макро эдийн засгийн үзүүлэлт, бүрэлдэхүүний тэнцвэр, улсын эдийн засгийн аюулгүй байдал, ба ерөнхий аж үйлдвэрийн аюулгүй байдлын чухал асуудлуудыг судалж макро эдийн засгийн менежментийн талаар бодлого, санал зөвлөмжийг гаргах; эдийн засгийн үйл ажиллагааны гол гол асуудлыг зохицуулах, анхаарал хандуулах, улмаар эдийн засгийн үзүүлэлтийг тохируулах; улсын онц чухал бараа материалын тээвэрлэлтийг зохицуулах зэргийг хариуцах.

3. Төсөв, санхүүгийн нөхцөлийг хураангуйлан шинжилж санхүү, мөнгө болон газрын бодлогыг боловсруулахад оролцох, мөн үнийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх; төсөв, санхүү болон газрын бодлогуудын хэрэгжилтийн үр дагавруудыг шинжилж, үнийн бодлогуудыг удирдан шалгах; улсын болон бусад тариф, төлбөрөөр зохицуулагддаг чухал эд барааны үнийг тогтоон зохицуулах болон холбогдох хууль, журмын дагуу үнийн зохицуулалтыг зөрчсөн үйл ажиллагааг мөрдөн илрүүлэх; Хятадын гадаад өрийн нийт хэмжээг ажиглаж, хяналт тавих, түүний бүтцийг тогтоох, олон улсын төлбөрийн тэнцэтгэлийг сурталчлан дэмжих.

4. Эдийн засгийн тогтолцооны бүтцийн өөрчлөлтийг удирдан чиглүүлэх, дэмжин сурталчлах ба зохицуулах; гадаад зах зээлтэй холбоотой томоохон асуудлуудыг судлах; эдийн засгийн тогтолцооны бүтцийг өөрчлөх иж бүрэн төлөвлөгөө боловсруулах, эдийн засгийн зорилтот бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг зохицуулах, мөн энэхүү төлөвлөгөөг бусад агентлагуудтай хамтран зохицуулах; эдийн засгийн тогтолцооны бүтцийн өөрчлөлтийн туршилтын төслүүдийг удирдан чиглүүлж, шинэчлэх туршилтын бүсүүдэд ажиллах.

5. Томоохон барилгын төслүүд болон үр ашгийн схем бүтцийг төлөвлөх; улсын үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ болон бүтэцтэй холбоотой зорилт, бодлого болон арга хэмжээнүүдийг боловсруулах; төв засгийн газрын хөрөнгө оруулалт болон тэнцвэртэй эрэлтийн үүднээс барилгын төслүүдтэй холбоотой зорилтот төлөвлөгөөнүүдийг уялдуулан зохицуулах; эдийн засгийн байгуулалтын төсөв санхүүгийн зардлыг зохицуулах; бүтээн байгуулалтын

<sup>14</sup> <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/jj/>



барилгын төслүүд, гадаадын санхүүжилттэй чухал төслүүд, гадаад нөөцийг хөгжүүлэх чухал хөрөнгө оруулалтын төслүүд, Төрийн зөвлөлийн зөвшөөрлөөр их хэмжээний хөрөнгө оруулалт зэрэгт зөвшөөрөл олгох, удирдах, хяналт тавих; барилгын төслүүд дэх гадаад зээлийн хэрэглээг удирдан чиглүүлэх; хувийн хөрөнгө оруулалтыг удирдан чиглүүлэх.

6.Стратегийн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хөхиүлэн дэмжих; аж үйлдвэрийн цогц бодлого боловсруулах ажлыг зохион байгуулах, анхдагч, хоёрдогч болон гуравдагч үеийн аж үйлдвэрүүдийн хөгжлийн гарцыг тодорхойлж, зохицуулахын зэрэгцээ аж үйлдвэрийн хөгжлийг холбогдох төлөвлөгөө, улсын эдийн засаг болон нийгмийн хөгжлийн гол гол бодлого төлөвлөгөөнүүдтэй уялдуулан, тэнцвэржүүлэх; хөдөө аж ахуй, хөдөөгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол томоохон асуудлуудыг зохицуулах; үйлчилгээний аж үйлдвэрийн хөгжлийн стратеги, хөгжлийн бодлогуудыг бусад яамдтай хамтран боловсруулах; орчин үеийн тээвэр зуучлалын стратеги, төлөвлөгөөнүүдийг боловсруулах; хэрэглээний өөрчлөлтийн чиг хандлагыг нарийвчлан судалж, хэрэглээг дэмжих бодлогын цогц арга хэмжээг боловсруулах.

7.Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөг нэгтгэн зохион байгуулах, эдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, мониторинг болон үнэлгээг хийх; бүс нутгийн эдийн засгийн зохицуулалттай хөгжил, баруун бүс нутгийн хөгжил, зүүн умард бүс нутаг ба бусад аж үйлдвэрийн хуучин баазуудын сэргээн ашиглалт ба Хятадын төв бүс нутгийн дэвшил зэргийг сурталчлан дэмжих стратеги, төлөвлөгөө болон бодлогуудыг боловсруулах; хотжуулах шинэ стратеги ба бодлогуудыг судлан санал болгох; бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг удирдан чиглүүлж, зохицуулах.

8.Үйлдвэрлэлийн цогц бодлогыг боловсруулах, зохион байгуулах; хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн ба түүхий эдийн импорт, экспортын ерөнхий хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, улмаар эдгээр төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх; үр буудай, хөвөн, элсэн чихэр гэх зэргийн улсын нөөцийн бараа бүтээгдэхүүнийг бусад яамдын хамтаар удирдан зохион байгуулах.

9.Нийгмийн хөгжлийн бодлогуудыг улсын эдийн засгийн хөгжлийн бодлогуудтай уялдуулан зохицуулах; нийгмийн хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө зэргийг боловсруулах ажлыг зохион байгуулах; хөгжлийн бодлогуудыг хүн ам, гэр бүл төлөвлөлт, шинжлэх ухаан технологи, боловсрол, соёл, эрүүл мэнд ба иргэний захиргаа зэрэгтэй уялдуулан боловсруулахад оролцож, нийгэм журмыг байгуулах ажлыг сурталчлан дэмжих; улам бүр өсөн нэмэгдэж буй ажил эрхлэлт, орлогын хуваарилалтыг зохицуулах ба нийгмийн аюулгүй байдал болон эдийн засгийн хөгжлийн уялдааг сайжруулах талаар судалж, санал болон бодлого боловсруулан дэвшүүлэх; нийгмийн үйл ажиллагааны хөгжил, шинэчлэл дэх томоохон асуудлуудын шийдвэрлэлт болон бодлогуудыг уялдуулан зохицуулах.

10.Тогтвортой хөгжлийн стратегийг дэмжин сурталчлах; эрчим хүчийг хэмнэж цацрагийг бууруулах ажлыг зохицуулах; эдийн засгийн дахин боловсруулалт, улсын эрчим хүч болон нөөц баялгийн хадгалалт, ашиглалтыг боловсруулах болон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; экологийг сайжруулах болон байгаль орчноо



хамгаалах төлөвлөгөө боловсруулахад оролцох; эко барилга, эрчим хүч ба баялгийн хадгалалт, ашиглалт зэрэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх ажлыг зохицуулах; хүрээлэн буй байгаль орчинд ээлтэй аж үйлдвэр ба цэвэр бүтээгдэхүүнийг дэмжихэд чиглэсэн холбогдох ажлуудыг зохицуулах.

11.Инновацид суурилсан хөгжлийн стратеги хэрэгжүүлэхийг дэмжих үүднээс холбогдох хэлтэстэй хамтран инноваци, бизнес эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө, бодлогыг боловсруулж, эдийн засгийн хөгжилд ахиц гаргах бодлогыг санал болгох; Үндэсний шинжлэх ухаан, технологийн томоохон дэд бүтцийг төлөвлөх, байршуулах чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллах; Өндөр технологийн үйлдвэрүүд болон шинэ аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, аж үйлдвэрийг шинэчлэх, томоохон техник хэрэгслийг сурталчлах, ашиглах зэрэг асуудлыг шийдвэрлэх.

12.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, эдийн засгийн тогтолцооны бүтцийн өөрчлөлт ба түүнийг гадаад орчинтой холбох тухайд холбогдох хууль, журмуудын төслийг боловсруулах, төлөвлөгөөг боловсруулах; төндөр шалгаруулалтыг хууль, журмын дагуу удирдан зохицуулах.

13.Улсын эдийн засгийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, зохион байгуулах; улсын эдийн засгийн дайчилгааг улсын эдийн засаг ба батлан хамгаалах салбартай харьцуулан судлах, улсын эдийн засгийн дайчилгаатай холбоотой чухал асуудлуудыг зохицуулах, тэрчлэн хэрэгжилтийг зохион байгуулах.

14.Улсын батлан хамгаалах дайчилгааны комисс, Төрийн зөвлөлийн баруун бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх бүлгийн алба, Төрийн зөвлөлийн Зүүн умард Хятадыг нөхөн сэргээх тэргүүлэх бүлгийн алба болон бусад хуучин аж үйлдвэрийн баазууд, эрчим хүчний хадгалалт ба цацрагийг бууруулах Үндэсний тэргүүлэх бүлгийн алба, Улсын үр буудай, материал хангамжийн ерөнхий газар болон Үндэсний эрчим хүчний захиргаа зэргийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохицуулах;

15.Төрийн зөвлөлөөс даалгасан бусад үүргийг биелүүлэх зэрэг болно.

Дээрх үйл ажиллагааны чиг үүргийг хэлтэс тус бүр холбогдох чиглэлийн дагуу (Хавсралт <sup>15</sup>) хариуцан хэрэгжүүлдэг. Зөвлөлийн дарга бүх хорооны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг бол хэлтсийн дарга нар хариуцсан хэлтсийн үйл ажиллагааг удирдан явуулж, үр дүнг Зөвлөлийн даргад тайлагнадаг байна.

### **Хорооны үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт**

Төрийн зөвлөлийн шинэчлэлийн төлөвлөгөөгөөр хорооны чиг үүрэг болон ерөнхий бүтцийг баталсан бол Төрийн зөвлөлийн Органик хуулиар яам комиссыг байгуулах, татан буулгах, тэдгээрийн удирдлагыг томилж, чөлөөлөх, үйл ажиллагааны хүрээ зэргийг тогтоосон байна. Тухайлбал,

Төрийн зөвлөлийн Органик хуулийн 2-р зүйлд зааснаар Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд, Ерөнхий сайдын орлогч, яамдын асуудал эрхэлсэн сайд, **комиссын асуудал эрхэлсэн сайд**, Ерөнхий аудитор, Ерөнхий нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

<sup>15</sup> [https://www.uschina.org/sites/default/files/2018.12.28\\_ndrc.pdf](https://www.uschina.org/sites/default/files/2018.12.28_ndrc.pdf)

Мөн 5-р зүйлд **Ерөнхий сайд** Төрийн зөвлөлийн гаргасан шийдвэр, тушаал, захиргааны журам, Төрийн зөвлөлийн Үндэсний Ардын Их Хурал эсвэл түүний Байнгын хороонд ирүүлсэн саналд, **боловсон хүчний томилгоо, чөлөөлөлтөд** гарын үсэг зурна.

8-р зүйлд Төрийн зөвлөлийн **яам, комисс байгуулах, тэдгээрийн удирдлагыг томилох, татан буулгах, нэгтгэхийг Ерөнхий сайд санал болгож, БХАТИХ, Их хурал хуралдаагүй тохиолдолд түүний байнгын хороо шийдвэрлэнэ.**

9-р зүйлд Яам болгон сайд, хоёроос дөрвөн дэд сайдтай байна. **Комисс бүр сайд, хоёроос дөрвөн дэд сайд, комиссын таван гишүүнээс бүрддэг.**

**Яам, комиссын ажил хариуцсан сайд нь яам, комиссын ажлын ерөнхий хариуцлагыг хүлээнэ. Яам, комиссыг хариуцсан сайд нар өөрсдийн харьяа хэлтсийнхээ ажлыг удирдан чиглүүлнэ; сайд нарын хурал, комиссын ерөнхий ба гүйцэтгэх хуралдааныг хуралдуулж, даргалах; заавар, тайланг Төрийн зөвлөлд хүргүүлэх чухал хүсэлтүүдэд гарын үсэг зурах; харьяа хэлтсүүдэд тушаал, заавар өгөх; дэд сайдууд сайд нарын ажилд туслах зэрэг болно.**

10-р зүйлд Яам, хороо нь ажилдаа баримтлах зарчим, бодлого, төлөвлөгөө, захиргааны чухал арга хэмжээний талаар зааварчилгаа гаргахаас гадна Төрийн зөвлөлд тайлан гаргаж өгөх бөгөөд Төрийн зөвлөл тус асуудлаар шийдвэр гаргана. Эрх бүхий яам, комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомж, Төрийн зөвлөлийн шийдвэрийн дагуу тушаал, заавар, дүрмийг гаргаж болно гэж тус тус хуульчилжээ.

Дээрх хуульд зааснаар Комиссын даргыг БНХАУ-ын Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаар батлан томилдог. Мөн хуульд Комиссын удирдлагын бүрэлдэхүүнийг тодорхой заасан байх ба комисс бүр сайд, 2-4 дэд сайд, комиссын 5 гишүүнээс бүрдэнэ хэмээн хуульчилжээ.

Мөн 2018 оны Төрийн зөвлөлийн институцийн шинэчлэлийн төлөвлөгөөний дагуу Үндсэн хууль болон Төрийн зөвлөлийн Органик хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан Төрийн зөвлөлийн ажлын дүрэм<sup>16</sup> (Гуо Фа [2018])-д зааснаар Яам, **хороо**, Ардын банк, Үндэсний аудитын газрын сайд, захирал, Ерөнхийлөгч, ерөнхий аудиторуд нь хэлтсийн ажлыг удирдан явуулах, үүрэг хариуцлагыг хэрэгжүүлнэ. Мөн бүх яам, **хороо**, Ардын банк, Үндэсний аудитын газар нь хууль тогтоомж, захиргааны журам, Төрийн зөвлөлийн шийдвэр, тушаалын дагуу чиг үүрэг боловсруулж, бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргах эрхтэй гэж заажээ.

Төрийн зөвлөлийн Захиргааны байгууллага байгуулах тухай<sup>17</sup> 227-р тушаалын 21-т зааснаар Төрийн зөвлөлийн удирдах албан тушаалтнуудыг Төрийн зөвлөлийн Органик хуулийн дагуу харин Төрийн зөвлөлийн харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг Төрийн зөвлөлийн Органик хуулийн зарим заалтад үндэслэн холбогдох дүрэм журмын дагуу тогтооно гэж тус тус зохицуулжээ.

<sup>16</sup> [https://zh.wikisource.org/wiki/国务院工作规则\\_\(2018年\)](https://zh.wikisource.org/wiki/国务院工作规则_(2018年))

<sup>17</sup> <https://baike.baidu.com/item/%E4%B8%AD%E5%8D%8E%E4%BA%BA%E6%B0%91%E5%85%B1%E5%92%8C%E5%9B%BD%E5%9B%BD%E5%8A%A1%E9%99%A2%E4%BB%A4%E5%BC%88%E7%AC%AC227%E5%8F%B7%E5%BC%89/23190041>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://baike.baidu.com/reference/3216360/3e33xUpd2p7sJRJ2nmgc1lw-CRH159Bxvf7qWsdCoZlg1PBC-sLAETW96WV3WqiMv9xfUy3FApVKjq3Kfilf4jDeczCqkAwbk2v2Xt3FltovaAZ5B0VuYborZpDAf5>
- <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/jgsz/>
- [https://zh.wikisource.org/wiki/国务院工作规则\\_\(2018年\)](https://zh.wikisource.org/wiki/国务院工作规则_(2018年))
- [https://www.uschina.org/sites/default/files/2018.12.28\\_ndrc.pdf](https://www.uschina.org/sites/default/files/2018.12.28_ndrc.pdf)
- <http://en.ndrc.gov.cn/>
- <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/znbm/>
- <http://www.ndrc.gov.cn/zwfwzx/jj/>
- <http://politics.people.com.cn/GB/1026/7163969.html>
- Organic Law of the State Council of the People's Republic of China  
[http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/13/content\\_1384048.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/13/content_1384048.htm)
- [http://www.xinhuanet.com/politics/2018lh/2018-03/17/c\\_1122552185.htm](http://www.xinhuanet.com/politics/2018lh/2018-03/17/c_1122552185.htm)
- <https://baike.baidu.com/item/国务院机构改革方案>
- <https://www.uschina.org/policy/national-development-and-reform-commission>
- <https://baike.baidu.com/item/%E4%B8%AD%E5%8D%8E%E4%BA%BA%E6%B0%91%E5%85%B1%E5%92%8C%E5%9B%BD%E5%9B%BD%E5%8A%A1%E9%99%A2%E4%BB%A4%EF%BC%88%E7%AC%AC227%E5%8F%B7%EF%BC%89/23190041>

UIH.MN  
СҮДАЛГААНЫ САН

## 2 БҮЛЭГ

---

НИЙГЭМ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа  
Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Гадаадын зарим орны хотын нийтийн аж ахуйн харилцааг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалт:

1. Австралийн Холбооны Улс
2. Бүгд Найрамдах Латви Улс
3. Румын Улс
4. Бүгд Найрамдах Солонгос Улс

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ



## УДИРТГАЛ

Аливаа улс ард иргэдээ эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах бүхий л нөхцөл, баталгаагаар хангах үүргийг хариуцдаг. Үүний дагуу хүн амыг шаардлага хангасан цахилгаан эрчим хүч, ундны ус болон ариун цэврийн байгууламж, нийтийн тээвэр, харилцаа холбоо зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээгээр хангах ёстой.

Улс орны хөгжил, бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаатай уялдан нийтийн аж ахуйн үйлчилгээний цар хүрээ жил ирэх тусам улам өргөжин тэлж байгаатай холбогдуулан салбарын хөгжлийн бодлого, стратегийн чиг хандлагыг шинээр тодорхойлон боловсруулах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигддаг байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээ (НААҮ)- ний салбарын бүтэц, зохион байгуулалтын үндэс нь салбарын үйл ажиллагаа ба тодорхой чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх хариуцлагын оновчтой хуваарилалттай шууд холбоотой байдаг. НААҮ-г хэрэгжүүлж буй байгууллага нь хэрэглэгчдэд үйлчилгээг тасралтгүй, жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллах ёстой.

НААҮ-ний салбар нь онцлог зохицуулалт бүхий салбар бөгөөд нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс ашгийн бус байх шаардлагатай онцгой объект бүхий ус хангамж, ариун цэврийн төвлөрсөн байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчийн харьяалалтай байж, тухайн байгууламжийн тусламжтайгаар үйлчилгээ үзүүлэх байгууллага нь төр, хувийн хэвшлийн оролцоотой байх боломжтой юм. Гэвч хуулийн хэрэгжилт, салбарын норм, стандартыг мөрдүүлэх ажлыг нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байдаг тул төрийн захиргааны байгууллага заавал хариуцах ёстой гэж үздэг байна<sup>18</sup>.

**Судалгааны хамрах хүрээ:** Энэхүү судалгааг захиалагчийн хүсэлтийн дагуу нийтийн аж ахуйн үйл ажиллагааг ерөнхий бие даасан хуулиар зохицуулдаг Бүгд Найрамдах Латви улс, Бүгд Найрамдах Румын улс, Австралийн Холбооны улс болон салбар хуулиудаар зохицуулж буй Бүгд Найрамдах Солонгос улсын холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд авч үзлээ.

**Судалгааны хураангуй:** Судалгаанд хамрагдсан орнуудын (Австрали, Латви, Солонгос, Румын) туршлагаас үзэхэд нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоос гадна нийлүүлэлтэд чиглэсэн аргаас татгалзаж эрэлтэд чиглэх болж, цаашид хязгаарлагдмал нөөцөд тулгуурласан хандлагыг дэмжсэн зохицуулалтыг бий болгохыг илүүд үзсэн байна. Мөн өртөг, зардлыг нөхөх үнэ тарифын нэгдсэн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, техник, технологийн болон үйлчилгээний стандартыг ОУ-ын түвшинд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх, хуучирсан техник, технологийг шинэчлэн засварлах шаардлагууд тавигддаг.

Энэ ч үүднээс дэлхий нийтээр 1989 оноос эхлэн улсын төсвийн ачааллыг

<sup>18</sup> Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал, Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж МОН/13/302 төсөл, 2014 он.

бууруулах, хувийн хөрөнгө оруулагчдыг дэд бүтцийн салбарууд /цахилгаан дулаан болон холбоо/ руу татах, хүний нөөцийн асуудлыг тэнцвэртэй хуваарилах, нийтийн үйлчилгээг хурдан шуурхай хүртээмжтэй, чанартай түгээх үүднээс тусгай зохицуулагч байгууллагуудыг байгуулан гүйцэтгүүлэх чиг хандлага руу шилжжээ. Тухайлбал, Төв болон Зүүн Европын орнуудад энэ чиг хандлага түлхүү хэрэгжснээр АНУ-ын зохицуулалтын загвар, Их британийн загварууд түгээмэл хэрэглэгддэг болжээ. Энэ нь бие даасан зохицуулалтын загвар бөгөөд мэргэжлийн зохицуулагч албадуудад тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг, хэт нүсэр биш, иргэдээс ирж байгаа өргөдөл гомдлыг шударга өрсөлдөөний комисс нь шийдвэрлэдэг, хууль шүүхийн байгууллагын оролцоо бага байдаг загвар юм.

Цаашлаад нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагууд нь бусад салбаруудтай үйл ажиллагаагаа нягт уялдуулах, салбарын олон талт харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлчилгээг ашигласны төлбөр, хураамж зэрэг салбар дундын зохицуулалтын харилцан хамаарлыг сайжруулах нь ихээхэн чухал талаар ОУ-ын байгууллагууд, дэлхийн зээлдүүлэгч агентлагаас улс орнуудад зөвлөсөн байна.

НААҮ-ний салбарын чиг үүргийг оролцогч нэгжүүдэд оновчтой хуваарилж, удирдлагын түвшинд ажиллах төрийн байгууллагууд, хувийн хэвшил, ТББ, хэрэглэгчдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох нь чухал байдаг байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын статус, эрх зүйн байдлыг тодорхойлж, түүнд тохирсон чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг тогтоох хэрэгтэй. Тухайлбал, Румын улсад нийтийн үйлчилгээг тухайн хотын хөгжлийн түвшин болон нийгэм-эдийн засгийн ач холбогдол, техник, хотын дэд бүтцийн хүчин чадалд нийцүүлэн удирдан зохион байгуулсан бөгөөд иргэдийн тав тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг хангах үүднээс хэд хэдэн хотуудад нийтийн ажил үйлчилгээг шилжүүлэн гүйцэтгүүлэх ассоциацуудыг (орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, эсхүл бичил бүс нутгийн хөгжлийн ассоциацуудыг) байгуулсан байна.

Мөн Румын улс нийтийн үйлчилгээг шууд удирдан зохион байгуулах болон төлөөлүүлэн хариуцуулах менежментийн аргыг хослуулах байдлаар хэрэгжүүлж байна.

Улс орнуудад нийтийн аж ахуйн үйлчилгээг зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд зөвшөөрлийг хугацаатай болон хугацаагүй олгож байна. Зөвшөөрлийг тухайн төрлийн үйлчилгээг зохих түвшинд эрхлэн явуулах ерөнхий шаардлагыг хангасан байдал, холбогдох техникийн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан олгох бөгөөд холбогдох хууль тогтоомжуудаар тогтоосон бусад шаардлагыг бүрэн хангасан байхыг шаарддаг байна. Тухайлбал, БНСУ-д үйл ажиллагааны төрөл болон хамрах нутаг дэвсгэрээс нь шалтгаалан зөвшөөрлийг олгох бөгөөд нэг хүнд хоёр болон түүнээс дээш цахилгаан эрчим хүчтэй холбоотой зөвшөөрлийг олгохгүй, мөн хамрах хүрээний хувьд тодорхой дүүрэг, нутаг дэвсгэрийг давхардуулан олгодоггүй байна.

*(Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү.)*



## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нийтийн аж ахуйн үйлчилгээ (НААҮ)- ний бүтэц, зохион байгуулалтын үндэс нь үйл ажиллагаа ба тодорхой чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх хариуцлагын оновчтой хуваарилалттай шууд холбоотой байдаг. НААҮ-г хэрэгжүүлж буй байгууллага нь хэрэглэгчдэд үйлчилгээг тасралтгүй, жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллах ёстой. Улс орон бүр энэхүү зарчмыг бүрэн хангах үүднээс энэ салбарынхаа эрх зүйн орчныг боловсронгуй болгоход ихээхэн анхаардаг байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээг бие даасан ерөнхий хуулиар болон салбарын хуулиар зохицуулдаг дараах улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг авч үзлээ.

### 1. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Австрали улсад нийтийн аж ахуйтай холбогдох харилцааг 2000 онд батлагдсан 16 бүлэг 261 зүйл бүхий **Нийтийн аж ахуйн**<sup>19</sup> (Utilities Act) тухай хуулиар зохицуулж байна. Мөн дээрх хуулиас гадна:

- Нийтийн үйлчилгээний техник зохицуулалтын тухай хууль (Utilities (Technical Regulation) Act 2014);
- Харилцаа холбооны суурилуулалтын тухай хууль (Utilities (Telecommunications Installations) Act 2001);
- Нийтийн үйлчилгээний (шугам сүлжээний) татварын тухай<sup>20</sup> (Utilities (Network Facilities Tax) Act 2006) зэрэг хуулиудаар нийтийн үйлчилгээтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж байна.

Нийтийн аж ахуйн тухай хуулиар нийтийн аж ахуйн үйлчилгээнд хамаарах үйлчилгээ болон түүний нэр томъёог тодорхойлж өгсөн байна. Үүнд:

#### 1.Цахилгаан эрчим хүчний үйлчилгээ

Цахилгаан эрчим хүчний үйлчилгээнд дараах зүйлс хамаарна.

- а) цахилгааны сүлжээгээр дамжуулан цахилгаан эрчим хүчийг хуваарилах;
- б) цахилгаан холболтын үйлчилгээ;
- в) 30 МВт ба түүнээс дээш хүчийг үйлдвэрлэх хүчин чадал;
- д) цахилгааны сүлжээгээр дамжуулан цахилгаан дамжуулах.

#### 2.Байгалийн хий/газ

Хуульд заасны дагуу нийтийн аж ахуйн үйлчилгээнд доорх зүйлс хамаарна.

- а) хийн дамжуулах сүлжээгээр хий дамжуулах;
- б) хийн түгээлтийн сүлжээгээр дамжуулан хийн хуваарилалт;
- в) хийн холболтын үйлчилгээ.

#### 3.Ус

Нийтийн аж ахуйн үйлчилгээнд дараах зүйлсийг хамруулахаар тусгажээ.

<sup>19</sup> Utilities Act 2000, <https://legislation.act.gov.au/View/a/2000-65/current/PDF/2000-65.PDF>

<sup>20</sup> Нийтийн үйлчилгээний шугам сүлжээ (Utility networks) гэдэгт цахилгаан, газ, бохир ус, цахилгаан холбоог дамжуулах болон түгээх сүлжээ багтана.



- а) түгээх зорилгоор ус хуримтлуулах, цэвэршүүлэх;
- б) ус хангамжийн сүлжээг бий болгох холболтын үйлчилгээ;
- с) усны сүлжээгээр дамжуулан ус түгээх;
- д) усан холболтын үйлчилгээ;
- е) ус хангамжаас ус нөөцлөх.

#### **4.Ариутгах татуургын үйлчилгээ**

Хуулиар дараах үйлчилгээг хамруулахаар заасан байна.

- а) ариутгах татуургын сүлжээг байгуулах;
- б) ариутгах татуургын холболтын үйлчилгээ;
- с) ариутгах татуургын үйлчилгээ.

#### **5.Бусад үйлчилгээ**

Тус хуульд заасны дагуу нийтийн аж ахуйн үйлчилгээг хэрэглэгч гэдэгт:

- а) Нийтийн аж ахуйн үйлчилгээг гэрээгээр хүлээн авч буй этгээд;
- б) Нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдох аман болон бичгээр хүсэлт гаргасан этгээдийг ойлгоно гэж заажээ.

#### ***Нийтийн аж ахуйн үйлчилгээний зөвшөөрөл***

Тус хуульд заасан үйлчилгээг зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд зөвшөөрлийг хугацаатай болон хугацаагүй олгож болно. Зөвшөөрлийг тухайн төрлийн үйлчилгээг зохих түвшинд эрхлэн явуулах ерөнхий нөхцөлийг хангасан байдал, холбогдох техникийн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж олгох бөгөөд цахилгаан болон усан хангамжийн үйлчилгээнд холбогдох хууль тогтоомжуудаар тогтоосон бусад шаардлагыг бүрэн хангасан байх шаардлага тавигддаг байна.

Өрсөлдөөн болон зохицуулалтын бие даасан хорооноос (цаашид хороо гэх) зөвшөөрөлтэй холбогдох шалгууруудыг тогтоож өгөх ба тус хороонд хандан зөвшөөрөлтэй холбогдох асуудал буюу түүнийг олгох, шилжүүлэх, төрлийг өөрчлөх, солих, зохих шаардлагаас чөлөөлүүлэх талаарх хүсэлтийг гаргадаг. Хорооноос хүсэлтийн дагуу холбогдох нэмэлт материалыг шаардах, нэмэлт материал гаргаж өгөх хүртэл хүсэлтийг хэлэлцэхгүй байх эрхтэй.

Мөн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг буцаах, сэргээх, хүчингүй болгох, цуцлах зэрэг асуудлыг зохицуулдаг байна. Хороо нь:

- Зөвшөөрөл эзэмшигч нь сүүлийн 5 жилийн хугацаанд тус хуулийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчиж холбогдох хариуцлага хүлээсэн;
- Тухайн зөрчил нь 1 буюу түүнээс дээш зөвшөөрлийн нөхцөлтэй холбоотой;
- Гаргасан зөрчилтэй холбоотойгоор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах нь сөрөг нөлөөтэй гэж үзсэн;
- Тухайн жилийн зөвшөөрлийн төлбөрийг мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн хугацаанд төлж барагдуулаагүй бол зөвшөөрлийг цуцална.

Мөн хорооноос зөвшөөрлийн төлбөрийг үйлчилгээний чиглэл тус бүрээр тогтоож өгөх ба бүтэн, эсхүл хагас жил тутамд төлбөрийг төлөх үүрэгтэй байдаг.

Мөн зөвшөөрөлтэй холбогдох зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээ, зөрчил

арилгах арга зам, урьдчилан сэргийлэх талаар зөвшөөрөл эзэмшигчид заавар зөвлөмж өгөх, чиглэл хүргүүлэх талаарх зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгаж өгсөн байна. Мөн зөвшөөрөл эзэмшигч нь явуулж буй үйл ажиллагаатай холбоотойгоор бусдын мэдээллийг олж авсан бол задруулахыг хориглосон байна.

Хороо нь зөвшөөрөл олгосон, өөрчилсөн, цуцалсан, хүчингүй болгосон талаар бичгээр хариу өгөх ба гаргасан шийдвэрээ мэдээллийн цахим хуудсаар, эсхүл ил тод байдлаар олон нийтэд танилцах боломжоор хангах үүрэгтэй байхаар хуульчилсан байна.

Хуулийн 3(А) бүлэгт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт үйлчилгээ эрхлэгчийн сүлжээний зохицуулалтын төлбөр төлөх үүрэг ба төлбөр ногдуулах аргачлалыг тусгаж өгсөн байна. Хуульд зааснаар эрчим хүчний үйлдвэрлэлийн салбар гэдэгт дараах салбар хамаарч байна.

- а) цахилгаан түгээх салбар;
- б) цахилгаан хангамжийн салбар;
- в) хий түгээх салбар;
- г) хийн хангамжийн салбар;
- д) бусад хууль тогтоомжоор хамааруулахаар заасан салбар.

Хуульд цахилгаан эрчим хүчний үйлчилгээ эрхлэгчид үйлдвэрлэлийн код олгох зохицуулалт, цахилгаан эрчим хүчний үйлчилгээ эрхлэгчтэй холбогдох асуудал болоод цахилгаан эрчим хүчний үйлчилгээ эрхлэгчийн үүрэг, холбогдох зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан байна. Цахилгаан эрчим хүчний үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчид юун түрүүнд сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг зайлшгүй санал болгох ёстой бөгөөд хэрэглэгчээс худалдан авах сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнтэй байх, түүнчлэн үйлчилгээ үзүүлсэн баримт дээр сэргээгдэх эрчим хүчний талаарх мэдээллийг тусгасан байхыг хуулиар үүрэг болгосон байна.

### ***Нийтийн аж ахуйн үйлчилгээ авах хүсэлт гаргах***

Хуулийн 6 дугаар бүлгээр нийтийн аж ахуйн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн этгээд үйлчилгээ эрхлэгчид хандаж амаар болон бичгээр, бусад цахим хэлбэр, утсаар хүсэлтээ гаргаж энгийн хэрэглэгчийн гэрээг байгуулдаг. Үйлчилгээ эрхлэгчид тус гэрээний загварыг зохицуулах хороонд хандаж гаргах бөгөөд тус хорооноос загварыг баталдаг байна. Энд онцлох нэг зохицуулалт нь ус хангамжийн болон ариутгах татуургын үйлчилгээ авахад тухайн үйлчилгээний шугам тавигдсан газрын өмчлөгч нь тухайн үйлчилгээг авч хэрэглэж буй хэрэглэгчийн төлбөрийг давхар хариуцдаг байна.

Цахилгаан эрчим хүч, байгалийн хийн үйлчилгээнээс бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч нь шугам сүлжээгүй алс газарт шинээр шугам сүлжээ оруулах, харилцан адилгүй техникийн боломжтой газруудад шугам сүлжээ өргөтгөх үүднээс хэрэглэгчдээс зохих хөрөнгө оруулалтын хураамж авч болохыг зааж өгсөн байна.

### ***Сүлжээний үйл ажиллагаа. (Network operation)***

Нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээний байгууламж суурилуулахтай холбоотой асуудлыг тус хуулиар зохицуулсан бөгөөд хуульд зааснаар газар, усан

дээр болон доогуур сүлжээний байгууламж, шугам, шуудуй тавих үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байгууламж, тоног төхөөрөмж барих, өргөтгөх нь сүлжээний байгууламж суурилуулах ойлголтод хамаарна. Сүлжээний үйл ажиллагаа гэдэг нь энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд нийтийн үйлчилгээний байгууллага, эсвэл ашиглалтын эрх бүхий этгээдийн гүйцэтгэсэн ажлыг ойлгоно.

Хуульд зааснаар зөвшөөрөл бүхий үйлчилгээ эрхлэгч нь сүлжээний байгууламж суурилуулахтай холбоотойгоор дараах ажлыг гүйцэтгэж болно.

- холбогдох газар эзэмших, нэвтрэх;
- судалгаа хийх, дээж авах, хөрсийг шинжлэх;
- үйлдвэр, машин механизм, тоног төхөөрөмж барих, суурилуулах, байрлуулах;
- мод огтлох, ургамал цэвэрлэх;
- нийтийн аж ахуйн үйлчилгээ хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг түр зогсоох;
- шороон малтлага хийх;
- газрыг тэгшлэх буюу зам тавих;
- ажлын байр, бусад барилга байгууламж, хашаа барих;
- бусад бүтэц;
- ашиглалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан суулгасан сүлжээний байгууламжийг нураах, устгах;
- хашаа, хананд хаалга, гарц тавих, хаалга, гарцыг зайлуулах;
- нийтийн эзэмшлийн зам, гүүрэн дээр замын хөдөлгөөнийг түр хугацаагаар саатуулах, хэсэгчлэн зогсоох;
- ажлын явцад хөндөгдсөн газар, хашаа, хана зэрэг бусад байгууламжийг сэргээн засварлах, шороо, ургамал, хог хаягдлыг зайлуулах.

Дээр дурдсан үйл ажиллагааг газар эзэмшигчийн зөвшөөрөлгүй явуулахыг хориглоно.

Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн сүлжээний эзэмшил, арчилгаатай холбоотойгоор дараах үйл ажиллагааг явуулж болно.

- байгууламжийн аливаа хэсгийг өөрчлөх, арилгах, засах, солих;
- байгууламжийг шаардлагатай материал, түүхий эдээр хангах;
- байгууламжийн зохистой ажиллагааг шалгах, зохих ёсоор хангах;
- сүлжээний хамгаалалттай холбоотой арга хэмжээ.

Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаагаа явуулахдаа бусдад аль болох төвөг чирэгдэл учруулахгүй байх, учрах аюул саадыг зайлуулах, багасгах арга хэмжээг авах үүрэгтэй.

Үйлчилгээ үзүүлэгчээс хувийн болон нийтийн эзэмшлийн газар дээр харилцаа холбоо, ус зайлуулах, гудамжны гэрэлтүүлэг зэргээр үйл ажиллагаа явуулах, мод, бут огтлох, зайлуулах бол явуулах үйл ажиллагааны зорилго, явагдах ажил, түүний хугацаа, газрын аль хэсэг хамрагдах, түүнийг нөхөн сэргээх, хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөр төлөх зэрэг асуудлыг тусгасан мэдэгдлийг 7 хоногийн өмнө өгөх үүрэгтэй. Харин бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, сүлжээний бүрэн

бүтэн байдалтай холбоотой яаралтай нөхцөл байдал бий болсон үед дээрх зохицуулалт хамаарахгүй.

Үйл ажиллагааны явцад соёлын зүйлс хөндөгдөх бол соёлын өвийн асуудал эрхэлсэн байгууллагад нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ. Бусдын эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулсан нөхцөлд урьд байсан байдалд нь нөхөн сэргээх үүрэгтэй гэж заажээ.

Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлэх албан хаагчдыг томилон, холбогдох албан үнэмлэх олгоно. Сүлжээ, байгууламжид нэвтрэн орсон газрын өмчлөгч эзэмшигч нь тухайн байгууламжийн хувьд өмчлөх эрхгүй байна.

Хуулийн 9 дүгээр бүлэгт нийтийн үйлчилгээнд хяналт шалгалтын ажилтан томилж оролцуулах асуудлыг зохицуулсан байна. Хуульд зааснаар үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан зөрчил нь цаашид хэрэглэгчдэд үзүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь зөвшөөрлийн шаардлага, шалгууртай нийцэхгүй байгаа, зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл түүнийг цуцлах нь хэрэглэгчдэд хохиролтой гэж үзсэн нөхцөлд хороо болон холбогдох яам зөвшилцөн, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтныг томилно. Хяналт шалгалтын ажилтан түүнийг томилсон албан тушаал, түүнд заасан чиг үүргийг гүйцэтгэнэ. Хяналт шалгалтын ажилтан нь тухайн томилогдсон үйлчилгээний нөхцлийг хангах үүрэгтэй бөгөөд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Үйлчилгээ эрхлэгчийн холбогдох үйл ажиллагаанд хяналт тавих;
- Сүлжээ, байгууламж болон холбогдох бусад газар байранд нэвтрэх;
- Шаардлагатай арга хэмжээ авах талаар бичгээр зааварчилгаа өгөх;
- Хяналт шалгалтын ажилтан нь яаманд мэдээлэл хүргүүлж байх ба яамнаас тусгайлсан асуудлаар тодорхой бүрэн эрхийг олгож болно.

Өрсөлдөөн болон зохицуулалтын бие даасан хороо нь өөрийн хяналтын байцаагч нарыг томилж ажиллуулах ба түүнд тавигдах шаардлагыг хуульд зааж өгсөн байна. Үүнд:

- Австралийн иргэн, эсхүл байнгын оршин суугч;
- Хорооны даргаас тухайн иргэн нь ажлын туршлага болон гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг судалсны дүнд бичгээр тухайн албан тушаалд ажиллах боломжтой талаар дүгнэлт гаргасан;
- Холбогдох сургалтад хамрагдаж, тухайн албан тушаалд тэнцэх боломжтой талаар хорооны дарга дүгнэлт гаргасан байна.

Хяналтын байцаагч нь оршин суугчийн зөвшөөрлөөр орон байранд нэвтрэх, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй байр болон сүлжээний байгууламжид хүссэн цагтаа нэвтрэх эрхтэй. Хяналтын байцаагч нь хувийн эзэмшлийн газарт нэвтрэх эрхтэй бөгөөд тухайн газар дахь байр, сууцанд нэвтрэх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авна.

Эзэмшигч зөвшөөрөл өгсөн тохиолдолд хяналтын байцаагч нь нэвтрэх болсон шаардлага, шүүхэд нотлох баримтаар хураан авах буюу олдсон эд зүйл, эзэмшигч нэвтрүүлэхээс татгалзах эрхтэй тухай, түүний зөвшөөрсөн зөвшөөрөл, он сар, цаг

хугацаа зэргийг тусгасан баримтанд гарын үсэг зуруулан, нэг хувийг эзэмшигчид өгнө. Эзэмшигч нэвтрүүлэхээс татгалзсан тохиолдолд холбогдох шүүхэд хандаж, нэвтрэх зөвшөөрөл хүснэ.

Хяналтын байцаагч нь холбогдох байр, байгууламжид нэвтэрсэн бол хянах, хэмжилт хийх, дээж авах, зураг болон бичлэг хийх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, материал авч орох, бичиг баримт хуулбарлан авах, нотлох баримтаар эд зүйл хураан авах эрхтэй. Зөрчил гаргасан нь тогтоогдохгүй, эсхүл 90 хоногийн хугацаанд тухайн асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол эд зүйлийг буцаан олгох буюу зохих нөхөн төлбөрийг төлнө.

Хуулийн 9А бүлэгт нийтлэг эрх ашиг, нийт хэрэглэгчдийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчим хүч байгалийн хий, усны үйлчилгээнд зохих хязгаарлалт хийх зохицуулалтыг тухай бүр гаргаж болох үндэслэлийг тусгасан байна.

Шүүхэд хэрэглэгчтэй холбогдох маргаан үүсгэх, нэхэмжлэл гаргахтай холбогдох харилцааг зохицуулахдаа 10000 доллар түүнээс дээш хэрэглэгчийн төлбөртэй холбогдох болон мөн дүнтэй хэрэглэгчид хохирол учруулсан маргааныг дүүргийн иргэний шүүхээр хянан шийдвэрлэхээр зохицуулсан байна. Үйлчилгээ эрхлэгч нь шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө үйлчлүүлэгчид шүүхэд маргаан шийдвэрлүүлэх талаарх мэдэгдлийг 7 хоногийн өмнө өгсөн байна. Хэрэглэгчдээс үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдуулан захиргааны шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах харилцааг мөн зохицуулсан байна.

### ***Нийгмийн хариуцлага***

Нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн сайн сайхан зэрэг Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулах, тодорхой үйлчилгээ эрхлэгч нартай хэлэлцээ хийх замаар тодорхой үр дүнд хүрэх, тэдэнд чиглэл өгөх, чиглэлийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд төрөөс нөхөн төлбөр олгох зорилгоор холбогдох яамдаас үйлчилгээ эрхлэгч нарт албан бичгээр төрийн холбогдох хөтөлбөрт үйл ажиллагаагаа нийцүүлэх, хэрхэн зохицуулах талаар чиглэл өгч болно. Тухайлбал, уг чиглэлээр тодорхой үйлчилгээг тодорхой салбар, бүлэгт үнэ төлбөргүй, хямдралтай үнээр, эсхүл тогтоосон үнээр нийлүүлэхийг зааж болно. Чиглэлд түүнийг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор үйлчилгээ эрхлэгчээс гарах зардлын тооцооллыг хавсаргасан байна. Үйлчилгээ эрхлэгч нар нь тус чиглэлийг дагаж мөрдөх үүрэгтэй байна.

Чиглэлд тодорхойлсон зардал, үнэтэй холбоотойгоор үйлчилгээ эрхлэгч холбогдох яамтай тохиролцоогүй бол Хороонд хандан гомдол гаргах эрхтэй бөгөөд Хороо түүнийг хянан шийдвэрлэнэ. Хорооноос хянан шийдвэрлэх маргааныг хуульд тусгайлан зааж өгсөн байна.

### ***Гэрэлтүүлэг, ус зайлуулах шугам***

Хуульд зааснаар гудамжны чимэглэлийн болон урлагийн зориулалттай гэрэлтүүлгийн шон гудамжны гэрэлтүүлэгт хамаарахгүй бөгөөд ус зайлуулах шугам сүлжээний хилээс гадна орших асуудал мөн хамаарахгүй гэжээ.



Ус зайлуулах шугамын сүлжээний кодыг холбогдох яамнаас тогтоон, үүний дагуу сүлжээний хилийг тогтоодог.

Гудамжны гэрэлтүүлгийн сүлжээнд гудамжны гэрэлтүүлэг, түүнтэй холбогдох бусад үйлчилгээ хамаарна. Гудамжны гэрэлтүүлгийн сүлжээ нь тухайн сүлжээнээс гадна орших дэд бүтцэд хамаарахгүй бөгөөд сүлжээний хүрээ болон цахилгаан эрчим хүчний сүлжээний уялдааг харгалзан үндсэн хүрээг холбогдох яамнаас тогтоож өгдөг байна.

## **2. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС**

### ***Нийтийн аж ахуйн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.***

Латви улсын Нийтийн үйлчилгээний салбарын харилцааг Нийтийн үйлчилгээний тухай хууль (On Regulators of Public Utilities)<sup>21</sup>, Эрчим Хүчний тухай хууль (Energy Law)<sup>22</sup>, Шуудангийн Үйлчилгээний тухай хууль (Postal Law)<sup>23</sup>, Цахилгаан Холбоо, Харилцааны тухай хууль (Electronic Communications Law)<sup>24</sup>, Төмөр замын тухай хууль (Railway Law)<sup>25</sup>, Усны тухай хууль (Law on Water Management Services)<sup>26</sup>-иудаар зохицуулж байна.

Нийтийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа нь Үндэсний хэмжээнд Нийтийн үйлчилгээний комисс буюу Зохицуулах Хороо (Public Utilities Commission)-ны удирдлага дор явагддаг.

Зохицуулах Хороо (PUC) нь Нийтийн Үйлчилгээний зохицуулалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бие даасан байгууллага юм.

Тус хороо нь эрчим хүч, цахилгаан, хий, дулаан, харилцаа холбоо, шуудан, төмөр замын салбар, халаалт, ус хангамж, хот, суурин газрын хог хаягдлын менежмент зэрэг олон салбаруудыг “Нийтийн үйлчилгээний зохицуулалтын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг,<sup>27</sup> жил бүр УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байна.<sup>28</sup>

2001 онд батлагдсан “Нийтийн үйлчилгээний зохицуулалтын тухай” (On Regulators of Public Utilities) хуульд хамгийн сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хууль нь 8 бүлэг, 47 зүйлтэй.

- ❖ Бүлэг I. Ерөнхий зүйл (1-5 зүйл)
- ❖ Бүлэг II. Нийтийн Үйлчилгээний Удирдах Газар – Зохицуулах хороо (6-11 зүйл)
- ❖ Бүлэг III. Нийтийн үйлчилгээний зөвшөөрөл олгох ба Нийтийн үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэл (12-18 зүйл)
- ❖ Бүлэг IV. Тариф тогтоох тухай (19-21 зүйл)
- ❖ Бүлэг V. Нийтийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа (22-28 зүйл)

<sup>21</sup> <https://erranet.org/member/puc-latvia/>

<sup>22</sup> [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Energy\\_Law.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Energy_Law.doc)

<sup>23</sup> [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Cab\\_Reg\\_No\\_265\\_Postal\\_Regulations.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Cab_Reg_No_265_Postal_Regulations.doc)

<sup>24</sup> [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Electronic\\_Communications\\_Law.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Electronic_Communications_Law.doc)

<sup>25</sup> <http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Railway.pdf>

<sup>26</sup> <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/lat172903.pdf>

<sup>27</sup> <https://www.linkedin.com/company/public-utilities-commission-of-latvia>

<sup>28</sup> [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Citi/On\\_Regulators\\_of\\_Public\\_Utilities.pdf](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Citi/On_Regulators_of_Public_Utilities.pdf)

- ❖ Бүлэг VI. Зохицуулах хорооны үйл ажиллагааг санхүүжүүлэх (29-31 зүйл)
- ❖ Бүлэг VII. Маргаан хянан шийдвэрлэх (32-35 зүйл)
- ❖ Бүлэг VIII. Зохицуулагчийн бүтэц, үйл ажиллагаа (36-47 зүйл)

Тус хуулийн зорилго нь эдийн засгийн хувьд бодит зардалдаа нийцсэн үнэ тариф бүхий аюулгүй, чанартай нийтийн үйлчилгээг тасралтгүй авах боломжоор хангах, мөн түүнчлэн нийтийн үйлчилгээний дүрэм, журам болон нийтийн үйлчилгээний эрх зүйн харилцааг тодорхойлж, тухайн салбарын хөгжил, дэвшил болон эдийн засгийн бодитой өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжихэд оршино. Энэхүү хуулиар нийтийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий журам болон зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх үндсэн зарчмыг тогтооно.

Төрөөс дараах салбарт нийтийн үйлчилгээг арилжааны зарчмаар зохицуулна. Үүнд:

- 1) эрчим хүч;
- 2) цахилгаан холбоо;
- 3) шуудангийн үйлчилгээ;
- 4) төмөр замын тээвэр;
- 5) хот суурин газрын хог хаягдлын менежмент;
- 6) усны нөөцийн менежмент.

Нийтийн үйлчилгээний зохицуулалт бүхий салбаруудад нийтийн үйлчилгээний төрлийг Засгийн газар тодорхойлно.

Нийтийн үйлчилгээ эрхлэгч гэдэг нь тодорхой нутаг дэвсгэрт нийтийн үйлчилгээ үзүүлдэг этгээдийг хэлэх бөгөөд тус этгээдийн нийтийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

“Нийтийн үйлчилгээний хэрэглэгчид (хэрэглэгчид) гэдэг нь нийтийн үйлчилгээ эрхлэгчдээс нийтийн үйлчилгээг авч буй хувь хүмүүс, хуулийн этгээдүүдийг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Нийтийн Үйлчилгээний Удирдах Газар- Зохицуулах хороо (Public Utilities Commission)- ны эрх үүрэг, бие даасан байдлын талаар хуульд дэлгэрэнгүй зохицуулж өгсөн байна. Нийтийн Үйлчилгээний Комисс нь (Зохицуулах хороо) зохицуулалт бүхий салбаруудын нийтийн үйлчилгээг удирдан зохицуулна. Энэхүү эрхийн хүрээнд хуулиар хүлээсэн үүргээ бие даан гүйцэтгэж, нийтийн аж ахуйн үйлчилгээний хэрэглэгчид болон үйлчилгээ эрхлэгчдийн мөрдөх захиргааны акт болон шийдвэрийг гаргадаг.

Зохицуулах хороо нь нийтийн үйлчилгээний хангамжийн үйл ажиллагаанд энэ хууль болон холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавина.

Зохицуулах хороо нь хуулиар батлагдсан төсвөө бие даан захиран зарцуулдаг байгууллагын болон гүйцэтгэх үүргийн хувьд бие даасан байгууллага юм. Зохицуулах хорооны шийдвэр гаргах байгууллага нь Зөвлөл байна. Тус Зөвлөл нь Зохицуулах хорооны нэрийн өмнөөс нийтийн үйлчилгээний хэрэглэгчид болон үйлчилгээ эрхлэгчдийн заавал дагаж мөрдөх захиргааны акт болон шийдвэрийг



гаргадаг.

Хуулийн 9 дүгээр зүйлд Зохицуулах хорооны эрх, үүргийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- нийтийн үйлчилгээний хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, нийтийн үйлчилгээ эрхлэгчдийн өсөлт, хөгжлийг дэмжих;
- үнэ тарифыг тооцох арга зүйг тодорхойлох;
- зохицуулалттай (холбогдох) салбартай холбоотой тусгай хууль тогтоомжоор үнэ тарифыг тодорхойлох журмыг зааж өгөөгүй бол үнэ тарифыг тогтоох;
- нийтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох буюу нийтийн үйлчилгээ эрхлэгчийг бүртгэх;
- энэхүү хуульд заасан журмын дагуу маргаан гарсан тохиолдолд маргааныг хянан шалгах
- зохицуулалттай (холбогдох) салбарууд дахь өрсөлдөөнийг дэмжих, нийтийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлд заагдсан нөхцөл болон ерөнхий зөвшөөрлийн заалт, чанарын тусгай шаардлага, техникийн зүйл заалт, стандарт болон гэрээний зүйл заалтуудад нийцэж буй эсэхийг хянах;
- зохицуулалттай (холбогдох) салбарыг хариуцсан яамдад хүсэлтийн дагуу мэдээлэл гаргаж өгөх, нийтийн үйлчилгээний зохицуулалттай холбоотой асуудлаар дээрх яамдад зөвлөмж өгөх;
- хорооны үйл ажиллагаа болон нийтийн үйлчилгээ эрхлэгчдийн нийтийн үйлчилгээний үйл ажиллагааг олон нийтэд мэдээллэх;
- салбарын тусгай хуулинд заасан бусад үүргийг гүйцэтгэх;

Зохицуулах хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргах ба нийтийн үйлчилгээний хэрэглэгчид болон үйлчилгээ эрхлэгчдийн заавал дагаж мөрдөх тогтоол, шийдвэрийг гаргана. Зохицуулах хороо нь нийтийн үйлчилгээ эрхлэгчид болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг хамгаалах үүрэгтэй.

Хуулийн гуравдугаар бүлгээр тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, лиценз олгох, хүчингүй болгох, хүчинтэй хугацааг түдгэлзүүлэх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой зохицуулалтыг хуульчилсан байна.

- Нийтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл нь тухайн тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрт хамаарах хэрэглэгчдийн өмнө ижил төрлийн үүрэг хүлээсэн гэж үзэх эрхийг нийтийн үйлчилгээ эрхлэгчид олгох ба эдгээр хэрэглэгчдэд нийтийн үйлчилгээг тодорхой заасан чанар, хэмжээгээр, тогтоосон тарифаар үзүүлэх үүргийг тус нийтийн үйлчилгээ эрхлэгчдэд ногдуулна.
- Зохицуулах хороо нь Засгийн газрын баталсан журмын дагуу нийтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон зохицуулалттай (холбогдох) салбарт үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг олгоно. Хэрэв салбарын тусгай хуульд заагаагүй бол, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах журмыг мөн Засгийн газар батална.

- Хэрэв зохицуулалттай (холбогдох) салбарт тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах журмыг салбарын хууль тогтоомжид тусгайлан заасан бол Зохицуулах хороо нийтийн үйлчилгээ эрхлэгч болон зохицуулалттай (холбогдох) салбарт үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар олгох ба уг тусгай зөвшөөрөлд нийтийн үйлчилгээний төрлийг зааж өгсөн байна.
- Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлт мөн түүнчлэн нийтийн үйлчилгээ тусгай зөвшөөрлийн нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг хянана.

Хуулийн тавдугаар бүлгээр Нийтийн үйлчилгээ эрхлэгчдийн талаарх харилцааг зохицуулсан байна.

1. Нийтийн үйлчилгээ эрхлэгчдийг тухайн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрлийн нөхцөлийн дагуу хүчинтэй хугацаанд нийтийн үйлчилгээг тасралтгүй хүлээн авах боломжоор хангана.
2. Нийтийн үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох салбарын хувьд тодорхойлогдсон нийтийн үйлчилгээний аюулгүй байдлын шаардлагууд болон ажилтнуудын мэргэжил, ур чадварт тавигдах шаардлагын биелэлтийг хангана.
3. Нийтийн үйлчилгээ эрхлэгчид нийтийн үйлчилгээний чанарыг техникийн үзүүлэлт, стандарт, гэрээний нөхцөлд нийцүүлэх үүрэгтэй. Хэрэв нийтийн үйлчилгээ эрхлэгч техникийн үзүүлэлт, стандарт, гэрээний нөхцөлд нийцсэн нийтийн үйлчилгээний чанарыг хангаж чадахгүй бол нийтийн үйлчилгээ эрхлэгч нь гэрээний нөхцөл болон хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хэрэглэгчид учирсан хохирлыг нөхөн төлнө.
4. Нийтийн үйлчилгээ эрхлэгч нийтийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд үр дүнтэй, эдийн засагт хэмнэлттэй, аюулгүй технологи, ажиллах арга барил нэвтрүүлэхийг дэмжинэ.
5. Нийтийн үйлчилгээ эрхлэгч нь Засгийн газраас гаргасан журамд нийцүүлэн үйлчилгээ авсан нийтийн үйлчилгээний төлбөрөө төлөөгүй болон бусад үүргээ биелүүлээгүй хэрэглэгчдэд нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэхийг зогсоох эрхтэй.

Зохицуулах хорооны үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг дараах байдлаар зохицуулсан байна.

Зохицуулах хорооны үйл ажиллагааг Төрөөс тогтоосон нийтийн үйлчилгээний зохицуулалтын хураамжаас цугларсан орлогоор санхүүжүүлнэ.

Нийтийн үйлчилгээний зохицуулалтыг хангахын тулд, зохицуулалттай (холбогдох) салбар дахь төрөөс тогтоосон нийтийн үйлчилгээний хураамжийг нийтийн үйлчилгээ эрхлэгч бүх этгээдүүд төлөх үүрэгтэй.

Төрөөс тогтоосон нийтийн үйлчилгээний хураамжийг улсын төсөвт төвлөрүүлж, Төрийн Сан дахь Зохицуулах хорооны дансанд шилжүүлнэ. Нийтийн үйлчилгээний зохицуулалтын хураамжаас олсон орлогыг зөвхөн Зохицуулах хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулна.

Нийтийн үйлчилгээ эрхлэгчдэд дараах тохиолдолд нийтийн үйлчилгээний

хураамжийг буцаан олгохгүй. Үүнд:

- Нийтийн үйлчилгээ эрхлэгчдэд олгосон тусгай зөвшөөрөл цуцлагдсан, түдгэлзүүлсэн;
- Нийтийн үйлчилгээ эрхлэгчийг бүртгэлээс хассан, эсвэл нийтийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн тухай тэмдэглэл бүртгэл дээр хийгдсэн;
- Нийтийн үйлчилгээний зохицуулалт дуусгавар болсон.

### **3. РУМЫН УЛС**

Румын улсын орон нутаг, хот суурин газруудад нийтийн үйлчилгээний байгууламжийг бий болгох, зохион байгуулах, хяналт тавих, шалгах нэгдсэн үйл ажиллагааг 2006 оны 3 дугаар сарын 8-нд батлагдсан **“Нийтийн үйлчилгээний тухай 51 дүгээр хууль”**<sup>29</sup> (Law No 51 on communal public services, adopted on 8 March 2006)-аар зохицуулж байна.

Энэ хуулинд сүүлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр<sup>30</sup> орон нутгийн нийтийн ашиглалтын хэрэгцээ болон нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн дараах тодорхой зохицуулалт бүхий үйл ажиллагааны цогцыг нийтийн үйлчилгээ гэж тодорхойлжээ. Үүнд:

- Ундны усны хангамж;
- Бохир ус зайлуулах болон цэвэрлэх үйл ажиллагаа;
- Хурын ус хуримтлуулах болон зайлуулах;
- Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хуваарилалт, ханган нийлүүлэлтийн төвлөрсөн систем;
- Хот суурин газрын эрүүл ахуй (хатуу хог хаягдлыг цэвэрлэх болон боловсруулах);
- Гудамж, талбайн гэрэлтүүлэг;
- Орон нутгийн захиргааны ангилалд харьяалагдах хувийн болон нийтийн өмч хөрөнгийн менежмент;
- Хотын нийтийн тээвэр.

Харин дулаан эрчим хүчийг үйлдвэрлэх, тээвэрлэх, түгээх ба хангах төвлөрсөн системийн үйл ажиллагааг тусгайлсан **Дулаан эрчим хүчээр хангах нийтийн үйлчилгээний тухай №325/2006 хууль**<sup>31</sup> (Law No 325/2006) ба төв системээр дамжуулан хангадаг дулаан эрчим хүчний орон нутаг дахь үнийн тухай **Засгийн газрын №36/2006 тогтоолоор** тус тус зохицуулж байна.

#### ***Нийтийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа***

Румыны орон нутгийн захиргааны шийдвэрээр тухайн орон нутгийн иргэдийн тав тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг хангах үүднээс хэд хэдэн хотуудад нийтийн ажил үйлчилгээг шилжүүлэн гүйцэтгүүлэх ассоциацуудыг (орон нутгийн төрийн

<sup>29</sup> [https://ec.europa.eu/competition/state\\_aid/public\\_services/2012\\_2014/romania\\_en.pdf](https://ec.europa.eu/competition/state_aid/public_services/2012_2014/romania_en.pdf)

<sup>30</sup> Энэхүү хуульд Засгийн газрын №13/2008 шуурхай арга хэмжээний шийдвэрээр 2008, 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>31</sup> Published in the Official Journal of Romania No 651, issued on 27 July 2006

захиргааны байгуулагууд, эсхүл бичил бүс нутгийн хөгжлийн ассоциацуудыг) байгуулжээ. Нийтийн үйлчилгээний тухай 51 дүгээр хууль болон орон нутгийн захиргааны түвшний шийдвэрээр нийтийн үйлчилгээг тухайн хотын хөгжлийн түвшин болон нийгэм-эдийн засгийн ач холбогдол, техник, хотын дэд бүтцийн хүчин чадалд нийцүүлэн байгуулж, удирдан зохион байгуулсан байна.

Нийтийн үйлчилгээ тус бүрийг үүсгэн байгуулах, бүтэц тогтоох, хөгжүүлэх, санхүүжүүлэх, удирдан зохион байгуулах зэргийг холбогдох хууль болон тухайн салбарын Засгийн газрын тогтоол, эсхүл зохицуулагч байгууллагаас баталсан бусад дүрэм, журмын дагуу явуулдаг.

Нийтийн үйлчилгээний тухай 51 дүгээр хуульд “нийтийн аж ахуйн үйлчилгээ”-г сонгогдсон операторууд, эсхүл бүс нутгийн операторууд үзүүлэхээр заажээ. Тэдгээр операторууд нь дор дурдсан хуулийн статусын аль нэгийг эдэлнэ.Үүнд:

- а) Хотын захирагчийн, эсхүл орон нутгийн тусгайлсан бүтцийн дотор байгуулагдсан захиргааны бус /that are no juridical persons/ үйл ажиллагааны газар;
- б) Холбогдох орон нутгийн захиргааны шийдвэрээр байгуулагдсан захиргааны бус /which are no juridical persons/ орон нутаг, эсхүл сумын/дүүргийн түвшний нийтийн үйлчилгээ;
- в) Холбогдох орон нутгийн захиргааны шийдвэрээр байгуулагдсан захиргааны /which are juridical persons/ орон нутаг, эсхүл сумын түвшний нийтийн үйлчилгээ;
- д) Орон нутгийн өмчит компаниуд;<sup>32</sup> хувьцаат хөрөнгө нь бүхэлдээ холбогдох орон нутгийн захиргааны эзэмшилд байдаг компаниуд;
- е) Хувийн өмчит компаниуд;<sup>33</sup>
- ф) Орон нутаг болон хувийн өмч хосолсон компаниуд: хөрөнгийн зарим хувь нь хувийн, зарим хувь нь төрийн, эсхүл аль нэг нийтийн байгууллагынх байна.

Эдгээр нийтийн үйлчилгээ үзүүлэгчид нь дараах үндсэн шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- нэг нэгдмэл мөн чанартай байх;
- гэрээнийхээ нөхцөлд заагдсан тоо, чанарын заалтуудыг ямагт ханган биелүүлж байх;
- үйл ажиллагаа нь хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн, урт хугацаанд удирдан зохион байгуулах боломжтой байх;
- бүх хэрэглэгчдэдээ тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүй гэрээнд заасан үйлчилгээг санал болгох;
- аливаа шийдвэрийг ил тод гаргаж, хэрэглэгчдээ хамгаалдаг байх.

Орон нутгийн нийтийн үйлчилгээний захиргааны байгууллага нь дараах шийдвэрүүдийг гаргана. Үүнд:

<sup>32</sup> Сүүлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Арилжааны компаниудын тухай №31/1990 (Law No 31/1990) хуулиар зохицуулагдахаар болсон.

<sup>33</sup> Мөн адил

- Бүх төрлийн нийтийн үйлчилгээг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн үүсгэн байгуулах, зохион байгуулах, удирдах үүднээс эдгээр ажил үйлчилгээнд шаардагдах бүх төрлийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж, бусад нийгэмлэгүүдтэй (олон нийттэй) харилцах, холбогдох;
- Нийтийн үйлчилгээг удирдан зохион байгуулах аргыг сонгох, нийтийн ажил үйлчилгээний болон концессийн гэрээний хэлбэрээр улсын ба хувийн өмчит менежмент бүхий хуулийн этгээдүүдийг нийтийн ашиглалтын тогтолцоо болон орон нутгийн захиргааны холбогдол бүхий ажил үйлчилгээнд оролцуулах;
- Гүйцэтгэлийн индикаторуудыг ажиглах, хянах, тайлагнах, тэрчлэн эдгээр индикаторуудыг тухайлсан нийтийн үйлчилгээний хамгийн шилдэг сайн операторын гүйцэтгэлтэй харьцуулан үзэх арга, аргачлалыг боловсруулан хэрэглэх;
- Орон нутаг, бичил-бүс нутаг, эсхүл сумын түвшинд нийтийн ажил үйлчилгээ үзүүлдэг зарим арилжааны компаниудын ногдох хөрөнгийг хандивлахад оролцох;
- Хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор зээлийн гэрээ байгуулах, эсхүл санхүүгийн баталгаа гаргах;
- Зохицуулагч байгууллагуудын боловсруулж баталсан арга зүйн хэм хэмжээний хүрээнд үнэ, төлбөр, татварыг тогтоох, тохируулах, шинэчлэн боловсруулах.

### ***Зохицуулагч байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа***

Нийтийн үйлчилгээний тухай 51 дүгээр хуульд зааснаар нийтийн үйлчилгээ явуулах эрх бүхий зохицуулагч байгууллагууд нь:

- Орон нутгийн нийтийн үйлчилгээний үндэсний зохицуулах хороо (the National Regulatory Authority of Local Public Services (цаашид **ANRSC** гэх));
- Үндэсний эрчим хүчний зохицуулах хороо (the National Energy Regulating Authority (цаашид **ANRE** гэх)) ба;
- Румыны Зам тээврийн хороо (the Romanian Road Transport Authority) (цаашид **ARR** гэх)) тус тус байна.

**ANRSC** буюу Орон нутгийн нийтийн үйлчилгээний үндэсний зохицуулах хороо нь дараах ажил үйлчилгээг эрхэлдэг албан ёсны зохицуулагч захиргаа буюу байгууллага юм. Үүнд:

- a) ундны усны хангамж;
- b) бохир ус зайлуулах болон цэвэрлэх үйл ажиллагаа;
- c) хурын ус хуримтлуулах болон зайлуулах;
- d) суурин газрын эрүүл ахуй (хатуу хог хаягдлыг цэвэрлэх болон боловсруулах);
- e) гудамж, талбайн гэрэлтүүлэг;
- f) орон нутгийн захиргаанд харьяалагдах хувийн болон нийтийн өмч хөрөнгийн менежмент;

г) хотын нийтийн тээвэр. (холбогдох тусгай хууль журмын дагуу хотын нийтийн тээврийг зохицуулна)

Тус хороо нь нийтийн үйлчилгээнд лиценз олгож, өөрийн зохицуулах хүрээ болон ижил төстэй ажил үйлчилгээний зах зээлийн арга зүй болон үндсэн зохицуулалтыг нь тухайн үйлчилгээнд мөрдүүлэх, хэрэгжүүлэх арга хэлбэрийг хянах зэрэг үйл ажиллагаа явуулна.

**ANRE** нь дулаан эрчим хүч үйлдвэрлэх, тээвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагаанд лиценз олгож, хянан зохицуулна.

Румынд дулаан эрчим хүчийг бүхий л хотын нутаг дэвсгэр, эсхүл хот, дүүргийг хангах дулааны станц ба дулаан, эрчим хүч хосолсон станцуудтай төвлөрсөн системээр хангадаг.

Дулаан эрчим хүчээр хангах нийтийн үйлчилгээний тухай №325/2006 хуульд тусгайлан зааснаар Захиргаа ба Дотоод хэргийн яам нь Улсын Сангийн яамтай хамтран дулаан эрчим хүчний үйлчилгээний салбарын бодлогыг хэрэгжүүлнэ. Энэ нь улсын эрчим хүчний бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм.

Дулаан эрчим хүчний хангамжийн тасралтгүй тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд орон нутгийн нийтийн захиргааны байгууллага нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

- а) орон нутгийн захиргааны бүтцийн түвшинд дулаан эрчим хүчний хангамжийн үйлчилгээний тасралтгүй тогтвортой үйл ажиллагааг ханган баталгаажуулах;
- б) орон нутгийн жил тутмын дулаан эрчим хүчний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- с) өөрийн бүтцэд эрчим хүчний газар нэгж үүсгэн байгуулах;
- д) үйлчилгээ үзүүлэгч нарын санал болгосон орон нутаг дахь дулаан эрчим хүчний үнэ тарифын тухай саналыг батлах;
- е) хүн амд ногдуулах орон нутгийн үнэ төлбөрийн хэмжээг батлах;
- ф) дулаан эрчим хүчний хангамжийн төв шугамтай холбогдох хөгжил, шинэчлэл, метрийн хөтөлбөрийг батлах;
- г) эрчим хүчний нөөцийг шинэчлэх боломж ба энэ боломжийг зохистойгоор ашиглах бүх талын судалгааг хийх;
- х) дулаан эрчим хүчээр хангах үйлчилгээний мониторинг;
- и) дулаанаар хангах нэгж нутаг дэвсгэрийг тодорхойлох;
- j) дулаан эрчим хүчээр хангах төвийн шугамын хамгаалалт, аюулгүй байдлын нутаг дэвсгэрийг хэрхэн тодорхойлсныг хянах;
- к) метрлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, батлах.

**ARR** нь хотын нийтийн тээврийн үйл ажиллагааг хариуцсан байгууллага бөгөөд нийтийн тээврийн зорчигчид, тээврийн гэрчилгээ олголт, операторууд тээврийн лицензид тавигдах шаардлага болон зам тээврийн хууль, дүрэм журмыг мөрдөж буй эсэхэд хяналт тавих зэрэгтэй холбоотой бүхий л зохицуулалт, арга аргачлалыг хариуцна.

### ***Нийтийн үйлчилгээг удирдан зохион байгуулах тухай***

Нийтийн үйлчилгээний тухай 51 дүгээр хуульд “нийтийн үйлчилгээг” дараах хоёр аргаар зохион байгуулах/үзүүлэхээр заажээ. Үүнд:



- а) шууд удирдан зохион байгуулах;
- б) төлөөлүүлэн удирдан зохион байгуулах.

Нийтийн үйлчилгээний менежментийн аргыг орон нутгийн (засгийн газрын) нийтийн захиргааны шийдвэрээр тус үйлчилгээний мөн чанар болон нөхцөл байдал, хамгийн бодит үнэ - чанарын хувийг тогтоох шаардлага, тухайн орон нутгийн захиргааны ашиг сонирхол, зорилго зорилт, нийтийн ашиглалтын тогтолцооны хэмжээ, бүрдэл зэрэгт нийцүүлэн шийддэг.

Үйл ажиллагааны тухайд менежментийн аль хувилбарыг сонгосноос үл шалтгаалан тухайн нийтийн үйлчилгээний онцлог, түүнтэй холбогдох хууль журам, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэнэ. Эдгээрийг орон нутгийн нийтийн үйлчилгээний захиргаанаас тухайн үйлчилгээнд тавигдах техникийн шаардлага, хуулийн зохицуулалтын дагуу тодорхойлон батална. Мөн нийтийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан бичил-бүс нутгийн хөгжлийн ассоциациудын хувьд тухайн ассоциац нь тусгайлсан журам зохицуулалт болон техникийн тодорхойлолтоо батална. Ийнхүү ассоциацийг үүсгэн байгуулагч орон нутгийн захиргаанаас санал асуухаар илгээж, эцэст нь Ассоциацийн ерөнхий хурлаас эдгээр бичиг баримтуудыг батална.

Нийтийн үйлчилгээг үзүүлдэг буюу ханган нийлүүлдэг нийтийн ашиглалтын систем нь:

- а) **шууд менежмент** бүхий тохиолдолд операторуудад гэрээ байгуулах шийдвэрийг үндэслэн нийтийн үйлчилгээний гэрээгээр хариуцуулна;
- б) **шууд бус буюу төлөөлүүлэн хариуцуулах менежментийн** тохиолдолд концессийн шийдвэр ба төлөөлүүлэх менежментийн гэрээнд үндэслэн хууль журамд нийцсэн концессийн гэрээний дагуу тус үйлчилгээг операторт хариуцуулна.

**Шууд менежмент** гэдэг нь орон нутгийн нийтийн (засгийн газрын) захиргаа нийтийн үйлчилгээтэй хамааралтай нийтийн ашиглалт хэрэглээний системийн менежмент, ажиллагаа, ашиглалт зэрэг бүх ажил үйлчилгээг өөрөө эрхлэн явуулахыг хэлнэ.

Операторууд нь Нийтийн үйлчилгээний 51 дүгээр хуулинд захирагдах ба орон нутгийн захиргааны (тухайлбал: орон нутгийн засгийн газрын бүтцэд хамаарч) бүтцийн дотор байгуулагдсан дараах шууд менежмент эрхлэгчид байж болно. Тухайлбал:

- орон нутгийн засаг захиргаадын тусгайлсан бүтцийн дотор зохион байгуулагдсан захиргааны бус /that are no juridical persons/ үйл ажиллагааны газар;
- орон нутгийн захиргааны шийдвэрийн дагуу байгуулагдаж, зохион байгуулагдсан захиргааны бус /which are no juridical persons/ орон нутаг, эсхүл сумын түвшний нийтийн үйлчилгээ;
- орон нутгийн захиргааны шийдвэрийн дагуу байгуулагдаж, зохион байгуулагдсан захиргааны /which are juridical persons/ орон нутаг, эсхүл сумын түвшний нийтийн үйлчилгээ.



Эдгээр операторууд нь үйл ажиллагаагаа орон нутгийн захиргаанаас энэхүү үйлчилгээний талаар болон нийтийн эзэмшлийн системтэй холбогдох үйлчилгээний тухай шийдвэр, хууль ёсны зохицуулагч байгууллагаас олгосон лицензийн үндсэн дээр явуулна.

**Төлөөлүүлэн хариуцуулах менежмент** гэдэг нь менежментийг төлөөлүүлэн хариуцуулах гэрээ гэж нэрийдэх гэрээний үндсэн дээр орон нутгийн (засгийн газрын) нийтийн захиргаа (эсхүл бичил-бүс нутгийн ассоциац) өөрийн нийтийн үйлчилгээний бүх ажил, үүрэг харицлагыг нэг буюу түүнээс дээш операторуудад шилжүүлэх, аль эсвэл тэдгээрийн тодорхой хэсгийг шилжүүлэх арга хэлбэр юм. Энэ төрлийн гэрээг орон нутгийн засгийн газрын даатган хариуцуулах шийдвэрээр баталгаажуулна. Төлөөлүүлэн хариуцуулах менежментийн тохиолдолд орон нутгийн захиргаад хэдийгээр ажил үйлчилгээний арга барилыг удирдах, хянах, шалгах үүргээс чөлөөлөгдөх боловч нийтийн үйлчилгээтэй холбогдох хөгжлийн стратеги, бодлого батлан гаргах эрхээ хадгалан үлдэнэ.

Төлөөлүүлэн хариуцуулах менежментийг Хувийн компанийн хуулиар зохицуулагддаг операторууд <sup>34</sup>, эсхүл бүс нутгийн операторууд хариуцан гүйцэтгэнэ. Үүнд:

- хувьцаат хөрөнгө нь бүхэлдээ холбогдох орон нутгийн захиргааны бүтцийн эзэмшилд байдаг арилжааны компаниуд;
- зарим орон нутгийн, эсхүл сумын бие даасан операторууд, эсхүл нийтийн үйлчилгээг дахин зохион байгуулсны үр дүнд үүсгэн байгуулагдсан, нэг гишүүнтэй буюу хувьцаа эзэмшигч нь тухайн орон нутгийн захиргаа дангаараа байдаг арилжааны компаниуд;
- хувийн өмчит арилжааны компаниуд;
- орон нутаг болон хувийн өмч хосолсон компаниуд.

Дээрх операторууд нь менежментийг төлөөлүүлэн шилжүүлсэн гэрээ ба эрх бүхий зохицуулагч албанаас олгогдсон лицензийн үндсэн дээр холбогдох техник болон хотын дэд бүтцийг ажиллуулж, удирдан зохион байгуулах хэлбэрээр нийтийн үйлчилгээг эрхэлнэ.

Төлөөлүүлэн хариуцуулах гэрээг шууд олгох процесс, нээлттэй процесс ба өрсөлдөөнт харилцан ярианы процесс зэрэг процессын дагуу олгодог байна.

#### **4.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

Бүгд Найрамдах Солонгос Улсад хот нийтийн аж ахуйг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд Усан хангамж болон ус хангамжийн системийн тухай хууль (Water supply and waterworks installation act) <sup>35</sup>, Цахилгаан эрчим хүчний хэрэглээний тухай (Electric utility act) <sup>36</sup>, Нийтийн тээврийн үйлчилгээний тухай (Passenger transport service act) <sup>37</sup>, Хор хаягдлын хяналтын тухай (Wastes control

<sup>34</sup> Бүс нутгийн оператор нь арилжаа эрхэлдэг компани бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг бүхэлд нь орон нутгийн засаг захиргааны хэлтэс эзэмшдэг бөгөөд харьяа хэлтсийн шийдвэр гаргах байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулагдсан бичил бүсийн хөгжлийн ассоциацийг байгуулдаг.

<sup>35</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46343&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46343&lang=ENG)

<sup>36</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=42763&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42763&lang=ENG)

<sup>37</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46645&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46645&lang=ENG)

act)<sup>38</sup> Ариутгах татуургын тухай хууль (Sewerage act)<sup>39</sup> болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээр хуулиудтай холбогдон гарсан дүрэм, журмуудаар зохицуулж байна.

### **Усан хангамж болон ус хангамжийн системийн тухай хууль**

Нийт иргэдийг чанартай усаар хангах, нийтийн ариун цэврийг сайжруулахын сацуу амьдрах орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий тус хуулиар төрийн болоод усан хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үүрэг хариуцлага, усан хангамжтай холбогдон гарах бүхий л харилцааг зохицуулдаг байна.

Төр нь усан хангамж, ус хангамжийн системийг хөгжүүлэх, шаардлагатай төсөл, хөтөлбөр боловсруулах, ус хангамжийн бизнес эрхлэгчдэд санхүүгийн болоод техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

Нийслэл хотын захирагч, аймаг, орон нутгийн Засаг дарга нар нь өөрийн эрх мэдлийн хүрээнд харьяа нутаг дэвсгэрийн ард иргэдийг чанартай, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангахад анхаарч ус хангамжтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд санхүүгийн болон техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй.

Ус хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүд нь ус хангамжийн дэс дараатай үйл ажиллагааг тогтмол явуулахад анхаарч ажиллана.

Нийслэл хотын захирагч болон аймаг, орон нутгийн Засаг дарга нар нь харьяа нутаг дэвсгэрээ усаар хангах ус хангамжийн ерөнхий болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламж хийгээд ус дамжуулах шугам хоолойг барих, сайжруулах, засвар үйлчилгээ хийх, солих, ус нөөцлөх, ариутгах, дамжуулах, түгээх, зайлуулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр боловсруулж, мөрдөж ажиллана.

Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, усан хангамжийн үйл ажиллагаа эрхлэгчид нь нийт иргэдийг эрүүл, ариутгасан усаар хангахыг зорьж ажиллана.

Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах, усны хэрэглээний эрэлтийг тодорхойлох зорилгоор нийслэл хотын захирагч болон орон нутгийн удирдлагууд нь таван жил тутам нэг хүнд ногдох зохистой усны хэрэглээг харгалзан өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн усны хэрэглээний эрэлтийг тооцож, түүнд хүрэх зорилт, хөтөлбөр боловсруулан Байгаль орчны сайдад танилцуулна. Байгаль орчны сайд нь Газар, дэд бүтэц, тээврийн сайдтай зөвлөлдөн тус хөтөлбөрийг батална.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд доорх асуудлуудад анхаарч ажиллана. Үүнд:

1. Усны алдагдлыг багасгах жил бүрийн зорилт тавьж, төсөл хэрэгжүүлж ажиллах;
2. Усны урсгалыг нэмэгдүүлэх жил бүрийн зорилт тавьж, төсөл хэрэгжүүлж ажиллах;

<sup>38</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46237&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46237&lang=ENG)

<sup>39</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46579&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46579&lang=ENG)

3. Ус хэмнэх болон ашигласан усыг цэвэршүүлэх зориулалттай ус хэмнэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
4. Ус нөөцлөх болон ус хэмнэхийн ач холбогдлыг нэмэгдүүлэх бусад шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллах зэрэг болно.

Байгаль орчны сайд нь хамгаалах шаардлагатай усны эх ундарга, түүний эргэн тойрны ай савыг хамгаалалтад авах бөгөөд химийн хортой бодис, муу ус, хог хаягдал, мал амьтны ялгадас, сэг зэм болон ус бохирдуулах бусад зүйлсийг усанд хийхийг хориглон, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад үүрэг болгоно.

Усны эх ундарга, түүний ай сав орчимд дараах үйл ажиллагаа явуулахыг зорьж буй этгээд нь харьяа орон нутгийн засаг захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Үүнд:

1. Барилга барих, томсгох, засварлах, үйл ажиллагааг нь өөрчлөх, барилга байгууламжийг зөөвөрлөх;
2. Мод ургамлыг тайрах, огтлох;
3. Ай сав газрыг ухах, малтах зэрэг болно.

Ус хангамжийн үйл ажиллагааг засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, Солонгосын Усны нөөцийн корпорацитай хамтарч явуулна. Ус хангамжийн үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллагын зөвшөөрлөөр, эсхүл тус байгууллагыг төлөөлөн хувийн байгууллагууд гүйцэтгэж болно. Ус хангамжийн үйл ажиллагаа эрхлэгч нь ус хангамжийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах зэрэг тооцоон дээр үндэслэн усны тарифыг уян хатнаар тогтооно.

Нийт иргэд ус хангамж болон ус хангамжтай холбоотой барилга байгууламж барих, суурилуулах зэрэг төрөөс санаачлан, хэрэгжүүлж буй бүхий л арга хэмжээг дэмжиж, бүх нийтийг эрүүл ахуйн шаардлага хангасан, ариутгасан усаар хангах ажлыг дэмжин оролцох үүрэгтэй болно.

### ***Цахилгаан эрчим хүчний хэрэглээний тухай хууль***

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний тухай хуульд цахилгаан эрчим хүчээр хангах үйл ажиллагааг сайжруулах, хэрэглэгчийн хүсэл, сонирхлыг хамгаалах, эрчим хүчийг үйлдвэрлэдэг, түгээдэг, эрчим хүчээр ханган ажилладаг байгууллагуудын ашиг сонирхол хийгээд тэдгээрийн хоорондын үйл ажиллагаа, цахилгаан эрчим хүчтэй холбогдон гарах бүхий л харилцааг зохицуулсан байна.

Тус хуулийн 3.4 дүгээр хэсэгт Нийслэл хотын захирагч болон аймаг, орон нутгийн Засаг дарга нар нь харьяа нутаг дэвсгэрийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийг байнгын тогтвортой эрчим хүчээр хангах бодлогыг өөрийн эрх мэдлийн хүрээнд боловсруулан, Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яамтай хамтран цахилгаан эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлж ажиллах үүргийг хуульчилсан байна.

Цахилгаан эрчим хүчтэй холбоотой аливаа үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Эрчим хүчний зохицуулах хороо (Electricity Regulatory Commission) хянан үзсэний

үндсэн дээр Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайд олгоно. Үйл ажиллагааны төрөл болон хамрах нутаг дэвсгэрээс нь шалтгаалан зөвшөөрлийг олгох бөгөөд нэг хүнд хоёр болон түүнээс дээш төрлийн цахилгаан эрчим хүчтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөхгүй гэжээ.

Тодорхой дүүрэг, нутаг дэвсгэрийг эрчим хүч үйлдвэрлэн хангах “дүүргийн цахилгаан эрчим хүчний бизнес” (district electric business) эрхлэгчдэд цахилгаанаар хангах зөвшөөрлийг нутаг дэвсгэр давхардуулан олгодоггүй байна.

Цахилгаан эрчим хүч худалдаалах үйл ажиллагаа эрхлэгч нь цахилгааны үнэ тариф болон цахилгаан, эрчим хүчээр хангах, худалдаалах нөхцөлийг Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайдын зөвшөөрлийн үндсэн дээр тогтооно.

Цахилгаан эрчим хүч худалдаалах үйл ажиллагаа эрхлэгч нь хэрэглэгчийн төлбөрийн хуудсан дээр тус хэрэглэгчийн ашигласан цахилгааны нарийвчилсан задаргааг тавьсан байх шаардлагатай.

Цахилгаан хангамжийн үйл ажиллагаа эрхлэгч нь цахилгаан эрчим хүчээр хангах чанартай үйлчилгээг тогтмолжуулах шаардлагатай бөгөөд үйлчилгээний чанараас шалтгаалан хэрэглэгч хохирсон тохиолдолд Эрчим хүчний зохицуулах хорооноос холбогдох цахилгаан хангамжийн үйл ажиллагаа эрхлэгчид тоног төхөөрөмжөө засах, солих, үйл ажиллагаагаа сайжруулах, болон бусад шаардлагатай арга хэмжээ авч хэрэглэгчийг хохиролгүй болгохыг үүрэг болгожээ.

### ***Нийтийн тээврийн үйлчилгээний тухай хууль***

Нийтийн тээврийн үйлчилгээг чиглэлийн нийтийн тээвэр, хот хоорондын тээвэр, иргэдийн хүсэлтээр чиглэл, цаг, давтамжаа тогтоож үйлчилдэг тээврийн үйлчилгээ гэж ангилдаг байна.

Газар, дэд бүтэц, тээврийн сайдын хяналтан дор нийтийн тээврийн үйл ажиллагааны зориулалт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар Зөвлөлдөх хороо ажиллана. Зөвлөлдөх хороо нь тухайн орон нутгийн иргэдийн тээврийн үйлчилгээг сайжруулах, тээвэрлэлтийн ачаалал, нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын тэнцвэртэй хөгжил, нийтийн тээврийн үнэ тариф, тээврийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын тоо хэмжээ зэрэг асуудлаар зөвлөлддөг байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлтэй этгээд нь нийтийн тээврийн чиглэлээ тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж харьяалах хотын захирагч болон аймаг, орон нутгийн удирдлагаас зөвшөөрөл авч, бүртгэлд хамрагдана. Зөвшөөрөл нь үйлчилгээний хамрах хүрээ болон хугацаанд хязгаарлалт тогтоосон, нэмэлт нөхцөлүүдтэй байж болох бөгөөд үйлчилгээний төрөл хийгээд нийтийн тээврийн чиглэлийг хатуу тогтоосон байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний зөвшөөрөл хүсч буй этгээд нь дараах зүйлсийг бүрдүүлсэн байна:

1. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь тухайн нутаг дэвсгэр дэх нийтийн тээврийн хүчин чадал болон чиглэлийн хэрэгцээ, шаардлагатай нийцсэн байх;

2. Нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь шаардлагатай тооны моторт тээврийн хэрэгсэл, гарааж болон яаралтай тохиолдолд засвар үйлчилгээ үзүүлэх боломжтой байх;
3. Тээврийн хэрэгсэл жолоодсон туршлага, замын хөдөлгөөний осолд орж байсан эсэх зэргийг мөн харгалзан үзэх зэрэг болно.

Хотын захирагч болон аймаг, орон нутгийн засаг дарга нар нь таван жил тутам харьяа нутаг дэвсгэрийнхээ нийтийн тээврийн хүчин чадлыг тооцож, тээврийн хангамжийн төлөвлөгөөг боловсруулан, харьяалах яамны сайдад танилцуулахын сацуу олон нийтэд мэдээлнэ.

Иргэд олон нийтийг тогтвортой, чанартай үйлчилгээгээр хангах үүднээс Газар, дэд бүтэц, тээврийн сайд болон нийслэл хотын захирагч, аймаг, орон нутгийн засаг дарга нар нь шаардлагатай тохиолдолд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгоно. Үүнд:

1. Үйл ажиллагааны төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулах;
2. Нийтийн тээврийн чиглэлийн замыг сунгах болон хасах;
3. Үйлчилгээний үнэ тарифаа өөрчлөх;
4. Үйлчилгээний нөхцөлөө өөрчлөх;
5. Үйлчилгээгээ сайжруулах;
6. Үйлчилгээний төлбөр хураах арга барилаа сайжруулах;
7. Хамтарсан гэрээгээ дуусгавар болгох;
8. Даатгалд хамрагдах;
9. Нийтийн тээврээр үйлчилж байх үедээ аюулгүй байдлыг хангаж, үйлчилгээгээ сайжруулах арга хэмжээ авч ажиллах;
10. Алслагдсан болон ашиг багатай чиглэлд үйлчлэх зэрэг болно.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй этгээд нь харьяалах яамнаас баталсан, тээврийн үйлчилгээний тогтсон үнэ тарифыг баримталж ажиллана.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчид нь иргэд олон нийтэд чанартай үйлчилгээ үзүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээг тогтмол явуулах үүднээс хамтарсан гэрээ байгуулан ажиллаж болно. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчид нь шаардлага хангасан этгээдийг авч ажиллуулах боломжтой бөгөөд олон нийтэд үйлчлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс анхаарал тавьж ажиллана.

Төрөөс нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчид дараах тохиолдолд шаардагдах санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой байна. Үүнд:

1. Нийтийн тээврийн хэрэгслийг сайжруулах болон зогсоолыг шинэчлэх;
2. Энгийн болон аюулгүй ажиллагааны үйлчилгээг өргөжүүлэх, сайжруулах;
3. Хуучирсан тээврийн хэрэгслийг солих;
4. Зогсоолыг нүүлгэх, томруулах, бүтэц, зохион байгуулалт, тоног төхөөрөмжийг нь шинэчлэх;
5. Нийтийн тээврийн үйлчилгээг өргөжүүлж, тоног төхөөрөмжийг сайжруулах;
6. Эдийн засгийн хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, аюулгүй ажиллагааг хангасан тоног төхөөрөмж, үйлчилгээг дэмжих зэрэг болно.

Төрөөс нийтийн тээврийн үйлчилгээг тогтвортой явуулах, нийтийн тээврийн үйлчилгээг дэмжих бодлогоор Тусгай татварын хязгаарлалтын тухай хуульд



заасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчийн татварыг хөнгөлөх болон татвараас чөлөөлөх боломжтой байна.

### ***Хог хаягдлын хяналтын тухай хууль***

Энэхүү хуулийн зорилт нь хог хаягдлыг бий болгох явцыг боломжит хэмжээгээр бууруулж, хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар дахин боловсруулах, устгалд оруулах зэргээр байгаль орчноо хэвээр хадгалах, хүмүүсийн амьдралыг сайжруулахад оршино.

Байгаль орчны сайдын тушаалын дагуу хог хаягдлыг төрөл болон дахин ашиглах байдлаар нь ангилна.

Нийслэл хотын захирагч, орон нутгийн засаг дарга нар хог хаягдлыг устгах болон дахин боловсруулах байгууламжийг барьж ашиглах, ажилтнуудын ур чадварыг сайжруулж, арга барилыг нэмэгдүүлэх, нийт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад хог хаягдлаа бууруулснаар байгаль орчноо хамгаалахын ач холбогдлыг байнга сануулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Төрөөс хог хаягдлыг устгах болон дахин боловсруулах талаар судалгаа, шинжилгээ хийх, шинэ арга, технологи боловсруулах, хэрэгжүүлж ашиглах зэрэгт нийслэл хотын захирагч хийгээд орон нутгийн удирдлагуудад техник, тоног төхөөрөмжийн болон санхүүгийн тусламж, дэмжлэгийг үзүүлэхийн сацуу хамтарч ажиллах үүрэгтэй.

Иргэн бүр байгаль, амьдарч буй орчин тойрноо цэвэр сайхнаар хадгалах үүрэгтэй бөгөөд үүний тулд хог хаягдлаа багасгах, дахин ашиглах шаардлагатай байна. Хот болон орон нутгийн захиргаанаас төлөвлөсний дагуу иргэд эзэмшиж, ашиглаж буй барилга байгууламж, газар нутгаа цэвэрлэх, хог бохирдлоос салгах үүргийг хүлээнэ. Хог боловсруулах байгууламж болон хог хаяхыг тусгайлан заасан цэгээс бусад газар хог хаягдал хаях, булах, шатаахыг хориглоно. Дээрх үүргийг биелүүлээгүй тохиолдолд харьяа нутаг дэвсгэрийн засаг захиргаанаас яаралтай арга хэмжээ авахыг иргэнд үүрэг болгоно.

Байгаль орчны яамнаас хог хаягдлыг дахин боловсруулахад орчны үнэлгээ хийх байгууллагыг дараах байгууллагууд дотроос сонгоно. Үүнд:

1. Улсын болон олон нийтийн судалгааны хүрээлэнгүүд;
2. Солонгосын байгаль орчны корпорац болон бусад байгууллагууд орно.

Хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг үнэлж дүгнэх эрх бүхий байгууллага нь үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрлөө бусдад өгөх, зээлдүүлэхийг хориглоно. Албан ёсны эрх бүхий дээрх байгууллагууд нь “Орчны дүн шинжилгээ, үнэлгээний тухай” хуульд заасан стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Нийслэл хотын захирагч болон орон нутгийн засаг дарга нар нь өөрийн хариуцаж буй газар нутгийн хог хаягдлын устгал, дахин боловсруулалт зэрэг үйл ажиллагааг өөрт олгосон эрх мэдлийн хүрээнд гүйцэтгэнэ.

Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгалд оруулах зэрэг үйл ажиллагааг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөөг

боловсруулж хот, орон нутгийн удирдлагаас зохих зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Үйлдвэрлэлийн хог хаягдлыг үйлдвэрлэл эрхэлж буй этгээд өөрөө устгах болон дахин боловсруулах эрхтэй болно. Мөн түүнчлэн зөвшөөрөл бүхий, шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжтэй байгууллага болон иргэнд хог хаягдлыг төлбөр төлсний үндсэн дээр устгуулах хийгээд дахин боловсруулахаар шилжүүлж болно. Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэж, дахин боловсруулалт хийсэн буюу устгалд оруулсан иргэн тухай бүр тэмдэглэгээ хийж байх шаардлагатай. Ижил үйл ажиллагаа эрхэлдэг 2 иргэн хамтран үйл ажиллагаа явуулж болно.

Үйл ажиллагааны доголдол гаргасан, үйлчлүүлэгчийг хохироосон, хүрээлэн буй орчныг бохирдуулсан, ард иргэдийн эрүүл мэндэд хор нөлөө үзүүлэх хүртэл хэмжээнд алдаа дутагдал гаргасан бол хог цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн болон аж ахуйн нэгжид мөнгөн торгууль ногдуулах, цааашлаад эрхийг нь цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.





## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Румын улс

- [https://ec.europa.eu/competition/state\\_aid/public\\_services/2012\\_2014/romania\\_en.pdf](https://ec.europa.eu/competition/state_aid/public_services/2012_2014/romania_en.pdf)

### Австралийн Холбооны улс

- <https://legislation.act.gov.au/View/a/2000-65/current/PDF/2000-65.PDF>

### Бүгд Найрамдах Лавти улс

- [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Energy\\_Law.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Energy_Law.doc)
- [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Cab.\\_Reg.\\_No.\\_265\\_-\\_Postal\\_Regulations.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Cab._Reg._No._265_-_Postal_Regulations.doc)
- [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Electronic\\_Communications\\_Law.doc](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Electronic_Communications_Law.doc)
- <http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Likumi/Railway.pdf>
- <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/lat172903.pdf>
- <https://www.linkedin.com/company/public-utilities-commission-of-latvia>
- [http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Citi/On\\_Regulators\\_of\\_Public\\_Uilities.pdf](http://www.vvc.gov.lv/export/sites/default/docs/LRTA/Citi/On_Regulators_of_Public_Uilities.pdf)
- <https://erranet.org/member/puc-latvia/>

### Бүгд Найрамдах Солонгос Улс

- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46343&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46343&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=42763&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42763&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46645&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46645&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46237&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46237&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46579&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46579&lang=ENG)
- [http://www.uncrd.or.jp/content/documents/18242EST\\_Korea.pdf](http://www.uncrd.or.jp/content/documents/18242EST_Korea.pdf)
- <http://english.seoul.go.kr/policy-information/environment-energy/climate-environment/1-environment-policies/>
- Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал, Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж МОН/13/302 төсөл, 2014 он.
- Styles of Regulation: The Choice of Approach to Utility Regulation in Central and Eastern Europe, JON STE

**“БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭДЭГ  
ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

*Д.Жигваагүнсэл*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ТОЙМ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ:

- *Бурхан багшийн их дүйчин өдрийг хэрхэн тэмдэглэдэг тухай*
- *Хууль эрх зүйн зохицуулалт*

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## Удиртгал

Энэхүү мэдээлэл, лавлагаанд гадаадын зарим улс орнуудад “Бурхан багшийн их дүйчин өдөр”-ийг хэрхэн тэмдэглэдэг тухай болон хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг авч үзлээ.

Судалгаанд Бурхан багшийн их дүйчин өдрийг өргөн дэлгэр тэмдэглэдэг улс орнууд болох Энэтхэг, Шриланка, Непал, Бангладеш, Бутан, Индонез, Сингапур, Тайланд, Камбож, Лаос, Малайз, Мьянмар, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Вьетнам зэрэг орнуудыг хамруулсан болно.

## Судалгааны тойм

Дэлхийн улс орнуудад тэр дундаа бурханы шашинтай, эсхүл бурханы шашны уламжлалтай орнуудад Бурхан багшийн их дүйчин өдрийг өнө эртнээс өргөн дэлгэр тэмдэглэж иржээ.

“Их дүйчин өдөр” (Весак)-ийг олон улсад тэмдэглэх тухай санаачилгыг<sup>40</sup> анх 1950 онд Шриланкад зохион байгуулагдсан Дэлхийн буддистуудын анхдугаар чуулганаас (World Fellowship of Buddhists) дэвшүүлж байжээ. Улмаар 1999 онд НҮБ-ын 54/115 дугаар Ерөнхий Ассамблейн тогтоол<sup>41</sup>-оор энэ өдрийг олон улсын тэмдэглэлт өдөр болгосон байна.

Судалгаанд хамруулсан ихэнх улс орнуудад Бурхан багшийн их дүйчин өдрийг албан ёсны бүх нийтийн баяр, амралтын өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд холбогдох хууль тогтоомждоо энэ өдрийг албан ёсны амралтын өдөр байхаар зохицуулсан байна. Зарим улс оронд уг баярыг тэмдэглэж ирсэн хэдий ч бүх нийтээр амардаггүй. Тухайлбал:

Бүх нийтийн баяр, амралтын өдөр болгон тэмдэглэдэг улс орнууд	Тэмдэглэдэг ч бүх нийтээр амардаггүй улс орнууд <sup>42</sup>
Шриланка, Индонез, Бутан, Непал, Өмнөд Солонгос, Бангладеш, Малайз, Сингапур, Тайланд, Мьянмар, Энэтхэг, Лаос	Япон, Хятад, Вьетнам,

Энэ өдрийг бүх нийтийн баяр, амралтын өдрийн хэмжээнд тэмдэглэдэг дээрх улс орнууд нь ихэвчлэн бурханы шашны өнө эртний уламжлалтай улсууд байна. Харин Хятад, Вьетнам зэрэг улсууд нь улс төрийн дэглэмийн нөлөөгөөр зөвхөн сүм хийдүүд, сүсэгтэн олон нь тэмдэглэн өнгөрүүлдэг байна.

Бурхан багшийн их дүйчин өдөр нь билгийн тооллын зуны эхэн сарын шинийн 15-ны өдөр тохиодог боловч билгийн тооллын цаглавар тооцооллын төв цэг, уур амьсгалын нөхцөл байдал, цагийн бүсчлэл зэргээс хамааран энэ өдөр нь улс орон бүрт аргын тооллын харилцан адилгүй өөр өөр өдөрт болдог байна.

Бурхан багшийн дүйчин өдөр буюу Весак өдрийн албан ёсны нэр нь эртний

<sup>40</sup> <http://wfbhq.org/general-conference-detail.php?id=015000018>

<sup>41</sup> 54/115. International recognition of the Day of Vesak at United Nations Headquarters and other United Nations offices- <https://undocs.org/A/RES/54/115>

<sup>42</sup> Өөрөөр хэлбэл, тэмдэглэлт өдөр байна.

Энэтхэгийн билгийн тооллын 4-5 дугаар сарыг нэрлэх Весакха (пали хэлээр “Весакха”, санскрит хэлээр “вайшакха”) хэмээх нэр томьёоноос үүсэлтэй. Их хөлгөний ёс, уламжлалд энэ өдрийг санскритаар “вайшакха” гэх бөгөөд үндэстэн бүрт ялимгүй өөрөөр тухайлбал, Буддхо Пурнима (Ассам), Буддхо Пурнима, эсхүл Буддхо Жоёонти (Бенгали), Дүйчэн Азом (Зонхо буюу Бутан хэлээр), Касоны тэргэл сартай өдөр (Мьянмар), Сагадаваа (Төвөд) гэх мэтчилэн нэрлэдэг байна.

Дээрх улс орнууд энэ өдрөөр ихэвчлэн мөргөл хийх, бурхан шүтээнд залбирал үйлдэх, мацаг барих, согтууруулах ундаа хэрэглэхгүй, худалдахгүй байх, бие, хэл, сэтгэлийн аливаа муу үйлийг тэвчих, өглөг хандив өгөх, бусдад туслах, энхтайвны жагсаал цуглаан хийх, мод тарих, цэвэрлэгээ хийх зэргээр нийгэм, олон нийтийг хамарсан сайн үйлсийг дэлгэрүүлдэг байна. Учир нь тухайлан энэ өдөр үйлдсэн буян асар ихээр арвиждаг гэж үздэг. Зарим улс оронд тухайлбал, Шриланкад эдгээр өдрүүдэд согтууруулах ундаа, мах зарахыг хориглох ба нядалгааны газруудын үйл ажиллагааг түр зогсоодог бол Лаост энэ баярын өдрөөр ёслолын бүжиг, яруу найраг, баярын парад жагсаал, гүн бясалгал, театрчилсан тоглолт, хүүхэлдэйн жүжиг, үзүүлбэр зэрэг олон үйл ажиллагааг явуулахаас гадна пуужингийн фестиваль зохион байгуулдаг байна.

*(Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү)*



## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Бурхан багшийн их дүйчин өдөр гэдэг нь Шагжамүни бурханы лагшин мэндэлсэн, төгс гэгээрлийн хутгийг<sup>43</sup> олсон, нирваан дүрийг үзүүлсэн<sup>44</sup> гурван их өлзийт үйлс тохиосон өдөр юм. Энэ өдрийг бурханы шашинтай болон бурханы шашны уламжлалтай орнууд өнө эртнээс тэмдэглэж иржээ.

***Бурхан багшийн их дүйчин өдрийг хэрхэн тэмдэглэдэг тухай:***<sup>45</sup>

Бурхан багшийн их дүйчин (Весак) өдөр нь билгийн тооллын зуны эхэн сарын шинийн 15-ны өдөр тохиодог бөгөөд билгийн тооллын цаглавар тооцооллын төв цэг, уур амьсгалын нөхцөл байдал, цагийн бүсчлэл зэргээс хамааран энэ өдөр нь аргын тооллын өөр өөр өдрүүдэд тохиодог байна. Тавдугаар сард ихэвчлэн тэргэл сартай өдөр 1 удаа тохиодог боловч тэргэл сартай өдрүүдийн хооронд 29.5 өдөр байх тул тухайн сард хоёр удаа тохиох нь бас бий. Тиймээс хэрвээ 5-р сард тэргэл сартай өдөр хоёр тохиовол Шриланка, Камбож, Малайз зэрэг орнуудад Весак өдрөө эхэлж тохиосон тэргэл сартай өдөр нь тэмдэглэдэг. Жишээлбэл: судалгаанд хамруулсан орнууд 2019 онд дараах өдрүүдэд тэмдэглэжээ:

*Бурхан багшийн их дүйчин өдрийг 2019 онд тэмдэглэсэн байдал*

Улс орнууд	Тэмдэглэсэн хугацаа
Тайланд, Непал, Бангладеш, Энэтхэг Мьянмар, Шриланк, Камбож	5 сарын 18
Индонез, Малайз, Вьетнам, Сингапур	5 сарын 19
Хятад	5 сарын 12
Бутан	6 сарын 17
Япон	4 сарын 8

Мөн бурханы шашин анх Энэтхэгээс өөр бусад улс үндэстнүүдийн дунд дэлхийн шашин болтлоо дэлгэрэхдээ тэдгээрийн уламжлалт зан заншил, соёлын хөрсөнд идээшсэн тул энэ өдрийг тэмдэглэх ёс заншил улс орон бүрт ялимгүй өөр өөр байна. Тухайлбал:

**Японд** Бурхан багшийн их дүйчин өдрийг Ханамацури (hanamatsuri-花祭), Канбуцуе (Kanbutsue-灌仏会), Гоутане (Goutan'e-降誕会), Бусшоуе (Busshoue-仏生会), Ёкубуцуе (Yokubutsue-浴仏会), Рюгэ (Ryuge'e-龍華会), Ханаешики (Hanaeshiki-花会式) гэхчлэн нэрлэх ба Бурхан багшийн төрсөн өдөр тэнгэрт есөн луу тодорч түүний дээрээс рашааны хур буулгасан гэсэн домогт үндэслэн Хятадын цаг тооны бичгийн 4-р сарын шинийн 8-ны өдөр тэмдэглэдэг байжээ. Орчин үед Японы Мейжигийн үеэс эхлэн нарны цаглавар буюу аргын тооллыг албан ёсоор хэрэглэж эхэлсэнтэй холбоотойгоор жил бүрийн 4-р сарын 8-ны өдрийг “Бурхан багшийн төрсөн өдөр” хэмээн тэмдэглэдэг болсон байна.

Японд энэ өдрөөр гол төлөв бурхан багшийн баримал дүрийн дээр тусгайлан бэлтгэдэг цай өргөх зан үйлийг үйлдэнэ. Сүм хийд тэргүүтэн шашны газрууд нь сүсэгтнүүд болон санваартнууддаа зориулсан ном ёслолыг үйлдэцгээнэ. Бүх

<sup>43</sup> Төгс гэгээрлийн хутаг- хилэнц нүгэл бүхнийг ариусган, орчлонгийн зовлонгоос гэтлээд, энэрэл нигүүлсэл хийгээд бодийн сэтгэлийг төгс боловсруулж, хамгийг илт мэдэгч билиг билгүүнийг олохыг хэлнэ.

<sup>44</sup> Нирваан дүрийг үзүүлэх- Бурхан багш тэргүүтний нас барахыг “нирваан дүрийг үзүүлэх” гэж өгүүлдэг уламжлалтай. Үүнийг мөнх бусын тухай сургаалыг үлгэрлэн харуулж буй ном гэж үзнэ.

<sup>45</sup> <https://en.wikipedia.org/wiki/Vesak>

нийтээр амардаггүй юм байна.

**Непал** улсад Бурхан багшийн их дүйчин өдрийг “Буддха Жаяанти” гэж нэрлэх бөгөөд улс орон даяар өргөн дэлгэр, ялангуяа Бурхан багшийн лагшин мэндэлсэн Лүмбүни цэцэрлэг болон Катманду дахь Сваяамбху<sup>46</sup> - “Сармагчны сүм” гэж алдаршсан сүмд олноороо цуглан тэмдэглэдэг. Сваяамбху суварган сүмийн гол үүд зөвхөн энэ өдөрт л зориулж нээгддэг тул Катмандугийн өнцөг булан бүрээс төдийгүй газар бүрээс хүмүүс ирж баярын ёслолд оролцоно. Энэ өдрийг бүх нийтийн амралтын өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд энэ өдөр сүсэгтнүүд бурханд мөргөх, залбирал үйлдэх, ном айлдвар сонсох ба бурхан шүтээнд цэцэг, зул, хүж тэргүүтэн тахил, өргөлийн зүйлсийг өргөж болно. Мөн өнчин ядууст хоол хүнс, хувцас өгч, сүм хийд, сургуулиудад мөнгөн хандив өргөх зэргээр өргөн дэлгэр тэмдэглэдэг.

**Шри Ланкад** Бурхан багшийн их дүйчин өдрийг Весак (аргын тооллоор гол төлөв 5-р сард тохионо) сарын шинийн 15-ны өдөр шашин, соёлын баяр ёслол хэмээн үзэж шашны ёс харгалзахгүйгээр 7 хоногийн (2019 оныг хүртэл 5 өдөр тэмдэглэдэг байсан. Өнгөрсөн 5-р сарын 17-21 өдрүүдэд төлөвлөгдсөн энэ баярыг Шриланкийн Засгийн газраас аюулгүй байдлыг хангах учир шалтгаанаар 2 өдөр (5-р сарын 17, 18 өдрүүдэд) тэмдэглэхээр хязгаарласан. Энэ нь урьд өмнөхөн нь 4-р сарын 21-нд Коломбо дахь Христийн сүмд бөмбөг тэсэлсний улмаас 250 гаруй хүн нас барсантай холбоотой) туршид тэмдэглэдэг.

Тус баярын өдрүүдэд (долоо хоногийн турш) согтууруулах ундаа болон мах худалдаалахыг хориглож, нядалгааны газруудын үйл ажиллагааг түр зогсоодог. Баяр тэмдэглэх зан үйл нь шашин номын үйл болон өглөг үйлдэх зэргээс бүрдэнэ. Коломбо, Канди, Галле хотууд зэрэг газар сайгүй Бурхан багшийн урд төрлийн тухай (“Үлгэрийн далай” (Jataka tales)-гаас сэдэвчилсэн) үзүүлсэн “тхоранас” хэмээх цахилгаан гэрэлтүүлэг бүхий самбар, чимэглэл, хөшөө зэргийг өглөгийн эзэд, шашны нийгэмлэг, аж ахуйн нэгжүүдийн өргөл хандиваар бүтээн байрлуулна.

Үүнээс гадна “Весак күүдү” хэмээгдэх өнгөт дэнлүүг гэрийн болон гудамжны дагуу өлгөж чимэглэдэг байна. Эдгээр гэрлээр бурхан, ном хийгээд хуврагийн чуулганы гэрэл гэгээг бэлгэдэнэ. “Дансаалас” хэмээх сүсэгтнүүд хаа сайгүй хоол хүнсний асруудыг байгуулж, гудамжаар зорчигсдыг идээ ундаа, мөхөөлдөс тэргүүтнээр үнэ төлбөргүй дайлна. Олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүд болон төр, засгийн байгууллагуудын төлөөлөгчид “Бхакти гий” (bhakti gee) хэмээх залбирал, мөргөлийн дууг дуулцгаадаг байна.

**Өмнөд Солонгост** Бурхан багшийн төрсөн өдрийг Солонгосын билгийн тооллын 4-р сарын шинийн 8-ны өдөр тэмдэглэдэг нь Хонконг, Макао, Вьетнам улсуудынхтай давхцдаг байна. Энэ өдрийг солонгосчууд “Сеока тансинил” (석가탄신일-Бурхан багшийн мэндэлсэн өдөр), эсхүл “Бучеоним осин нал” (부처님 오신 날- Бурхан заларсан өдөр) гэхчлэн нэрлэх бөгөөд бүх нийтийн албан ёсны амралтын өдөр байдаг. Эдүгээ тус улсын соёлын томоохон баяруудын нэг болсон энэхүү өдрөөр олон зуун мянган лянхуа цэцгийн дүрст дэнлүүгээр сүм хийдийг төдийгүй гудамж талбайг хүртэл бүтэн сарын туршид чимэглэнэ. Мөн сүм хийдүүд мөргөлчид

<sup>46</sup> Сваяамбху: Swayambhunath – манай “соёмбо” гэдэг үгтэй гарвал болон утга нэгтэй. “Өөрөө гарсан” гэсэн үг.



сүсэгтнүүдэд үнэ төлбөргүй зоог өргөдөг. Өглөөний цай болон өдрийн хоолонд өргөдөг гол зоог нь санчэ бибимпап (**sanchae bibimbap**) байна. Бусад улс орнуудынхтай адил өглөг өгөх, номын үйлд шамдах, буян хийх, нүглийг тэвчих, бусдад туслах, мөргөл хийх, бясалгал үйлдэх зэрэг зан үйлийг мөн хийдэг.

**Лаост** энэ өдрийг Викакха Боукса (Vixakha Bouxa festival) баяр гэх бөгөөд энэ нь Тайчуудын Висакха пужа буюу Бурхан багшийн дүйчин өдрийн хурал номын үйлийн Лаос хувилбар юм. Эдгээр нь хоорондоо их төстэй. Бурхан багшийн мэндэлсэн, гэгээрсэн хийгээд нирваан дүр үзүүлсэн өдрүүд бүгд энэ өдөрт тохиосон хэмээн үздэг. Энэ өдөр нь тухайн улсын баримталдаг билгийн тооллын Весак буюу 5 дугаар сар орчимд болно. Энэхүү баяр нь ёслолын бүжиг, яруу найраг, баярын парад жагсаал, гүн бясалгал, театрчилсан тоглолт, хүүхэлдэйн жүжиг, үзүүлбэр зэрэг олон үйл ажиллагаанаас бүрдэнэ. Викакха Боукса баярын нэгэн том бүрэлдэхүүн хэсэг нь “Боун Банг Фэй” хэмээх пуужингийн фестиваль юм. Тухайн сар нь (5 сар) жилийн хамгийн халуун хуурай улирал байдаг учраас гар аргаар хийсэн том пуужингуудыг хөөргөдөг нь тэнгэрээс хур бороо хайрлахыг хүсэж байгаа утга учиртай. Уламжлалт ёсоор лам хуврагууд хулс модны хөндийд дарь зэрэг бодисыг дүүргэн пуужин хийдэг байсан бол орчин үед жирийн хүмүүс хийх болсон ба хэн нь хамгийн өнгө үзэмжтэй, хурдтай, өндөрт хөөрөх пуужин бүтээснийг шалгаруулах уралдаан тэмцээн хүртэл зохион байгуулдаг болжээ. Энэхүү фестиваль нь Тайланд болон Лаос Улсын хил хоорондох Мекхонг мөрний хоёр эрэг дээр зохион байгуулагддаг тул заримдаа хоёр улсын багууд тэмцээн зохион байгуулж өрсөлддөг ажээ. Энэ нь гадны жуулчид зорин ирж үздэг алдартай үйл ажиллагааны нэг болсон байна.

**Вьетнамд** Бурхан багшийн мэндэлсэн өдөр нь 1975 оноос өмнө Өмнөд Вьетнамын бүх нийтийн баяр ёслол, амралтын өдөр байсан бөгөөд энэ өдөр асар олон тооны гэрэлт дэнлүү хөөргөдөг, дэнлүүт жагсаал хийдэг байжээ. Гэвч Сайгон умард Вьетнамд эзлэгдсэнээс хойш бүх нийтийн баяр ёслол байхаа больсон ч, 2000-аад оноос хойш энэ баяр улс орон даяар дахин сэргэж эхэлсэн байна. Бурхан багшийн дүйчин өдрийг жил бүр сүм хийд, сүсэгтнүүд нь тэмдэглэдэг бөгөөд 2008, 2014, 2019 онуудад олон улсын төлөөлөгчдийг хүлээн авч өргөн хэмжээнд зохион байгуулжээ.

**Малайзад** бурханы шашинтнууд Бурхан багшийн их дүйчин өдрийг тэмдэглэдэг. Тэд өглөө эртлэн сүм хийдэд ирж найман бацаг сахилыг (*амь таслах, хурьцал үйлдэх, дуу дуулах, бүжиг бүжиглэх, гоёл чимэглэл зүйх, өндөр суудалд суух зэргийг тэвчинэ*) сахина. Өнчин, ядууст өглөг хандив өгөх, тахил өргөх, ном унших, залбирал үйлдэх зэрэг зан үйлийг үйлдэнэ. Хэдийгээр Үндсэн хуульдаа Исламын шашинт улс гэж заасан боловч Бурхан багшийн дүйчин өдрийг бүх нийтийн баяр, амралтын өдөр болгон тэмдэглэдэг байна.

**Бангладешт** бурханы шашинтнуудын хамгийн чухал тэмдэглэлт өдрүүдийн нэг нь Бурхан багшийн дүйчин өдөр юм. Бангла хэлээр энэ баярыг “Буддхо Пурнима” гэнэ. Бангладешт Читтагонг, Дхака болон бусад бурханы шашны дурсгалт газруудад амьдардаг хүмүүс нь тэмдэглэдэг хэдий ч энэ өдөр нийтийн баяр, амралтын өдөр байна.

**Индонезид** энэ өдрийг бүх Индонез даяар “Вайсак өдөр” хэмээн нэрлэж



тэмдэглэцгээнэ. Боробудур хэмээх газарт олон мянган хуврагууд хуран чуулж ном унших, бясалгал үйлдэх, Прадаксина хэмээх сүмийг гороолох зан үйл, ёслолуудыг үйлддэг. Энэ нь бурханы шашны сүм хийдүүдэд үзүүлж буй хүндэтгэлийн хэлбэр юм. Энэхүү онцгой чухал өдөр лам хуврагууд эгэл дарууг бэлгэдэх ариун ус савлаж, гэгээрлийг бэлгэдэх зулыг өргөн газар газарт түгээнэ. Мөн лам хуврагууд “Пиндапада” нэрт зан үйлд оролцох ба энэ нь сүсэгтэн олноос лам хуврагуудад өглөг, хандив өргөх зан үйл юм. Хэдийгээр Индонез нь албан ёсоор исламын улс боловч бурханы шашин, хиндү шашин шүтдэг ард иргэд олонтой (1,7 сая бурханы шашинтнуудтай) тул Вайсак өдрийг 1983 оноос хойш бүх нийтийн баяр, амралтын өдөр болгон тэмдэглэж иржээ.

**Сингапурт** сүсэгтэн олны удаа дараагийн санал хүсэлтийг харгалзан үзэж 1955 оноос Христийн шашны үүсэлтэй “ариун сүнсний даваа гараг” (Whit Monday) хэмээх баярыг халж Бурхан багшийн дүйчин өдрийг бүх нийтийн баяр, амралтын өдөр болгосон байна. XX зууны эхэн үед Сингапурт Бурхан багшийн дүйчин өдрийг Цейлоны арлаас нүүж ирсэн хүмүүсийн дунд тэмдэглэдэг байсан бол дэлхийн II дайны дараа Сингапурын Буддист Ассоциациас тэргүүлэн Бурхан багшийн их дүйчин өдрийг бүх нийтийн баяр, амралтын өдөр болгох санал хүсэлтийн хөдөлгөөнийг өрнүүлсний улмаас 1954 оноос эхлэн нийтээр тэмдэглэх болжээ.

**Энэтхэгт** энэ өдрийг “Буддха Жаяанти” буюу “Бурхан багшийн мэндэлсэн өдөр” хэмээн бүх нийтээрээ тэмдэглэдэг уламжлалтай. Бурханы шашинтнууд энэ өдөр сургаал ном сонсох, хэлэлцэх, уншихаас гадна бүтэн өдрийн туршид цагаан өмсгөл өмсөж, цагаан хоол хүртэнэ. Энэчлэн шувуу, хорхой шавьж, бусад амьтдыг хэдэн зуу, мянгаар нь гэтэлгэх үйлийг (сэтэрлэх гэж ярьдаг. “Цэ-тор” буюу “насны тотгороос гэтэлгэх” гэдэг.) үйлдэцгээнэ. Энэ нь аюулгүйн өглөгийг үйлдэж, буян хурааж буй үйл юм. Зарим сүсэгтнүүд энэ дүйчин буюу өлзийт сайн өдрүүдэд Их хөлгөний найман бацаг сахилыг (*амь таслах, хурьцал үйлдэх, дуу дуулах, бүжиг бүжиглэх, гоёл чимэглэл зүйх, өндөр суудалд суух зэргийг тэвчинэ*) хүртэж нэгэн өдрийн турш ариун ёс суртахуун, зан төлөвийг дадуулдаг байна. Өнчин, ядуу, өтгөс буурлуудад тусалж, халамжийн байгууллагуудад мөнгөн хандив, хоол хүнс, хувцас хэрэглэлийг хандивлана. Торонд хоригдсон амьтдыг худалдан авч чөлөөлдөг. Засгийн газрын байгууллагууд, шуудангийн албад, банкууд энэ өдрөөр амарна. Харин дэлгүүр хоршоо, бусад бизнесийн байгууллагууд амарч, эсхүл ажиллах цагаа багасгаж болно. Ихэнх орон нутгийнхан шашны ёслолд оролцохоор зорчдог тул нийтийн тээвэр амардаггүй байна.

**Бутанд** Бурханы шашин нь Үндсэн хуулиараа төрийн шашин байдаг. Тиймээс бурханы шашны баярыг улс орон даяар ёслол төгөлдөр тэмдэглэнэ. Бурхан багшийн их дүйчин өдрийг Бутанд “Бурхан багшийн нирваан дүрийг үзүүлсэн өдөр” хэмээн тэмдэглэхээс гадна Бурхан багшийн тэнгэрийн орноос заларсан өдөр, Анхдугаар номын хүрдийг эргүүлсэн өдөр зэргийг мөн тэмдэглэдэг байна. Эзэн хааны төрсөн өдрөөс гадна ширээнд залагдсан өдөр, Врүгва гаржүдийн ёсны их багш нар болох гурав болон дөрөвдүгээр дүрийн Врүг Жалбой нарын мэндэлсэн өдөр, Ловон Бадмажунайн мэндэлсэн өдөр, Тимпү Их Цэжү хурал зэрэг бурханы шашны холбогдолт баяруудыг бурханы шашинт ард түмний нэгэн адилаар номын ёсоор нь тэмдэглэдэг бөгөөд эдгээр өдрүүдэд ном унших, бясалгал үйлдэх, мөргөл

хийх зэрэг зан үйлийг хийдэг уламжлалтай.

**Монгол Улсад** 1990-ээд оноос эхлэн Гандантэгчинлин хийдэд Бурхан багшийн их дүйчин өдрийг тэмдэглэж ирсэн. 2003 онд Засгийн газрын 163 дугаар тогтоолоор “Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх журам”-ыг батлан, уг тогтоолын 11-рт Бурхан багшийн их дүйчин өдрийг оруулсан байна. Сүүлийн жилүүдэд энэ өдрөөр Бурханы шашны олон байгууллага, сүсэгтнүүд Гандантэгчинлин хийдээс Сүхбаатарын талбай хүртэл шашны сүрт жагсаал зохион байгуулах, төв талбай дээр нийтийн бясалгал үйлдэх, сайн дурын ажил хийх зэргээр тэмдэглэдэг болсон. Ингэхдээ нийслэлийн засаг захиргаанаас зөвшөөрөл авдаг байна. Түүнчлэн энэ өдөр сүсэгтэн олон муу бүхнийг цээрлэн “их хөлгөний найман бацаг сахил” хэмээх нэгэн өдрийн сахилыг сахих, мацаг барих, маань тарни унших, бусдад өглөг өгөх, нийгмийн туст ажилд оролцох гэх зэрэг маш олон арга хэлбэрээр буян номын үйлд шамддаг уламжлалт тогтжээ. Энэ нь хүмүүнлэг энэрэнгүй ёсыг дээдэлсэн, өв соёлоо хойч үедээ уламжлуулсан, бусдад туслах буянт үйлсийг сурталчилсан, монголын шашин, соёлын нэгэн чухал үйл ажиллагаа юм.

### **Хууль эрх зүйн зохицуулалт:**

“Их дүйчин өдөр”-ийг олон улсад тэмдэглэн өнгөрүүлэх тухай уриалгыг<sup>47</sup> анх 1950 онд Шриланка-д зохион байгуулагдсан Дэлхийн буддистуудын анхдугаар чуулганаас (World Fellowship of Buddhists) дэвшүүлсэн байна. Энэхүү чуулганаас гаргасан уриалгын утга нь: *“Дэлхийн Бурханы шашинтнуудын энэхүү чуулганаас Балбын сүр жавхлант их хааны шинийн арван тавны Весак өдрийг Балбын нийтийн тэмдэглэлт баярын өдөр болгосон өлзийт сайн үйлийг сайшааж, даган баясахын сэтгэлээр олон, цөөн хэдий тооны боловч бурханы шашинт улс орны засгийн газруудад шинийн арван тавны энэхүү өдрийг нийт хүн төрөлхтний тусыг бүтээсэн агуу их хүмүүсийн нэг хэмээн дэлхий даяар алдар нь дуурссан Бурхан багшийг хүндэтгэж “Нийтийн тэмдэглэлт баяр”-ын өдөр болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хүсч байна”* гэжээ.

Улмаар 1999 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 54/115 дугаар тогтоол<sup>48</sup>-оор Весак өдрийг олон улсын тэмдэглэлт өдөр болгосноор Бурхан багшийн их дүйчин өдөр (Весак өдөр) нь НҮБ-ын Нью-Йорк дахь төв байр болон бусад ялангуяа Зүүн-Өмнөд азийн улсууд дахь салбаруудад хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэглэлт өдөр болжээ.

Бурхан багшийн их дүйчин өдрийг баяр, амралтын өдөр болгон тэмдэглэдэг улс орнууд тухайн өдрийг холбогдох хууль тогтоомжид дараах байдлаар журамлан зохицуулсан байна. Тухайлбал:

**Шриланкад:** Үндсэн хуулийн 2-р бүлгийн 9-р зүйлд: “Шриланкийн Бүгд Найрамдах Улс нь бусад шашны энэ хуулийн 10 ба 14 (1)(е) зүйлд заасан эрхүүдийг хангахын сацуу Будда сасанаг хамгаалан дэлгэрүүлэх Төрийн үүргийн дагуу Буддизмд тэргүүлэх байр суурийг олгоно”<sup>49</sup> гэж заасан байдаг.

<sup>47</sup> <http://wfbhq.org/general-conference-detail.php?id=015000018>

<sup>48</sup> 54/115. International recognition of the Day of Vesak at United Nations Headquarters and other United Nations offices- <https://undocs.org/A/RES/54/115>

<sup>49</sup> [https://www.constituteproject.org/constitution/Sri\\_Lanka\\_2015?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Sri_Lanka_2015?lang=en)

Тиймээс Хөдөлмөрийн хуулийн буюу Дэлгүүр ба албаны ажилтнуудын (Ажил эрхлэлт болон цалин урамшуулалын зохицуулалт) хуульд:<sup>50</sup> амралт авах болон чөлөө авах өдрүүдийг Долоо хоног тутмын амралт, Жил тутмын амралт, өвчин зэрэг хүндэтгэх шалтгаан бүхий чөлөө, бүх нийтийн амралт, **Шинийн 15-ны Поая амралт (Бурхан багшийн дүйчин)**, жирэмсний амралт гэж ангилсан байна. Үүнээс гадна журмын зохицуулалттай амралтуудад **“Весак шинийн 15-ны Поая өдрийн дараах өдрийн амралт”** гэж бас оруулжээ. Мөн Бурхан багшийн дүйчин өдрүүдээр амрах хуваарийг тухайн жил нь Газет сониндоо зарладаг.

Энэ тухай 1971 оны №29 Амралтын өдрийн тухай хууль<sup>51</sup>-ийн “бүх нийтийн болон банкны амралт” хэмээх 1-р хэсэгт *“Шинийн арван тавны Поая өдөр болон бүтэн сайн өдөр бүрийг а) бүх нийтийн амралтын өдөр; б) банкны амралтын өдөр болохыг үүгээр тунхагласугай”*; мөн 8 дугаар зүйлд: *“энэ хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Шинийн арван тавны Поая өдрүүд жил бүрийн аль сарын аль өдрүүдэд байх тушаалыг Газет-д хэвлэж тодорхой заана”* гэжээ.

Хуулийн “Шинийн арван тавны Поая өдрийг тэмдэглэх тухай” 2 дугаар хэсгийн Зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох тухай 13 дугаар зүйлд:

“(1) Аливаа шинийн арван тавны өдөр буюу Поая өдөр эрхлэхийг хориглох үйл ажиллагаа:

(a) шөнийн клуб, бүжиг, цэнгээний газар;

(b) орон нутгийн болон гадаадын согтууруулах ундаагаар үйлчилдэг газрууд, согтууруулах ундааны дэлгүүр, бар, эсхүл согтууруулах ундаа худалдаалан хадгалдаг газар;

(c) аливаа морин уралдааны бооцоо тавих газар, эсхүл үүнтэй ижил төстэй мөрий бооцоот үйл ажиллагаа; эсхүл

(d) аливаа махны худалдаа.

Амьтан нядлахыг хориглосон 14 дүгээр зүйлд: “Хэн боловч шинийн арван тавны Поая өдөр худалдааны зорилгоор ямар ч амьтан нядлахгүй, эсхүл худалдаалах болон худалдахыг санал болгохгүй бөгөөд ямар ч амьтны мах зарахыг хориглоно.

Мөн 15-р зүйлд зааснаар “Соёлын асуудал эрхэлсэн яамнаас урьдчилан авсан зөвшөөрлийн дагуу үзүүлбэр, үзвэрийг ажиллуулж болно гэхчлэн тус тус зохицуулжээ.

**Сингапурт:** “Амралтын тухай хууль”-ийн төгсгөл хэсэгт бүх нийтийн амралтын өдрүүдийг жагсаалтаар оруулсан байна. Үүнд нийтээр амрах 10 баяр байгаагийн 7 дугаарт Весак өдөр<sup>52</sup> оржээ. Бурхан багшийн дүйчин өдрийг тэмдэглэх тухайд Сингапурын “Ажил эрхлэлтийн тухай хууль”-ийн дагуу Весак өдрийг тэмдэглэх хуанлийг дараах байдлаар тооцож гаргасан байна. Үүнд:

Огноо	Гараг	Баяр
2019.05.19 Ням*		Vesak Day 2019
2019.05.20 Даваа		Vesak Day Holiday 2019

<sup>50</sup> Shop and Office Employees (Regulation of Employment and Remuneration) Act (No. 19 of 1954) [https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p\\_lang=en&p\\_isn=50743](https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_lang=en&p_isn=50743)

<sup>51</sup> Holidays Act (<https://www.lawnet.gov.lk/1946/12/31/holidays-act-2/>)

<sup>52</sup> <https://sso.agc.gov.sg/Act/HA1998>

2020.05.07 Пүрэв	Vesak Day 2020
2021.05.26 Лхагва	Vesak Day 2021
2022.05.15 Ням*	Vesak Day 2022
2022.05.16 Даваа	Vesak Day Holiday 2022
2023.06.02 Баасан	Vesak Day 2023
2024.05.22 Лхагва	Vesak Day 2024

(Санамж: Ням гарагт таарч буй баярын амралтын өдрүүдийг дараагийн даваа гарагаар нөхөж тэмдэглэнэ. Энэхүү хүснэгтэд заасан өдрүүд нь зөвхөн тооцоо ба албан ёсны өдрүүдийг зарласны дараа өөрчлөлт хийх боломжтой.)

**Малайзад:** Амралтын өдрийн тухай хууль<sup>53</sup> 1951 №369-д бүх нийтийн амралтын өдрүүдийн жагсаалтыг оруулсан байдаг. Үүний 4 дүгээрт Бурхан багшийн дүйчин өдрийг оруулжээ.

**Индонезид:** 2019 болон 2020 онуудад Засгийн газраас бүх нийтийн амралтын өдрийг зарласан жагсаалт<sup>54</sup>-ын 7 дугаарт Вайсак өдөр орсон байдаг.

**Бутанд:** 2007 оны Хөдөлмөр болон ажил эрхлэлтийн тухай хууль<sup>55</sup>-аар Бутан дахь ажил эрхлэлт, амралт, цалин хөлсний харилцааг зохицуулсан байдаг. Бутаны ихэнх баяр, амралтууд нь Азийн уламжлалт шашин, соёлын баярууд байдаг. Бүх ажилтнууд жилдээ наанадаж нийт 9 баяраар (Бурхан багшийн их дүйчин өдөр орно) албан ёсоор бүх нийтээр амардаг. Үүнийг тус хуулийн “Ажил, амралтын цаг” хэмээх VII бүлэгт дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

*108-р зүйл. Ажилтан жил бүр Сүр жавхлант эзэн хааны төрсөн өдөр, Үндэсний өдрийн баяруудыг оролцуулан багадаа нийт 9 баяраар<sup>56</sup> цалинтай (ердийн ажлын өдрийн цалингийн хэмжээгээр) амрах эрхтэй.*

*109-р зүйл. Ажил олгогч 108 дугаар зүйлд заасан аль нэгэн баярын өдрийг өөр нэгэн баяраар сольж амрахыг зөвшөөрч болно.*

*110-р зүйл. Хэрвээ ажилтан нийтийн баяр, амралтын өдрөөр ажиллах шаардлагатай бол ажил олгогч тухайн ажилтны өдрийн цалин дээр 50%-ийн нэмэгдэл цалин олгоно” гэхчлэн заасан байна.*

**Тайландад:** Бүх нийтийн баяр, амралтын өдрүүдийг Засгийн газрын тогтоолоор<sup>57</sup> зохицуулах ба ихэнх баярыг улсын болон хувийн секторын аль аль нь тэмдэглэдэг. Жилд үндсэндээ 16 баяр, амралтын өдөр байдаг ч Засгийн газраас илүү олныг зарлан тэмдэглэж болно. Эдгээрийн нэг нь Весак өдөр буюу Бурхан багшийн дүйчин өдөр байна. Тайландууд энэ өдрийг Бурхан багшийн мэндэлсэн, гэгээрсэн, нирваан дүрийг үзүүлсэн өдөр гэж үзэн тэмдэглэдэг уламжлалтай.

**Энэтхэгт:** Баяр амралтын өдрүүдийг цөөнхийн баяр (restricted), албан ёсны (Gazetted holiday), тэмдэглэлт өдөр (observance) гэж гурав ангилах ба Бурхан багшийн дүйчин өдөр нь албан ёсны бүх нийтийн амралтын өдөр байна<sup>58</sup> Энэтхэгт

<sup>53</sup> [http://www.kabinet.gov.my/bkpp/pdf/akta\\_warta/1951\\_12\\_31\\_act369.pdf](http://www.kabinet.gov.my/bkpp/pdf/akta_warta/1951_12_31_act369.pdf)

<sup>54</sup> <https://publicholidays.co.id/>

<sup>55</sup> The Labour and Employment Act of 2007 <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/bt/bt021en.pdf>

<sup>56</sup> <https://publicholidays.asia/bhutan/2019-dates/>

<sup>57</sup> "กำหนดเวลาทำงานและวันหยุดราชการ: วันหยุดราชการประจำปี (Designation of public workdays and holidays: annual public holidays)". Secretariat of the Cabinet website (in Thai). Archived from the original on 16 January 2014. Retrieved 20 April 2012).

<sup>58</sup> <https://www.timeanddate.com/holidays/india/>

нийт 66 баяр, тэмдэглэлт өдөр байгаагаас 17 нь албан ёсны баяр, амралтын өдөр байдаг. Эдгээр баяр амралтын өдрийг 1881 оны “Хэлэлцэн тохиролцох арга хэрэгслүүдийн тухай хууль” (the Negotiable Instruments Act, 1981)- д үндэслэн зарлана. Энэ нь гол төлөв Засгийн газар ба түүний албад, банкинд хамааралтай. Харин аж үйлдвэр, хувийн сектор болон бусад аж ахуйн нэгжүүдэд шууд мөрдөхгүй байж болно.

**Лаост:** 1994 оны Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар Нийтээр тэмдэглэх баярын өдрийг Засгийн газраас тогтооно гэжээ. 2019 оны нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн жагсаалтад<sup>59</sup> Весак өдрийг бүх нийтийн амралтын өдөр байна гэж тэмдэглэсэн байна.



---

<sup>59</sup> <https://www.timeanddate.com/holidays/laos/visakhabousa-day>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://en.wikipedia.org/wiki/Vesak>
- <http://wfbhq.org/general-conference-detail.php?id=015000018>
- 54/115. International recognition of the Day of Vesak at United Nations Headquarters and other United Nations offices- <https://undocs.org/A/RES/54/115>
- [https://www.constituteproject.org/constitution/Sri\\_Lanka\\_2015?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Sri_Lanka_2015?lang=en)
- Shop and Office Employees (Regulation of Employment and Remuneration) Act (No. 19 of 1954)  
[https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p\\_lang=en&p\\_isn=50743](https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_lang=en&p_isn=50743)
- Holidays Act (<https://www.lawnet.gov.lk/1946/12/31/holidays-act-2/>)
- <https://sso.agc.gov.sg/Act/HA1998>
- [http://www.kabinet.gov.my/bkpp/pdf/akta\\_warta/1951\\_12\\_31\\_act369.pdf](http://www.kabinet.gov.my/bkpp/pdf/akta_warta/1951_12_31_act369.pdf)
- <https://publicholidays.co.id/>
- The Labour and Employment Act of 2007  
<https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/bt/bt021en.pdf>
- <https://publicholidays.asia/bhutan/2019-dates/>
- "กำหนดเวลาทำงานและวันหยุดราชการ: วันหยุดราชการประจำปี" (Designation of public workdays and holidays: annual public holidays)"

## КОРОНАВИРУС БА ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

(2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар)

*Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа,  
Э.Энхтүвшин, Д.Халиун*

### АГУУЛГА

1. АНУ
  2. БНСУ
  3. БНХАУ
  4. ХБНГУ
  5. Иран
  6. Испани
  7. Итали
  8. ОХУ
  9. Франц
  10. Япон
- Хавсралт

UIH.MN  
СҮДАЛГААНЫ САН



## 1. АНУ

### Эх сурвалж:

- <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>
- [https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC\\_AA\\_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html](https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html)
- <https://www.usa.gov/coronavirus>
- <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>
- <https://www.whitehouse.gov/briefings-statements/remarks-president-trump-address-nation/>

АНУ	
<b>Нөхцөл байдал</b>	2020.03.23-ны байдлаар Covid-19 шинэ төрлийн коронавирусийн халдварын 35070 тохиолдол бүртгэгдээд байгаагаас 458 хүн нас бараад байна. <sup>60</sup> Халдвар нийслэл хот болон нийт 50 муж, Пуэрто Рико, Гуам, Виржин арлуудад бүртгэгдээд байна. <sup>61</sup> (Засгийн гарын цахим хуудсан дээр хамгийн сүүлийн байдлаар 2020-03-20-ны байдлаар мэдээ байна.)
<b>Холбооны Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд</b>	2020.01.31-нд Ерөнхийлөгч Доналд Трамп “Шинэ төрлийн коронавирусийн Covid-19 өвчин халдаах өндөр эрсдэл бүхий цагаач болон цагаач бус иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглох, энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ авах тухай” 9984 дугаартай зарлиг батлав. Тус зарлигт БНХАУ-аас АНУ руу аялан ирсэн гадаадын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглосон байна. 2020.02.28-нд Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах төв нь онцын шаардлагагүй тохиолдолд Исламын Бүгд Найрамдах Иран Улс руу зорчихгүй байхыг ард иргэддээ сануулав. 2020.02.29-нд <ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхийлөгч Доналд Трамп “Шинэ төрлийн коронавирусийн Covid-19 өвчин халдаах өндөр эрсдэл бүхий цагаач болон цагаач бус иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглох, энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ авах тухай” 9992 дугаартай зарлиг батлав. Тус зарлигт Исламын Бүгд Найрамдах Иран Улсаас АНУ руу аялан ирсэн гадаадын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглосон байна.</li> <li>• Ерөнхийлөгчийн ажлын албанаас Итали болон БНСУ-аас ирж байгаа бүх аялагчдыг эрүүл мэндийн үзлэг шалгалтад зайлшгүй хамруулсны дараа хилээр нэвтрүүлэх үүрэг өгсөн байна.</li> </ul> 2020.03.13-нд Ерөнхийлөгч Доналд Трамп Үндэсний хэмжээнд онц байдал зарлав.
<b>Хууль тогтоомжийн чиглэлээр:</b>	2020.03.06-нд “Коронавирустай тэмцэх, хариу арга хэмжээ авахад нэмэлт төсөв батлах тухай” (Coronavirus Preparedness and Response Supplemental Appropriations Act, 2020) <sup>62</sup> хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар коронавирусийн дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад зориулж холбооны агентлагуудад 8.3 тэрбум ам.долларын яаралтай тусламж олгохоор шийдвэрлэжээ. Дээрх тусламжийн хөрөнгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулна. Үүнд:

<sup>60</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>

<sup>61</sup> [https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC\\_AA\\_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html](https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html)

<sup>62</sup> <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>

- Вакцин болон шаардлагатай бусад эмнэлгийн хэрэгслүүдийг боловсруулах, үйлдвэрлэх болон худалдан авахад
- Улсын болон орон нутгийн эрүүл мэндийн агентлаг, байгууллагуудад тусламж олгоход;
- Өвчний тархалтын нөлөөнд өртсөн жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгоход;
- АНУ-ын Элчин сайдын яамд болон Төрийн департаментын барилга байгууламжуудаас нүүлгэн шилжүүлэлт хийх болон бусад яаралтай бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулахад;
- Өвчин дэлгэрсэн бусад улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд зэрэг болно.

2020.03-18-нд

**“Коронавирусийн хариу арга хэмжээ-гэр бүлүүдийг тэргүүн ээлжинд хамгаалах тухай”** (Families first coronavirus response act) хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар Covid-19 өвчний улмаас ажиллах боломжгүй болсон ажилчдад цалинтай чөлөө олгох, коронавирусийг үнэгүй оношлох, хүнсний тусламжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах ажилтнуудыг хамгаалах талаар нэмэлт арга хэмжээ авах зэрэг асуудлуудыг зохицуулахаар болсон байна.

2020.03-19-нд

Covid-19 өвчний эсрэг эдийн засгийн гурав дахь багц арга хэмжээний төслийг Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцэн баталсан бөгөөд Сенатын танхимаар хэлэлцэн хараахан шийдэлд хүрээгүй байна.

2020.03-20-нд

Сангийн яамнаас Татвар төлөх өдрийг 2020-04-15-аас 2020-07-15 хүртэл хойшлуулсан байна. Энэ хугацаанд нийт татвар төлөгчдөд татвар төлөөгүй хугацаанд нэмэлт хүү тооцохгүй, торгууль ногдуулахгүй гэж мэдэгдсэн байна. Харин татварын буцаан олголтоо авч болох бөгөөд хүсэлт гаргасан иргэний асуудлыг яаралтай шийдвэрлэх болно гэж мэдэгдэв.

2020.03.11-нд

- Ерөнхийлөгч Доналд Трамп Covid-19 өвчний улмаас дэлхийн эдийн засаг болон Америк улсын эдийн засаг, иргэдийн амьдралд ихээхэн хохирол учирч байгаа тул **Европоос ирэх бүх аялал жуулчлал, ачаа тээврийг 2020.03.11-ний өдрөөс 30 хоногийн хугацаанд хориглосон** шийдвэр гаргаснаа мэдэгдэв. Тус хориг нь ИБУИНВУ-д хамаарахгүй байна. Түүнчлэн зохих эрүүл мэндийн үзлэгээр орсон АНУ-ын иргэд хилээр нэвтрэх эрхтэй байна.<sup>63</sup>

2020-03-16-нд **Европоос ирэх бүх аялал жуулчлал, ачаа тээврийг хориглосон шийдвэрт ИБУИНВУ-ийг хамруулахаар тогтсон байна.**

2020-03-21-нд **Канад улстай** хиллэх хилээ хаасан байна.

Ерөнхийлөгч болон түүний ажлын албанаас өвчний дэгдэлтийн улмаас хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхийг төлөвлөж буй бусад арга хэмжээнүүд<sup>64</sup>:

- Ерөнхийлөгч энэ өвчний дэгдэлтээс болж хохирсон бизнес эрхлэгчид болон ажилчдад эдийн засгийн хувьд тусалж дэмжихээ мэдэгдэв:
  - Жижиг бизнес эрхлэгчдийг удирдах газарт коронавирусийн дэгдэлтийн улмаас хохирсон бизнес эрхлэгчдэд зээл олгож ажиллахыг үүрэг болгов. Энэхүү зээл нь коронавирусийн улмаас үүссэн бэрхшээлийг даван туулахад нэмэр болно гэж үзэж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 50 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэхийг Конгресст уриалав.
- Ерөнхийлөгч банкируудтай уулзаж, өвчний дэгдэлтийн үеэр эдийн засагт нөлөөлөх хор нөлөө нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд түлхүү байгаа тул энэхүү санхүүгийн хямралыг даван туулахад зээлийн бодлогодоо өөрчлөлт оруулж, зээл олголт болон зээлийн эргэн төлөлтөнд уян хатан байдлаар хандаж хамтарч ажиллахыг хэлэлцэн зөвшилцөв.

<sup>63</sup> <https://www.whitehouse.gov/briefings-statements/remarks-president-trump-address-nation/>

<sup>64</sup> <https://www.whitehouse.gov/briefings-statements/president-donald-j-trump-taken-unprecedented-steps-respond-coronavirus-protect-health-safety-americans/>

- Ерөнхийлөгч эрүүл мэндийн даатгалын компанийн удирдлагуудтай уулзаж коронавирусийн оношлуурын төлбөрийг эрүүл мэндийн даатгалд хамруулах болон телевизээр нэвтрүүлж буй өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчийн зөвлөгөөг нэвтрүүлэх зардлыг эрүүл мэндийн даатгалын компаниуд төлөх зэрэг шийдвэрт хүрсэн байна.
- Ерөнхийлөгч Сангийн яаманд хандан коронавирусийн дэгдэлтийн улмаас хохирол амссан тодорхой иргэд болон бизнес эрхлэгчдээс авах татварыг хойшлуулах санал тавихаа мэдэгдэв.
  - Энэ арга хэмжээ нь эдийн засагт 200 тэрбум ам.долларын хөрвөх чадварыг бий болгоно гэсэн тооцоо хийгдсэн байна.
- Ерөнхийлөгч цалингаас суутгах татварыг түр хугацаанд чөлөөлөх хууль батлахыг Конгресст уриалав.
- Ерөнхийлөгч коронавирусийн халдварын улмаас өвдсөн, хөл хорионд орсон, эсхүл өвдсөн хүн асарсан ажилчдад санхүүгийн тусламж үзүүлэх яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ мэдэгдэв.
  - Дээрх ажилчдад үзүүлэх санхүүгийн тусламжийн талаар арга хэмжээ авахыг Конгресст уриалав.
- Ерөнхийлөгч коронавирустай тэмцэхэд бүхий л нөөц бололцоогоо дайчлан хамтран ажиллахыг засгийн газар болон хувийн хэвшлийнхэнд уриалав.
- Ерөнхийлөгч өөрийн ажлын албанд эрүүл мэндийн ажилтнуудын амны хаалтны хангалтыг нэмэгдүүлэхийг үүрэг болгов.
  - Ерөнхийлөгчийн ажлын албанаас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын аюулгүй байдлыг ханган, тэдэнд өвчин халдварлахаас сэргийлэх үүднээс олон тоогоор амны хаалтыг үйлдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ авахаа мэдэгдэв.
- Ерөнхийлөгчийн ажлын албанаас үр дүнтэй эмчилгээ, вакцин гаргаж авах үйл ажиллагаанд дорвитой алхмуудыг авч хэрэгжүүлсээр байна.
- Ерөнхийлөгчийн ажлын алба нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хооронд нь холбосноор өвчний оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлж, хамрах цар хүрээ нь өргөжсөөр байна.
  - Орон даяар 1 сая оношлуур тараасан бөгөөд долоо хоногийн эцсээр буюу 2020-03-14-ний байдлаар 4 сая оношлуур нэмж тараахаар ажиллаж байна.
  - Орон даяар бүх мужуудын лабораториудыг оношлуураар хангасан ба хувийн лабораториуд мөн оношлуур хүлээн авснаар оношлох үйл ажиллагаа өргөн хүрээг хамарч байна.
- Ерөнхийлөгчийн ажлын албанаас коронавирусийн оношилгоо болон эмчилгээг эрүүл мэндийн даатгалд багтааснаар нэмэлт төлбөргүйгээр хийгдэх боломжтой гэж мэдэгдэв.

#### **Хуулийн төслүүд өргөн барив.**

- Коронавирусийн дэгдэлттэй холбоотой нийгэм, эдийн засагт гарч буй хүндрэлүүдийг шийдвэрлэх, даван туулах зорилгоор Конгрессын гишүүд 10 хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн барьсан байна.<sup>65</sup> Үүнд:
  - Covid-19 өвчний оношилгоог эрүүл мэндийн даатгалд хамруулах;
  - Covid-19 өвчинтэй тэмцэж буй эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах;
  - Шинэ коронавирусийн дэгдэлтийн улмаас ажиллах боломжгүй болсон иргэдэд ажилгүйдлийн тэтгэмж олгох;
  - Тахал, вирусийн аюул, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон бусад шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн санаачилгаар Засгийн газраас яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх;
  - Covid-19 өвчний улмаас дэлхийн түүхий эд, бараа материал нийлүүлэлтийн үйл ажиллагаанд доголдол

<sup>65</sup> <https://www.congress.gov/search?q={%22source%22:%22legislation%22}&searchResultViewType=expanded&KWICView=false>

гарсан тул үлэмж хохирол амссан тодорхой ажилчдын асуудлыг 1974 оны Худалдааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар зохицуулах;

- Covid-19 тархсантай холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүднээс Сургуулийн үдийн хоолны тухай хуульд шаардлагатай өөрчлөлт оруулах;
- Covid-19 тархсантай холбоотой Холбооны сонгуулийн үеэр эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг мужийн засгийн газруудад даалгах;
- Сургуулийн хөл хорионы үеэр эмзэг бүлгийн хүүхдүүдэд хүнсний тусламж үзүүлэх эрхийг Хөдөө аж ахуйн сайдад олгох;
- Covid-19 өвчний улмаас ажилтнуудад цалинтай чөлөө олгох зэрэг болно.

Холбооны, мужийн засгийн газрууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь Covid-19 вирусны тархалтыг хязгаарлах, үр дүнтэй эмчилгээг бий болгохоор чармайн ажиллаж байна.

### **Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд**

- Орон нутгийн захиргааны байгууллага нь өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өвчний талаарх мэдээллийг хүргэн ажиллаж байна.
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах төв нь дэлхий нийтээр тархсан вирусийг судлан шинжлэх, тухайн орон нутагтаа хэрхэн энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх (хөл хорио тогтоох, хүмүүс олноор цуглах арга хэмжээг цуцлах, ажилтнуудад зайнаас ажиллах боломжоор хангах гэх мэт), тусламж үйлчилгээ үзүүлэх зэргээр ажиллаж байна.
- Холбооны засгийн газрын агентлаг-Эрчим хүчний газар нь хүрээлэн буй орчноо хамгаалах, цөмийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан болон технологийн шинэ нээлтийг судлах, турших чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний лабораториудад Covid-19-ын судалгаа шинжилгээг явуулж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн газар нь ажил олгогчид болон ажилтнуудад ажлын байран дээр Covid-19-өөс хэрхэн урьдчилан сэргийлэх, ажлын байраа хэрхэн ариутгаж, халдваргүйжүүлэх талаар мэдээллийг хүргэж байна.
- Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг нь Covid-19-ийг устгах, халдваргүйжүүлэх болон усаа хэрхэн хамгаалах талаар мэдээллийг хүргэж байна.
- Хүнс болон эм зүйн газар нь эмийн үйлдвэрүүдтэй хамтран вакцин, эм, оношилгооны тест гаргах ажлыг гүйцэтгэж байна. Эмнэлгийн ажилтан, мэргэжилтнүүдэд оношилгооны тестийг хэрхэн ашиглах талаар мэдээллийг тогтмол хүргэж байна.
- Онцгой тохиолдолд бэлэн байдал хангах газраас шинэ эмчилгээг судалж, турших үйл ажиллагааг явуулж байна.
- Хөдөө аж ахуйн газар нь хүнсний аюулгүй байдал болон тэжээвэр амьтдыг хэрхэн сэргийлэх талаарх мэдээллийг хүргэж байна.
- Хэрэглэгчийн санхүүгийн эрхийг хамгаалах товчооноос өвчин дэлгэрсний улмаас санхүүгийн хүндрэл, бэрхшээлтэй тулгарвал (төлбөр тооцоо төлөх, орлогогүй болох гэх мэт) хэрхэн зээл, тусламжид хамрагдаж, хүндрэлээс гарч болох талаар зөвлөгөө өгч байна.<sup>66</sup>
- Жижиг бизнес эрхлэгчдийн газраас бизнес эрхлэгчдэд Covid-19-ийн улмаас санхүүгийн болон бусад хүндрэл бэрхшээлтэй тулгарахаас хэрхэн урьдчилан сэргийлэх болон нэгэнт өртсөн тохиолдолд хэрхэн хүндрэлээс гарах талаар заавар зөвлөмж өгөхөөс гадна **“Гамшгийн үе дэх эдийн засгийн зээл” буюу хүү багатай тусгайлсан зээлд** хамрагдаж болох талаар мэдээллийг түгээж байна.
- Холбооны нөөцийн газраас (Federal Reserve) Covid-19 өвчний дэгдэлтийн үеэр эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа

<sup>66</sup> <https://www.consumerfinance.gov/about-us/blog/protect-yourself-financially-from-impact-of-coronavirus/>

	<p>болон хөдөлмөрийн зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахын тулд банк санхүүгийн байгууллагуудтай хамтран зээлийн хүүг 0 хүртэл хувь бууруулахаар шийдвэрлэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2020-03-16-ны байдлаар өвчний тархалт өндөр байгаа Миннесота, Аризона, Хавай, Хойд Каролин болон нийт 30 гаруй мужид мужийн хэмжээнд ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоогоод байна.</li> <li>• <b>Сургуулиудад хөл хорио тогтоосонтой холбоотой үнэгүй үдийн хоолонд хамрагддаг сурагчдад гэрээр нь хүнсний тусламж өгч эхэлсэн байна.</b></li> </ul>
<b>Аялал жуулчлал болон тээврийн талаар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Холбооны агаарын тээврийн удирдлагаас үйлчлүүлэгчиддээ заавар зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.</li> </ul>
<b>Өвчний тархалтын үеэр гарч болох гэмт хэргээс сэргийлэх талаар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдал болон Дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах агентлагаас Covid-19 өвчинтэй холбоотой гарч болзошгүй залилан, луйвраас сэргийлэх зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.</li> <li>• Холбооны худалдааны комисс нь Covid-19-ийн талаар хуурамч мэдээлэл явуулах болон хуурамч эм, эмчилгээ зарж борлуулж буй компаниудын эсрэг арга хэмжээ аван ажиллаж байна.</li> </ul>
<b>Олон улсын харилцааны хувьд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• АНУ-ын Төрийн департамент (Department of State) нь Covid-19 өвчинтэй тэмцэх ажилд бусад улс орнуудын засгийн газартай хамтран ажиллаж, АНУ руу зорчих болон АНУ-аас бусад улс орон руу зорчих иргэдэд зөвлөмж хүргэн ажиллаж байна.</li> <li>• АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь Covid-19 өвчинтэй тэмцэхэд олон улсын байгууллагуудад санхүүжилт олгож байна.</li> </ul>

## 2.БНСУ

### Эх сурвалж:

- Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас <http://ncov.mohw.go.kr/>
- БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас, [https://korea.assembly.go.kr:447/res/tra\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp)
- Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас, <https://gia.gov.mn/>
- БНСУ-ын банк <http://www.bok.or.kr/eng/bbs/E0000634/view.do?ntId=10057026&menuNo=400069>

БНСУ	
<b>Нөхцөл байдал</b>	<p>Анх бүртгэгдсэн: 2020.01.21 2020.03.23, 11:00 (Солонгосын цагаар)<sup>67</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн 24 цагт шинээр илэрсэн тохиолдол –64</li> <li>• Нийт тохиолдол – 8961 Нас барсан-111 Эдгэрсэн-3166</li> </ul>
<b>Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд</b>	<p>2020.02.23-ны өдөр БНСУ-ын Ерөнхийлөгч Онцгой байдлын эрсдэлийг хамгийн дээд түвшинд шилжүүлсэн. 2020.02.26-ны өдөр Үндэсний Ассамблей эрх баригч болон сөрөг хүчний гишүүдээс бүрдсэн Корона вирустай тэмцэх арга хэмжээ авах онцгой албаны байнгын хороог байгуулсан. 2020.03.17-ны өдөр Боловсролын яамнаас бүх шатны сургуулийн хичээл эхлэх хугацааг 4 дүгээр сарын 16 болгож хойшлуулав. 2020.03.22-ны өдөр:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 4 дүгээр сарын 6-ны өдөр хөл хориог цуцлах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллахыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад үүрэг болгов.</li> <li>• <b>Европоос ирж буй нислэгүүдэд хорио цээрийн дэглэмийг чангатгав.</b> 3 сарын 22-ны 00 цагаас эхлэн Европоос ирж буй бүх хүмүүст коронавирусийн шинжилгээ хийж, сөрөг гарсан тохиолдолд 14 хоног өөрийгөө тусгаарлах зөвлөмжийг өгч байна. Үүний дагуу одоогийн байдлаар Европоос ирсэн 6 нислэгээр 1442 хүн ирснээс 152 хүнийг түр тусгаарлаад байна. Европоос ирж байгаа хүмүүсийн 92 хувь нь Солонгос улсын иргэд байна. Харин бизнесийн зорилгоор ирж буй иргэдэд байнгын ажиглалт, хяналт тавихаар шийдвэрлэсэн байна.</li> <li>• 4 сарын 5 хүртэл Гамшгийн аюулгүй байдлын төв штабын хурлыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн.</li> </ul>
<b>Хууль тогтоомжийн чиглэлээр:</b>	<p>Солонгосын Үндэсний Ассамблей болон Ерөнхийлөгчийн зүгээс улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг зохицуулах зорилгоор дараах хууль тогтоомжийг батлан гаргаад байна. Үүнд:</p> <p>2020.02.26-д 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p><b>1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт</b><sup>68</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>• Халдварт өвчний дэгдэлтийн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар</li> <li>• 1-р зэргийн халдварт өвчний дэгдэлт нь эм, ариун цэврийн хэрэглэл ба бусад бүтээгдэхүүний үнэ мэдэгдэхүйц өсөх, нийлүүлэлтийн хомсдолд хүргэх тохиолдолд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нь дээрх бүтээгдэхүүнийг тус улсаас тодорхой хугацаанд экспортлох, гаргахыг хориглож болно. Хоригийг зөрчсөн тохиолдолд <b>таван жилээс</b></li> </ul>

<sup>67</sup> <http://ncov.mohw.go.kr/> Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас

<sup>68</sup> [https://korea.assembly.go.kr:447/res/tra\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp)



хэтрэхгүй хугацаагаар хорих, эсвэл 50 сая вон хүртэл торгууль ногдуулж болно.

- Сэжигтэй өвчтөн эрүүл мэндийн үзлэг, мөрдөн байцаалтад хамрагдаж халдвар авсан нь тогтоогдсон бол эмнэлэгт тусгаарлана. Энэхүү арга хэмжээг дагаж мөрдөөгүй бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл 10 сая воноор торгох ялаар шийтгэж болно.
- Эмнэлгийн ажилтнууд өвчтөний гадаадад зорчсон аялалын мэдээллийг цагдаа болон бусад байгууллагатай хамтран шалгах эрхийг олгох, мэдээлэл шалгагчаар ажиллах ажилтны тоог өргөжүүлсэн.

## **2.Хорио цээрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт**<sup>69</sup>

- Хорио цээр тогтоосон халдварт өвчний бүсэд нэвтрэхийг хориглох
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын баталсан төлөвлөгөөний дагуу эмнэлгийн байгууллагын ажилтнуудыг байнга мэдээллээр хангах, сургах
- Халдварт өвчний дэгдэлтээс шалтгаалж хорио цээрийн бүсийг тогтоох, цуцлах гэх мэт.

## **3.Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт**<sup>70</sup>

Сэтгэл зүйн эмчилгээний шинэ тасаг нээх, эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг бүхий л төрлийн байгууллагууд халдварт өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчлан зохицуулсан. Тухайлбал:

- эмнэлгийн байгууллагын ажилтан, өвчтөн, асран хамгаалагч, ажилчдын халдварын хяналтын тогтолцоог бий болгох
- эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдад эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой халдварын гарал үүсэл, шалтгааныг хянах зорилгоор халдварын хяналтын тогтолцоог бий болгох
- өвчтөний онош хадгалах системийг бий болгох ингэснээр эмнэлэг хаалттай байсан ч өвчтөний онош бүртгэлийг шууд харах боломжтой болно.
- халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн хэн ч бай шинжилгээ өгөхөөс татгалзвал тухайн иргэнийг 3 сая вон хүртэлх торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэхээр заасан.

## **4.Цагаачлалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2020.03.05)**<sup>71</sup>

Тус нэмэлт, өөрчлөлтөөр БНСУ оршин суух болон ажиллах зөвшөөрөлгүй гадаадын иргэний ажиллуулсан бол 30 сая вонын торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэх, мөн тус улсад ажиллаж буй ажилтан, түүний төлөөлөгч Хууль зүйн сайдын зөвшөөрөлгүйгээр ажлын байраа өөрчилсөн бол 10 сая воноор торгохоор заасан. Энэхүү захиргааны шийтгэлийг хууль зүйн сайд чөлөөлөх буюу хүчингүй болгох эрхийг өгсөн.

### **Өдөр тутамд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ**

Тус улсын Гадаад хэргийн сайд Кан Гён Хва “Халдварын эрт үеийн шинжилгээ, оношилгооны боломжийг нэмэгдүүлэх хүрээнд хамгийн хурдан, аюулгүй оношилгоо болох машин дотор шинжилгээ хийх явуулын “Drive-thru” аргыг нэвтрүүлж иргэд 10 минутад багтаан шинжилгээ өгөх боломжтой болов. Мөн Инчоны нисэх буудлаар зорчигчдыг 3 шатны шинжилгээнд хамруулах зэрэг арга хэмжээ авч байна” хэмээн мэдэгдэв.

- 🚦 Коронавирусийн талаар албан ёсны мэдээллийг хот тус бүрт албан ёсны цахим хуудас<sup>72</sup> ажиллуулж байна. Энэхүү цахим хуудаст тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн статистик мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж, асуулт асууж хариулт авах булан, эмнэлгийн хаяг, байршил болон амны хаалт зэрэг шаардлагатай зүйлсийг худалдах талаарх мэдээллийг оруулах боломжтой. Мөн албан ёсны мэдээллүүдийг оруулдаг.

- 🚦 3 дугаар сарын 9-өөс эхлэн амны хаалт худалдан авах ажлын зохион байгуулалтад оруулав. Төрсөн оны төгсгөлийн

<sup>69</sup> [https://korea.assembly.go.kr:447/res/tra\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp) БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

<sup>70</sup> [https://korea.assembly.go.kr:447/res/tra\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp) БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

<sup>71</sup> [https://korea.assembly.go.kr:447/res/tra\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp) БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

<sup>72</sup> [https://www.sejong.go.kr/prog/vod/covid19/sub01\\_07/list.do?searchCategory=63664514](https://www.sejong.go.kr/prog/vod/covid19/sub01_07/list.do?searchCategory=63664514) Сэжон хотын коронавирус19 албан ёсны мэдээллийн цахим хуудас



оронгоор ангилан заасан өдөр эмийн сан, зарим дэлгүүрээс өөрийн биеийн байцаалттай ирж худалдаж авах боломжтой. 1 хүн 1-2 ширхгийг авах боломжтой бөгөөд нэг амны хаалтны үнэ 1500 вон. Харин өндөр настан, 10-аас доош насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн хүн нь авах боломжтой бөгөөд хуваарьт өдрөө авч чадаагүй амралтын өдрөөр авч болохоор зохицуулж байна.

1,6 төгссөн бол	Даваа гараг
2,7 төгссөн бол	Мягмар гараг
3,8 төгссөн бол	Лхагва гараг
4,9 төгссөн бол	Пүрэв гараг
5,0 төгссөн бол	Баасан гараг

- Зөвлөгөө өгөх 24 цагийн лавлах утаснуудыг ажиллуулж байна. Шинж тэмдэг илэрч буй хүн зөвлөгөө утас өгөх утсанд мэдэгдэж мэдээлэл авсны дараа эмнэлгийн байгууллагад хандана.
- “Covid-19”-ийн Гамшгаас урьдчилсан сэргийлэх төв штаб Улсын сэтгэлзүйн эрүүл мэндийн төв, Үндэсний сэтгэцийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эмч нараас бүрдсэн Сэтгэлзүйн зөвлөгөөний нэгдсэн баг байгуулж халдварын бүсэд ажиллаж буй эмч, сувилагч нарт сэтгэлзүйн зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг хийж байна.
- БНСУ-ын Химийн хүрээлэнгийн эрдэмтэд (CRIST) SARS, MERS вирусийн эсрэг биеэс шинэ төрлийн коронавирусийн үйлчлэлийг сулруулагч эсийг олсон бөгөөд энэ нь вакцин, эмчилгээний аргыг гаргаж авахад тус болно гэж үзэж байна. Коронавирусийн гадаргуу хэсэгт байрлах “спайк” уургийн үйлчлэлийг сулруулж чадвал халдварыг саармагжуулж чадах эсрэг биетийг гаргаж авах боломжтой болох юм. Саармагжуулах эсрэг биет нь вирус хүний биед нэвтрэхэд үйлчлэлийг нь сулруулж, дархлаа бий болгох эс юм. Эрдэмтдийн өмнө илрүүлж байсан SARS, MERS вирусийг саармагжуулах 11 төрлийн биетийн гурваас нь “спайк” хэмээх уурагтай нийлэгжих боломжтой биетийг олсон гэж тэмдэглэв. Эрдэмтэд энэ биетийг вирус дээр туршихаар төлөвлөж байна.<sup>73</sup>
- Вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цэргийн 96 эмчийг нэмэлтээр орон нутгийн харьяа эмнэлгүүдэд ажиллуулж байгаа бөгөөд мэргэжлийн дотрын эмч нар аж.

#### Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр:

“COVID-19” вирусийн тархалт эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн үзэж байгаа ч Солонгосын Төв банк бодлогын хүүгээ 1.25 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргав. Түүнчлэн хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Төв банкнаас олгох тусгай зээлийн хэмжээг 5 их наяд вон (4.1 тэрбум ам.доллар)-оос 30 их наяд вон болгон нэмэгдүүлэв. Төв банк эдийн засгийн өсөлтийг 2.3 хувь хэмээн таамаглаж байснаа 2.1 болгон буулгажээ.<sup>74</sup>

**2020 оны 03 дугаар сарын 12-ний** өдөр Үндэсний Ассамблейн Төсөв, дансны тусгай хороо коронавирустэй тэмцэх үндэсний хэмжээний тэмцлийг дэмжих нэмэлт төсөв 11.7 их наяд воноор нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна<sup>75</sup>. Тус төсвийг коронавирустэй тэмцэх ажилд зориулахаас гадна жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой гэж хууль санаачлагчид мэдэгдсэн байна.

Тус улсын Засгийн газраас Корона19 халдварын улмаас хохирол амсч буй иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжийг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.<sup>76</sup>

Доор дурдсан эдийн засгийн тусламжийн үйлчилгээг авахыг хүсэгч нь Зээлийн нөхөн сэргээх хороо, Солонгосын хөрөнгө

<sup>73</sup> <https://gia.gov.mn/53/item/668> Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газрын 3 дугаар сарын 12-ны өдрийн мэдээлэл

<sup>74</sup> <https://gia.gov.mn/53/item/651> МУ-ын ТЕГ-ын 2 дугаар сарын 28-ны өдрийн мэдээлэл

<sup>75</sup> [https://korea.assembly.go.kr:447/wha/pre\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/wha/pre_read.jsp) БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

<sup>76</sup> Ц.Өнөрзаяа, БНСУ-ын Күүкмин их сургуулийн багшийн орчуулга

оруулалтын менежментийн корпораци (Үндэсний аз жаргалын сан) болон бичил санхүүгийн санд өргөдөл гаргах боломжтой.

Төрөл	Нэр	Агуулга
<b>ЗЭЭЛ</b>	Жижиг бизнесийн эдийн засгийн аюулгүй байдлын хөрөнгө	жижиг бизнес эрхлэгчид 70 сая вонын зээлийг 2 жилийн хугацаатай олгож, 3 дахь жилдээ эгүүлэн төлөх нөхцөлтэйгөөр
	Шинээр үүсгэн байгуулж үйл ажиллагаа эхлэх хөрөнгө	1 хүний 20 сая хүртэлх воныг 5 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй зээл
	Захын худалдаачдад зориулсан зээл	жижиг худалдаачдад 1 хүний 10 хүртэлх сая вонын 2 жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй зээл
	Тусгай хөрөнгийн дэмжлэг	жижиг дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид 1 жилийн хугацаатай (3 жил хүртэл сунгах боломжтой) 500 сая хүртэлх вонын зээлийг жилийн 1%-ийн хүүтэй
<b>ТАТВАР</b>  (Коронавирусийн халдвараас болж хохирол амсч буй орон нутгийн татвар төлөгч болон эрүүл мэнд, аялал жуулчлал, үзвэр, хоол, зочид буудлын салбарын татвар төлөгчид)	Компанийн татвар, НӨАТ-ын мэдэгдэл болон татвар төлөх хугацааг сунгах	Дээд тал нь 9 сар хүртэл
	Хураамж, хугацаа хэтэрсэн хураамжийг хойшлуулах	Хураамж-дээд тал нь 9 сар хүртэл Хэтэрсэн хураамж-дээд тал нь 1 жил хүртэл
	Татварын байцаалт хойшлуулах болон түр зогсоох	
	Коронавирусийн цэвэрлэгээ, ариутгалыг төр хариуцах	
<b>ОРОН НУТГИЙН ТАТВАР</b>  (Халдвар авсан өвчтөн болон тусгаарлалтад орсон иргэн, вирусийн халдвар авсан иргэн очсоноос үүдэлтэйгээр үйл ажиллагаагаа түр зогсоож хүнд байдалд байгаа ААН-д)	Хувийн эзэмшлийн татвар, орон нутгийн орлогын албан татвар, иргэний татвар зэргийн мэдэгдэл, төлөх хугацааг сунгах	6 хүртэл сар, нэмж 6 сар сунгах боломжтой.
	Хураамж болон хугацаа хэтэрсэн хураамжийг хойшлуулах	6 хүртэл сар, нэмж 6 сар сунгах боломжтой.
	Татварын байцаалтаас чөлөөлөх	
	Орон нутгийн татварыг бууруулах	
<b>ГААЛИЙН ТАТВАР</b>  (Хятадад байгаа үйлдвэр хаагдсанаас түүхий эдийн	Төлөх хугацааг хойшлуулах, хуваан төлөх боломж олгох	Дээд тал нь 1 жил
	Өдөрт нь гаалийн буцаан олголт хийх, гаалийн татварын байцаалтыг хойшлуулах	

хангамж болон экспортын хямралд орсон ААН)	Гамшгийн үед туслах төв ажиллуулах	
<b>ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>  (Сайн түрээслэгч хөтөлбөр)	<p>Жижиг дунд үйлдвэр эрхлэгч болон жижиг бизнес эрхлэгч нарын оны эхний 6 сарын түрээсийн төлбөрийг бууруулсан түрээслэгчийн уг хассан түрээсийн төлбөрийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг ААН албан татвараас суутган чөлөөлнө.</p> <p>Захын мухлагуудын түрээсийн төлбөрийг 20% хүртэл бууруулсан тохиолдолд тухайн захад хуучин кабель, усны төхөөрөмж, ус шүршигч зэрэг галын аюулаас хамгаалах төхөөрөмжийн багцыг үнэгүй суурилуулж өгнө.</p> <p>Улсын өмчлөлд байдаг хөрөнгийн хувьд 4 сарын 1-ээс он дуустал одоо авч байгаагийн 1/3 хувиар бууруулна.</p> <p>Улсын өмчит газруудын түрээсийн төлбөрийг 6 сарын турш 20-35 хүртэл хувиар бууруулна.</p>	
<b>БУСАД<sup>77</sup></b>	<p><b>Моргежийн зээл</b> (Халдварт өвчний тусгай бүсэд амьдардаг оршин суугчид хамаарах бөгөөд хориг тогтоосон шийдвэр гарснаас хойших хугацаа хамаарна)</p> <p><b>Зээлийн төлбөрийг зогсоох</b></p>	<p>Хугацаа хэтэрсэн бол 3 сар түдгэлзүүлэх, нэмэлт хүүгээс 3 сарын хугацаанд чөлөөлнө.</p> <p>Уламжлалт захын худалдаачдын зээлийн үндсэн төлбөрийг 6 сар зогсоосон.</p>

**2020.03.16-нд** Банкны мөнгөний бодлогын зөвлөл суурь ханшийг 3 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 50 хувиар буюу 1.25%-иас 0.75% болгон бууруулав. Мөн зээлийн хүүг 0.50-0.75%-иас 0.25% хүртэл бууруулжээ<sup>78</sup>.

**2020.03.18-нд**

- Үндэсний Ассамблей коронавирусийн тархалтаас үүдэлтэй сөрөг нөлөөнөөс эдийн засгаа хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор 11.7 их наяд вон буюу 9.4 тэрбум долларын төсвийг нэмж баталлаа.
- Сангийн яамны мэдээлснээр:
  - Халдварт өвчний хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор төсвийг 0.15 их наяд воноор
  - Жижиг бизнес эрхлэгчид болон хохирогчдыг дэмжих төсвийг 1.4 их наяд воноор
  - ард иргэдийн амьдралын тогтвортой байдлыг хангах үүднээс төсвийг 0.8 их наяд воноор
  - Тусгай гамшгийн бүсийн болсон Дэгу, Чэонго, Гёнсан, Бонгва зэрэг хотын төсвийг 1.0 их наяд воны санхүүжилтийг нэмэгдүүлэв.<sup>79</sup>

**Халдварт өвчний хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх** төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Маск үйлдвэрлэх, нийлүүлэх
- Эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх

<sup>77</sup> [http://ncov.mohw.go.kr/upload/viewer/skin/doc.html?fn=1583916829598\\_20200311175349.hwp&rs=/upload/viewer/result/202003/](http://ncov.mohw.go.kr/upload/viewer/skin/doc.html?fn=1583916829598_20200311175349.hwp&rs=/upload/viewer/result/202003/) Эдийн засгийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ-Солонгос хэлээр

<sup>78</sup> <http://www.bok.or.kr/eng/bbs/E0000634/view.do?nttlId=10057026&menuNo=400069> БНСУ-ын банк

<sup>79</sup> [http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board\\_id=#](http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board_id=#) Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас

- Эмчилгээний хөгжүүлэлтэд
- Эмнэлгийн ажилтнуудын нэмэлт дэмжлэг (коронавирусийн улмаас орон нутагт ажилласан эмнэлгийн ажилтнуудын дэмжлэг)

**Жижиг бизнес эрхлэгчид болон хохирогчдыг дэмжих** төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Жижиг бизнес эрхлэгчдийн хөрөнгийн нийлүүлэлтийг өргөжүүлэх
- Хохирол амсаж буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх (нисэх, тээвэр, хүргэлтийн үйлчилгээ эрхэлдэг бизнест)

**Ард иргэдийн амьдралын тогтвортой байдлыг хангах** зорилгоор нэмэгдүүлж буй төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Бага орлоготой өрхөд хэрэглээний купон олгох
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Бага орлоготой өрхүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах
- НӨАТ-ыг бууруулах
- Бага орлоготой ажилчдад халамж дэмжлэг үзүүлэх
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал дэмжлэг үзүүлэх (хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааны тодорхой хэсэгт тусламж үзүүлэх)
- Цахим хичээлийн хүрээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

**Тусгай гамшгийн бүсийн болсон Дэгү, Чэонго, Гёнсан, Бонгва зэрэг** хотын төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- **Гамшгаас хамгаалах бэлэн байдалд**
- Хохирол амссан дэлгүүрүүдийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх
- Цахилгааны төлбөрийг бууруулах (6 сар хүртэл хугацаагаар 50 хувь бууруулах)
- Бага орлоготой өрхийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах 3 сарын хугацаанд 50 хувь бууруулах)
- Дэгү, Гёнонгбүк хотод зориулсан тусгай дэмжлэг (Халамж, жижиг бизнесийн бодлогын сан зэрэг халамжийн санд зориулсан)

**Халдвар, чиглэлээр:** **хамгааллын** Халдварт өвчний тархалтыг барих, хамгаалалт, хяналтыг сайжруулах чиглэлээр дараах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

**Нэгдүгээрт:** “Хяналт шалгалтыг өргөжүүлэх, Хяналтын байдлыг сайжруулах” Бид өвчтөнийг эрх олох болно.

1. Хяналтын зорилтыг өргөжүүлэх

Уушгины хатгалгааны шалтгаан тодорхойгүй өвчтөнүүдийг эмчийн үзлэгээр эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай.

Баталгаажсан өвчтөнтэй холбоо тогтоосон хүмүүсийн дунд ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй байсан ч зайлшгүй шаардлагатай бол эмч, асран хамгаалагч, гэр бүл болон бусад байцаагчаар шинжилгээ хийлгэх, хорио цээрийг дэглэмээс гаргахын өмнө шинжилгээ хийлгэх.

2. Шуурхай үзлэг, оношилгоо

Түүврийн цуглуулга хийх боломжтой скрининг эмнэлэг өргөжиж байна.

Оношилгооны шинжилгээний байгууллагуудын тоо өргөжиж (3-р сард 100-аас дээш), өдөрт 10,000 гаруй тохиолдол оношлох боломжтой болсон.

3.Хяналтын хүртээмжийг сайжруулсан

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн удирдлагын төв аюулгүй, үр дүнтэй шинжилгээ, оношилгоо зохион

---

байгуулах ажлын хүрээнд “Тээврийн хэрэгслийн явуулын үзлэгийн төв”-ийг байгуулаад байна. Түүнчлэн эмчилгээний төвүүдийг шинээр нээн ажиллуулж байгаа бөгөөд 03 дугаар сарын 04-ний өдөр шинээр 3 эмчилгээний төв нээжээ. Хэрэв сэжигтэй өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эмнэлгийн байгууллагад очиж чадахгүй байгаа ахмад настуудын хувьд орон нутгийн түүвэр цуглуулах баг (эмч, сувилагчдыг оролцуулан) очиж үзнэ.

**Хоёрдугаарт:** Эмнэлгийн байгууллагууд, асрамжийн газрууд гэх мэт эмзэг бүлгийн газруудад өвчтөний шилжилт хөдөлгөөнийг хориглох, амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх замаар бид хамтын халдвараас урьдчилан сэргийлэх болно.

1.Өвчтөний эмнэлгийн байгууллагад орохыг хориглох

Хэрэв халуурах, амьсгалын замын шинж тэмдэг, сэжигтэй шинж тэмдэг илэрвэл (дүрслэл, цээжний таагүй байдал, ерөнхий сулрал гэх мэт) яаралтай тусламжийн өрөөнд орохын өмнө оношилгооны шинжилгээ хийдэг.

Яаралтай эмнэлгийн тусламж авах шаардлагатай хүнд өвчтөнүүд тусдаа хорио цээрийн бүсэд байх ёстой.

2.Эмнэлгийн байгууллагад амьсгалын замын өвчтэй хүмүүсийг тусгаарлах

Хэрэв эмчийн үзлэгээр аюулгүй байдлыг хангах боломжтой бол өвчтөн эмнэлгийн байгууллагад шууд очихгүйгээр утасны зөвлөгөө, жорыг авах боломжтой бөгөөд ингэснээр эмнэлгийн байгууллагад халдвар авахаас сэргийлнэ.

3.Хэрэв өвчтөн халуурах, ханиалгах зэрэг шинж тэмдэг илэрвэл өвчтөний уулзалтыг хориглоно. Бүх зочид халуунаа шалгуулж, амны хаалт зүүж, гараа ариутгаж, шинжилгээ хийлгэх ёстой.

4.Шилжилт хөдөлгөөнийг хаах

Халуурах, ханиалгах зэрэг шинж тэмдэг бүхий ажилчдыг ажлаас нь чөлөөлж, оношилгооны шинжилгээнд хамруулдаг. Шинж тэмдэг илрээгүй байсан ч Хятад, Хонконг, Макао зэрэг цагаачлалын тусгай журамд хамрагдсан газруудаар аялж байсан бол 14 хоногийн турш ажлаас чөлөөлөгдөнө<sup>80</sup>.

---



---

<sup>80</sup> [http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board\\_id=#header](http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board_id=#header) Халдвар хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл, солонгос хэлээр

### 3.БНХАУ

#### Эх сурвалж:

- <http://en.nhc.gov.cn/>
- <http://www.consul.mn/>
- <http://www.xinhuanet.com>
- <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>
- <https://gia.gov.mn/12/item/652>
- [http://en.nhc.gov.cn/2020-03/25/c\\_78235.htm](http://en.nhc.gov.cn/2020-03/25/c_78235.htm)

	БНХАУ
<b>Нөхцөл байдал</b>	<p>2020.03.24-ны байдлаар Хятадын Үндэсний эрүүл мэндийн хороо (ХҮЭМХ)-ноос гаднаас ирж буй иргэдээс 47 тохиолдол илэрч, 33 сэжигтэй тохиолдол илэрсэн бол 4 хүн нас барсан байна. Нийт бүртгэгдсэн тохиолдол 81218, нас барсан -3281 хүн, эдгэрч, эмнэлгээс гарсан – 73650 хүн байна.<sup>81</sup></p> <p>Сүүлийн үед БНХАУ-ын хэмжээнд COVID-19 халдварын тохиолдол гадаадаас ирж буй иргэдээс илэрч байгаатай холбогдуулан 3 дугаар сарын 23-ны өдрийн 00:00 цагаас эхлэн Бээжин хотод буух олон улсын нислэгийг нислэг үйлдэж буй агаарын тээврийн компаниас хамааран нэр бүхий 12 нисэх буудалд буулгаж, зорчигчдыг шалган нэвтрүүлэх болсон байна.<sup>82</sup></p> <p>Хүбэй мужийн шинэ коронавирусийн уушгины тахлаас урьдчилсан сэргийлж, хянах төв 2020.03.24-ний өдөр мэдэгдэл гаргаж: 2020.03.25-ны 00:00 цагаас эхлэн Хүбэй мужийн Үхань хотоос бусад нутгуудын Хүбэйгээс гарах замын хөл хориог цуцалж, Хүбэйгээс гарах хүмүүс Хүбэйн Эрүүл мэндийн код дээр суурилсан "Ногоон код" авсан нөхцөлд аюулгүй, дэг журамтай зорчиж болно. Үхань хотод мөн Хүбэй муж, Үхань хотоос гарахгүй хатуу хөл хорио тогтоох бодлогыг хэрэгжүүлж, 2020.04.08-ны 00:00 цагаас эхлэн Үхань хотод тавьсан хөл хориог цуцлан, Хүбэй мужийн эрүүл мэндийн кодоод суурилсан "Ногоон код" авсан нөхцөлд Хүбэй муж, Үхань хотоос гарч, аюулгүй эмх цэгцтэй зорчиж болно гэжээ.</p> <p>Энэхүү мэдэгдэлд тэмдэглэхдээ, 2020.03.25-ны 00:00 цагаас эхлэн Хүбэй мужийн Эрүүл мэндийн кодын "Ногоон код" эзэмшдэг хот орж хөдөлмөр үйлчилгээ хийх хүмүүс нуклейн хүчлийн шинжилгээ хийсний дараа "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлж, тусгай зориулалттай хүргэх" аргаар ажилд орох аюулгүй байдлыг нь баталгаажуулна гэжээ. Үхань хот тахлын эрсдэлд үнэлгээ хийсний дараа урьдчилан сэргийлж хянах ажлыг сайтар хийх нөхцөлд боломж бүрдсэн аж ахуйн нэгжүүдийн ажлыг сэргээхийг дэмжиж байна. Гэхдээ Хүбэй мужийн дотоодын их дээд сургууль, дунд бага сургууль, тусгай мэргэжлийн сургууль, хүүхдийн цэцэрлэг зэргийн үйл ажиллагааг үргэлжлэн түр хойшлуулахаар шийдвэрлэжээ.<sup>83</sup></p> <p><b>Вакцин:</b> БНХАУ-д шинэ коронавирусийн зарим вакцины клиникийн туршилтыг ойрын хугацаанд эхлүүлэхийг төлөвтэй байна. Шанхайд бүтээж буй вакцины клиник туршилтыг 4 дүгээр сарын дундуур эхлүүлэхийг мэдэгдсэн. Судалгааны зарим баг клиник туршилтад хамрагдах сайн дурынхныг бүртгэж эхэлсэн.<sup>84</sup></p>
<b>Авч зарим арга хэмжээ</b>	Халдварын голомттой бүсэд (Хүбэй мужийн Үхань болон бусад 15 хот, 50 сая хүн ам) карантин тогтоох, олон нийтийн тээвэр, үүнд автобус, галт тэрэг, нисэх онгоц, усан онгоц зэргийн хөдөлгөөнийг түр хаасан. Үхань хотын нисэх буудал, галт

<sup>81</sup> [http://en.nhc.gov.cn/2020-03/25/c\\_78235.htm](http://en.nhc.gov.cn/2020-03/25/c_78235.htm)

<sup>82</sup> <http://www.consul.mn/index.php?moduls=19&id=292>

<sup>83</sup> [http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c\\_1125763807.htm](http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c_1125763807.htm)

<sup>84</sup> [http://www.xinhuanet.com/english/2020-03/17/c\\_138888228.htm](http://www.xinhuanet.com/english/2020-03/17/c_138888228.htm)



тэрэгний буудал, метро зэргийн үйл ажиллагааг түр зогсоож, хөл хорио тогтоосон. Үйлдвэр, сургууль, оффисуудын үйл ажиллагааг түр зогсоож, ажлаа гэрээсээ хийхийг уриалсан зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.<sup>85</sup> Хүбэй мужийн Чаньжян хот (1 сая орчим оршин суугчтай)-ын дарга вирусийн халдвар авсан байж болзошгүй хүний талаар мэдээлэл өгч, шинжилгээгээр халдвар авсан нь тогтоогдсон нөхцөлд 10 мянган юань /1425 ам.доллар/-ийн урамшуулал олгоно хэмээн мэдэгдсэн.

Хятадын Засгийн газар томоохон технологийн компаниуд болох Alibaba Group Holding Ltd, Tencent Holdings Ltd нартай хамтран Ханжоу болон бусад зарим хотод халдвартай холбоотойгоор иргэдийн хөдөлгөөний хянах, болзошгүй эрсдэлийг бууруулахад big data болон QR код зэрэг технологийг ашигласан системийг нэвтрүүлсэн бөгөөд үүнийг “one map, one QR code, and one index” гэж нэрлэж байна.

Хотын оршин суугчид болон хотод нэвтэрсэн хүн бүр аппликейшн дээрх асуумжийг бөглөх бөгөөд өөрсдийн бүртгэлийн дугаар, гадаад, дотоодод зорчсон тухай болон биеийн байдлынхаа талаарх мэдээллийг оруулсны дараа тухайн хүний эрүүл мэндийн байдлыг илтгэсэн өнгө бүхий QR кодыг авах юм.



【绿码】

凭码通行



【黄码】

实施7天内隔离，连续  
(不超过)7天健康打卡正常  
转为绿码



【红码】

实施14天隔离，连续14天  
健康打卡正常转为绿码

Улаан кодтой иргэн 14 хоног өөрийгөө тусгаарлаж, өөрийн биеийн байдлын талаар тогтмол мэдээлнэ.

Шар кодтой иргэн 7 хоног өөрийг тусгаарлаж, холбогдох мэдээлэл өгнө.

Ногоон кодтой иргэн чөлөөтэй зорчино. Тусгаарлалтын тогтоосон хугацаа дууссаны дараа ямарваа нэгэн шинж тэмдэг илрээгүй бол улаан, шар өнгө бүхий код ногоон болно. Иргэдийн эрүүл мэндийн байдлын мэдээлэлд Ханжоугийн Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих төв байнгын хяналт тавьж ажиллана.<sup>86</sup>

- БНХАУ-ын Засгийн газар “бага эрсдэлтэй” газар орны Цагаачлалын албыг виз болон паспортын үйлчилгээг сэргээх, “дунд эрсдэлтэй” газарт нөхцөл байдалтайгаа уялдуулан үйлчилгээг сэргээж болох зөвлөмж өгсөн байна.
- Тус улсын Цинхуа болон Бээжингийн их сургуулиудын албан ёсны цахим хуудсанд 2020 оны 6 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хичээлийг байршуулж эхлээд байгаа бол жижиг сургуулиуд “WeChat” аппликейшныг ашиглан оюутнуудад хичээлүүдийг хүргэж байна.<sup>87</sup>

<b>Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр</b>	БНХАУ-ын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулахаас гадна “Covid-19” вируст өртсөн бүс нутгуудын жижиг, дунд бизнес эрхлэгч болон иргэдийн зээлийн хүүг бууруулах, зээлээ эргэн төлөх хугацааг хойшлуулах зэрэг төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч үйлдвэрлэлийн сүлжээнд тасалдал үүссэн нь дэлхийн
--	---

<sup>85</sup> <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>

<sup>86</sup> <https://www.weforum.org/agenda/2020/03/coronavirus-covid-19-hangzhou-zhejiang-government-response/>

<sup>87</sup> <https://gia.gov.mn/12/item/652>



---

эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй байна.

2020.02.25-ны өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн хуралдаанаар жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүг бууруулах, халдварын улмаас зээлээ төлж чадаагүй иргэдийн зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах, торгууль ногдуулахгүй байх шийдвэр гаргаад байна. Тус хуралдаанаар жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэхээр 500 тэрбум юанийг төсөвлөв. Мөн хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн зээлийн хүүг 0.25 нэгжээр бууруулж 2.5% болгожээ.<sup>88</sup>

Хятадын Төв банк өнгөрсөн долоо хоногт бодлогын хүүгээ бууруулж, банкууд болон зээлдэгчдэд ирэх зээлийн хүүгийн дарамтыг багасгахад туслах үүднээс зээлд их хэмжээний бэлэн мөнгө зах нийлүүлж эхлээд байна.

Мөн БНХАУ-ын Ардын банкны дэд дарга Лю Гуокян эдийн засгийн өсөлтийг дэмжих, үйлдвэрлэлийн алдагдлыг нөхөх үүднээс дотоодын нэр бүхий өсөн банканд нэг жилийн хугацаатай, бага хүүтэй зээлийг санхүүжүүлэх чиглэлд тусгай санхүүжилт гаргаж, бизнес эрхлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр богино хугацаанд зээл олгох чиглэл өгсөн байна. Хамгийн сүүлд тус улсын Сангийн яамнаас “Covid-19” вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулж улсын төсвөөс 8 тэрбум юань гаргах болсноо зарласан. Түүнчлэн Төв банк нь санхүүгийн байгууллагуудад олгосон 200 тэрбум юань буюу 28.65 тэрбум ам.долларыг нэг жилийн хугацаатай, зээлийн байгууламжийн хүүгээ 3.25-аас 3.15 хувь болгон бууруулах болсноо мэдэгдээд буй.

#### **Хонконг**

Бослого тэмцлийн улмаас эдийн засаг нь өнгөрсөн онд 1.2 хувиар агшсан бол одоо шинэ коронавирусийн гамшиг Хонконгийн санхүүгийн нөхцөл байдлыг улам доройтуулахаар байгаа юм. Тиймээс Хонконгийн эрх баригчид хоёр сая орчим иргэнийхээ татварыг хөнгөлөх, бага орлоготой иргэдийн байрны нэг сарын түрээсийн төлбөрийг чөлөөлөх, амьжиргааны түвшин доогуур 200 мянган өрхөд нэг удаагийн тэтгэмж олгохоор болжээ.<sup>89</sup>

---

---

<sup>88</sup> <https://gia.gov.mn/12/item/652>

<sup>89</sup> <https://livetv.mn/p/163369>

#### 4.ХБНГУ

##### Эх сурвалж:

1. Холбооны Улсын Эрүүл мэндийн Яам <https://www.bundesgesundheitsministerium.de/coronavirus.html>
2. 2020 coronavirus pandemic in Germany [https://en.wikipedia.org/wiki/2020\\_coronavirus\\_pandemic\\_in\\_Germany](https://en.wikipedia.org/wiki/2020_coronavirus_pandemic_in_Germany)
3. COVID-19-Fälle in Deutschland [https://de.wikipedia.org/wiki/COVID-19-F%C3%A4lle\\_in\\_Deutschland](https://de.wikipedia.org/wiki/COVID-19-F%C3%A4lle_in_Deutschland)
4. Үндэсний пандемийн төлөвлөгөө-Шинэ төрлийн корона вирусийн өвчлөлийн нэмэлт "Ergänzung zum Nationalen Pandemieplan – COVID-19 – neuartige Coronaviruserkrankung" (PDF). [www.rki.de](http://www.rki.de). Robert Koch Institute. Retrieved 4 March 2020.
5. “Америкчууд вирусийн тархалтын улмаас галт зэвсэг ихээр худалдаж авч буй тул АНУ-д буй Монголчууд сонор сэрэмжтэй байх нь зүйтэй” Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газар <http://www.sonin.mn/news/culture/109580>

	ХБНГУ
Нөхцөл байдал	<p><b>2020-03-11</b> Канцлер А.Меркель мэдэгдэл хийв:<sup>4</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>- Компаниудын төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор Германы хөгжлийн банк (KfW)–наас энэ 7 хоногтоо багтаан санхүүжилт олгоно</li> <li>- Хилийг хаахгүй</li> </ul> <p><b>2020-03-12</b> Эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын газраас “тахал” гэж албан ёсоор зарлаагүй байна.<sup>3</sup></p>
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<p><b>2020-01-31</b> Халдвараас хамгаалах хуулийн 6 ба 7 дахь зүйлийг үндэслэн “бүртгүүлэх үүрэг”-ийг журамлав. Тус журмаар, мөн сэжигтэй тохиолдол батлагдаагүй ч бүртгүүлэх үүрэг хүлээнэ.<sup>3</sup></p> <p><b>2020-02-27</b> Дотоод хэргийн болон Эрүүл мэндийн яамны хамтарсан хямралын штаб байгуулагдав.<sup>3</sup></p> <p><b>2020-03-02</b> Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдэлийн үнэлгээний түвшинг ахиулж “тааруу” гэж зарласан.<sup>3</sup></p> <p><b>2020-03-04</b> Үндэсний пандемийн төлөвлөгөөнд корона вирусийн өвчлөлийн талаар нэмэлт оруулав.<sup>4</sup></p> <p><b>2020-03-06</b>–ны өдрөөс хойш Норд-райн-вэст-фалэн муж улсын Хайнсберг тойргийг “онцгой тархалттай бүс”-ээр зарласан.<sup>3</sup></p> <p><b>2020-03-11</b> ДЭМБ “цар дэгдэлт” (пандеми) зарлав.<sup>3</sup></p> <p><b>2020-03-11</b> Бундестаг коронавирусийн талаар Засгийн газрын сонсгол хийв.<sup>1</sup></p> <p><b>2020-03-12</b> Хэдийгээр хил залгаа улс орнууд дунд сургуулийг хаасан байгаа ч Германы Боловсролын сайд сургуулийг хаах тухай асуудал огт яригдахгүй гэж мэдэгдлээ.</p> <p><b>2020-03-13</b> Германы 16 улсын 14 нь дунд сургууль, цэцэрлэгийг хэдэн долоо хоногийн турш хаахаар шийдвэрлэв.</p> <p><b>2020-03-14</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэлээд хэдэн улсад олон нийтийн үйл ажиллагаа явуулахыг хориглов. Тухайлбал, Берлин, Шлесвиг-Холштайн, Заарланд улсуудад түүнээс гадна мөн баар, цэнгээнт газруудыг хаав.</li> <li>- Көлнд хотын төвд цуглахыг хориглов.</li> </ul> <p><b>2020-03-15</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Баварид хямралын дундуур орон нутгийн сонгууль явагдлаа. Сонгуулийн штабын олон ажилтан ажлын байраа орхисноос сонгууль үр дүнгүй болох эрсдэл нүүрлэв.</li> <li>- Германы Дотоод хэргийн сайдын шийдвэрээр Франц, Швейцар, Австри, Дани болон Люксембургтэй хилээ хаав. Арга хэмжээ Даваа гаригаас эхэлж хэрэгжих ба бараа тээвэр болон орон нутгийн нислэг хамаарахгүй аж.</li> <li>- Германы төмөр зам бүс нутгийн тээврээ хязгаарлаж, тийз шалгалтыг зогсоов.</li> </ul> <p><b>2020-03-16</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бавари Улсад 14 хоногийн <b>онц байдал зарлаж</b>, олон нийтийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, эмнэлгийн тусламж, хангамжид зориулан нэмэлт хөрөнгө гаргахаар шийдвэрлэв.</li> </ul>

- Бүх спортын болон цэнгээнт газруудыг хаав. Хооллох зориулалтаар ресторанууд 15:00 хүртэл ажиллана, гэхдээ зөвхөн 30 хүртэлх үйлчлэгч авна. Их дэлгүүр, химийн бодис зардаг дэлгүүр, банк, хөнгөн зуушны газар болон үндсэн хэрэгцээ хангадаг бүх төрлийн аж ахуйн нэгжүүд уртасгасан цагаар, бүр Ням гарагийн өдөр ажиллаж болно. Харин чухал биш (барааны) дэлгүүрүүдийг бүгдийг хаана.<sup>3</sup>
- ХБНГУ-ын Тээврийн яам Иран, Хятадаас ирэх бүх нислэгийг зогсоолоо.<sup>3</sup>
- Үдэш нь Меркель Холбооны Улсын хэмжээнд Баваритай ижил арга хэмжээ авч байгааг мэдэгдэв, хот хоорондын тээвэр, шашны хурал цуглаанд нэгдэх, талбайд тоглох болон аялал жуулчлалыг хориглов.<sup>3</sup>

**2020-03-17**

- Үдэш нь Меркель, ЕХ-ны бусад удирдагчидтай зөвшилцөн ЕХ-ны бус иргэнийг 30 хоногийн хугацаанд ЕХ руу нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэснийг мэдэгдэв.

**2020-03-18**

- ЕХ-ны Итали, Швейцар, Дани, Люксембург болон Испани улсын иргэдийг агаарын болон усан замаар Герман руу нэвтрэхийг хориглов. Хоёр талын хэлэлцээрийн дагуу Хятад, Иранаас агаарын тээврээр зорчигч хүлээж авч байсныгаа хоёр өдрийн өмнөөс эхлэн бүр мөсөн хориглов. Эдгээр зорчигчдоос вирусийн шалгалт авалгүй, биеийн халууныг нь хэмжилгүй нэвтрүүлж байсан аж.
- Засгийн газраас ЕХ-ны бус оронд аялж явсан хэдэн мянган иргэнээ тусгай үүргийн онгоцоор татан авах ажиллагаа зохион байгуулав.
- Олон нийтийн эрүүл мэндийн даатгалын компаниуд хямралтай холбогдох бүх зардлыг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр нөхөн олгохоо мэдэгдэв.

**2020-03-20**

- Бавари Улс анхлан 4 хоногийн өмнө Австри Улсад хэрэгжүүлсний нэгэн адил **хөл хорионы цаг тогтоов**. Хөл хорио 24 цагт эхэлнэ, зөрчигчид 25 мянга хүртэл еврогийн торгууль оногдуулна. Гэхдээ ажилд явах болон их дэлгүүр, ундааны дэлгүүр, эмийн сан руу ганцаар буюу гэр бүлийн нэг гишүүний хамтаар явахыг зөвшөөрсөн хэвээр аж. Мөн дээрх нөхцөлтэйгээр задгай талбайд спортоор хичээллэх, хамтран амьдрагчийндаа, эсвэл өндөр настныд зочлох, өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах, ерөнхийдөө бүх төрлийн тусламж үзүүлэх болон амьтан арчилж болно. Драйв-Ин болон Тэйк-Эвайгаас бусад бүх ресторан (хоолны газар), үсчиний газрыг хаав.
- Заарланд Улс мөн 24:00 цагаас эхлэн хөл хорио тогтоов. Гэхдээ зарим хөнгөлөлттэй. Улс хооронд, ялангуяа Францтай хил залгаа нутгаар униформ буюу халааттай зорчихоор журамлав.

**2020-03-21**

- Засгийн газар Холбооны Улсын засгийн газарт муж Улсуудын ЗГ-тай харьцуулахад илүү эрх мэдэл олгох хуулийн төсөл боловсруулав. Шинэ хуулийн дагуу Эрүүл мэндийн сайд нь Муж улсуудын хил нэвтрэхийг хориглох, халдвар авсан хүний харилцсан замналыг тогтоох, мөн эмч, эмнэлзүйн оюутан болон эмнэлгийн ажилтнуудыг халдварт өвчинтэй тэмцэх ажилд дайчлах эрхтэй болно.

**2020-03-22**

- Засгийн газар болон холбооны улсууд 2-оос дээш хүн цугларах, олон нийтийн газарт хүнээс 1.5 метрийн зай барих (гэр бүл, хамтран амьдрагч болон нэг гэрт амьдардаг хүмүүст хамаарахгүй) асуудлаар зөвшилцөлд хүрэв.
- Ресторан болон үсчин зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний газруудыг хаав.

**Бусад арга хэмжээ**

**2020-03-15**

		<ul style="list-style-type: none"> <li>- Баварид хямралын дундуур орон нутгийн сонгууль явагдлаа. Сонгуулийн штабын олон ажилтан ажлын байраа орхисноос сонгууль үр дүнгүй болох эрсдэл нүүрлэв.</li> </ul>
	<b>2020-03-17</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Роберт Кох Институт (RKI) Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдлийн үнэлгээний түвшинг ахиулж “өндөр” гэж зарлав.<sup>3</sup></li> <li>- Европын комисс хамтарч анагаах механизм олох ажлыг эхлүүлэв.</li> </ul>
	<b>2020-03-18</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Гёттинген Их сургуулийн эрдэмтэд корона вирусийн хүний эсэд бэхжин үлдэх чадварыг нойр булчирхайн үрэвсэл, зарим төрлийн хорт хавдрын эмчилгээнд хэрэглэдэг Япон Улсад үйлдвэрлэсэн “Мезилат Камостата” гэх эмээр устгах боломжтойг тогтоосон байна.<sup>5</sup></li> <li>- Роберт Кох Институт, хэрэв нийгмийн харилцааг (хавьтлыг) эрс бууруулахгүй, шууд харилцааг 1.5 метрээс доошгүй зайнд барихгүй бол өвчлөгчдийн тоо 10 сая хүрнэ хэмээн анхааруулав.</li> </ul>
	<b>2020-03-19</b>	Германы нэгэн амны хаалт үйлдвэрлэгч бүх үйлдвэрлэсэн хаалтыг борлуулж дууссанаа мэдэгдэв. Зарим эмнэлэг хамгаалах хувцас дутагдаж буйгаа зарлав.
<b>Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ</b>		<p>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь томуугийн вирусээс хамгаалах аргатай яг адилхан:<sup>1</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>• Гарыг тогтмол, сайн угаах</li> <li>• Зөв ханиах, нийх</li> <li>• Өвчтөнөөс зай барих</li> <li>• Гар барихгүй байх</li> </ul> <p><b>Арга хэмжээний хэрэгжих хэлбэрүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аяллаас зайлсхийх<sup>1</sup></li> <li>• Нийтийн тээврээс татгалзах</li> <li>• Гэрээсээ ажиллах</li> <li>• 1000-аас дээш хүн оролцсон арга хэмжээнд оролцохгүй байх</li> <li>• 60-аас дээш настай ахмадууд пневмокодын эм тариулах</li> <li>• Гадаад аяллаас ирсэн бол: <ul style="list-style-type: none"> <li>○ Шаардлагагүй хүнтэй уулзахгүй байх; гэртээ байх. 14 хоногийн дотор шинж тэмдэг илэрвэл утсаар урьдчилан ярьж, эмчид хандах</li> <li>○ Иран, Итали, Япон, БНСУ-аас ирсэн бол 30 хоногийн хугацаанд байх хаягийг өгөх</li> <li>○ Хятадаас ирсэн бол нэмээд дэлгэрэнгүй хувийн мэдээлэл өгөх</li> </ul> </li> </ul>
<b>Эдийн засгийн нөлөөллийг чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ</b>	<b>2020.03.13</b>	<ul style="list-style-type: none"> <li>• ЕХ руу Германаас гарах экспортыг хөнгөвчлөхөө мэдэгдэв. Засгийн газар хямралд өртөөд байгаа урлаг, уран сайхан, соёлын байгууллагууд болон том арга хэмжээ зохион байгуулагч компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болов.</li> <li>• Хувийн бүх компаниудад хүссэн хэмжээгээр нь хязгааргүй зээл олгохоо амлав.</li> <li>• Герман 10 000 ш агааржуулагч сэнс захиалж авахаар шийдэв (энэ Италийнхаас 2 дахин их хэмжээ аж), энэ нь тухайн үйлдвэрийнх нь бүтэн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ юм.</li> </ul>

## 5. ИРАН

Иран	
<b>Нөхцөл байдал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Иран Улс нь коронавирусийн халдварын улмаас нас барсан хүний тоогоор БНХАУ-ын дараа 2-р байранд, халдвар авсан хүний тоогоор БНХАУ, БНСУ зэрэг улсуудын дараа орж дэлхийд 4-р байранд орж байна. Эрүүл мэндийн яамны 2020.03.23ны өдрийн мэдээллээр 18000 хүн халдвар авч, 1284 хүн нас барсан байна. Өнгөрсөн 24 цагийн хугацаанд 149 хүн нас барсан ба энэ нь 10 минут тутамд нэг хүн “Covid-19”-ийн улмаас нас барж байна гэсэн үг юм.</li> <li>- Парламентын 23 гишүүн коронавирусийн халдвар авсан тул Парламентын үйл ажиллагааг одоогоор зогсоосон байна.</li> <li>- Коронавирусийн тархах гол цөм нь Ираны сүм хийд болоод байна. Хэдий халдвар авагчдын тоо олон болоод Эрүүл мэндийн яамнаас сүм хийдүүдийг хаах зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг биелүүлэхгүй байгаа.</li> <li>- Ираны Эрүүл мэндийн сайд Киануш Жаханпур коронавирусийн эсрэг тэмцэлд АНУ-ын зүгээс тус улсад авсан эдийн засгийн хатуу хориг арга хэмжээнүүд саад болж байгааг онцолжээ.</li> </ul>
<b>Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн яамнаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж гаргасан</li> <li>- Улс хоорондох агаарын тээврийг бүрэн зогсоосон</li> <li>- Агаарын харилцаагаа тасалсан улсуудаасаа өөрийн улсын иргэдээ авчрах болсон</li> <li>- Сүм хийдийг хаах зөвлөмж гаргасан</li> <li>- Бүх сургуулийг сарын хугацаатай хааж, зайны сургалтад шилжсэн</li> <li>- Кум хотод эмнэлэг хүрэлцээгүй болсноор майханд ор бэлтгэн, сэжигтэй тохиолдлуудыг хүлээн авч эхэлсэн</li> <li>- Ираны Ардын армийн 300.000 цэргийг корона вирусаас урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулахаар болсон</li> <li>- ОХУ-аас коронавирусийн дэгдэлттэй тэмцэхэд тусламж үзүүлэхийг хүссэн</li> <li>- Шинэ корона вирусийн халдвар шоронд тархаж болзошгүй гэж болгоомжлон эрх баригчид нийт 70,000 хоригдлыг сулласан тухай Хууль зүйн сайд Эбрахим 2020.03.22-нд мэдээлсэн</li> </ul>
<b>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Гарын ариун цэвэр сахих</li> <li>- Амны хаалт хэрэглэх</li> <li>- Дархлааг дэмжих эм хангамжийг сайжруулах</li> <li>- Такси болон орчны цэвэрлэгээ ариутгал хийх</li> <li>- Уулзалт, цугларалтыг хязгаарлах</li> </ul>
<b>Эдийн засгийн нөхцөл байдал</b>	Иран Улсын хувьд газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн асуудал буурч байгаа явдал эдийн засгийн хувьд хүнд байдалд орж байна. Энэ тал дээр дорвитой арга хэмжээ авч чадахгүй байгаа бөгөөд тархалтыг намжаах байдал дээр анхаарч байна.

## 6.ИСПАНИ

Улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ<sup>90</sup>:

- Итали Испани чиглэлийн шууд нислэгийг түр зогсоосон.
- Парламентын үйл ажиллагааг 1 долоо хоногийн хугацаанд түр хаасан.

Үндэсний эрүүл мэндийн системийн Дотоод бүс нутгийн зөвлөлөөс (Inter-territorial Council of the National Health System) коронавирусийн халдвартай бүс нутагт авсан арга хэмжээнүүд<sup>91</sup>

	Испани
<b>Нөхцөл байдал</b>	2020.03.23-ны 17 цагийн байдлаар <sup>92</sup> <ul style="list-style-type: none"> <li>- Нийт бүртгэгдсэн -29909</li> <li>- Шинээр бүртгэгдсэн - <b>+1141</b></li> <li>- Нийт нас барсан - 1813</li> </ul>
<b>Улс орон даяар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд<sup>93</sup></b>	<ul style="list-style-type: none"> <li>- 2020.03.11-наас Улс орон даяар 15 хоногийн хугацаатай <b>онц байдал зарласан</b>.</li> <li>- Парламентын үйл ажиллагааг 2020.03.25-ны өдөр хүртэл (15 хоног) түр зогсоосон.</li> <li>- 2020.03.19-нд Канарын арлууд руу нисэх нислэгийг түр хязгаарласан. Балеарийн арлуудын бүх нислэгийг түр хориглосон.</li> <li>- 2020.03.22-нд Ерөнхий сайд улс орон даяар 15 хоногийн хугацаатай зарласан онц байдлыг 2020.04.11 хүртэл сунгах хүсэлтийг Парламентад өргөн мэдүүлэхээ мэдэгдсэн. Ийнхүү сунгахыг Парламентаар батлах ёстой бөгөөд Парламентын ээлжит хуралдаан хуваарийн дагуу Лхагва гарагт хуралдахаар байна.</li> <li>- 2020.03.22-нд Мурсия мужийн Тэргүүн зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх эдийн засгийн үйл ажиллагааг түр хаах шийдвэр гаргав.</li> <li>- 2020.03.22 Испаний Зэвсэгт хүчин нь хэт ачаалалтай эмнэлгээс өвчтөнүүдийг ачаалал бага бусад эмнэлэг рүү шилжүүлэх, эрүүл мэндийн тоног төхөөрөмж зөөвөрлөх, гадаадад байгаа испаничуудыг нутаг буцаах арга хэмжээнд оролцон ажиллахаар болсныг Ерөнхий сайд мэдэгдлээ<sup>94</sup>.</li> <li>- 2020.03.22 Засгийн газраас гадаадын иргэдийг агаарын зам болон далайн боомтоор нэвтрэхийг 30 хоногийн хугацаанд түр хязгаарлав. Европын Холбооны улсуудын удирдагчид ийнхүү хилээ түр хаах арга хэмжээг ижил хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцов<sup>95</sup>.</li> <li>- Дрон ашиглан иргэдийнхээ хөдөлгөөнийг хянах болсон<sup>96</sup>.</li> </ul>
	<b>Сургууль болон бусад боловсролын байгууллагад хамааралтай арга хэмжээ</b> <ul style="list-style-type: none"> <li>- Бүх боловсролын байгууллагын танхимаар хичээллэх үйл ажиллагааг түр зогсоох</li> <li>- Боловсролын бусад нэмэлт үйл ажиллагааг түр зогсоох</li> <li>- 2020.03.18-нд Баскийн Боловсролын сайд цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр хаасан шийдвэрийг тодорхойгүй хугацаагаар сунгав.</li> </ul>

<sup>90</sup> <https://www.worldometers.info/coronavirus/>

<sup>91</sup> <https://www.lamoncloa.gob.es/lang/en/gobierno/news/Paginas/2020/20200310covid19-measures.aspx>

<sup>92</sup> <https://www.worldometers.info/coronavirus/>

<sup>93</sup> [https://en.wikipedia.org/wiki/2020\\_coronavirus\\_pandemic\\_in\\_Spain](https://en.wikipedia.org/wiki/2020_coronavirus_pandemic_in_Spain)

<sup>94</sup> <https://www.thestar.com.my/news/world/2020/03/22/spain039s-pm-to-see-coronavirus-state-of-emergency-extension-for-15-more-days---reports>

<sup>95</sup> <https://www.thestar.com.my/news/world/2020/03/22/spain039s-pm-to-see-coronavirus-state-of-emergency-extension-for-15-more-days---reports>

<sup>96</sup> <https://www.telesurenglish.net/news/Spain-Takes-Sweeping-Measures-as-COVID-19-Escalates-20200318-0027.html>

	<p><b>Байгууллага, ажлын байранд хамааралтай арга хэмжээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Боломжтой бол зайнаас гэрээсээ ажиллах (утсаар гэх мэт);</li> <li>- Онцгой байдлын үед хөдөлмөрийн үйл ажиллагааны тасралтгүй төлөвлөгөөг хянах, шинэчлэх;</li> <li>- Уян хатан ажлын цагийг хэрэгжүүлэх, нэг ээлжинд ажиллаж байгаа ажилчдын тоог багасгах видео хурал хийхийг уриалга гаргасан.</li> </ul> <p><b>Эрсдэлт бүлгийнхэнд хамааралтай арга хэмжээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ахмад настнуудад зориулсан гэрийн асаргааг дэмжих;</li> <li>- Архаг өвчнөөр шаналж буй, плурипатологи, төрөлхийн дархлаа дарангуйлагдсан өвчтэй настай хүмүүс орон гэр, оршин суугаа газраасаа аль болох гарахгүй байх;</li> <li>- Хүмүүстэй харьцахдаа аль болох хол зайнаас, дор хаяж 1 м зайнаас харьцах.</li> </ul>
<b>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хувь хүний үүрэг хариуцлагаа ухамсартай мөрдөх, онцын шаардлагагүй бол аялахгүй байх;</li> <li>- Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрвэл шууд эмнэлэг явах биш эхлээд гэртээ байж хэсэг хугацаанд ажиглах.</li> </ul>
<b>Эдийн засгаа хамгаалах арга хэмжээ</b>	<p>Испаний Ерөнхий сайд коронавирусийн улмаас эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад 200 тэрбум еврогийн тусламжийн багцыг зарлав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Моргейжийн төлбөрийг хойшлуулах;</li> <li>- нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөвчлөх;</li> <li>- хамаатан садангаа асрах шаардлагатай ажилчдад ажлаас чөлөө олгох зэрэг арга хэмжээг хамруулсан байна.</li> </ul> <p>200 тэрбум еврогийн тал хувь нь бизнес эрхлэгчдэд, 17 тэрбум еврог COVID 19 өвчний нөлөөнд хамгийн их өртөж болзошгүй эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэхэд зарцуулахаар болжээ. Түүнчлэн, ажилгүйдлээс сэргийлэх, COVID 19-ийн вакциныг гаргахад дэмжлэг болох юм<sup>97</sup>.</p>
<b>Урьдчилан сэргийлэх зорилгоор</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Гараа савандаж угаах, дор хаяж 20 секунд угаах. Саван, ус байхгүй бол спирт бүхий гар ариутгагч бодис хэрэглэх;</li> <li>- Угаагаагүй гараараа нүд, хамар, амандаа хүрэхээс зайлсхийх;</li> <li>- Өвчтэй хүмүүстэй ойр дотно харьцахаас зайлсхийх;</li> <li>- Ханиалгах, эсхүл найтаах үед ам, хамраа салфетка, алчуур эсхүл, ханцуйгаараа (гар биш) дарах.</li> </ul>

<sup>97</sup> <https://english.elpais.com/society/2020-03-17/spain-announces-200-billion-relief-package-against-effects-of-coronavirus.html>



## 7.ИТАЛИ

### Эх сурвалж:

- Италийн Засгийн газар -<http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>
- Италийн эрүүл мэндийн яам-<http://www.salute.gov.it/nuovocoronavirus>

	Итали
<b>Нөхцөл байдал</b>	<b>2020.03.23, 16:00 цагийн байдлаар:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Нийт тохиолдол – 59138</li> <li>- Нийт нас барсан тохиолдол 5476</li> <li>- Нийт эдгэрсэн- 7024</li> </ul>
<b>Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд<sup>98</sup></b>	<p>Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) нь 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдөр Хятад дахь коронавирусийн дэгдэлт тархалтыг олон улсад нөлөөлж болзошгүй нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал гэж зарласан. Үүнээс нэг өдрийн хойно Италийн засгийн газар нь 1-р сарын 22-наас эхлэн авч хэрэгжүүлж байсан <i>анхны урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ өөрчилж</i>, халдварын тархалтын өргөн цар хүрээт шинж чанарыг харгалзан онц байдал зарлаж, улсыг бүх газар нутгийн хэмжээнд халдварыг тогтоон, зогсоох анхны арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн. Итали улсад Covid-19 өвчний анхны тохиолдлууд бүртгэгдсэн 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлээд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>2020.01.30. Эрүүл мэндийн яамны тушаалаар:</b> <ul style="list-style-type: none"> <li>- ЭМЯ-нд ажлын хэсэг байгуулж, ОУ-ын холбогдох байгууллагуудтай байнгын харилцаатай байж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд Хятадын талаас нислэгийг түр зогсоосон хэдий ч Хятад руу явах болон Хятадаас ирэх бүх нислэг, мөн Ухань хот руу болон Уханиас ирэх нислэгийг Итали улсын зүгээс нөхцөл байдлыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг Олон улсын өндөр түвшинд авч хэрэгжүүлэхээр болжээ.</li> </ul> </li> <li>• <b>2020.01.31. Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар:</b> <ul style="list-style-type: none"> <li>- ДЭМБ-аас тунхагласан “Олон улсын нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл”-ийг дагалдан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх онцгой нөхцөл байдлыг хууль ёсоор 6 сарын хугацаанд тогтоож, нийгмийн хамгааллын энэхүү шаардлагыг хангахад шаардагдах төсвийн санг баталсан.</li> <li>- Итали Хятадын хоорон дахь нислэгийг түр зогсоосон.</li> </ul> </li> <li>• <b>2020.02.01. Үйл ажиллагааны хорооны хуралдаанаар:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Вирусийн тархалтын тухайн үеийн нөхцөл байдалтай уялдсан үйл ажиллагааг дүгнэн түр хугацаагаар агаарын болон усан замын хөдөлгөөнтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулж бэлтгэх тухай хэлэлцэв.</li> <li>- Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд “Тусгай үйл ажиллагааны нэгж” байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргав.</li> </ul> </li> <li>• <b>2020.02.04-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:</b></li> </ul>

<sup>98</sup> <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299>.

- 
- Нийгмийн хамгааллын газартай хамтран бүх нисэх буудал, боомтын эрүүл мэндийн хяналт үзлэгийг эрс сайжруулах шийдвэр гаргав. Энэ хүрээнд Ром хотод гаднаас ирж буй бүх хөдөлгөөнд эрүүл мэндийн хяналтын коридор, халуун хэмжигч скайнер ажиллуулж эхэлсэн.
  - **2020.02.07-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
    - Итали Хятадын хоорондох нислэгийг түр зогсоосон шийдвэрийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв.
  - **2020.02.21-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
    - Эрүүл мэндийн яамнаас №85/Covid-19 “Шинэ албан ёсны хөл хорионы арга хэмжээ ба идэвхтэй хяналт” зөвлөмж бүхий захирамжийг хэвлэн нийтлэв. Үүнд: шинжилгээний хариу эерэг гарсан хүмүүсийн ойрын хавьталд орогчид албан ёсоор хөл хорионд орох, ойрын 14 хоногт эрсдэлтэй бүсэд байсан хүмүүс гэртээ тусгаарлах, орон нутгийн захиргаанд үнэн зөв мэдээлэх үүрэгтэй талаар зөвлөсөн.
  - **2020.02.23-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаан, Засгийн газрын хуралдаанаар:**
    - СнЗ-ийн ерөнхийлөгч, ерөнхий сайд Конте-ийн санаачилгаар Covid-19 өвчний тархалтыг зогсоон, удирдах шуурхай арга хэмжээ бүхий зарлиг батлав. Энд Ломбарди, Венето зэрэг халдварын өндөр тархалттай бүс нутгуудыг “Улаан бүс” хэмээн зарлав.
  - **2020.02.24-ний Засгийн газрын хуралдаанаар:**
    - Эдийн засаг ба санхүүгийн сайд Роберто Гуалтиери Улаан бүс хэмээгдэх хотуудад оршин суугч татвар төлөгчдийн үүргийн тухайд интервенц хийх шийдвэр гаргав.
  - **2020.02.25-ны СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлиг:**
    - 2020.02.23-ны шуурхай арга хэмжээний зарлигт нэмэлт оруулав. Үүнд бүх төрлийн спортын үйл ажиллагаа, сургуулилт, сургууль болон дээд боловсролын үйл ажиллагаа, хорих ангиуд дахь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, жолооны шалгалтыг хэрхэн өгөх зохицуулалт, соёл ба аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зохицуулсан.
  - **2020.02.28-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
    - Covid-19 амьдралын нөхцөл байдалтай холбоотой гэр бүл, ажилтнууд ба бизнесийг шуурхай дэмжих арга хэмжээний талаар зарлигийг батлав.
  - **2020.03.01-ний СнЗ-ийн хуралдаанаар:**
    - Ерөнхий сайд Конте Covid-19-ын халдварын тархалтыг зогсоох, хянах талаар өмнө 2020.02.23-ны өдөр баталсан зарлигийг дахин шинэчлэн, интервенцийн ажлыг нэгдсэн байдлаар хийх зохицуулалтыг бий болгох үүднээс бүх нутаг дэвсгэрт урьчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зарлиг гаргав.
  - **2020.03.04-ний Засгийн газар, нийгмийн хамгааллын байгууллагууд, орон нутгийн захиргааны хамтарсан хурлын шийдвэрээр:**
    - Ерөнхий сайд Конте, Боловсролын сайд Люсиа Аззолина нар Итали даяар боловсролын бүх үйл ажиллагааг 3.5-3.15-ныг хүртэл халдвараас сэргийлэх үүднээс түр зогсоох шийдвэрийг зарласан.
  - **2020.03.06-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
    - Covid-19 –ийн тархалттай тэмцэх шуурхай бөгөөд онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шүүхийн үйл ажиллагааг дахь сөрөг үр дагаврыг арилгах, үндэсний эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах тухай зарлигийг
-

батлав.

- **2020.03.08-ны СнЗ-ийн хуралдаанаар:**

- Ерөнхий сайд 2020 оны 3-р сарын 1-4-ний өдрийн тогтоолууд үр дүнгүй байгаа учраас дахин тогтоол гаргаж Ломбарди мужийн бүс болон бусад 14 мужийн нутаг дэвсгэр дэх (таван Эмилиа-Ромагнагаас, таван нь Пьемонт, гурав нь Венецо, нэг нь Марчегээс) 16 сая хүнийг хамруулан хэсэгчлэн хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргав.
- Ерөнхий сайдын 2020 оны 3-р сарын 8-ны өдрийн зарлигтай холбогдуулан Дотоод хэргийн сайд Лусиана Ламоргезе "бэхэлсэн бүсэд хяналт тавих ажлыг гүйцэтгэх удирдамжийг батлав. Энэ хүрээнд онцын чухал шалтгаант ажил, эрүүл мэндийн асуудал зэргээс бусад тохиолдолд тус бүсээс гарах болон нэвтрэхийг хориглов.
- Мөн бүх төрлийн иргэний ёслолын үйл ажиллагааг түр зогсоосон. Үүнд: оршуулгын зан үйл ч багтсан.
- Бар цэнгээний газрууд үйлчлүүлэгч тус бүрийн хооронд 1 метрийн зайтай байх нөхцөлийг ханган оройн 18.00 цаг хүртэл ажиллаж болно.
- Чийрэгжүүлэх газрууд, музей, усан сан, театрууд, бооцоот тоглоомын газруудыг хааж, спорт зааланд олноороо бэлтгэл хийхийг хориглосон.

- **2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар:**

- **03 дугаар сарын 11-нээс** эхлэн Италийн бүх нутаг дэвсгэрт хорио, цээрийн дэглэм тогтоож урьд өмнө авсан арга хэмжээгээ улам бүр чангатгасан.<sup>99</sup>
- хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасан.
- Эрүүл мэндийн систем, иргэд, бизнесийн үйл ажиллагаанд өгч байгаа дэмжлэгийг улам бүр бэхжүүлж, иргэний хамгаалалт болон аюулгүй байдлын нөөц боломжийг нэмэгдүүлэх үүднээс 2020 онд цаашид өрийг хэрхэн зохицуулах талаар Парламентад тавьсан тайланг (3 дугаар сарын 5-нд баталсан) хэлэлцэж, Сайд нарын Зөвлөлийн №36 зарлигийг батлав. Танхимын захиргаанаас санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.

- **2020.03.14-ний өдөр.** Ерөнхий сайд 2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасантай холбогдуулан Ерөнхий сайд Конте Италийн үйлдвэрчний эвлэл болон нийгмийн түншлэлийн байгууллагуудтай видео уулзалт хурал хийж ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, зайнаас ажиллах нөхцөл бололцоогоор хангах, зайлшгүй тохиолдолд 1 метрээс ойргүй зайг барьж ажиллах, ажилтнуудын цалин хөлс, амралт, бусад нэмэгдлийг доголдолгүй олгох, үйл ажиллагааны онцгой горимд шилжих, урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны санамжийг байнга түгээх, ажлын байранд томоор хүмүүст харагдах газарт байрлуулах зэрэг авах арга хэмжээний тухай протоколд гарын үсэг зурлаа.

- **2020.03.16-ны Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар:**

- Covid 19 цар тахлын онц байдал зарласантай холбогдуулан Улсын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлж, гэр бүл, ажилтан, бизнест эдийн засгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай тогтоолыг шинэчлэн

<sup>99</sup> <http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>- Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

баталлаа. Уг тогтоолд:

- ✓ Улсын эрүүл мэндийн систем, иргэний хамгаалалт ба онцгой байдлын ажилд оролцох бусад төрийн байгууллагуудыг санхүүжүүлэх ба бэхжүүлэх бусад арга хэмжээ;
  - ✓ Ажлын байр ба орлогыг хамгаалах үүднээс ажил эрхлэлт ба ажилчдыг дэмжих;
  - ✓ Банкны системээр ба төв даатгалын санг ашиглан гэр бүлийн, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй, бизнес эрхлэгчдийг кредит дэмжлэг үзүүлэх;
  - ✓ Татвар болон хувь хандив, бусад татварын үүргүүдтэй холбоотой төлбөрийн үүргийг түр зогсоох, ажлын байрны ариутгалд татварын урамшуулал олгох, ажил үйлчилгээгээ эрхэлж байгаа ажилтнуудад бонус шагналт цалин олгох зэрэг үндсэн 4 чиглэл ба бусад салбаруудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд интервенц хийхээр болжээ.
- **2020.03.19-нд Сайд нарын Зөвлөлөөс** Иргэний хамгааллын яамтай зөвшилцөн бүх Италийн хэмжээнд гол шаардлагатай бүс нутгуудад ажиллах эмч нарын зорилтот хүчийг сайн дурын үндсэн дээр бүрдүүлэх шийдвэр гарган 2020.03.20-ны өдрөөс бүртгэж эхлэхээр болжээ. Эмч нарын бүрэлдэхүүн хамгийн ихдээ 300 байх ба тэд эрүүл мэндийн дэд бүтцийг дэмжих чиглэлээр ажиллана.
  - **2020.03.20-нд Эрүүл мэндийн сайдын тушаалаар:**
    - Цэцэрлэгт хүрээлэн, зуслангийн байшин, олон нийтийн амралт зугаалгын газрууд, тоглоомын талбайд олноор цугларч тоглох, зугаалахыг хориглох;
    - мөн эмнэлэг, нисэх буудлын доторх хоолны газар, хүнсний худалдаанаас бусад энэ чиглэлийн үйл ажиллагаа, үйлчилгээг хаах;
    - Зайлшгүй шаардлагатай зөвшөөрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээг наанадаж 1-1,5м-ийн зайтай байх нөхцөлийг бүрдүүлэх;
    - Амралтын болон түүний өмнөх ба дараах өдрүүдэд шалтгаангүй бол өөрийн гэрээс өөр газарт зорчих хөдөлгөөнийг тус тус хориглосон. Эдгээр нь 2020.03.21-03.25 хүртэл хүчинтэй.
  - **2020.03.22-ны Эрүүл мэндийн яам болон Дотоод хэргийн яамны хамтарсан тушаалаар** Тусгай ажлын шаардлага болон эрүүл мэндийн шалтгаантайгаас бусад тохиолдолд нийтийн болон хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосон.
  - **2020.03.22-ны өдрийн СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлигаар** хүнсний дэлгүүр, эмийн сан, ахуйн хэрэглээний дэлгүүр болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээнээс бусад үйлдвэрлэл, үйлчилгээнүүдийг хаасан. Энэ нь 2020.03.23-наас 04.03-ныг хүртэл хүчинтэй.

Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ<sup>100</sup>

**Вирус тархахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх гаргасан зөвлөмж:**

- Нийтийг хамарсан бүхий л үйл ажиллагааг түр зогсоох;
- Вирус өндөр тархалттай бүс нутгийг хэсэгчлэн болон бүх газар нутгаар хөл хорио тогтоох;
- Хүмүүс олноор цугларсан газар, агааржуулалт тааруу газраас зайлсхийх;

**Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:**

<sup>100</sup> <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299> - СнЗ-ийн 2020.03.11-ний тогтоол. "Covid-19 халдварын тархалтыг зогсоох урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай"

- Бүх боомт, нисэх буудал, хяналтын цэгүүдэд халуун хэмжигч скайнер, эрүүл мэндийн хяналтын коридорыг ажиллуулсан.
- ДЭМБ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг дагах.
- 2020.03.21-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Италийн Ерөнхий сайд Контетай утсаар ярихдаа туслах санал тавьж Covid 19 эсрэг арга хэмжээнд халдваргүйжүүлэлт ариутгалын машин, төхөөрөмж, цэргийн эмнэлэг, вирус судлалын 100 орчим мэргэжилтнээс бүрдсэн 8 бригадыг илгээхээр болов.

**Хилийн хяналт, зорчих хөдөлгөөний арга хэмжээ:**

- Италийн Засгийн газрын болон Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар Covid-19-ийн халдварын тархалтыг зогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор 2020.01.31-нээс Итали Хятадын хооронд нислэгийг түр зогсоосон.
- Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд тусгай үйл ажиллагааны нэгж байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь Хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргасан.

**Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр авч буй зарим арга хэмжээ**

- **2020.01.31-ний СнЗ-ийн хуралдаанаар:**  
ДЭМБ-аас зарласан онцгой нөхцөл байдлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн санг баталсан.
- **2020.02.24-ний Засгийн газрын хуралдаанаар:**  
Эдийн засаг ба санхүүгийн сайд Роберто Гуалтиери Улаан бүс хэмээгдэх хотуудад оршин суугч татвар төлөгчдийн үүргийн тухайд интервенц хийх шийдвэр гаргав.
- **2020.03.11-ний Засгийн газрын хуралдаанаар:**  
Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.

## 8.ОХУ

### Эх сурвалж:

- ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru>
- ОХУ-ын Эрүүл мэндийн яамны цахим хуудас – <https://www.rosminzdrav.ru/ministry/covid19>
- ОХУ-ын Харилцаа холбоо, мэдээллийн технологи, олон нийтийн харилцаа холбооны хяналтын алба (Роскомнадзор)-ны цахим хуудас – <http://rkn.gov.ru>
- Москва хотын захирагчийн албаны цахим хуудас – <https://www.mos.ru>
- Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/>

	ОХУ
<b>Сүүлийн үеийн нөхцөл байдал</b>	<p><b>2020.03.23, 17:42 (Москвагийн цагаар) – Эрүүл мэндийн яам<sup>101</sup>:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Нийт тохиолдол – 438</b></li> <li>• <b>Эмчлэгдсэн – 17</b></li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• <b>2020.03.23-ний өдрийн байдлаар ОХУ-ын хилээр 69,932 хүн нэвтэрч</b> эрүүл ахуй, хорио цээрийн хяналтад оржээ.</li> <li>• <b>2020.03.17-ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин тус улсын Засгийн газрын гишүүдтэй хийсэн ээлжит уулзалтын үед “Covid-19” вирус тус улсын 26 бүс нутагт 114 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс 104 нь импортлож, 10 нь контакт тохиолдол</b> гэж мэдээлсэн байна.<sup>102</sup></li> <li>• <b>2020.03.11-ний өдрийн ОХУ-ын Онц байдлын штабын мэдээ:</b> ОХУ-д нийт <b>28 тохиолдол</b> (Үүнээс 25 нь Италиас буцаж ирсэн ОХУ-ын иргэд, 2 нь БНХАУ-ын иргэд, 1 нь Итали Улсын иргэн) илэрсэн. БНХАУ-ын 2 иргэн, ОХУ-ын 1 иргэн, Diamond Princess хөлөг онгоцон дээр байсан ОХУ-ын иргэн, <b>нийт 3 хүн эмчлэгдсэн</b>.</li> <li>• Италиас буцаж ирсэн ОХУ-ын 25 иргэнээс “Covid-19” вирус илэрсэнтэй холбогдуулан сүүлийн 2 долоо хоногт Итали Улсад зорчсон бүх иргэдийг тогтоож тусгаарласан. Мөн ОХУ-ын нутаг дэвсгэрт тэдэнтэй холбоо тогтоосон хүмүүсийг тогтоож эмнэлгийн хяналтад авах ажил хийгдэж байна<sup>103</sup>.</li> </ul>
<p><b>ОХУ-ын Засгийн газраас авч байгаа гол арга хэмжээнүүд<sup>104</sup></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зохицуулах зөвлөл,</li> <li>- Онц байдлын штаб,</li> </ul>	<p><b>Гадаадын иргэдийг ОХУ-ын нутаг дэвсгэрт оруулахыг түр хугацаагаар хязгаарлав:</b></p> <p>Хязгаарлалтад “Шереметьево” олон улсын онгоцны буудлын тусгай тоногдсон “F” терминалаар дамжих гадаад улсын нийслэл хотуудын тогтмол нислэгүүд, мөн заасан улс руу тухай орны иргэдийг хүргэх, тэндээс өөрийн иргэдийн авчрах тусгай үүргийн нислэгүүд хамаарахгүй.</p> <p>Хязгаарлалтад Хамтын нөхөрлөлийн улсууд, Абхаз, Өмнөд Осетийн иргэдэд хамаарахгүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>2020.03.23-ны өдрөөс эхлэн гадаадын бүх улсаас</b> ирэх зорчигчдын 2 талын нислэгийг;</li> <li>• <b>2020.03.20-ны өдрөөс эхлэн Арабын Нэгдсэн Эмират Улсаас</b> ирэх зорчигчдын 2 талын нислэгийг;</li> </ul>

<sup>101</sup> ОХУ-ын Эрүүл мэндийн яамны цахим хуудас – <https://www.rosminzdrav.ru/ministry/covid19>.

<sup>102</sup> Владимир Путин провёл очередное совещание с членами Правительства. 17 марта 2020 года, 16:40, Москва, Кремль.

Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://kremlin.ru/events/president/news/63001>.

<sup>103</sup> ОХУ-ын Онц байдлын штабын 2020.03.11 мэдээ. О решениях оперативного штаба по предупреждению завоза и распространения новой коронавирусной инфекции на территории России и подтверждённых случаях заболевания. Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/news/39123/>.

<sup>104</sup> Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/>.



- Эрүүл мэндийн яам,
  - Роскомнадзор
- **2020.03.18**-ны өдрөөс эхлэн **Беларус Улсын иргэд**, тус улсаас ирж байгаа гадаадын иргэдийг;
  - **2020.03.18**-ны өдрөөс эхлэн **гадаадын иргэдийг** (2020.05.01-нийг хүртэл);
  - **2020.03.16**-ны өдрөөс эхлэн **Европын холбооны улсууд болон Швейцар, Норвеги** улсаас ирэх зорчигчдын 2 талын нислэгийг;
  - **2020.03.16**-ны өдрөөс эхлэн **гадаадын иргэдийг Орос-Польш, Орос-Норвегийн улсын хилийн хуурай замаар** (үүнд Беларусь Улсын иргэд хамаарахгүй);
  - **2020.03.13**-ны өдрөөс эхлэн **Итали Улсын иргэд**, тус улсаас ирж байгаа гадаадын иргэдийг;
  - **2020.03.13**-ны өдрөөс эхлэн **Итали, Герман, Испани, Франц** улсуудын 2 талын нислэгийг;
  - **2020.03.07**-ны өдрөөс эхлэн **Иран Улсаас ирэх зорчигчдыг**;
  - **2020.03.01**-ны өдрөөс эхлэн **Солонгос Улсаас ирэх гадаадын иргэдийг**;
  - **2020.02.28**-ны өдрөөс эхлэн **агаарын тээврийн хэрэгслээр ирсэн Иран Улсын иргэдийг**;
  - **2020.02.20**-ны өдрөөс эхлэн **БНХАУ-ын иргэдийг**.

#### Бусад арга хэмжээнүүд:

- **2020.03.23** – “Covid-19” вирусийн улмаас өөрсдийгөө тусгаарлан гэртээ байгаа хүмүүст зориулж тус улсын Засгийн газар **үнэ төлбөргүй цахим үйлчилгээг** нэвтрүүлсэн байна. Үүнд:
  - цахим сүлжээний компаниуд, Харилцаа холбооны яамтай хамтран нэгдсэн цахим сан;
  - мөн соёлын хөтөлбөрийн цахим хуудсаар томоохон соёлын арга хэмжээг зохион байгуулж, шууд дамжуулахаар төлөвлөж байна.
- **2020.03.21** – ОХУ-ын Засгийн газрын нөөц сангаас халдварт **өвчнийг оношлох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авахад** нийт 22.5 тэрбум рубль хуваарилсан.
- **2020.03.20** – Роскомнадзор нь Улсын ерөнхий прокурор, хууль сахиулах байгууллагуудтай хамтран коронавирустай холбоотой хуурамч мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.
  - Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим сүлжээнүүдээс баталгаагүй, олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах эрсдэлтэй мэдээллүүдээ устгахыг шаардав.
  - Тус байгууллага нь өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд худал мэдээлэл тараасан этгээдэд захиргааны арга хэмжээ авна.
- **2020.03.19** – Боловсролын байгууллагуудад халдварын эсрэг дэглэмийг дагаж мөрдөх, **шаардлагатай бол зайны сургалтад** шилжих арга хэмжээ авч эхэлсэн.
  - Боловсролын яамнаас алсын зайн сургалтыг зохион байгуулах, дэмжих нэгдсэн журам боловсруулах ажлын хэсэг байгуулсан.
- **2020.03.19** – Эмнэлгийн байгууллагуудад эмийн жорыг цахим хэлбэрээр олгохыг Эрүүл мэндийн сайдын 2020.03.19-ний өдрийн №198 тушаалаар үүрэг болгов.
  - Эрүүл мэндийн яамнаас бүс нутгийн анхан шатны эмч нар архаг өвчтэй иргэдэд **3 хүртэл сарын хүчинтэй жор** олгохыг зөвлөж байна.
  - “Covid-19” вирусийн халдвар тархаж байгаатай холбогдуулан архаг өвчтэй иргэд, ахмад настнууд нийтийн тээврээр зорчих, олон нийтийн газар (дэлгүүр, клиник орно) зочлохыг багасгаж, шаардлагатай бол гэрээсээ эмчид хандахыг зөвлөж байна.
- **2020.03.18** – Зарим эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлийн тусгай журам тогтоосон:

- мэс заслын болон үзлэгийн хамгааллын хувцас, хэрэгсэл, нийт 36 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлийн тусгай журам тогтоосноор халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг эргэлтэд оруулах боломжтой болно гэж үзэж байна.
- **2020.03.18** – “Covid-19” вирусийн **халдвар авсан иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа, халдвар авах эрсдэлтэй хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхэд** Засгийн газрын нөөц сангаас **11.8 тэрбум рубль** олгохоор болсон байна.
- **2020.03.17** – Москва хотод “Covid-19” вирус өвчний талаарх **мэдээллийн төв нээгдэв**.
  - Төвийн үндсэн үүрэг бол коронавирусийн эсрэг авч буй арга хэмжээний талаар холбооны болон бүс нутгийн удирдлагуудын уялдаа холбоог хангах явдал юм.
  - Төв нь олон нийтийн сүлжээнд хэвлэгдсэн мэдээллийг боловсруулах, найдвартай байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, хуурамч мэдээлэл олж илрүүлэх, вирус дэлхийн хэмжээнд тархсан тухай албан ёсны мэдээллийг цуглуулна.
- **2020.03.16** – “Covid-19” вирусийн шинэ халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэхэд эмнэлгийн байгууллагуудын ажлыг зохион байгуулах түр журам” (Эрүүл мэндийн сайдын 2020.03.16-ны өдрийн №171 тушаал)-ыг Холбооны субъектүүдэд хүргүүлэв. Үүнд:
  - насанд хүрэгчид, хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд “Covid-19” вирусийн халдварт өвчний оношлогоо, эмчилгээний талаарх зайнаас зөвлөх төвүүдийг байгуулав,
  - эмнэлгийн ажилтнуудын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Холбооны төвүүдийн дуудлага хүлээн авах нэгдсэн утасны дугаартай болов,
  - Фтизиопульмонологи ба халдварт өвчин судлалын эрдэм шинжилгээ, судалгааны төвийн мэргэжилтнүүд бүс нутгийн эмнэлгийн ажилчдад зориулж зайн сургалт, семинар, 24 цагийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна.
- **2020.03.14** – “Covid-19” вирусийн сэжигтэй шалтгаанаар хорио цээрийн дэглэмд байгаа иргэдэд тусгай журмаар өвчний лист олгоно.
  - “Covid-19” вирусийн халдварын эсрэг ажиллаж байгаа эмч нарыг шагнах сан байгуулсан.
- **2020.03.14** – Засгийн газрын дэргэд ОХУ-д “Covid-19” вирусийн халдвар тархахтай тэмцэх **Зохицуулах зөвлөлийг байгуулж**, Зөвлөлийн үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг баталсан байна. Зохицуулах зөвлөлийг ОХУ-ын Ерөнхий сайд удирдана.
- **2020.03.14** – ОХУ-ын Ерөнхий сайд тус улсад “Covid-19” вирусийн халдвар тархахтай тэмцэх **багц арга хэмжээний батлав**.

**Цаашид авч хэрэгжүүлэхээр бэлтгэлгэж байгаа бусад арга хэмжээнүүд:**

- **2020.03.23** – **Эрсдэл бүлгийн иргэдэд чиглэсэн:**
  - 45 ба түүнээс дээш настай, 65 ба түүнээс дээш настай, 80-аас дээш настай иргэдийн тоог, мөн тэднээс архаг өвчлөл, ялангуяа зүрх судасны өвчин, чихрийн шижин өвчтэй эсэхийг тогтоохоор ажиллаж байна. Олж авсан мэдээллийг харгалзан үзэж, энэ ангиллын иргэдийн хяналтыг сайжруулах, хүнд нөхцөлд байгаа тохиолдолд бүх төрлийн тусламж үзүүлэх зорилгоор эмнэлгийн байгууллагуудтай ажиллах алгоритм боловсруулахаар ажиллаж байна.
  - Сайн дурынхныг энэ ажилд татан оролцуулахаар ажиллаж байна.

**Москва хотын  
захиргаанаас авч  
байгаа арга хэмжээ**

Москва хотын захирагч С.Собянин улсын хилийг бүрэн хаах боломжгүй тул вирус зөөвөрлөгдөн орж ирэх магадлал өндөр хэвээр байна, “Covid-19” вирусийн халдвар авах таагүй нөхцөл үүссэн орнуудаас ирж буй иргэдээс **урьдчилан сэргийлэх үзлэг, хяналт тавих шаардлагыг улам бэхжүүлнэ** хэмээн мэдэгдэв.<sup>105</sup>

- Москва хотын захирагч С.Собянин эрүүл мэнд, нийтийн тээвэр болон аж ахуйн ажилтан албан хаагчдыг 2020.03.05-ны өдрөөс эхлэн **ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДАЛД ШИЛЖҮҮЛЭВ**.
- Москва хотын захирагч хорио цээрийн үр дагаврыг албан ёсоор **ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ** гэж зарласан.
- Москва хотын гудамжинд 2020.04.10-ны өдрийг хүртэл олон нийтийн арга хэмжээ, 50-иас дээш хүн цугларч чөлөөт цагаа өнгөрөөхийг хориглосон.
- 2020.03.26-ны өдрөөс 04.14-ний өдрийг хүртэлх хугацаанд 65-аас дээш насны болон архаг өвчтэй иргэдийг хорио цээрийн дэглэмд заавал байхыг үүрэг болгов.
- Улсын сургууль, нийслэлийн боловсролын газрын харьяа коллеж, спорт сургууль, нэмэлт боловсролын байгууллагуудын хичээлийг 2020.03.21-ний өдрөөс 04.12-ны өдрийн хооронд хичээлүүдийг цуцлав.
  - Энэ хугацаанд сурагчдын тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй зорчих картыг түр түдгэлзүүлэв.
  - Сурагчид Москвагийн цахим сургуулийг ашиглан гэртээ хичээлийн хөтөлбөрөө үргэлжлүүлэн эзэмшинэ. Хотын коллежууд оюутнуудын зайн сургалтыг зохион байгуулна.
  - Эцэг эхчүүдэд хүүхдүүдээ хорио цээрийг зөрчин олон нийтийн газар гарч ирэхгүй байхыг зөвлөж байна.
  - Үнэгүй хооллох эрхтэй бүх оюутнуудад энэ хугацаанд хүнсний иж бүрдэл өгч байна.
  - Эцэг эхийн хүсэлтээр 1-4 дүгээр ангийн сурагчдын хичээлийг 12-аас илүүгүй сурагчидтайгаар хийж болно. Хичээлийн өмнө хүүхдүүдийн температурыг хэмжих ба сургуулийн байрыг тогтмол халдваргүйжүүлнэ.
  - Сургуулийн өмнөх бүлгүүд хэвийн ажиллах ба эцэг эх нь хүүхдээ цэцэрлэгт авчрах эсэхийг шийднэ.
- Олон нийтийн газарт халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг нэмэгдүүлсэн. Үүнд:
  - Худалдаа, үйлчилгээний газрууд, соёл, спорт, хүн амын нийгмийн хамгаалал, боловсрол, бусад байгууллагуудад чийгтэй цэвэрлэгээг илүү олон хийж, хэт ягаан туяаны цацраг туяагаар агаар, агааржуулагч, агааржуулалтын системийг ариутгаж байна.
  - Нийтийн тээвэрт чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна. Тухайлбал, метроны тасалбар худалдах машиныг цаг тутамд цэвэрлэж байна. Метроны галт тэрэгний дотор агаарыг зөөврийн хэт ягаан туяаны гэрлээр цэвэршүүлж, агаар шүүлтүүрийг илүү олон удаа сольж байна.
- Москвад жижиглэн худалдааны үлдэгдэл болон үнийн талаарх цахим мониторинг зохион байгуулав.
  - Дэлгүүрүүдэд бараа бүтээгдэхүүн тасалдалгүй байх шаардлагатай арга хэмжээг авч байна.
- Москва хотын засаг захиргаа өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан хөдөлгөөн нь хязгаарлагдмал байгаа иргэд, ААН-үүдэд болон нийгмийн зорилтот бүлэгт зориулсан нэмэлт арга хэмжээ боловсруулж байна.
- Нийтийн тээврийн зорчигчид болон поликлиникин өвчтөнүүдийн биеийн халууныг тогтмол хэмжиж байна.
- “Covid-19” вирусийн өвчлөл гарсан орноос ирж буй иргэд аяллын бүртгэлд хамрагдах ба 14 хоногийн турш гэртээ өөрийгөө тусгаарлан эмчийн зөвлөгөөг дагахыг үүрэгжүүлэв.
- Москва хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуй нэгж, байгууллагууд дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгав. Үүнд:
  - ажиллагсдын биеийн халууныг ажлын байран дээр тогтмол хэмжих, халуунтай хүнийг тусгаарлах,

<sup>105</sup> Коронавирус. О дополнительных мерах по предотвращению распространения инфекции.

Эх сурвалж: Москва хотын захирагчийн цахим хуудас - <https://www.sobyanin.ru/koronavirus-o-dopmerah-po-predotvrascheniyu-rasprostraneniya-infektsii> .

- гэртээ өөрийгөө тусгаарлах боломжоор хангах,
- “Covid-19” вирус илэрсэн хүний бүх холбоотой хүмүүсийн мэдээллийг авах, өвчтөн байсан газрыг халдваргүйжүүлэх.
- Москва хотын эрүүл мэндийн газарт зарим хүнд өвчтэй болон 60-аас дээш насны хүмүүст гэрт нь эмнэлгийн тусламж үзүүлэхийг даалгав.
- Эмнэлгийн байгууллагуудад бэлэн байдлаа хангахыг даалгав.
- Дараагийн мэдэгдэл гарах хүртэл Онц байдлын штаб 24 цагаар ажиллана.

#### Авч хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээнүүд<sup>106</sup>

- 1) Олон нийтийн арга хэмжээнүүдийг 2020.04.10-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хориглов. Тухайлбал, Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн форум, Красноярскийн эдийн засгийн форум, Сочийн Хөрөнгө оруулагчдын форум, Ялтын эдийн засгийн форумуудыг цуцалсан байна<sup>107</sup>.
- 2) Москва хотын нисэх онгоцны буудлуудад эмнэлгийн пост ажиллуулж байна. Хятад, Иран, Өмнөд Солонгос улсуудаас ирсэн бүх иргэдийг тусгаарлах, асуумж бөглүүлэх, гэрэл зураг авах, “Covid-19” вирусийн шинжилгээ авч байна. Шаардлагатай тохиолдолд эмч нар тэдэнд эмнэлгийн чөлөө өгнө.
  - “Covid-19” вирусийн халдвар авах таагүй нөхцөл байдалтай Итали болон бусад орноос буцаж ирсэн иргэд (мөн халдварын шинж тэмдэггүй жуулчид) Москва хотын даргын захирамжийн дагуу тусгай +7(495)870-45-09 дугаарт **буцаж ирсэн тухайгаа мэдээлэх үүрэгтэй**. Мөн тэд 2 долоо хоногийн турш гэртээ хорио цээрийн дэглэмд байна. Тэдэнд эмнэлгийн чөлөөг гэрт нь шууд хүргэж байна.
- 3) Олон улсын нисэх онгоцны буудлын бүх зорчигчдын биеийн халууныг хэмжиж байна.
- 4) Хотын эмнэлгүүдэд “Covid-19” вирусийн халдвар авсан байж болзошгүй өвчтөнүүдийг хэвтүүлэх нэмэлт эмнэлгүүдийг бэлтгэсэн.
- 5) Цэцэрлэг, сургуулиудад хүүхдүүдийн температурыг өдөр бүр хэмжиж байна.
- 6) Москва хотын метроны буудлуудад алсын зайнаас биеийн халуун хэмжигчийг байрлуулсан.
- 7) **Халдварын тархацын янз бүрийн хувилбарт шуурхай авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.**

<b>Хорио цээрийн дэглэм зөрчсөн этгэдэд хүлээлгэх хариуцлага</b>	Хорио цээрийн дэглэм зөрчиж, тусгаарласан газраас дур мэдэн гарсан этгээдэд Эрүүгийн хуулийн 236 дугаар зүйл буюу “Эрүүл ахуй халдваргүйжүүлэлтийн дэглэм зөрчих” гэсэн үндэслэлээр хариуцлага хүлээлгэнэ. Уг хэрэг нь <b>нийгэмд учруулсан хор уршгаасаа хамаарч 80 мянган рубль (3.6 сая орчим төгрөг) хүртэлх мөнгөн торгууль оноох болон 5 хүртэлх жилийн хорих ялтай аж.</b> <sup>108</sup> <ul style="list-style-type: none"> <li>• Москва хотод видео камераар хорио цээрийн дэглэмд хяналт тавьж байна.</li> </ul>
<b>Эдийн засгийн байдал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>2020.03.19</b> – Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түрээсийн төлбөрийг 2020 онд түр хойшлуулав.<sup>109</sup></li> <li>• <b>2020.03.17</b> – Шинэ коронавирусын халдвар тархаж байгаагаар холбогдуулан нөхцөл байдал улам хүндэрсэн тохиолдолд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлав.</li> <li>• <b>2020.03.18</b> – 2020 онд гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй тур оператор</li> </ul>

<sup>106</sup> Контроль ситуации в Москве. Эх сурвалж: Москва хотын захирагчийн албаны цахим хуудас – <https://www.mos.ru/city/projects/covid-19/#rec167197919> .

<sup>107</sup> Шинэ коронавирус (Covid-19)-т халдвартай холбоотой нөхцөл байдлын талаар.

Эх сурвалж: Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09

<sup>108</sup> Эх сурвалж: Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09.

<sup>109</sup> Распоряжение Правительства РФ от 19.03.2020 № 670р. Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/> .

---

компаниудын нөөц санд оруулах шимтгэлийн хэмжээ 1 рубль байхаар шийдвэрлэв.<sup>110</sup>

- **2020.03.12** – ОХУ-ын Төсвийн байнгын хорооны дарга Алексей Кудрин “Covid-19” вирусийн тархалт дэлхийн эдийн засагт ямар хэмжээнд сөргөөр нөлөөлөхийг одоо хэлэх боломжгүй. Урьдчилсан байдлаар дэлхийн эдийн засгийн өсөлт 0.4 пунктээр, **ОХУ-ын эдийн засгийн өсөлт 0.1-0.2 пунктээр буурч магадгүй**. Энэ бол урьдчилсан таамаглал, 2 сарын дараа арай бодитой тооцоо хэлж болох юм” гэжээ.<sup>111</sup>
- 

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

<sup>110</sup> Распоряжение Правительства РФ от 18.03.2020 № 660р. **Эх сурвалж:** ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/>.

<sup>111</sup> **Эх сурвалж:** Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09.

## 9. ФРАНЦ

### Эх сурвалж:

- БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus>
- Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662>

Франц <sup>112</sup>	
<b>Сүүлийн үеийн нөхцөл байдал</b>	<p><b>2020.03.12, 19:30 (Парисын цагаар) – БНФУ-ын Засгийн газрын мэдээ<sup>113</sup>:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Нийт тохиолдол – 2876</b> (2020.01.24-ний өдрөөс хойших)</li> <li>• <b>Нас барсан хүний тоо – 61</b> Нас барсан анхны тохиолдол 2020.02.14-ний өдөр бүртгэгдсэн байна.</li> <li>• Засгийн газар “Covid-19” вирусийн <b>тархалтыг хязгаарлах шинэ арга хэмжээ авах, эрүүл мэндийн хямралаас урьдчилан сэргийлэх, эмчлэх төлөвлөгөөний 2-р үе шатанд</b> явж байна.</li> <li>• “Эмнэлгийн ажилтнууд, байгууллагууд нөхцөл байдлын талаар шуурхай мэдэгдэж, Францад тохиолдож болзошгүй хэргийг хэрхэн зохицуулах талаар зөвлөмж гаргасан тул Францын бүх эрүүл мэндийн систем энэ өвчнийг эмчлэхэд бэлэн байна” хэмээн тус улсын Засгийн газрын цахим хуудсанд мэдэгдсэн байна.</li> <li>• Ерөнхий сайд Э.Макрон тус улс “Covid-19” вирусийн <b>голомтот халдварын цэг болох нь “гарцаагүй” боллоо</b> хэмээн мэдэгджээ. (2020.03.09)<sup>114</sup></li> <li>• Үндэсний ассамблейн доод танхимын 4 гишүүн өвчний халдвар авсан нь тогтоогдсон. (2020.03.09)<sup>115</sup></li> </ul>
<b>БНФУ-ын Засгийн газраас авч байгаа зарим арга хэмжээ</b>	<p><b>03.12</b> – Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндээ хамгаалах зөвлөмжүүдээ тогтмол боловсруулан иргэдээ зөвлөж байна (“Covid-19” вирус авсан хүмүүс болон энэ вирус тархсан газарт амьдардаг иргэдэд өгч байгаа зөвлөмж” хэсгээс харна уу)</p> <p><b>03.09</b> – Өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбоотойгоор эмнэлгийн хамгааллын хэрэгслийн экспортод хязгаарлалт тогтоов.</p> <p><b>03.08</b> – Ач холбогдолгүй 1000-аас дээш хүнтэй <b>цуглаан</b> хийхийг хориглов.</p> <p><b>03.06</b> – Гидро спирт (hydro-alcoolique)-тэй гелийн <b>борлуулалтын үнийг</b> тогтоох тогтоолыг нийтлэв. – Эмнэлгүүдэд цагаан төлөвлөгөө, асрамжийн газруудад цэнхэр төлөвлөгөөг идэвхжүүлэв.</p> <p><b>02.29</b> – “Covid-19” вирусийн эсрэг Батлан хамгаалах зөвлөл болон БНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Сайд нарын онцгой зөвлөл хуралдав. Вирусийн тархалтыг хязгаарлах шинэ арга хэмжээ авах, эрүүл мэндийн хямралаас урьдчилан сэргийлэх, эмчлэх төлөвлөгөөний 1-р үе шатнаас 2-р үе шатанд шилжих үйл явцыг албан ёсоор баталсан байна. – Хязгаарлагдмал орон зайд 5000-аас дээш хүний цугларалт хийхийг хориглов.</p> <p><b>02.28</b> – “Covid-19” өвчний нөхцөл байдлыг <b>“давагдашгүй хүчин зүйл”</b> гэж зарлав.</p> <p><b>02.24</b> – Биологийн оношилгооны чадварыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэдэн сая нэмэлт FFP2 амны хаалт захиалав.</p> <p><b>02.24</b> – SAMU-ийн төв штабын байранд 70 эмнэлгийн байгууллага, нийт 107 эмнэлгийн байгууллага “Covid-19” өвчний шинж тэмдэг бүхий өвчтөнүүдийг хүлээн авах бэлтгэлээ хангасан байна.</p>

<sup>112</sup> Informations Coronavirus. Эх сурвалж: БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus> .

<sup>113</sup> Informations Coronavirus. Эх сурвалж: БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus> .

<sup>114</sup> Шинэ коронавирус (Covid-19)-т халдвартай холбоотой нөхцөл байдлын талаар.

Эх сурвалж: Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09

<sup>115</sup> Мөн тэнд.



	<p><b>02.19</b> – Үхань хот, Хүбэй мужийн эмнэлгүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмжийг тусламж болгон илгээжээ. Энэ нь эрүүл мэндийн хамгаалалтын хувцас, амны хаалт, бээлий, ариутгалын бодис бүхий 17 тонн ачаа болсон байна.</p> <p><b>02.17</b> – Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан практик гарын авлага илгээв.</p> <p><b>02.13</b> – Францад “Covid-19” вирусийн идэвхтэй тархалтыг бууруулах бэлтгэлийг хангахын тулд эрүүл мэндийн тогтолцоог дайчлах ажлыг зохион байгуулах зорилготой ORSAN төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэв. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь Францад “Covid-19” вирусийн идэвхтэй тархалтыг бууруулах бэлтгэлд эрүүл мэндийн тогтолцоог дайчлах ажлыг зохион байгуулах явдал юм.</p>
<b>Эрүүл мэндийн чиглэлээр авч байгаа арга хэмжээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын нисэх онгоцны буудлуудад Хятад, Хонконг, Макао руу нисэх зорчигчдыг хүлээн авах тусгай үйлчилгээг зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>Олон улсын нисэх онгоцны буудлуудад “Covid-19” вирус тархсан газар нутгаас буцаж ирж байгаа зорчигчдод заавар, зөвлөмжийн дагуу хяналт тавин ажиллаж байна.</li> <li>Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яам нь батлагдсан тохиолдол бүрийг нэн даруй мэдээлэх үүрэгтэй боловч шалгаж буй хэргийн талаар (сэжигтэй хэрэг, шалгалтын явцад гарсан тохиолдол гэх мэт) мэдээлэл өгдөггүй юм байна.</li> <li>Европ, Гадаад харилцааны яам: <ul style="list-style-type: none"> <li>олон улсын эпидемиологийн нөхцөл байдал, ДЭМБ-ын зөвлөмжийг тусган “Covid-19” вирус тархсан улс орнуудад аялагч хүмүүст өгч байгаа зөвлөмжөө шинэчилсэн байна;</li> <li>халдварт өвчний голомт болсон Хүбэй мужид амьдарч байсан Франц, Европын иргэдийг эх оронд нь буцаах үйл ажиллагааг 4 удаа зохион байгуулсан. Ийнхүү буцаж ирсэн бүх францчууд ирснээс хойш 14 хоног тусгаарлагдсан ба энэ үед эрүүл ахуйн дүрмийг хатуу мөрдөж ажиллажээ.</li> </ul> </li> <li>“Covid-19” вирус нь оюутан, сургуулийн ажилтан, сургуульд нөлөөлсөн бол эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдэгдэх шаардлагатай. Ингэснээр сурагч, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах бүхий л арга хэмжээг бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран хийнэ. Нөлөөлөлд өртсөн сургуулиуд түр хугацаагаар хаагдана.</li> </ul>
<b>“Covid-19” вирус авсан хүмүүс болон вирус тархсан газарт амьдардаг иргэдэд өгч байгаа зөвлөмж</b>	<ul style="list-style-type: none"> <li>Өдөрт 2 удаа биеийн халуунаа хянах;</li> <li>амьсгалын замын халдварын шинж тэмдэг (ханиалгах, амьсгал давчдах гэх мэт)-ийг ажиглах;</li> <li>гараа тогтмол угаах, эсвэл гар ариутгагч уусмал хэрэглэх;</li> <li>сул дорой хүмүүстэй (жирэмсэн, архаг өвчтэй, өндөр настан гэх мэт) холбоо барихаас зайлсхийх;</li> <li>эмзэг бүлгийн хүмүүс (эмнэлэг, амаржих газар, ахмад настнуудын амьдрах орон сууц гэх мэт)-рүү байнга очихоос зайлсхийх;</li> <li>шаардлагагүй бол гэрээсээ гадуур гарахаас зайлсхийх (томоохон цуглаан, ресторан, кино театр гэх мэт);</li> <li>ажилчид /оюутнууд: шинж тэмдэг илрээгүй тохиолдолд та ажилдаа буцаж очих боломжтой;</li> <li>хүүхдүүд, сурагчдыг цэцэрлэг, сургууль, ахлах сургууль, коллежид явуулж болно;</li> <li>“Covid-19” вирусийн талаар мэдээллийг 0 800 130 000 гэсэн төлбөргүй утас руу залгаж авах;</li> <li>хэрэв та амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн (халуурах, эсвэл халуурах мэдрэмж, ханиалгах, амьсгал давчдах), вирус тархсан газар амьдардаг, эсвэл вирус тархсан бүсээс буцаж ирснээс хойш 14 хоногийн дотор дараах арга хэмжээнүүдийг авах: <ul style="list-style-type: none"> <li>шинж тэмдгийн талаар мэдээлэхийн тулд Samu Centre-ийн 15 дугаараар (<b>ярианы болон сонсголын бэрхшээлтэй хүмүүс</b> 114 дугаараар) холбоо барих;</li> <li>бусадтай холбоо барихаас зайлсхийх.</li> </ul> </li> </ul>



**Эдийн засгийн  
чиглэлээр авч  
байгаа арга хэмжээ**

- Төрийн худалдан авах гэрээ байгуулсан компаниудыг хүргэлт хойшлогдсон тохиолдолд **торгууль ногдуулахгүй**.
- 2020.03.02-ны өдрөөс эхлэн Хөрөнгө оруулалтын банк (BPI) нь энэ хүнд хэцүү үед тэднийг дэмжих зорилгоор ЖДҮ эрхлэгчдийн хүссэн бүх **зээлийг баталгаатай гаргаж байна**.
- **Эдийн засгийн тогтвортой байдлын алба** 2020.03.03-ны өдөр Эдийн засаг, сангийн яаманд байгуулагдав. Энэхүү нэгж нь тус улсын эдийн засагт үзүүлэх эрүүл мэндийн хямралын үр дагаврыг даван туулахын тулд улс орны эдийн засгийн байдлын талаарх шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой.
- Эдийн засаг, сангийн яамнаас дараах арга хэмжээг зарлав:
  - ноцтой хүндрэл бэрхшээлтэй тулгарах, ялангуяа нийгмийн болон татварын хураамжийг хэсэгчлэн ашиглах, хуваарилахтай холбоотой компаниудад тохиолдсон тохиолдол бүрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;
  - нийлүүлэлтийн шинэ эх үүсвэр, ялангуяа барилга, химийн тодорхой салбаруудад баталгааны журмыг хурдасгах, байгаль орчны болон бусад стандарт, Европын стандартад нийцүүлэн хангамжийн эх үүсвэрээ төрөлжүүлэхэд нь тусалж байна;
  - зарим стратегийн салбарууд, тухайлбал, автомашины салбарыг гадаадад хүргэх үйл ажиллагааг хараат бус болгохын тулд хангамжийн талаар төлөвлөгөө боловсруулах шаардлагатай;
  - Францын банкны менежерийн хамт орон нутаг дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор зээлийн зуучлалыг сэргээхээр шийдсэн.
- Covid-19” вируст нэрвэгдсэн компаниудад үзүүлэх тусламжийн системийг хялбарчлах:
  - Компаниуд нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах хүсэлтийг цахимаар илгээх боломжтой байх;
  - “Covid-19” вирусийн эдийн засгийн нөлөөллөөс болж дампуурах аюулд өртөж буй ААН-үүдэд татварын шууд хөнгөлөлт үзүүлнэ;
  - Хөдөлмөрийн яамтай холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийг хадгалахын тулд хэсэгчилсэн үйл ажиллагааны тогтолцоог бэхжүүлэх, хялбаршуулах (хариу арга хэмжээ 48 цаг, маш жижиг ААН-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үзүүлэх тэтгэмжийг нэмэгдүүлэх).

**Орон нутгийн  
сонгууль зохион  
байгуулахтай  
холбоотой авч  
байгаа арга хэмжээ**

**Тус улсад хотын болон орон нутгийн сонгууль 3 дугаар сарын 15, 22-ны өдрүүдэд болно.**

- Сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүднээс Дотоод хэргийн сайд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч баталгааг гаргасан байна.
- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сонгогчдын болон санал авах байранд сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах гишүүдийн эрүүл мэндийг хангахад чиглэсэн байна.
- Санал авах бүх байрны дотоод зохион байгуулалтыг төлөвлөхдөө уг байранд удаан хугацаагаар зөвшөөрөлгүй байхаас зайлсхийхээр хийсэн байна.
- Сонгогчдод болон сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах гишүүдэд зөвлөгөө өгч байна.

## 10.ЯПОН

### Эх сурвалж:

- Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, [https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/newpage\\_00032.html](https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/newpage_00032.html)
- Японы Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яам, <https://www.meti.go.jp/english/covid-19/index.html>
- Японы Гадаад хэргийн яам, [https://www.mofa.go.jp/ca/fna/page4e\\_001051.html](https://www.mofa.go.jp/ca/fna/page4e_001051.html)
- Японы хэвлэл, мэдээллийн цахим хуудсууд [www.nhk.or.jp](http://www.nhk.or.jp) [www.nippon.com](http://www.nippon.com), [www.japantimes.co.jp](http://www.japantimes.co.jp)

Япон	
Нөхцөл байдал	<p>2020.03.25, 12:00 цагийн байдлаар</p> <p><b>Нийт бүртгэгдсэн тохиолдол –1193</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Нас барсан хүний тоо – 43 (Diamond Princess хөлөг онгоцны зорчигсдоос халдвар авсан хүний тоо – 712; эмнэлгээс гарсан – 590, эрчимт эмчилгээнд – 11, нас барсан – 10 хүн) - 2020.02.27-нд БНХАУ-ын Үхань хотоос өөрсдийн 800 гаруй иргэнийг 5 тусгай үүргийн нислэгээр эх оронд нь авчирсан.</li></ul> <p><b>Хууль тогтоомжийн тухайд:</b></p> <ul style="list-style-type: none"><li>• “Онц байдал зарлах” хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд “Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг 10-ны өдөр Парламентдаа өргөн барьж, улмаар 13-ны өдөр баталсан. Ингэснээр коронавирусийн халдвар улс оронд хурдан тархаж, хүмүүсийн амьдрал, эдийн засагт ноцтой нөлөөлөх нөхцөл үүсэх бол Ерөнхий сайд онц байдлыг хоёр жил хүртэл хугацаагаар зарлах эрхтэй болж байгаа юм. Онц байдал зарлагдсаны дараа мужийн захирагчид оршин суугчдыг гэртээ байхыг шаардаж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох, олон нийтийн арга хэмжээ цуцлах, хойшлуулах зэрэг эрхтэй болно. Мөн орон нутгийн засаг захиргаа эм, хоол хүнс зэрэг зайлшгүй шаардлагатай материалыг тэдэнд зарахыг шаардаж болно. Тэд эмнэлгийн тусламж үзүүлэх зорилгоор хувийн газар, байгууламжийг түр хугацаагаар ашиглах эрхтэй болно.<sup>116</sup></li><li>• 2020.03.12-нд Ерөнхий сайд Ш.Абе коронавирусийн халдварын тархалтыг <i>state of historic emergency</i> буюу “түүхэн онц байдал” гэж зарласан бөгөөд ингэснээр халдвартай холбоотой Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тов, агуулга, илтгэгч нарын мэдээллийг заавал баримтжуулж, бүртгэх юм. Энэхүү заалтыг 2012 онд батлагдсанаас хойш анх удаа хэрэглэж байгаа юм.<sup>117</sup></li></ul> <p><b>Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай:</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Амны хаалтны хомсдол үүссэнтэй холбогдуулан Японы өөрийн хамгаалах хүчний нөөцөөс 350 000 амны хаалтыг Засгийн газарт 2020.03.12-ны өдөр хүлээлгэн өгөв.<sup>118</sup></li><li>• <b>Японы Засгийн газрын 2020.03.10-ны өдрийн хуралдаанаар:</b> 2020.03.15-ны өдрөөс эхлэн <b>амны хаалт дамлан худалдаалахыг</b> (худалдаж авсан үнээс давуулж зарах) хориглож, зөрчсөн тохиолдолд <b>3 сая хүртэл иенийн (28.5 мянган ам.доллар) торгууль, эсхүл жил 5 хүртэл хугацаагаар хорих</b> ял оногдуулахаар шийдвэрлэсэн.</li></ul>

<sup>116</sup> <https://www.mhlw.go.jp/content/10900000/000606693.pdf>

<sup>117</sup> <https://thediplomat.com/2020/03/japan-takes-additional-measures-to-fight-coronavirus-outbreak/>

<sup>118</sup> <https://www.nippon.com/en/news/ntv20200312003/coronavirus-sdf-delivers-350-000-masks-to-govt.html>

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд

- **2020.02.25-нд Шинэ коронавирусийн халдварыг хянах төв штабаас:**  
“Basic Policies for Novel Coronavirus Disease Control”<sup>119</sup>/Шинэ коронавирусийн халдварыг хянах Үндсэн бодлого/-ийг гаргасан. Энэхүү баримт бичиг нь одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид үүсэх нөхцөл байдлын хариу арга хэмжээнүүдийг нэгтгэсэн баримт бөгөөд өвчтөний өсөлтийн түвшинг бууруулах, тархалтыг багасгахын зэрэгцээ тархалтыг эрт зогсоох, хүнд тохиолдлуудыг багасгах, Японы нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгахад чиглэгдэж байна. Тус баримтыг үндэслэн яам, агентлагууд хоорондоо хамтран ажиллаж, тодорхой арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ. Үндсэн бодлогыг шинээр үүсэж буй нөхцөл байдал, эсхүл шинэ шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл дээр үндэслэж шинэчилнэ.  
Халдварын хяналтын тухай хуулийн дагуу шинэ төрлийн коронавирусийн халдварт өвчнөөр халдварлагдсан байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд үзлэг шинжилгээнд хамруулна.  
Хэрэв халдварын тохиолдол нь батлагдсан бол холбогдох хуулийг үндэслэн тархвар судлалын идэвхтэй судалгаа хийж, халдвар авсан хүнтэй харьцсан хүмүүсийг тогтооно.  
Халдвар авсан хүнтэй харьцсан хүмүүсийн хувьд халдварыг тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд өөрийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих, өөрийгөө тусгаарлах арга хэмжээг авна.

Баримтын бичгийн товч агуулга:<sup>120</sup>

**Иргэд, хувийн сектор, бүс нутгуудад мэдээлэл түгээх чиглэлээр:**

- Үнэн зөв, тодорхой мэдээлэл түгээж, тайван хариу үйлдлийг хөхүүлэн дэмжих;
- Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ажлаасаа чөлөө авах, зайнаас ажиллахыг хөхүүлэн дэмжих;
- Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах шаардлагыг эргэн харах;
- Вирус тархсан улс оронд байгаа Япон Улсын иргэдэд мэдээлэл өгч, тусалцаа үзүүлэх;
- Олон нийт, гадаадын Засгийн газар, гадаад жуулчдад зөв зохистой, түргэн шуурхай мэдээлэл түгээх.

**Япон дахь халдварын нөхцөл байдлын талаарх ойлголт:**

- Коронавирусийн халдварыг оношлох PCR оношилгоонд анхаарлаа төвлөрүүлж, эмнэлэгт хэвтэхийг шаарддаг уушгины хатгалгааны өвчтөнүүдийн оношийг бататгах, Японд тархсан халдварт өвчний хяналтын системийг бэхжүүлэх.

**Халдварыг хяналтад авах арга хэмжээ:**

- Өвчтөний тоо нэмэгдсэн газар, бүсэд иргэдийг олон нийтийн газар явахгүй байхыг сайн дураар татгалзахыг уриалах.
- Орон нутгийн удирдлагаар дамжуулан, сургуулиудын удирдлагуудад сургуулиудыг үйл ажиллагааг түр зогсоох зэрэг холбогдох арга хэмжээ авахыг уриалах.

**Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд гаргасан зөвлөмж:**

- Шинэ коронавирусийн халдварын сэжигтэй өвчтөнүүдийг нэгдсэн эмнэлэгт хүлээн авахын өмнө халдварын хяналтын арга хэмжээг авсан байх, бага зэргийн томуу хэлбэрийн шинж тэмдэг бүхий өвчтөнүүд гэрээр эмчлүүлэх. Ахмад настан, суурь өвчтэй хүмүүст шаардлагатай эмчилгээг эрт үе шатанд үзүүлэх;
- Хэвтэж эмчлүүлэх тусламж үзүүлэх эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх;
- Халдварын хяналтын арга хэмжээг чангатгах.

**Хилийн хяналтын арга хэмжээ:**

- Японд зорчих халдвар авсан хүмүүсийн тоо огцом нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор одоо үйлчилж буй нэвтрэх хязгаарлалт болон аяллын зөвлөмжийг дагаж мөрдөх.

<sup>119</sup> <https://www.mhlw.go.jp/content/10200000/000603611.pdf>

<sup>120</sup> <https://www.mhlw.go.jp/content/10200000/000603611.pdf>

	<p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Амны хаалт, халдваргүйжүүлэх бодисын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тасалдуулахгүй явуулах;</li> <li>- Олон улсын нягт хамтын ажиллагааг үргэлжлүүлж, мэдээлэл солилцох. Японд бий болж буй мэдлэг, мэдээллийг ДЭМБ, холбогдох бусад байгууллага, улс орнуудтай идэвхтэй хуваалцах;</li> <li>- Өвчтөн болон халдварыг хянах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ажилтнуудын хүний эрхийг хангахад анхаарах.</li> </ul>
Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ	<p><b>Вирус тархахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх гаргасан зөвлөмж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Ерөнхий сайд Ш.Абэ Олон нийтийг хамарсан соёл урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээ</i> хэмжээг 3 сарын 29 хүртэл цуцлах, <i>зохион байгуулах хугацааг нь хойшлуулах, хамрах хүрээг нь хумих зэрэг арга хэмжээ авахыг уриалсан.</i></li> <li>- Хүмүүс олноор цугларсан газар, агааржуулалт тааруу газраас зайлсхийх;</li> <li>- Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагч нар арга хэмжээний хэмжээнээс үл хамааран, нягтрал өндөр байх тохиолдолд, мөн агааржуулалт тааруу газар арга хэмжээ зохион байгуулахаас татгалзах. Арга хэмжээ зохион байгуулах тохиолдолд агааржуулалтад онцгой анхаарахын тус тус зөвлөсөн;</li> </ul> <p><b>Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- PCR буюу Полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээг эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Ингэснээр Эрүүл мэндийн байгууллага нь хувийн хэвшлийн лабораторид шинжилгээ хийлгэх, цаашид тэдгээрийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.</li> <li>- ДЭМБ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг дагах.</li> </ul> <p><b>Хилийн хяналт, зорчих хөдөлгөөнийг арга хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Япон Улсын Засгийн газрын коронавирусийн асуудлаарх Ажлын хэсгийн 2020.03.05-ны өдрийн хуралдаанаас хил гаалийн хяналтыг бэхжүүлэх чиглэлд БНХАУ, БНСУ-аас Япон Улсад зорчих иргэдийг зөвхөн Нарита болон Кансай олон улсын нисэх онгоцны буудлаар хүлээн авах, Японы хилээр нэвтэрсний дараа 14 хоногийн хугацаанд хөл хорионд байлгах, мөн Японд олон нийтийн тээврийн хэрэгсэл ашиглахгүй байхыг уриалсан. Эдгээр арга хэмжээг энэ сарын 9-ний өдрөөс сарын сүүл хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.</li> <li>- Мөн 2020.03.07-ны 00:00 цагаас эхлэн БНСУ болон Ираны зарим мужаас Японд зорчих иргэдэд хилийн хориг тогтоохоор шийдвэрлэсэн.</li> <li>- 2020.03.09-30-ныг хүртэл гадаадын зарим улстай визгүй зорчих журмыг түр зогсоох.</li> <li>- 2020.03.08-наас өмнө олгосон нэг, олон удаагийн орох визийн хүчинтэй хугацааг түр зогсоох шийдвэрийг тус тус гаргасан.</li> <li>- 2020.03.09-нөөс хойш БНХАУ, БНСУ иргэдийг хилээр нэвтрүүлэхгүй байх.<sup>121</sup></li> </ul>
Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр авч буй зарим арга хэмжээ	<p>Японы Засгийн газар шинэ коронавирусийн халдвараас үүдэлтэй эдийн засгийн үр нөлөөг бууруулахад 4.1 тэрбум ам.доллар баталсан.</p> <p><i>Вирусийн халдварын тархалттай тэмцэхэд зориулсан (2.6 тэрбум ам.доллар) иенийн яаралтай тусламжийн багцыг баталсан.</i> Түүнчлэн Японы Засгийн газар вирусийн халдварын тархалтын улмаас хомсдоход хүрсэн ариутгалын спиртийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд энэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч компаниудад татаас олгохоор болсон.</p> <p>Засгийн газар энэ асуудлыг зохицуулахын тулд үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг сайжруулахад зориулан хөрөнгө оруулж буй компаниудад татаас олгох бөгөөд томоохон компаниудын уг зардлын гуравны хоёрыг, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн зардлын дөрөвний гурвыг дааж, үйлдвэрлэлийн шугам тутамд 30 сая иен (286 мянга орчим ам.доллар) хүртэлх хэмжээний татаас олгохоор болжээ.<sup>122</sup></p>

<sup>121</sup> [https://www.mofa.go.jp/ca/fna/page4e\\_001051.html](https://www.mofa.go.jp/ca/fna/page4e_001051.html)

<sup>122</sup> <https://www.csis.org/analysis/global-economic-impacts-covid-19>

---

**Японы Засгийн газрын 2020.03.10-ны өдрийн хуралдаанаар:**

*Вирусийн тархалттай тэмцэхэд зориулсан 1 триллион (9.6 тэрбум доллар) иенийн яаралтай тусламжийн хоёр дахь багцыг батлав. Үүнийг бэлэн мөнгөний дутагдалтай жижиг, дунд бизнест 500 тэрбум иенийн хүүгүй зээл олгох, сургууль хаалттай байгаа үед хүүхдээ асарч freelancer буюу чөлөөт ажилтнуудад Засгийн газар өдөрт 4,100 иен олгох зэргээр зарцуулах юм.*<sup>123</sup>

**2020.03.12-ны** байдлаар Засгийн газраас дээрх арга хэмжээг хангалтгүй гэж үзэн гурав дахь багцыг батлахаар төлөвлөж байна.<sup>124</sup>

**“Токио-2020” зуны XXXII олимпийн наадам**

Токио-2020 зуны XXXII олимпийн наадам нэг жилээр хойшилж байгааг Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ болон Олон улсын олимпийн хороо/ОУОХ/-ны ерөнхийлөгч Томас Бах нар 2020.03.24-ны өдөр баталсан. Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ ОУОХ-ны ерөнхийлөгч Томас Бахт санал тавин зөвшөөрч ийнхүү Токио-2020 олимп 2021 оны зун зохион байгуулагдахаар болж байна.

Зуны Олимп, Параолимпийн наадмыг зохион байгуулахад Япон улс ойролцоогоор 1.35 их наяд иен буюу 12,6 тэрбум ам.доллар зарцуулах тооцоог өнгөрсөн 2019 оны сүүлээр гаргажээ. Зардлыг Токио хотын төсвөөс 597 тэрбум иен, Японы Олимп зохион байгуулах хорооноос 603 тэрбум иен, Засгийн газраас 150 тэрбум иенийг гаргаж бүрдүүлжээ. Гэхдээ Олимпийг зохион байгуулах зардал ард иргэдийн дунд маргаан дэгдээсэн халуун сэдэв болсон юм. Учир нь энэ нь 2013-2018 оны хоорондох Японы Засгийн газрын зардлаас (1.06 их наяд иен) бараг 10 дахин их төсөв аж. Үүний зэрэгцээ Японы бизнес эрхлэгчдээс Олимпийн наадмыг зохион байгуулахад 348 тэрбум иен буюу 3.3 тэрбум ам.долларыг хандивласан байна. Мөн Японы Тоёота, Бриджстон, Панасоник зэрэг томоохон компаниуд Олимпийн наадмын спонсорын эрхийн төлөө Олон улсын Олимпийн хороотой хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулжээ.

ДНБ-д нөлөөлөх нь

Коронавирусийн халдвар хэдийн Японы эдийн засгийг хямрал руу түлхэж эхэлсэн юм. Эдийн засгийн судалгааны “Fitch” байгууллагын тооцоолсноор Японы эдийн засгийн өсөлт коронавирусийн халдварын нөлөөгөөр энэ онд таамаглаж байснаас 0.2-1.1 хувиар буурах гэнэ. Харин Олимпийн наадмыг хойшлуулсан нь Японы ДНБ-д 0.5-0.8 хувиар нөлөөлж магадгүй аж. “SMBC Nikko Securities” байгууллагын эдийн засагчдын тооцоолсноор Японы ДНБ-д жилийн алдагдал нь зургаан тэрбум ам.доллар орчим болох гэнэ. Олимпийн наадмыг үзэхээр ирэх жуулчид Японд нийт 240 тэрбум иенийг зарцуулна гэж тооцжээ. Япон нь Олимпийн наадмыг үзэх 7.8 сая тасалбараас 4.5 саяыг нь хэдийн борлуулаад байжээ. Олимпийн наадмыг хойшлуулсан нь тасалбарт хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна.<sup>125</sup>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

<sup>123</sup> <https://www.japantimes.co.jp/news/2020/03/10/national/politics-diplomacy/cabinet-bill-shinzo-abe-state-of-emergency-coronavirus/#.Xmr4RaeB1uU>

<sup>124</sup> <https://www.japantimes.co.jp/news/2020/03/12/national/japan-third-measures-coronavirus/#.Xmr2BaeB1uV>

<sup>125</sup> <https://news.mn/r/2278723/>

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч, Р.Нургүл*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ОРШИЛ

СУДАЛГААНЫ ТОЙМ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

*Гадаадын зарим орны мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зарим зохицуулалт*

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
2. Бүгд Найрамдах Казахстан Улс
3. Бүгд Найрамдах Эстони Улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



## СУДАЛГААНЫ ОРШИЛ

Дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хууль нь хоорондоо төстэй байх нь түгээмэл байдаг талаар “Freedom of Information Around the World 2006” материалд тэмдэглэжээ. Энэ нь хуулиа батлан гаргаж буй орнууд хуультай орны туршлагыг загвар болгон ашиглаж байгаатай холбоотой юм. Тухайлбал, үүнд Америкийн хууль ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн Канад, Австралийн холбооны болон муж улсын хуулийн загвар Английн уламжлал бүхий орнуудад түгээмэл хэрэглэгдэж байна<sup>126</sup>.

Дээрх материалд дурдсанаар дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд дараах нийтлэг зохицуулалтын талаар тусгасан байна.

### ***Мэдээлэл авах эрхийг хангах байгууллагууд /Types of bodies covered/<sup>127</sup>***

Мэдээлэл авах эрхийн тухай хууль нь голдуу төрийн хүнд суртал бүхий гүйцэтгэх болон захиргааны байгууллагууд болох үндэсний хэмжээний эрүүл мэнд, байгаль орчин, хууль сахиулах, цэргийн, харилцаа холбоо, тээврийн чиг үүргийн яам, агентлагууд, тэдгээрийн харьяа орон нутгийн байгууллагуудтай харилцах харилцааг зохицуулахад чиглэсэн байдаг. Цөөн тохиолдолд хууль тогтоох болон шүүх байгууллагатай харилцах харилцааг зохицуулж болно.

Хуульд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн болон бусад байгууллагыг тодорхой зааж өгөх нь чухал бөгөөд энэ нь хамгийн сайн туршлагад орно. Тухайлбал, Ирланд зэрэг зарим орон хуульдаа холбогдох байгууллагуудын нэрийг тодорхой (positive list of bodies) заасан байдаг. Ингэснээр хамааралтай болон хамааралгүй байгууллагуудыг ойлгоход илүү хялбар болох юм. Гэвч байгууллагыг үүсгэн байгуулах, нэр өөрчлөгдөх, бүтцийн өөрчлөлт хийгдэх болгонд парламентаар, эсхүл ямар нэг зохицуулалтаар уг жагсаалтыг шинэчлэн батлах шаардлага гарах бөгөөд үүнд ихээхэн цаг хугацаа зарцуулах болно. Түүнчлэн Засгийн газар шинэ байгууллагыг нэмэхээс татгалзах тохиолдолд асуудлыг илүү хүндрэлтэй болгоно. Тухайлбал, Ирландад цагдаагийн байгууллага хамааралгүй байна. Канадад хувьчлагдсан болон шинээр байгуулагдсан байгууллагын мэдээллийг авах нь ихээхэн маргаантай байдаг.

Зарим улс орнууд нууц мэдээлэл эзэмших тусгай байгууллагыг оруулдаггүй. Жишээлбэл, Их Британи, Энэтхэгт аюулгүй байдлын болон тагнуулын алба нь ордоггүй.

Энэ нь тухайн байгууллагын бүх үйл ажиллагааг хаалттай болгох ба ингэснээр авлигаас урьдчилан сэргийлэх, албан тушаалаа урвуулан ашиглах, тухайн байгууллагын мэдэлд буй байгаль орчинд учрах аюулын талаарх мэдээлэл зэрэг зайлшгүй хянах механизмыг байхгүй болгоно. Түүнчлэн бусад олон мэдээллийг хаалттай болгох юм.

Тиймээс үүнийг шийдэх сайн арга нь тухайн байгууллагыг хуулийн хүрээнд

<sup>126</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 20  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

<sup>127</sup> мөн тэнд

хамруулж нууцлах шаардлагатай мэдээллийн хувьд хамгаалах баталгаагаар хангах явдал юм.

Холбооны улсуудын хувьд холбооны хуулиас гадна муж улс бүр нь тус тусдаа хуультай байдаг. Эдгээр хуулиуд нь холбооны хуулиас өмнө батлагдсан байх бөгөөд дэвшилтэт заалтуудыг хожим холбооны хуульд тусгасан байна. Тухайлбал, Америкт бүх муж улс нь тус тусын нээлттэй засгийн газрын хуулийг баталсан бөгөөд тэдгээрийн зарим нь холбооны хууль батлагдахаас олон жилийн өмнө буюу 19-р зууны сүүл, 20-р зууны эхэн үед батлагджээ.

Ихэнх улс оронд хувийн хэвшлийн эзэмшиж буй мэдээллийн авах эрх нь хязгаарлагдмал байх бөгөөд зарим орны хуульд ийм мэдээллийг хэрхэн авч болох талаар зохицуулжээ. Тухайлбал, Өмнөд Африкийн Мэдээлэл авах эрхийг хангах тухай хууль нь хувь хүн болон төрийн байгууллагад шаардлагатай бол хувийн хэвшлийн мэдээллийг албадан авах болон бусад аргаар авч болох талаар зохицуулсан байна. Мөн зохицуулалтыг Антигуа болон Барбудагийн Мэдээлэл авах эрхийн тухай хуульд тусгажээ.

### **Авах боломжтой мэдээлэл /What is Accessible/<sup>128</sup>**

Улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд хувь хүн ямар мэдээллийг авах эрхтэй байх талаар янз бүрээр тодорхойлсон байдаг. Хуулиа эрт баталсан орнуудын хувьд бичлэг (records), албан ёсны бичиг баримт, файлд хандах эрх гэсэн бол хуулиа шинээр баталсан орнууд голдуу мэдээлэл авах эрх гэж тодорхойлсон байна. Практикт эдгээр тодорхойлолтын хувьд бараг ялгаа байхгүй.

Ихэнх орны хуульд хадгалсан арга хэрэгслээс үл хамааран бүх мэдээллийг авах эрхтэй байх талаар түгээмэл тодорхойлсон. Швед зэрэг зарим оронд боловсруулалтын шатанд буй бичиг баримтыг албан ёсны бичиг баримтад хамруулахгүй, мөн баримт бичгийн төслийг эцсийн шийдвэр гаргахад хэрэглэдэггүй. Энэ нь мэдээллийн өргөн хүрээг хуулийн хамрах хүрээний гадуур үлдээх юм.

Энэтхэгийн Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар хувь хүн хоол хүнсийг амсаж үзэх, зам тавьж буй материалын дээжийг үзэх эрхийг олгосон байна.

Мэдээлэл авах эрх нь зөвхөн бичгэн мэдээлэлд хамааралтай байх талтай. Энэ нь шийдвэр гаргахад аман мэдээлэл (тухайлбал, хуралд хэлсэн үг) шаардлагатай тохиолдолд учир дутагдалтай байдаг. Үүнийг шийдэх сайн арга нь бүх төрлийн мэдээллийг авах боломжийг шаардах явдал юм. Тухайлбал, Дани Улсад шийдвэр гаргахад чухал шаардлагатай аман мэдээллийг хүлээн авсан байгууллага нь тэмдэглэх үүрэгтэй байна.

### **Мэдээлэл авах эрхийг эдлэх этгээд /Who can ask/<sup>129</sup>**

Ихэнх улс орнууд хууль ёсны ашиг сонирхол, иргэний харьяалал, оршин суугаа газраас үл хамааран хүн бүрт мэдээлэл авах боломжийг олгоно. Финланд зэрэг

<sup>128</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Bainsar, page 22

[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

<sup>129</sup> мөн тэнд

зарим улсад хүсэлт гаргагчийг ялгаварлан гадуурхахгүй байхын тулд эзэн тодорхойгүй хүсэлт гаргахыг зөвшөөрдөг.

### ***Хязгаарлагдмал мэдээллийг чөлөөлөх /Exemptions/<sup>130</sup>***

Улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд зарим мэдээллийг авах эрх хязгаарлагдмал байх нь нийтлэг байдаг. Үүнд үндэсний аюулгүй байдал, олон улсын харилцаа, хувийн нууц, худалдааны нууцлал, эрх зүйн албадлага болон нийгмийн хэв журам, нууцын мэдээлэл, дотоод хэлэлцүүлэг зэрэг орно. Ихэнх Парламентын засаглалтай улсуудад Засгийн газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн бичиг баримтууд болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг тодорхой хугацаагаар авах эрхийг хязгаарладаг. Тухайлбал, Ирланд Улсад энэ нь арван жил байна. Харин Шинэ Зеландад Засгийн газрын баримт бичгийг хүсэлтийн дагуу цаг алдалгүй гаргаж өгдөг.

Ихэнх орны хуульд мэдээллийг, эсхүл түүний зарим хэсгийг нууцад оруулахын өмнө хор хохирлыг тогтоох талаар заасан. Хохирлын тест нь хамгаалагдах мэдээллийн төрлөөс хамааран өөр өөр байна. Хувийн нууц, дотоод шийдвэр, үндэсний аюулгүй байдлыг хамгийн өндөр түвшинд хамгаалах шаардлагатай байдаг.

Зарим орны хуульд "олон нийтийн ашиг сонирхлын тест" хэмээх ойлголтыг оруулсан байдаг. Энэ нь төрийн байгууллага болон хяналтын байгууллагад олон нийтэд ил болгох ашиг сонирхол болон мэдээлэл авах эрхийг хязгаарлах ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх үүрэг хүлээлгэнэ. Уг зохицуулалт нь мэдээллийг олон нийтэд ил болгох ашиг сонирхлын ач холбогдол нь ийнхүү ил болгосноор учируулах хор хохирлоос илүү тохиолдолд хор хохирол байгаа ч мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийг олгоно. Үүнийг ихэвчлэн зөрчил, авлига, түүнчлэн хувь хүн, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл түгээхэд ашигладаг. Зарим улсад үүнийг олон нийтэд чухал хамааралтай аливаа хэрэгцээний улмаас мэдээллийн хязгаарлалтыг чөлөөлөхөд хэрэглэнэ.

Ихэнх орны хуульд хохирлын түвшин нь буурсан тохиолдолд мэдээллийг ил болгох талаар зохицуулсан байна. Зарим орны хуульд тодорхой хугацааны хязгаарлалт тавьдаг. Тухайлбал, Мексикт Холбооны ил тод байдлын тухай хуульд энэ хугацааг арван хоёр жил байхаар заасан байна.

### ***Хүлээлгэх хариуцлага /Sanctions/<sup>131</sup>***

Бараг бүх улс орон мэдээлэл авах эрхийн тухай хуульдаа төрийн байгууллага, ажилтан хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар заасан байдаг.

Үүнд байгууллага эсхүл, ажилтан мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзах, баримт бичгийг өөрчлөх, устгах тохиолдлууд орно. Тухайн байгууллагад эсхүл, тухайн

<sup>130</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 22  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

<sup>131</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 22-23  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

ажилтанд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно. Ихэнх орны хууль нь ноцтой зөрчилд торгууль ногдуулах түүнчлэн, шоронд хорих заалттай байдаг. Тухайлбал, Польшийн Олон нийтийн мэдээллийг авах эрхийн тухай хуульд торгох, эрх чөлөөг нь хязгаарлах эсхүл, нэг жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл хүлээлгэхээр заасан.

### ***Мэдээллийг цахимаар авах боломж /E-FOI/***

Мэдээлэл авах эрхийг хангах бас нэг хэлбэр нь цахим системийг ашиглах явдал юм.

Ихэнх улс орнууд мэдээлэл авах эрхийн тухай хуулиар засгийн газрын байгууллагуудад цахим хуудсандаа тодорхой төрлийн мэдээллийг тогтмол гаргах үүргийг хүлээлгэсэн. Польшийн Олон нийтийн мэдээллийг авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагууд өөрсдийн бодлого, хууль эрх зүйн зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, захиргааны акт болон шийдвэрийн агуулга, төрийн өмчийн талаарх нарийвчилсан мэдээллийг цахим хуудсаараа олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Эстоний Олон нийтийн мэдээллийн тухай хуулийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, бусад олон нийтийн мэдээллийг эзэмшигчид цахим хуудас хөтлөх үүрэгтэй бөгөөд гэмт хэрэг, эдийн засгийн статистик зэрэг өргөн хүрээний мэдээллийн жагсаалтыг байрлуулах; байгууллагын статус болон бүтцийн нэгжийн талаар; ажилтны ажил үүргийн тодорхойлолт, тэдгээрийн хаяг, мэргэшил, цалингийн хэмжээ; эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл; төсөв, төсвийн төсөл; хүрээлэн буй орчны төлөв байдлын талаарх мэдээлэл; хуулийн төсөл, зохицуулалт, төлөвлөгөө зэрэг мэдээллийг цахим хуудсандаа байрлуулах үүрэгтэй. Мөн эдгээр мэдээллийг "хуучирсан, алдаатай, худал" биш гэдгийг баталгаажуулах шаардлагыг тавьдаг.

Европын холбооны зөвлөл нь мэдээлэл авах эрхийн талаарх журмын дагуу ихэнх баримт бичгээ цахим хэлбэрээр олгох боломжийг бүрдүүлсэн байна.

Ер нь хүсэлт гаргагч цахим шуудан эсхүл, цахим хуудсанд суурилсан маягтыг ашиглан мэдээлэл авах боломжтой. Тухайлбал, Турк Улсад гол яамдууд иргэдэд цахим сүлжээ ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд хэрэглэгчийн онлайнаар гаргасан хүсэлтийг идэвхтэй дэмжиж ажилладаг.

### ***Affirmative Publication<sup>132</sup> буюу Proactive disclosure<sup>133</sup>***

Ихэнх улс орны хуульд засгийн газрын байгууллагуудад зарим төрлийн мэдээллээ тогтмол гаргах үүрэг хүлээлгэсэн нь нийтлэг зохицуулалтын нэг юм. Үүнд засгийн газрын бүтэц, үндсэн албан тушаалтнуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хууль тогтоомжийн баримт бичиг, бодлого, төлөвлөгөө, маягт, шийдвэр зэрэг орно. Сүүлд хуулиа баталсан орнуудын хувьд зарим төрлийн хориглосон мэдээллийн жагсаалтыг гаргаж өгөх хандлагатай байна.

<sup>132</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 25  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

<sup>133</sup> Мөн тэнд

Мэдээллээр идэвхтэй хангах нь төрийн байгууллагуудад ч ашигтай бөгөөд зарим энгийн хүсэлтэд хариу өгөх ажлыг хөнгөвчлөх тул байгууллагын ачааллыг бууруулах юм. Тухайлбал, Европын холбооны зөвлөлийн 2003 оны жилийн тайланд хүмүүс шууд авах боломжтой баримт бичгийн тоо нэмэгдэхийн хэрээр хүсэлт гаргасан баримт бичгийн тоо буурсан талаар тэмдэглэжээ.

### ***Шүгэл үлээхүй / Whistleblowing*<sup>134</sup>**

Зарим улс оронд мэдээлэл авах эрхийн тухай хуулиар шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг зохицуулсан. Тухайлбал, Шведийн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль нь төрийн албан хаагчид төрийн байгууллагын үйл ажиллагааг нэрээ нууцлан шүүмжлэх үндсэн эрхийг олгосон байна.

## **СУДАЛГААНЫ ТОЙМ**

Энэхүү судалгаанд Казахстан, Эстони, Герман зэрэг улсуудын туршлагыг судлав. Судалгаанд захиалагчаас ирүүлсэн захиалгын дагуу эдгээр улсуудын ижил төрлийн хуулийг авч үзсэн бөгөөд тухайн хуулийн зохицуулах харилцаа, бүтэц, хамрах хүрээ, хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар судалсан болно.

Дээрх улсуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

### ***Хуулийн зохицуулах харилцаа.***

Судалгаанд хамрагдсан улсууд нь хуулийн зохицуулах харилцааг доорх байдлаар тодорхойлсон байна.

**Германы Мэдээллийн эрх чөлөөний хуулиар** иргэн хүнд Холбооны Улсын яам, төрийн байгууллага болон Холбооны Улс (ХУ)-ын бусад байгууллагуудын албан ёсны мэдээлэлд хандах эрх олгож, мэдээлэл авах харилцааг зохицуулдаг.

**Казахстаны Мэдээлэл авах эрхийн тухай хууль** нь хүн бүр хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр мэдээллийг чөлөөтэй авах, түгээх зэрэг Үндсэн хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох харилцааг зохицуулна.

**Эстоний Олон нийтийн мэдээллийн тухай хуулийн** (*Public Information Act*<sup>1</sup>) зорилго нь олон нийт, хүн бүр ардчилсан нийгмийн засаглал болон нээлттэй нийгмийн зарчимд суурилсан олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах, нээлттэй байх боломжийг хангах, түүнчлэн, мэдээллээр хангах үүргийн хэрэгжилтийг хянах боломж бүрдүүлэхэд оршино.

### ***Хамрах хүрээ***

**Герман.** Мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн эцэслэн батлагдсан бичиг баримтад хамаатай. Хувийн болон байгууллагын мэдээлэлд хамааралгүй бөгөөд зөвхөн хүсэлт гаргагчийн мэдээллийн ашиг сонирхол нь тухайн хүний хамгаалах ашиг сонирхлоос хэтийдсэн, эсхүл хувь хүн өөрөө зөвшөөрсөн бол хувийн мэдээлэлд хандах эрх олгоно. Гэхдээ хувийн хэрэг болон хувийн хэргийн систем доторх

<sup>134</sup> Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 25  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)

агуулгад хандаж мэдээлэл авах эрхгүй байна. (*Мэдээллийн эрх чөлөө нь Үндсэн хуульд тусгасан “үгээ хэлэх эрх чөлөөтэй” холбоогүй бөгөөд “мэдээлэлд хандах”, “ил тод байдал”, “акттай танилцах” зэрэг утгаар хэрэглэгдэнэ.*)

**Казахстан.** Тус хууль нь нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авахтай холбогдох харилцааг зохицуулна. Бусад хууль тогтоомжоор зохицуулсан өргөдөл гаргах, хүсэлт хянан үзэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх журам зэрэгт хамааралгүй байна.

**Эстони.** Уг хууль нь мэдээллийг авах, дахин хэрэглэх нөхцөл, журам, арга; мэдээлэл өгөхөөс татгалзах; зарим хязгаарлагдмал мэдээллийг авах журам; мэдээллийн санг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах, хянах; мэдээллийн хүртээмж, түүнд төрөөс тавих хяналт зэрэг асуудлыг хамаарна. Нууцын зэрэглэлтэй мэдээлэл, гадаадын мэдээлэл, бусад хуулиар зохицуулагдсан зарим архивын мэдээ баримт болон олон улсын гэрээ, эсхүл тусгай хуульд зохицуулсан мэдээлэлд хамааралгүй болно.

#### Хариуцлага

**Герман** Улс нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд мэдээллийн аюулгүй байдлын талаарх гол зохицуулалтаа тусгасан бөгөөд хариуцлагын талаар Эрүүгийн хуульд зохицуулжээ.

**Казахстан** Улсын хувьд мэдээлэл авах эрхийг хууль бусаар зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Захиргааны зөрчлийн тухай хуульд тусгасан бөгөөд мөнгөн торгууль хүлээлгэхээр заасан байна.

**Эстони** Улс нь Олон нийтийн мэдээллийн тухай хуулиараа (*Public Information Act<sup>1</sup>*) хариуцлагын асуудлыг зохицуулсан бөгөөд мөнгөн торгууль хүлээлгэхээр тусгасан. Түүнчлэн хууль зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль болон Жижиг гэмт хэргийг хянан шийдвэрлэх хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

(*Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү.*)





## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ

#### 1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Зохицуулах харилцаа. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар иргэн хүнд Холбооны Улсын яам, төрийн байгууллага болон Холбооны Улс (ХУ)-ын бусад байгууллагуудын албан ёсны мэдээлэлд хандах эрх олгож, мэдээлэл авахыг нь зохицуулдаг. Ингэхдээ эрх зүй, эдийн засаг, аж ахуй, эсхүл өөр ямар ч байдалтай байсан ашиг сонирхлоо илэрхийлэх, нотлох албагүй.

Захиргааны процессын тухай хуульд зааснаар ХУ-ын яам, төрийн байгууллага нь хувийн хэвшлийн хуулийн этгээд буюу бие хүнд үйлчлэх үүргийн дагуу хүссэн мэдээллийг нь хувийн хэвшлийн этгээдэд гаргаж өгснөөр мэдээлэл өгөх үүргээ хэрэгжүүлж, хандах эрхийг хангадаг.

“Мэдээллийн эрх чөлөө” гэдэг ойлголт нь өргөн хүрээтэй, олон салаа утгатай учир буруу ойлгогдох эрсдэлтэй аж. Мэдээллийн эрх чөлөө нь Үндсэн хуульд тусгагдсан “Үгээ хэлэх эрх чөлөө”-тэй огт холбоогүй юм. Тиймээс “Мэдээлэлд хандах”, “Ил тод байдал” (Хамбург муж улс), эсхүл “Акттай танилцах” (Бранденбург муж улс) хэмээх ойлголтууд илүү оновчтой ажээ.

Мэдээллийг цаашид хэрхэн ашиглах асуудлыг энэ хуулиар бус харин Мэдээллийг цаашид ашиглах тухай хуулиар зохицуулж байна.

Хамрах хүрээ. Холбооны Улсын Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль<sup>135</sup> 2006 оны 1-р сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэхээс өмнө Холбооны Улсын хэмжээнд иргэн нь төрийн байгууллагын акттай танилцах эрхгүй байсан. Энэ хооронд ХБНГУ-ын 13 муж улс өөрийн эрх мэдлийн хүрээнд тусдаа Муж Улсын мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, мөрдүүлээд байна.

Бавари, Нидерзаксен болон Заксен гэсэн гурван муж улсууд ийм тусгайлсан хуульгүй аж.

Харин Хамбург, Бремен, Райнланд-Пфалц муж улсад мэдээлэл авах хүсэлт гаргахаас гадна мэдээлэлжүүлэх үүрэг бүхий байгууллагууд мэдээллийг идэвхтэй хэвлэн нийтлэж байхаар зохицуулсан Ил тод байдлын тухай хуультай ажээ.

Уг хуульд мэдээлэлд хандах эрхийг хязгаарлагдмал хангах, эсхүл бүр мөсөн гаргаж өгөхгүй байх олон хориглох заалтууд тусгагдсан байна.

Мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн эцэслэн батлагдсан бичиг баримтад хамаатай бөгөөд төлөвлөлтийн шатанд яваад хандах эрхийг олгохгүй.

Мэдээллийн эрх чөлөөнд цаашлаад хувийн болон байгууллагын мэдээлэл багтахгүй. Хүсэлт гаргагчийн мэдээллийн ашиг сонирхол нь тухайн хүний хамгаалах ашиг сонирхлоос хэтийдсэн, эсхүл хувь хүн өөрөө зөвшөөрсөн бол

<sup>135</sup> Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (герман)-Informationsfreiheitsgesetz  
<https://de.wikipedia.org/wiki/Informationsfreiheitsgesetz>



хувийн мэдээлэлд хандах эрх олгоно. Гэхдээ хувийн хэрэг болон хувийн хэргийн систем доторх агуулгад хандаж мэдээлэл авах эрхгүй. Нэр болон ажилтны албан байгууллагын хаягийн тухай мэдээлэлд хандах эрхийг үндсэндээ хангана. Энэ нь мэргэжлийн шинжээчийн мэдээлэлд мөн хамаарна.

Холбооны Улсын Мэдээний болон Үндсэн хуулийг хамгаалах албанд салбарын түвшинд хорио тогтоосон аж. Эдгээр нь Холбооны Улсын сангийн яамандаа мэдээлэл өгөх үүрэг багатай ч 2013 онд ХУ-ын нэгдсэн төсвийн журамд оруулсан өөрчлөлтөөр тухайн салбарыг уг хуулийн хамрагдах хүрээнээс гаргажээ.

Бундестаг нь Германы Бундестагийн Судалгааны албаны боловсруулсан ажлуудыг нийтлэхийг олон жил цааргалсны эцэст 2015 онд ХУ-ын Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарч, 2016 оны 2-р сарын 18-ны өдрөөс хойш захиалгын дагуу боловсруулсан бүх мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг Бундестагийн веб хуудаст нийтэлдэг болсон байна.

Хуулийн бүтэц. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (“Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль”) <sup>136</sup> нь доорх зүйл заалтаас бүрдэнэ. Үүнд:

1. Ерөнхий зүйл
2. Нэр томьёо, ойлголтын тодорхойлолт
3. Нийтийн тусгай зүйлийг хамгаалах
4. Төрийн байгууллагын шийдвэр гаргах процессыг хамгаалах
5. Хувь хүнтэй холбоотой өгөгдлийг хамгаалах
6. Оюуны өмч болон байгууллага, аж ахуйн нэгжийн нууцыг хамгаалах
7. Хүсэлт гаргах ба процесс
8. Гуравдагч этгээдийн оролцооны процесс
9. Хүсэлтийг татгалзах; Шүүх
10. Хураамж, төлбөр
11. Хэвлэн нийтлэх үүрэг
12. Мэдээллийн эрх чөлөөний Холбооны Улсын Төлөөлөгч
13. (Гарчиггүй)
14. Тайлан, үнэлгээ
15. Хүчин төгөлдөр болох

Процесс. Төрийн байгууллага нь ерөнхийдөө зөвхөн хүсэлтийг үндэслэн мэдээллээр хангах боломж олгоно. Ингэхдээ “даруйхан” мэдээлэл өгөх, акттай танилцах боломж олгох, эсхүл “бусад байдлаар”, жишээлбэл, ярианы бичлэг сонсгох буюу мэдээллийн санд хайлт хийлгүүлнэ. Хүсэлт нь хэвшмэл загваргүй бичгээр үйлдсэн байх, эсхүл амаар буюу телефон утсаар байж болно. Төрийн байгууллага нь 500 евро хүртэлх хэмжээний төлбөр, хураамж авч болно. Хүсэлтийг гүйцэтгэхэд Захиргааны хэргийн процессын тухай хуульд заасан журмыг мөрдөнө. Хүсэлтийг татгалзах нь захиргааны акт бөгөөд шүүхэд давж заалдах боломжтой.

Байгууллагын нууц үгүй болсноор, гуравдагч этгээдэд мэдээлэл өгөхийг нийтлэг

<sup>136</sup> Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль (Мэдээллийн эрх чөлөөний хууль)- Gesetz zur Regelung des Zugangs zu Informationen des Bundes <https://www.gesetze-im-internet.de/ifg/>

байдлаар хориглох боломжгүй болдог. Иймд төрийн байгууллагууд тохиолдол бүр дээр гуравдагч этгээдийн хамгаалах үнэ цэнэ, дээд түвшний ашиг сонирхол зэргийг сайтар нягталж шалгасны эцэст мэдээлэл гаргаж өгөх хэрэгтэй болж байна.

Хүлээлгэх хариуцлага. ХБНГУ-д Мэдээллийн эрх чөлөөний хуулиар мэдээллийн аюулгүй байдлын гол зохицуулалтаа хийгээд “хариуцлага”-ын талаар Эрүүгийн хуульдаа тусгасан нь дэвшилттэй буюу мэдээлэл аль болох нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй болсныг судлаачид тэмдэглэдэг.<sup>137</sup>

## 2. Бүгд Найрамдах Казахстан улс

Тус улсад мэдээлэл авах эрхийн талаарх асуудлыг Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар (*О доступе к информации*) зохицуулдаг.

Зохицуулах харилцаа. Энэ хууль нь хүн бүр хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр мэдээллийг чөлөөтэй авах, түгээх зэрэг Үндсэн хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох харилцааг зохицуулна<sup>138</sup>.

Хуулийн бүтэц. Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*) нь 21 зүйлтэй байна. Үүнд:

- 1 дүгээр зүйл. Үндсэн ойлголт
- 2 дугаар зүйл. Мэдээлэл авах талаарх Казахстан улсын хууль тогтоомжууд
- 3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ
- 4 дүгээр зүйл. Мэдээлэл авах эрхийг хангах үндсэн зарчим
- 5 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хязгаарлах
- 6 дугаар зүйл. Авах эрхийг хязгаарлаагүй мэдээлэл
- 7 дугаар зүйл. Мэдээлэл ашиглагчийн эрх, үүрэг
- 8 дугаар зүйл. Мэдээлэл эзэмшигч
- 9 дүгээр зүйл. Мэдээлэл эзэмшигчийн эрх, үүрэг
- 10 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хангах арга замууд
- 11 дүгээр зүйл. Хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх
- 12 дугаар зүйл. Мэдээлэл эзэмшигч нь байрлаж буй байрандаа мэдээллийг хэрхэн байршуулах тухай
- 13 дугаар зүйл. Төрийн байгууллага болон тэдгээрийн харьяа байгууллагуудын хуралдааны талаарх мэдээллийг авах эрхээр хангах
- 14 дүгээр зүйл. Төв гүйцэтгэх байгууллагын удирдлага, Засаг дарга, үндэсний дээд боловсролын байгууллагын дарга нарын тайлан
- 15 дугаар зүйл. Мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх
- 16 дугаар зүйл. Интернетийн орчинд мэдээлэл байршуулах
- 17 дугаар зүйл. Мэдээллийг "Цахим засгийн газар" цахим хуудсанд байршуулах
- 18 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хууль бусаар хязгаарласан талаар гомдол гаргах
- 19 дүгээр зүйл. Мэдээлэл авах асуудлыг хариуцах комиссын тухай
- 20 дугаар зүйл. Мэдээлэл авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд

<sup>137</sup> Ч.Базар 2011

<sup>138</sup> Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*), <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

хүлээлгэх хариуцлага

21 дүгээр зүйл. Хуулийг хэрэгжүүлэх журам зэрэг болно.

Хамрах хүрээ<sup>139</sup>. Энэ хууль Казахстан Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авахтай холбогдох харилцааг зохицуулна. Захиргааны хэргийн тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасан хувь хүн болон хуулийн этгээдийн гаргасан өргөдөлд хамааралгүй. Мөн Үндэсний архивын сан болон архивын тухай хуульд заасан хүсэлт хянан үзэх талаарх журамд хамааралгүй болно. Түүнчлэн, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуульд тусгасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх журамд хамааралгүй байна.

Хүлээлгэх хариуцлага<sup>140</sup>. Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчвөл Казахстан улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Мэдээлэл авах эрхийг хууль бусаар хязгаарлах тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Захиргааны зөрчлийн тухай хуульд (Об административных правонарушениях) зохицуулсан байна<sup>141</sup>. Үүнд:

1. Мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзах, санаатай буруу мэдээлэл өгөх тохиолдолд албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 30, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 50, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 100 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
2. Интернетийн орчин, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр худал, буруу мэдээлэл түгээх тохиолдолд албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 30, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 50, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 100 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
3. Авах эрхийг хязгаарлаагүй мэдээллийг хязгаарласан мэдээллийн ангилалд оруулах тохиолдолд албан тушаалтанд 20 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
4. 1 болон 3-т заасан тохиолдлыг захиргааны хариуцлага хүлээлгэснээс хойш 1 жилийн дотор давтан үйлдвэл албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 50, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 100, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 300 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.

*Жич: торгуулийн нэгж (месячный расчетный показатель) нь 2020 оны байдлаар 2525-2651 тенгетэй тэнцүү байна*<sup>142</sup>. Тенге нь Казахстан улсын мөнгөн тэмдэгт болно.

<sup>139</sup> Мэдээлэл авах эрхийн тухай хууль (О доступе к информации), 3 дугаар зүйл, <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

<sup>140</sup> Мэдээлэл авах эрхийн тухай хууль (О доступе к информации), 20 дугаар зүйл <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

<sup>141</sup> Захиргааны зөрчлийн тухай хууль (Об административных правонарушениях), 456-1 дүгээр зүйл <http://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235>

<sup>142</sup> [https://finance.kz/articles/2020\\_zhyl\\_aylyq\\_eseptik\\_korsetkish\\_aek\\_pen\\_en\\_tomengi\\_zhalaqy\\_molsheri\\_etzh-1402](https://finance.kz/articles/2020_zhyl_aylyq_eseptik_korsetkish_aek_pen_en_tomengi_zhalaqy_molsheri_etzh-1402)

### 3. Бүгд Найрамдах Эстони улс

Эстони улсад уг асуудлыг Олон нийтийн мэдээллийн тухай хуулиар (*Public Information Act*<sup>143</sup>) зохицуулж байна.

Зохицуулах харилцаа<sup>143</sup>. Энэхүү хуулийн зорилго нь олон нийт, хүн бүр ардчилсан нийгмийн засаглал болон нээлттэй нийгмийн зарчимд суурилсан олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах, нээлттэй байх боломжийг хангах, түүнчлэн, мэдээллээр хангах үүргийн хэрэгжилтийг хянах боломж бүрдүүлэхэд оршино.

Хуулийн бүтэц. Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*<sup>143</sup>) нь дараах бүлгүүдтэй байна. Үүнд:

- 1 дүгээр бүлэг. Ерөнхий зүйл
- 2 дугаар бүлэг. Мэдээлэл авах эрх бүхий байгууллагууд
- 3 дугаар бүлэг. Хүсэлтийн дагуу мэдээлэл авах зөвшөөрөл олгох
- 4 дүгээр бүлэг. Мэдээллийг тодруулах
- 5 дугаар бүлэг. Хязгаарлагдмал мэдээлэл
- 5<sup>1</sup> дугаар бүлэг. Мэдээллийн сан
- 6 дугаар бүлэг. Хяналт
- 6<sup>1</sup> дугаар бүлэг. Хүлээх хариуцлага
- 7 дугаар бүлэг. Хэрэгжүүлэх нөхцөл зэрэг болно.

Хамрах хүрээ<sup>144</sup>. Энэ хууль нь дараах асуудлыг хамаарна. Үүнд:

- мэдээлэл авах болон мэдээллийг дахин хэрэглэх нөхцөл, журам, арга, түүнчлэн, мэдээлэл өгөхөөс татгалзах үндэслэл;
- ашиглах эрх нь бусад хууль тогтоомжид зохицуулагдаагүй хязгаарлагдмал мэдээллийг авах эрх олгох журам;
- мэдээллийн сан бүрдүүлэх, удирдах үндэслэл, мэдээллийн сангийн удирдлагын хяналт;
- мэдээллийн хүртээмжийг зохион байгуулахад төрийн хяналт тавих журам зэрэг болно.

Хуульд дараах асуудлууд хамааралгүй байна. Үүнд:

- нууцад хамаарах хугацаа дуусаагүй төрийн нууцын зэрэглэлтэй эсхүл, гадаадын мэдээлэл;
- Архивын тухай хуульд заасан журмын дагуу хэрэглэгдэх Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны архивын мэдээ, баримтууд (авах эрхийг хязгаарласнаас бусад);
- Санамж бичгийн хариу болон тайбар хүсэх тухай хуульд (*Response to Memoranda and Requests for Explanations Act*) заасан журмын дагуу хариу өгөхдөө бүртгэгдсэн мэдээллийг судалж дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл цуглуулах, баримтжуулах шаардлагатай тохиолдол;
- мэдээлэл авах журам, арга хэлбэр нь олон улсын гэрээ, эсхүл тусгай хуульд өөрөөр зохицуулагдсан хязгаарлагдмал мэдээлэл болон тусгай нөхцөл бүхий мэдээлэл зэрэг орно.

<sup>143</sup> Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*<sup>1</sup>), 1 дүгээр бүлэг, 1 дүгээр зүйл  
<https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

<sup>144</sup> Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*<sup>1</sup>), 1 дүгээр бүлэг, 2 дугаар зүйл,  
<https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

Түүнчлэн энэ хуультай холбоотой захиргааны хэрэгт холбогдох асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

Хүлээлгэх хариуцлага<sup>145</sup>. Хуульд зааснаар олон нийтэд буруу мэдээлэл түгээх, дотоод хэрэгцээнд зориулагдсан мэдээллийг задруулах эсхүл, Мэдээлэл хамгаалах газрын (*Data Protection Inspectorate*) дүрэм, зааврыг дагаж мөрдөөгүй бол 300 хүртлэх нэгжтэй тэнцэх мөнгөн торгуулиар торгох шийтгэл хүлээлгэнэ.

Мөн хууль зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн (*Penal Code*) Ерөнхий хэсэг болон Жижиг гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн (*Code of Misdemeanour Procedure*) дагуу хариуцлага хүлээлгэнэ.



---

<sup>145</sup> Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*<sup>1</sup>), 6<sup>1</sup> дугаар бүлэг, 54<sup>1</sup> дүгээр зүйл, <https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*<sup>1</sup>)  
<https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>
- Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*)  
<http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>
- Захиргааны зөрчлийн тухай хууль (*Об административных правонарушениях*), <http://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235>
- Төрийн өмчийн тухай хууль (*О государственном имуществе*), 1 дүгээр зүйл  
<http://adilet.zan.kz/rus/docs/Z110000041>
- Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль  
(Мэдээллийн эрх чөлөөний хууль) - Gesetz zur Regelung des Zugangs zu  
Informationen des Bundes <https://www.gesetze-im-internet.de/ifg/>
- Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to  
Government Information Laws, David Banisar  
[https://www.researchgate.net/publication/228245794\\_Freedom\\_of\\_Information\\_Around\\_the\\_World\\_2006\\_A\\_Global\\_Survey\\_of\\_Access\\_to\\_Government\\_Information\\_Laws](https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws)



# 3 БҮЛЭГ

---

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨРИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

(Харьцуулсан судалгаа)

Р.Оргилмаа, Д.Халиун

## **Нэг. Гадаадын зарим орны үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үндсэн чиг үүрэг**

Энэхүү лавлагаанд гадаадын 20 улс орны Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын голлох чиг үүрэг болон харьяалах субъектийн талаар авч үзэв.

Тус байгууллагын чиг үүргийн хувьд газарзүйн байршил, түүх, Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал зэргээс шалтгаалаад улс орон бүрт харилцан адилгүй байх хэдий ч лавлагаанд хамрагдсан улс орнуудын хувьд голлох чиг үүрэг нь нийтлэг байна.

Эдгээр байгууллага нь ихэвчлэн Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын харьяанд, цөөн тохиолдолд засгийн газрын бие даасан агентлаг хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

Дэлхийн улс орнуудын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн голлох чиг үүрэг:

- Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг хэлэлцэн, болзошгүй нөхцөл байдлыг дүгнэж, авах арга хэмжээг эрэмбэлэх;
- Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдад үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын талаар шаардлагатай асуудлаар зөвлөгөө өгөх, зөвлөхийн үүрэг гүйцэтгэх;
- Үндэсний аюулгүй байдлын асуудлаар бодлого боловсруулах, эсхүл бодлого боловсруулах үйл явцад санал, зөвлөмж гаргах;
- Үндэсний аюулгүй байдлын асуудлыг хамаарсан яамдын үйл ажиллагааг нэгтгэн зангидах, зохицуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих зэрэг болно.

### *Хүснэгт 1. Зарим улс орнуудын ҮАБЗ-ийг харьяалах субъект*

Д/д	Харьяалах субъект	Улсын нэр
1.	Ерөнхийлөгч	АНУ, Бразил, Гүрж, Иран, Кени, Сьерра-Леон, Өмнөд Африк, Серб, Франц, Эстони;
2.	Ерөнхий сайд	Австрали, Армени, Бангладеш, Израил, Их Британи, Словени, Тринидад-Тобаго;
3.	Засгийн газрын бие даасан агентлаг	Чех, Энэтхэг;
4.	Бусад	Канад <sup>146</sup> - Аюулгүй байдлын тодорхой асуудлыг хамаарсан

<sup>146</sup> Governance. Unlike the other four nations discussed above, Canada has multiple Cabinet committees responsible for various aspects of national security:

- The Cabinet Committee on Intelligence & Emergency Management is the only one chaired by the Prime Minister. Its vice-chair is the Minister of Justice and Attorney General, and the members are the Ministers of: Global Affairs; Public Services and Procurement; Public Safety and Emergency Preparedness; Fisheries, Oceans and the Canadian Coast Guard; Health; and National Defence;

		Засгийн газрын хороодыг Ерөнхий сайд болон салбарын сайд нар тэргүүлнэ.
--	--	---

**Хоёр. Гадаадын зарим орны Үндсэн хуульд аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллага (ҮАБЗ)-тай холбоотой асуудлыг зохицуулсан байдал**

Энэхүү судалгаанд Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагатай холбоотой асуудлыг Үндсэн хуульдаа тусгасан 26 улсыг түүвэрлэн авч судалсан болно. (Хүснэгт 2.)

Судалгаанд хамрагдсан улс орнуудаас Үндсэн хуульдаа Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагыг Ерөнхийлөгч даргална гэж заасан 21 улс, Ерөнхий сайд тэргүүлнэ гэж заасан 3 улс (Армен, Косово, Непал) байна. (Хүснэгт 3.)

Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын тайлагнах процедуртай холбоотой зохицуулалтыг Үндсэн хуульдаа тусгасан 2 улс байгаагаас Кени Улсын холбогдох байгууллага нь жил бүр Парламентад тайлагнах бол Непал Улсын хувьд жил бүрийн тайлангаа Ерөнхийлөгчид хүргүүлж, Сайд нарын Зөвлөлөөр дамжуулан Парламентад танилцуулдаг байна. (Хүснэгт 4.)

Улс орнуудын Үндсэн хуульдаа холбогдох байгууллагын чиг үүргийг хэрхэн тусгасныг авч үзвэл судалгаанд хамрагдсан орнуудаас Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын бие даан болон бусад субьекттэй хамтран хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан 19 улсаас бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг 17 улс, бусад субьекттэй хамтран хэрэгжүүлэх чиг үүргийг 6 улс тусгасан байна. Бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг ерөнхийд нь тоймловол:

- Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдад үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын талаар шаардлагатай асуудлаар зөвлөгөө өгөх, зөвлөхийн үүрэг гүйцэтгэх;
- Үндэсний аюулгүй байдлын асуудлаар бодлого боловсруулах, эсхүл бодлого боловсруулах үйл явцад санал, зөвлөмж гаргах;
32.	<b>Kosovo 2008 (rev. 2016)</b>	<p><b>62. Chapter V &gt; Article 84</b></p> <p>The President of the Republic of Kosovo:</p> <p><b>23</b> may request meetings of the Kosovo Security Council and chairs them during a State of Emergency;</p> <p><b>63. Chapter VI &gt; Article 94</b></p> <p>The Prime Minister has the following competencies:</p> <p><b>5</b> chairs the Kosovo Security Council;</p> <p><b>64. Chapter XI &gt; Article 127</b></p> <p>Kosovo Security Council</p> <p>The Security Council of the Republic of Kosovo in cooperation with the President of the Republic of Kosovo and the Government develops the security strategy for the Republic of Kosovo. The Security Council of the Republic of Kosovo shall also have an advisory role on all matters relating to security in the Republic of Kosovo.</p> <p>Emergency provisions</p> <p>The Security Council of the Republic of Kosovo shall be chaired by the Prime Minister with the support of the Government, except during a State of Emergency as provided by this Constitution.</p> <p>The President of the Republic of Kosovo may require meetings of the Security Council of the Republic of Kosovo and the Council is obliged to closely coordinate its work with the President. The Security Council of the Republic of Kosovo shall closely cooperate with international authorities.</p> <p>Members of the Security Council of the Republic of Kosovo shall be appointed and dismissed in a manner provided for by law.</p> <p><b>65. Chapter XI &gt; Article 131 &gt; 8</b></p> <p>The Security Council of the Republic of Kosovo, only during the State of Emergency, shall exercise executive functions which shall be limited to those functions which specifically relate to the State of Emergency. In a State of Emergency the Security Council of the Republic of Kosovo shall be chaired by the President of the Republic of Kosovo, as provided by law. During the State of Emergency, the Security Council of the Republic of Kosovo shall closely cooperate with the Government, the Assembly and international authorities.</p>

33.	Kyrgyzstan 2010 (rev. 2016)	<b>66. SECTION III &gt; Article 64 &gt; 9</b> 9. The President: 1 shall chair the Security council which is established in accordance with the law;
34.	Lebanon 1926 (rev. 2004)	<b>67. PART II &gt; Chapter Four &gt; First &gt; Article 49</b> The President of the Republic is the Chief of State, and the symbol of the unity of the Homeland. He ensures the respect of the Constitution, and the maintenance of Lebanon's independence, its unity, and its territorial integrity in accordance with the provisions of the Constitution. He chairs the Higher Defence Council. He is the Commander in Chief of the armed forces which are subject to the authority of the Council of Ministers. <b>68. PART II &gt; Chapter Four &gt; Second &gt; Article 64</b> The Prime Minister is the Head of Government. He represents it, speaks in its name, and is responsible for executing the public policy made by the Council of Ministers. He assumes the following powers: 1 He presides over the Council of Ministers. By law, he is Vice President of the Supreme Council of Defense.
35.	Macedonia (Republic of) 1991 (rev. 2011)	<b>69. III &gt; 2 &gt; Article 84</b> The President of the Republic of Macedonia <ul style="list-style-type: none"> <li>[...]</li> <li>appoints three members to the Security Council of the Republic of Macedonia;</li> </ul> <b>70. III &gt; 2 &gt; Article 86</b> The President of the Republic is President of the Security Council of the Republic of Macedonia. The Security Council of the Republic is composed of the President of the Republic, the President of the Assembly, the Prime Minister, the Ministers heading the bodies of state administration in the fields of security, defence and foreign affairs and three members appointed by the President of the Republic. The Council considers issues relating to the security and defence of the Republic and makes policy proposals to the Assembly and the Government. <b>71. AMENDMENT XIII &gt; 1</b> In appointing the three members, the President shall ensure that the Security Council as a whole equitably reflects the composition of the population of Macedonia.
36.	Montenegro 2007 (rev. 2013)	<b>72. PART 3 &gt; 2 &gt; Article 95</b> The President of Montenegro: [...] 2 Commands over the Army on the basis of the decisions of the Defense and Security Council; 73. <b>PART 3 &gt; 7</b> 74. <b>ARTICLE 130. RESPONSIBILITY</b> The Defense and Security Council shall: <ol style="list-style-type: none"> <li>1. Make decisions on commanding over the Army;</li> <li>2. Analyze and assess the security situation in Montenegro and decide to take adequate measures;</li> <li>3. Appoint, promote and discharge from duty the Army officers;</li> <li>4. Propose to the Parliament proclamation of the state of war and state of emergency;</li> <li>5. Propose the use of Army in international forces;</li> <li>6. Perform other duties stipulated by the Constitution and the law.</li> </ol> <b>ARTICLE 131. COMPOSITION</b> The Defense and Security Council of Montenegro shall consist of the President of Montenegro, the Speaker of the Parliament and the Prime Minister. The President of Montenegro shall act as the President of the Defense and Security Council. <b>ARTICLE 132. PROCLAMATION OF THE STATE OF WAR</b> The state of war shall be proclaimed when there is direct danger of war for Montenegro, when Montenegro is attacked or war is declared against it. If the Parliament is not able to meet, the Defense and Security Council shall adopt the decision to proclaim the state of war and submit it to the Parliament for confirmation as soon as the Parliament is able to meet. <b>ARTICLE 133. PROCLAMATION OF THE STATE OF EMERGENCY</b> The state of emergency may be proclaimed in the territory or part of the territory of Montenegro in case of the following: <ol style="list-style-type: none"> <li>1. Big natural disasters;</li> <li>2. Technical-technological and environmental disasters and epidemics;</li> <li>3. Greater disruption of public peace and order;</li> <li>4. Violation or attempt to abolish the constitutional order.</li> </ol> If the Parliament is not able to meet, the Defense and Security Council shall adopt the decision to proclaim the state of emergency and submit it to the Parliament for confirmation as soon as it is able to meet.



		<p>The state of emergency shall last until the circumstances that have caused it have ceased to exist.</p> <p><b>75. APPENDIX &gt; Article 4</b></p> <p>The Defence and Security Council shall be constituted within 10 days as of the day when this Law enters into force.</p>
37.	<b>Mozambique 2004 (rev. 2007)</b>	<p><b>76. TITLE VI &gt; CHAPTER II &gt; Article 161</b></p> <p>In matters of national defence and of public order, the President of the Republic shall have power to:</p> <p><b>d</b> preside over the National Council of Defence and Security;</p> <p><b>77. TITLE VII &gt; CHAPTER II &gt; Article 179 &gt; 2</b></p> <p>2. The Assembly of the Republic shall have exclusive power to:</p> <p><b>n</b> define defence and security policy, after consulting the National Defence and Security Council;</p> <p><b>78. TITLE XIII</b></p> <p>NATIONAL DEFENCE AND NATIONAL DEFENCE AND SECURITY COUNCIL</p> <p><b>79. TITLE XIII &gt; CHAPTER II</b></p> <p>NATIONAL DEFENCE AND SECURITY COUNCIL</p> <p><b>80. TITLE XIII &gt; CHAPTER II &gt; Article 268 &gt; 1</b></p> <p>The National Defence and Security Council shall be the State consultative body for matters pertaining to national sovereignty, territorial integrity, the defence of democratically established authority, and security.</p> <p>The National Defence and Security Council shall be presided over by the President of the Republic and the law shall determine its composition, which shall include two members appointed by the President of the Republic and five members appointed by the Assembly of the Republic.</p> <p><b>81. TITLE XIII &gt; CHAPTER II &gt; Article 270</b></p> <p>The organisation and functioning of the National Defence and Security Council shall be established by law.</p>
38.	<b>Myanmar 2008</b>	<p><b>82. Chapter V &gt; A &gt; Part 2</b></p> <p>Formation of the National Defence and Security Council</p> <p>The National Defence and Security Council led by the President, to enable it to discharge the duties assigned by the Constitution or any law, shall be formed with the following persons:</p> <p><b>83. Chapter V &gt; A &gt; Part 3 &gt; 204</b></p> <p>204. The President has:</p> <p><b>b</b> the power to grant amnesty in accord with the recommendation of the National Defence and Security Council.</p> <p>The President may establish or sever diplomatic relations with foreign countries with the approval of the Pyidaungsu Hluttaw. However, in situation which requires immediate action, the President may sever diplomatic relations with any foreign country after coordination with the National Defence and Security Council. The President shall submit that action to the Pyidaungsu Hluttaw for its approval.</p> <p>213. The President:</p> <p><b>a</b> shall have the right to take appropriate military action, in co-ordination with the National Defence and Security Council formed in accord with the Constitution, in case of aggression against the Union;</p> <p><b>84. Chapter VII &gt; 340</b></p> <p>With the approval of the National Defence and Security Council, the Defence Services has the authority to administer the participation of the entire people in the Security and Defence of the Union. The strategy of the people's militia shall be carried out under the leadership of the Defence Services.</p> <p>[...]</p> <p>The President shall appoint the Commander-in-Chief of the Defence Services with the proposal and approval of the National Defence and Security Council.</p>
39.	<b>Nepal 2015 (rev. 2016)</b>	<p><b>85. PART 28 &gt; 266 &gt; 1</b></p> <p>There shall be a National Defense Council to formulate policies for Nepal's overall national interests, security and defense, and in order to make recommendations to the Council of Ministers, Government of Nepal on mobilization or control of Nepal Army comprising following Chairperson and members:-</p> <p><b>86. PART 28 &gt; 267 &gt; 6</b></p> <p>Powers of cabinet, Designation of commander in chief</p> <p>Mobilization of Nepal Army shall be declared by the President according to the decision by Council of Ministers, Government of Nepal on recommendation of National Defense Council during wars on security of any parts, territorial integrity or sovereignty of Nepal, external attacks, armed insurgency or serious crisis arisen due to extreme economic breakdown. Decision of mobilization of Nepal Army shall have to be approved by the House of Representatives within a month of the declaration.</p>
40.	<b>Niger 2010 (rev. 2017)</b>	<p><b>87. Title III &gt; Section 1 &gt; Article 63</b></p> <p>He is assisted by the Superior Council of National Defense [Conseil supérieur de la défense] and by the National Council of Security [Conseil nationale de sécurité].</p>

		<p><b>88. Title III &gt; Section 1 &gt; Article 65</b> The National Council of Security gives its opinion on matters related to the security of the Nation, to the defense of the Nation, to the foreign policy and[,] in a general manner[,] on all matters related to the strategic and vital interests of the country. A law determines the composition, the attributions and the functioning of the National Council of Security.</p>
41.	<b>Poland 1997 (rev. 2009)</b>	<p><b>89. Chapter V &gt; Article 135</b> The advisory organ to the President of the Republic regarding internal and external security of the State shall be the National Security Council.</p>
42.	<b>Portugal 1976 (rev. 2005)</b>	<p><b>90. Part III &gt; Title X &gt; Article 274</b> Supreme National Defence Council 1. The Supreme National Defence Council shall be chaired by the President of the Republic and shall be composed as laid down by law. The said composition shall include members elected by the Assembly of the Republic. 2. The Supreme National Defence Council shall be the specific consultative body for matters concerning national defence and the organisation, operation and discipline of the Armed Forces. It may possess such administrative responsibilities as the law may confer upon it.</p>
43.	<b>Romania 1991 (rev. 2003)</b>	<p><b>91. TITLE III &gt; CHAPTER V &gt; Section 1 &gt; Article 119</b> The Supreme Council for National Defense organizes and coordinates, in a uniform manner, the activities related to national security and the defense of the country, its participation in the maintenance of international security and collective defense in military alliance systems, as well as in peace keeping or peace restoring operations.</p>
44.	<b>Russian Federation 1993 (rev. 2014)</b>	<p><b>92. SECTION ONE &gt; CHAPTER 4 &gt; Article 83</b> The President of the Russian Federation: [...] g shall form and head the Security Council of the Russian Federation, the status of which shall be determined by federal law;</p>
45.	<b>Senegal 2001 (rev. 2016)</b>	<p><b>93. TITLE III &gt; Article 45</b> The President of the Republic is responsible for the National Defense. He presides over the Superior Council of the National Defense and the National Council of Security.</p>
46.	<b>Tajikistan 1994 (rev. 2003)</b>	<p><b>94. Chapter 4 &gt; Article 69</b> Powers of the President:  <ul style="list-style-type: none"> <li>[...]</li> <li>Creates the Security Council and leads it;</li> </ul> </p>
47.	<b>Tunisia 2014</b>	<p><b>95. Title Four &gt; Part One &gt; Article 77</b> He/she also has the following powers:  <ul style="list-style-type: none"> <li>[...]</li> </ul> Chairing the National Security Council, to which the Head of Government and Speaker of the Assembly of the Representatives of the People are invited;  <b>96. Title Four &gt; Part Two &gt; Article 93</b> It is mandatory for the President of the Republic to preside over the Council of Ministers on issues relating to defence, foreign policy, and national security as concerns the protection of the state and of the national territory from internal and external threats. The President may also attend the Council of Ministers' other meetings, and if so, he/she presides over the meeting.</p>
48.	<b>Turkey 1982 (rev. 2017)</b>	<p><b>97. PART THREE &gt; CHAPTER TWO &gt; II &gt; I &gt; 2 &gt; ARTICLE 118</b> The National Security Council shall be composed of Vice-Presidents of the Republic, ministers of Justice, National Defence, Internal Affairs, and Foreign Affairs, the Chief of the General Staff, the commanders of the Land, Naval and Air Forces under the chairpersonship of the President of the Republic. The National Security Council shall submit to the President of the Republic the advisory decisions taken with regard to the formulation, determination, and implementation of the national security policy of the State and its views on ensuring the necessary coordination. The President of the Republic shall evaluate decisions of the National Security Council concerning the measures that it deems necessary for the preservation of the existence and independence of the State, the integrity and indivisibility of the country, and the peace and security of society. The agenda of the National Security Council shall be drawn up by the President of the Republic taking into account the proposals of the Vice-Presidents of the Republic and the Chief of the General Staff. In the absence of the President of the Republic, the National Security Council shall convene under the chairpersonship of the Vice-President of the Republic. The organization and duties of the General Secretariat of the National Security Council shall be regulated by presidential decree.</p>
49.	<b>Turkmenistan 2008 (rev. 2016)</b>	<p><b>98. SECTION III &gt; CHAPTER II &gt; Article 71</b> The President of Turkmenistan shall: [...] Advisory bodies to the head of state</p>

		7 form and preside over the National Security Council of Turkmenistan;
50.	<b>Uganda 1995 (rev. 2017)</b>	<p><b>99. CHAPTER 12 &gt; National Security Council &gt; 219</b> There shall be a National Security Council which shall consist of the President as Chairperson and such other members as Parliament may determine.</p> <p><b>100. CHAPTER 12 &gt; General &gt; 221</b> It shall be the duty of the Uganda Peoples' Defence Forces and any other armed force established in Uganda, the Uganda Police Force and any other police force, the Uganda Prisons Service, all intelligence services and the National Security Council to observe and respect human rights and freedoms in the performance of their functions.</p>
51.	<b>Ukraine 1996 (rev. 2016)</b>	<p><b>101. Chapter V &gt; Article 106</b> The President of Ukraine: <b>18</b> heads the Council of National Security and Defence of Ukraine;</p> <p><b>102. Chapter V &gt; Article 107</b> The Council of National Security and Defence of Ukraine is the co-ordinating body to the President of Ukraine on issues of national security and defence. The Council of National Security and Defence of Ukraine co-ordinates and controls the activity of bodies of executive power in the sphere of national security and defence. The President of Ukraine is the Chairman of the Council of National Security and Defence of Ukraine. The President of Ukraine forms the personal composition of the Council of National Security and Defence of Ukraine. The Prime Minister of Ukraine, the Minister of Defence of Ukraine, the Head of the Security Service of Ukraine, the Minister of Internal Affairs of Ukraine and the Minister of Foreign Affairs of Ukraine, are ex officio members of the Council of National Security and Defence of Ukraine. The Chairman of the Verkhovna Rada of Ukraine may take part in the meetings of the Council of National Security and Defence of Ukraine. Head of state decree power Decisions of the Council of National Security and Defence of Ukraine are put into effect by decrees of the President of Ukraine. The competence and functions of the Council of National Security and Defence of Ukraine are determined by law.</p>
52.	<b>United Arab Emirates 1971 (rev. 2009)</b>	<p><b>103. PART IV &gt; CHAPTER 3 &gt; Article 65</b> At the beginning of every financial year, the Council of Ministers submits to the President of the UAE a detailed report on the internal achievements and on the UAE's relations with other states and international organizations. The President of the UAE then submits the report to the Supreme Council. The report also contains the recommendations of the Cabinet on the best ways to strengthen the foundations of the UAE, consolidate its security and stability, and achieve its goals and progress in all fields.</p> <p><b>104. PART IX &gt; Article 141</b> A Supreme Defense Council shall be set up under the chairmanship of the President of the UAE. Among its members shall be the Vice President of the UAE, the Prime Minister of the UAE, the Ministers of Foreign Affairs, Defense, Finance, Interior, the Commander in Chief and the Chief of the General Staff. It shall advise and offer views on all matters pertaining to defense maintenance of the peace and security of the UAE, forming of the armed forces, their equipment and development and the determination of their posts and camps.</p> <p><b>105. PART IX &gt; Article 143</b> Any Emirate shall have the right to request the assistance of the Federal Armed Forces or the Security Forces in order to maintain security and order within its territories whenever it is exposed to danger. Such a request shall be submitted immediately to the Federal Supreme Council for decision.</p>
53.	<b>Venezuela (Bolivarian Republic of) 1999 (rev. 2009)</b>	<p><b>106. TITLE VII &gt; Chapter I &gt; Article 323</b> The National Defense Council is the highest consultative organ for planning and advising the Public Power as to matters relating to the overall defense of the Nation, its sovereignty and the integrity of its geographical space. To this end, it is also charged with establishing the Nation's strategic concept. Presided over by the President of the Republic, it also includes the Executive Vice President, the President of the National Assembly, the Chief Justice of the Supreme Tribunal of Justice, the Chairman of the Republican Ethic Council and the Ministers of Defense, Internal Security, Foreign Relations and Planning, and any others whose participation may be deemed appropriate. The pertinent organic law shall determine the organization and attributions of the National Defense Council.</p>
54.	<b>Viet Nam 1992 (rev. 2013)</b>	<p><b>107. CHAPTER V &gt; Article 70</b> The National Assembly has the following duties and powers: [...] Advisory bodies to the head of state, Leader of first chamber, Attorney general, Head of state selection, Electoral commission, Supreme/ordinary court judge removal, Head of government selection, Head of government removal, Deputy executive, Standing</p>

		<p>committees, Head of state removal, Cabinet removal, Supreme court selection, Cabinet selection</p> <p><b>7</b> To elect, release from duty, remove from office the State President and Vice-President, the Chairman of the National Assembly, the Vice-Chairmen and members of the Standing Committee of the National Assembly, the Prime Minister, the President of the Supreme People's Court, the Head of the Supreme People's Procuracy, the President of the National Council of Election, the Head of the State Audit, and the heads of other organs created by the National Assembly; to sanction the proposals of appointment, release from duty, remove from office the Vice-Prime Minister, Ministers and other members of the Government, judges of the People's Supreme Court; sanction the list of members of the Defence and Security Council and of the National Council of Election.</p> <p><b>108. CHAPTER VI &gt; Article 89</b></p> <p><b>1</b> The National Defence and Security Council consists of a Chairman, Vice Chairmen and other members who are approved by the National Assembly under the nomination of the State President.</p> <p><b>2</b> The National Defence and Security Council shall operate as a collegium and take its decisions by a vote of the majority.</p> <p>Power to declare/approve war</p> <p><b>3</b> The National Defence and Security Council proposes to the National Assembly to decide on the state of war, and in case the National Assembly cannot meet, proposes to the National Assembly's Standing to decide on that; mobilizes all forces and potentialities of the country for national defence; exercises special duties and powers entrusted by the National Assembly in case of war; decides on the participation of the armed forces in activities contributing to the protections of peace in the region and in the world.</p>
55.	<b>Yemen 1991 (rev. 2015)</b>	<p><b>109. PART ONE &gt; Chapter IV &gt; Article 38</b></p> <p>The National Defense Council, headed by the President of the Republic, will exist to attend to matters pertaining to means of safeguarding the Republic and its security. The law shall determine its composition, duties and other functions.</p> <p><b>110. PART THREE &gt; Chapter II &gt; The First Branch &gt; Article 119</b></p> <p>The responsibilities of the President of the Republic are as follows:</p> <p>[...]</p> <p><b>7</b> To name the members of the National Defense Council according to the law.</p>
56.	<b>Zimbabwe 2013 (rev. 2017)</b>	<p><b>111. CHAPTER 11 &gt; PART 1 &gt; 209</b></p> <p>National Security Councilы</p> <p>There is a National Security Council consisting of the President as chairperson, the Vice-Presidents and such Ministers and members of the security services and other persons as may be determined in an Act of Parliament.</p> <p>The functions of the National Security Council are--</p> <p>The commanders of the security services must provide the National Security Council with such reports on the security situation in Zimbabwe as the Council may reasonably require.</p>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://gsdrc.org/publications/national-security-office-responsibilities-and-functions/>
- [https://cdainstitute.ca/wp-content/uploads/2016/07/Davies\\_Analysis\\_November\\_2016.pdf](https://cdainstitute.ca/wp-content/uploads/2016/07/Davies_Analysis_November_2016.pdf)
- <https://www.jewishvirtuallibrary.org/israel-national-security-council>
- <https://iranprimer.usip.org/blog/2019/apr/01/supreme-national-security-council-iran>
- <https://www.gov.uk/government/groups/national-security-council>
- <https://kenyanconstitution.manjemedia.com/national-security/>
- <https://www.opm.gov.tt/about/business-and-departments-of-government-under-the-opm/>
- [https://www.revolvy.com/page/National-Security-Council-\(India\)](https://www.revolvy.com/page/National-Security-Council-(India))
- <http://www.nsa.gov.rs/eng/savet-i-biro.php>
- <https://www.sns.am/en>
- <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/525062018008/consolide/current>

# ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ОРОН ТООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

Г.Билгээ, О.Нарантуяа

## Гадаадын зарим орнуудын парламентын судалгааны албаны орон тооны талаарх мэдээлэл

	Улсын нэр	Парламентын танхим	Парламентын гишүүний тоо	Судалгааны албаны нэр	Судалгааны албаны орон тоо
1	<b>Австрали</b>	Хоёр танхимтай	Төлөөлөгчдийн танхим-151 Сенат-76	Парламентын номын сан нь: -судалгаа шинжилгээ -мэдээлэл, сурталчилгаа гэсэн үндсэн 2 хэсэгтэй.	Судалгааны хэсэг 80 ажилтантай  Мэдээллийн хэсэг 60 ажилтантай <sup>153</sup>
2	<b>АНУ</b>	Хоёр танхимтай	Сенат-100 Төлөөлөгчдийн танхим-435	Конгрессийн судалгааны алба	700 ажилтантай <sup>154</sup>
3	<b>Бангладеш</b>	Нэг танхимтай	Парламент нь 350 гишүүнтэй	Номын сан болон Судалгааны алба	11 ажилтантай <sup>155</sup>
4	<b>Чех</b>	Хоёр танхимтай	Сенат-81 Доод танхим-200	Парламентын институт 3 хэсэгт хуваагддаг.	27 ажилтантай <sup>156</sup>
5	<b>Солонгос</b>	Нэг танхимтай	Парламент нь 300 гишүүнтэй	Үндэсний Ассамблейн Судалгааны алба (NARS)	126 ажилтантай <sup>157</sup>
6	<b>Герман</b>	Хоёр танхимтай	Бундестаг-709 Бундесрат-69	Судалгаа, мэдээллийн алба	100 ажилтантай <sup>158</sup>
7	<b>Вьетнам</b>	Нэг танхимтай	Парламент нь 498 гишүүнтэй	Хууль зүйн судалгааны институт 3 газарт хуваагддаг.	300 ажилтантай <sup>159</sup>
8	<b>Канад</b>	Хоёр танхимтай	Сенат-дээд танхим 105 Нийтийн танхим-доод танхим 338	Парламентын номын сан	300 ажилтантай <sup>160</sup>
9	<b>Турк</b>	Нэг танхимтай	Үндэсний Их Хурал 600 <sup>161</sup>	Судалгааны хэлтэс Department of Research Services (Research Center)	40 ажилтантай <sup>162</sup>
10	<b>Уганда</b>	Нэг танхимтай	Парламент 459 <sup>163</sup>	Судалгааны хэлтэс	39 ажилтантай <sup>164</sup>

<sup>153</sup> Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага, 2018 он, УИХТГ, МХШҮХ-ийн СМЛА

<sup>154</sup> Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага, 2018 он, УИХТГ, МХШҮХ-ийн СМЛА

<sup>155</sup> Бангладешийн парламентын Тамгын газар <http://www.parliament.gov.bd/index.php/en/secretariat/organogram-of-bp-secretariat>

<sup>156</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans <https://www.ndi.org/sites/default/files/development-of-parliamentary-research-services-CEE.pdf>

<sup>157</sup> National assembly of research service <http://www.nars.go.kr/eng/contentView.do?cmsCd=CM0108&sgrp=S02>

<sup>158</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans гарын авлага

<sup>159</sup> Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага, 2018 он, УИХТГ, МХШҮХ-ийн СМЛА

<sup>160</sup> Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага, 2018 он, УИХТГ, МХШҮХ-ийн СМЛА

<sup>161</sup> Туркийн Үндсэн хуулийн 75 дугаар зүйл. [https://global.tbmm.gov.tr/docs/constitution\\_en.pdf](https://global.tbmm.gov.tr/docs/constitution_en.pdf)

<sup>162</sup> [https://www.tbmm.gov.tr/armer\\_eng/org\\_structure.html](https://www.tbmm.gov.tr/armer_eng/org_structure.html)

<sup>163</sup> <https://www.parliament.go.ug/find-an-mp>

<sup>164</sup> The Role of Parliamentary Library and Research Resources in Supporting Parliamentarians to be Well-informed: The Case of Uganda. 2013. 6 дахь тал. <http://library.ifa.org/168/7/187-rugambwa-en.pdf>



11	<b>Унгар</b>	Нэг танхимтай	Үндэсний ассамблей 199	Номын сангийн мэдээллийн алба	199 ажилтантай <sup>165</sup>
12	<b>Польш</b>	Хоёр танхимтай	Сенат-дээд танхим 100 Сэжм-доод танхим 460	Судалгааны хэлтэс Дотроо 8 судалгааны хэсэгтэй.	91 ажилтантай <sup>166</sup>
13	<b>Словак</b>	Нэг танхимтай	Үндэсний зөвлөл-150	Парламентын институт Дотроо 3 судалгааны хэсэгтэй.	19 ажилтантай <sup>167</sup>
14	<b>Словени</b>	Хоёр танхимтай	Үндэсний Зөвлөл-дээд танхим-40 Үндэсний Ассамблей-Доод танхим-90	Судалгаа, мэдээллийн хэлтэс 5 судалгааны хэсэгтэй.	40 ажилтантай <sup>168</sup>
15	<b>Энэтхэг</b>	Хоёр танхимтай	Rajya Sabha-Дээд танхим 245 Lok Sabha- Доод танхим 545	Номын сан, судалгаа, лавлагаа, мэдээллийн алба	90 ажилтантай <sup>169</sup>
16	<b>Япон</b>	Хоёр танхимтай	Зөвлөлийн танхим-Дээд танхим 242 Төлөөлөгчдийн танхим-Доод танхим 465	Номын сангийн судалгаа, хуулийн лавлагааны товчоо	900 ажилтантай <sup>170</sup>

**Парламентын судалгааны албаны ажилтнуудын тоог парламентын гишүүдийн тоотой харьцуулсан байдал<sup>171</sup>**

Энэхүү судалгаанд судалгааны албаны болон номын сангийн ажилтнуудыг оруулсан болно.

Словани	7(90-доод танхим)
Унгар	15 (386)
Польш	91 (460 доод танхим)
Чех	24 (281-2 танхим)
Словак	9 (150)
Серби	8 (250)
Босни-Херцеговин	5 (57-2 танхим хоёулаа)
Монтенегро	5(81)
Косова	6 (120)
Албани	3 (140)

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

<sup>165</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans, 22 дахь тал <https://www.ndi.org/sites/default/files/development-of-parliamentary-research-services-CEE.pdf>

<sup>166</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans, 22 дахь тал

<sup>167</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans, 23 дахь тал

<sup>168</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans, 23 дахь тал

<sup>169</sup> <http://loksabhaph.nic.in/Secretariat/Functioning.aspx>, Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба-УИХТГ, 2012 он

<sup>170</sup> Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага, 2018 он, УИХТГ, МХШҮХ-ийн СМЛА

<sup>171</sup> Development of Parliamentary Research Service in Central Europe and the Western Balkans, 67 дахь тал <https://www.ndi.org/sites/default/files/development-of-parliamentary-research-services-CEE.pdf>



# МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУУЛЬ ТОГТООМЖООР ПАРЛАМЕНТЫН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ НЭЭЛТТЭЙ БОЛОН ХААЛТТАЙ ДЭГИЙГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ, О.Нарантуяа

Судалгаанд Монгол Улсын болон гадаадын 12 улсын хууль тогтоомжоор парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй болон хаалттай дэгийг зохицуулсан байдлыг судлав.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульд дээрх асуудлыг тусгаагүй, харин Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудаар зохицуулсан байна.

Гадаадын туршлагыг судалгаанд авч үзэхдээ Бүгд Найрамдах Улс (БНУ)-уудыг сонгон авсан. (Хүснэгт 1) Эдгээр 12 улсын Үндсэн хууль болон ерөнхий нэршлээр Дэгийн хуулийг авч үзэхэд, Словени Улсын Үндсэн хуульд парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй болон хаалттай дэгийн талаар тусгаагүй байна.

**Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан улсуудын засаглалын хэлбэр, парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй, хаалттай дэгийг зохицуулсан байдал**

Бүгд найрамдах засаглал (БНЗ)-ын хэлбэр	Парламентын танхимын тоо	Д/д	Улсын нэр	Парламентын нэгдсэн хуралдааны нээлттэй, хаалттай дэгийг зохицуулсан байдал	
				Үндсэн хууль	Дэгийн хууль
Парламентын БНЗ	1	1	Болгар	✓	✓
		2	Кыргыз	✓	✓
		3	Словак	✓	✓
		5	Эстони	✓	✓
	2	6	Австри*	✓	✓
		7	Герман *	✓	✓
		8	Словени*	-	✓
		9	Чех*	✓	✓
Ерөнхийлөгчийн БНЗ	1	9	Өмнөд Солонгос	✓	✓
	2	10	Франц*	✓	✓
Хагас ерөнхийлөгчийн БНЗ	1	11	Финланд	✓	✓
	2	12	ОХУ*	✓	✓

Тайлбар: \* Хоёр танхимтай бөгөөд парламентын доод танхимыг судалгаанд авсан болно.

Эдгээр улсуудын хууль тогтоомжийг үзэхэд, парламентын нэгдсэн нэгдсэн хуралдаан олон нийтэд нээлттэй дэгээр хуралдана. Харин дараах тохиолдлуудад нэгдсэн хуралдааныг хаалттай горим руу шилжүүлнэ:

- хууль тогтоомжоор тогтоосон асуудлыг хэлэлцэх бол;
- эрх бүхий субъектийн санал гаргасан бол;
- гишүүдийн санал хураалтаар шийдвэрлэсэн бол (Киргиз);
- хэлэлцэх асуудал нь нууцад хамаарах бол (Болгар, Киргиз, Словени, Чех).

Парламентын **нэгдсэн хуралдааныг хаалттай горим руу шилжүүлэх** саналыг дараах эрх бүхий субъектүүд гаргаж байна. Үүнд:

- Парламентын дарга (Австри, ОХУ, Болгар, Өмнөд Солонгос, Финланд);
- Парламентын дэд дарга (Чех);
- Парламентын гишүүд:
  - хүрэлцэн ирсэн гишүүдийн 1/5-ээс доошгүйн саналаар (Австри);
  - гишүүдийн 1/10-ийн саналаар (Болгар);
  - 10 ба түүнээс дээш гишүүдийн гарын үсэг зурснаар (Өмнөд Солонгос);
  - гишүүдийн 1/10-ийн шаардсанаар (Франц);
  - гишүүдийн 2/3-ын саналаар (Эстони);
- Ерөнхийлөгч (ОХУ);
- Ерөнхий сайдын (Франц);
- Засгийн газар (Болгар, Чех).

**Хаалттай хуралдааны** дэгтэй холбоотой харилцааг тодорхой заасан зарим асуудал байна. Үүнд:

- хуралдааныг хаалттай горим руу шилжүүлэх шийдвэрийг Парламент гаргах ба ингэхдээ Киргиз, ОХУ, Словак, Эстонид гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхийг;
- Өмнөд Солонгос, Словенид хаалттай хуралдаан хийх асуудлыг хэлэлцүүлэг хийхгүйгээр санал хураахыг;
- Киргиз, ОХУ, Чех улсууд хаалттай хуралдаанд оролцох эрх бүхий албан тушаалтныг;
- хаалттай хуралдаанаар хориглосон үйлдлийг (Киргиз, ОХУ);
- хаалттай хуралдаантай холбоотой олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хуралдааны тэмдэглэл зэрэг бусад харилцааг (Болгар, ОХУ, Словени) тус тус тодорхой заасан.

Словак, Чех улсын парламент нь улсын төсвийн тухай хууль, улсын санхүү, эсхүл татвар, зардлын хуулийн төслийг **нээлттэй хэлэлцэнэ**.

Зарим онцлог зохицуулалтаас дурдахад, Австрийн Холбооны Зөвлөлд олон нийт хаалттай хуралдах саналыг хэлэлцэж эхлэх, эсхүл санал хураахаас өмнө хуралдааны танхимаас гарна, ОХУ-ын Төрийн Думд хаалттай хуралдаан хийх шийдвэрийг тухайн хуралдаан эхлэхээс нэгээс доошгүй цагийн өмнө гаргана гэсэн байна.

**Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖООР  
ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ БОЛОН ХААЛТТАЙ  
ХУРАЛДААНЫ ДЭГИЙГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**

*29 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам*

29.1.Хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай **хуралдаанаар хэлэлцэнэ**.

29.2.Хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан энэ хуулийн 29.1-д зааснаас бусад асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

29.3.Энэ хуулийн 29.1, 29.2-т зааснаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны **хуралдааныг нээлттэй хийнэ**.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

*5 дугаар зүйл. Хуралдааны нийтлэг журам*

5.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан асуудлыг нууцын горимоор хаалттай **хуралдаанаар хэлэлцэнэ**.

*/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

5.2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.2-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

*6 дугаар зүйл. Хаалттай хуралдааны дэг*

6.1.Энэ хуулийн 5.1-д заасан хаалттай **хуралдаанд** Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, тухайн асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн болон холбогдох төрийн бусад байгууллагын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, мөн газрын нууцын асуудал хариуцсан ажилтан, түүнчлэн тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оролцуулж болно.

*/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

6.2.Шаардлагатай бол энэ хуулийн 6.1-д зааснаас бусад хүнийг хаалттай **хуралдаанд** оролцуулж болох бөгөөд тэднээр нууц задруулахгүй байх баталгааг урьдчилан гаргуулна.

6.3.Хаалттай **хуралдаанд** дуу, дүрс бичлэг хийх, гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж авч орох, утсаар ярихыг хориглоно.

*/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

6.4.Хаалттай **хуралдааны** талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

6.5.Энэ зүйлд заасан журам мөн хуулийн 5.2-т заасан хуралдааныг зохион байгуулахад үл хамаарна.

6.6.Энэ хуулийн 5.2-т заасан хаалттай **хуралдаанд** асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд оролцож болох бөгөөд хуралдааны явцыг энэ хуулийн 54.1-д заасны дагуу тэмдэглэнэ.

*/Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*7 дугаар зүйл. **Нээлттэй хуралдааны** дэг*

7.1.**Нээлттэй хуралдаанд** тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын болон нам, эвслийн бүлгийн ажлын албаны холбогдох ажилтан, энэ хуулийн 53<sup>1</sup>.2-т заасан сурвалжлах эрхтэй хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан оролцож болно.

*/Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

*/Энэ хэсгийг 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

7.2.**Нээлттэй хуралдааны** явцыг энэ хуульд заасны дагуу дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан бэхжүүлнэ.



**Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУУЛЬ ТОГТООМЖООР  
ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ БОЛОН ХААЛТТАЙ  
ХУРАЛДААНЫ ДЭГИЙГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

**2.1.АВСТРИ УЛС**

**ҮНДСЭН ХУУЛЬ**

33.Үндэсний Зөвлөл болон түүний хороодын нээлттэй хуралдааны талаарх тайланг нийтэлсний төлөө хэн ч хариуцлага хүлээхгүй.

37.3.Холбооны Зөвлөлийн **хуралдаан нээлттэй байна**. Гэхдээ Хуралдааны дэгд заасны дагуу шийдвэрээр **олон нийтийг хуралдааны танхимаас гаргаж болно**. Үндсэн хуулийн 33 дугаар зүйл нь Холбооны зөвлөл ба түүний хороодын олон нийтийн уулзалтад хамаарна.

39.3.Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан журам Холбооны зөвлөлийн хуралдаанд мөн хамаарна.

**ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ДҮРЭМ<sup>172</sup>**

36.1.Холбооны Зөвлөлийн хуралдааны хэлэлцүүлэг **олон нийтэд нээлттэй байна**.

36.2.Хэрэв Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч, эсхүл хүрэлцэн ирсэн гишүүдийн тавны нэгээс доошгүйн саналаар **олон нийтийг хуралдааны танхимаас гаргах тухай** Холбооны зөвлөлийн шийдвэр гарсан бол олон нийтийг танхимаас гаргана. Олон нийт уг саналыг хэлэлцэж эхлэх, эсхүл санал хураахаас өмнө хуралдааны танхимаас гарна.

**2.2.БОЛГАР УЛС**

**ҮНДСЭН ХУУЛЬ**

82.Үндэсний Ассамблейн **хуралдаан нээлттэй** явагдана. Үндэсний Ассамблей онцгой шийдвэр гаргах бол **хуралдааныг хаалттай хийж болно**.

**ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ<sup>173</sup>**

49.2.Үндэсний Ассамблейн шийдвэрээр **Үндэсний Ассамблейн болон Сайд нарын зөвлөлийн гишүүн бус хүмүүс хуралдаанд байлцаж болох** ба хуралдаан даргалагчийн тогтоосон журмын дагуу тусгайлан зассан суудалд сууна. Хуралдааны үед тэд тогтоосон журмыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд зөвхөн хуралдаан даргалагчийн урилгаар үг хэлж болно.

49.3.Хуралдаанд оролцогчдоос шуугиан, эсхүл эмх замбараагүй байдал гарсан тохиолдолд хуралдаан даргалагч эмх цэгцийг тогтоох үүрэгтэй ба тэдгээрийн заримыг, эсхүл бүх оролцогчдыг гаргаж болно.

<sup>172</sup> Rules of Procedure of the Austrian Federal Council.  
<https://www.parlament.gv.at/ENGL/PERK/RGES/GOGNR/index.shtml>

<sup>173</sup> Rules of Procedure of the National Assembly of Bulgaria (Issued by the National Assembly Prom. SG. No. 35 of 2 May 2017) <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

50.1.Үндэсний Ассамблейн хуралдаан дор дурдсан тохиолдолд **хаалттай хуралдана**. Үүнд:

- 1) төрийн чухал ашиг сонирхолтой холбоотой бол;
- 2) Нууцад хамаарах мэдээллийг хамгаалах тухай хуульд заасан баримт бичгийг хэлэлцэх бол.

50.2.Хуралдаан даргалагчийн, Үндэсний Ассамблейн гишүүдийн аравны нэг, эсхүл Сайд нарын зөвлөл энэ зүйлийн 1.1-т заасны дагуу хаалттай хуралдах тухай санал гаргаж болно.

50.3.Хэрэв хуралдаан энэ зүйлийн 1-т заасны дагуу явагдах бол хуралдаан даргалагч эрх бүхий бүх этгээдэд хуралдааны танхим болон бельэтажийг орхиж гарахыг, мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээний шууд нэвтрүүлгийг зогсоохыг даалгана. Санал гаргагчийн үндэслэлийг сонссоны дараа Үндэсний ассамблей уг саналыг хэлэлцэн санал хураана. Санал хураалтын дүнгээс хамаарч **хуралдааныг нээлттэй, эсхүл хаалттай хэлбэрээр хийнэ**.

50.4.Энэ зүйлийн 1.2-т заасан тохиолдолд **хуралдааныг хаалттай хийнэ**. Хуралдаан даргалагч нь Нууцад хамаарах мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу **хаалттай хуралдааныг** зарлах ба бусад этгээдэд хуралдааны танхим болон бельэтажийг орхиж гарахыг даалгана, мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээний шууд нэвтрүүлгийг зогсооно. Энэ асуудлаар хэлэлцэхгүй, мөн санал хураахгүй бөгөөд хаалттай танхимд хуралдаан үргэлжилнэ.

50.5.**Хаалттай хуралдааны** хэлэлцүүлэг, тэмдэглэл нь нууцад хамаарах мэдээлэл болох ба Үндэсний Ассамблейн бүх гишүүд болон түүнд нэвтрэх эрхтэй бусад этгээдүүд холбогдох үүргийг хүлээнэ.

50.6.**Хаалттай хуралдааны** шийдвэрийг олон нийтэд нээлттэй байна.

51.1.Үндэсний Ассамблейн **нээлттэй хуралдааныг** Болгарын үндэсний радиогоор тодорхой давтамжтайгаар, нийт нутаг дэвсгэрийг хамарсан байдлаар, Болгарын үндэсний телевиз болон парламентын суваг (BNT)-аар дамжуулж гаргана. Нэвтрүүлгийн дохиог үнэ төлбөргүй ашиглуулна. Үндэсний Ассамблейн **нээлттэй хуралдааныг** бодит цаг хугацаанд Үндэсний Ассамблейн цахим хуудсаар дамжуулан шууд дамжуулна.

51.2.Үндэсний Ассамблейн шийдвэрээр **нэгдсэн хуралдааныг** Болгарын үндэсний телевиз, Болгарын үндэсний радиогоор шууд дамжуулна.

51.2.Парламентын хяналтыг хэрэгжүүлж байгаа Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдааныг Болгарын үндэсний телевизийн BNT-2 хөтөлбөр, Болгарын үндэсний радиогоор шууд дамжуулна.

## 2.3.ГЕРМАН УЛС

### ҮНДСЭН ХУУЛЬ

42.1.Бундестагийн **үйл ажиллагаа нээлттэй байна**. Гишүүдийн аравны нэгийн хүсэлт буюу Холбооны Засгийн газрын хүсэлтийг үндэслэн гуравны хоёрын саналаар **нээлттэй байдлыг халж** болно.

## БУНДЕСТАГИЙН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

*19 дүгээр зүйл. Хуралдаан*

Бундестагийн **хуралдаан нээлттэй байна**. Үндсэн хуулийн 42.1-т заасны дагуу Бундестаг **хаалттай хуралдаж болно**.

### 2.4.КИРГИЗ УЛС

#### ҮНДСЭН ХУУЛЬ

77.2.Хэлэлцэж буй асуудал нь хаалттай хуралдааныг шаардахаас бусад тохиолдолд Жогорку Кенешийн **хуралдаан нээлттэй байна**.

#### ЖОГОРКУ КЕНЕШИЙН ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ<sup>174</sup>

*35 дугаар зүйл. Жогорку Кенешийн хуралдаан*

1.Жогорку Кенешийн хуралдаан дараах хэлбэртэй байна:

1) ээлжит;

2) ээлжит бус;

3) **нээлттэй**;

4) **хаалттай**.

*36 дугаар зүйл. Жогорку Кенешийн хаалттай хуралдаан*

1.Жогорку Кенешийн хуралдаан нь төрийн, цэргийн болон хууль тогтоомжид заасан бусад нууцад хамаарах асуудал хэлэлцэхээс бусад тохиолдолд **нээлттэй байна**.

2.Тодорхой үндэслэл бүхий онцгой тохиолдолд асуудлыг **хаалттай хуралдаанаар** хэлэлцэх тухай шийдвэрийг Жогорку Кенеш гаргана.

3.**Хаалттай хуралдаан хийх** тухай шийдвэрийг хүрэлцэн ирсэн гишүүдийн 50-аас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

4.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Акыйкатчы (Омбудсмен), Жогорку Кенеш дэх Ерөнхийлөгч болон Засгийн газрын бүрэн эрхт бөгөөд байнгын төлөөлөгчид Жогорку Кенешийн **хаалттай бүх хуралдаанд оролцох эрхтэй**.

Дээд шүүхийн дарга, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын дарга, Үндэсний банкны дарга, Аудитын дарга, Ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд Жогорку Кенешийн **хаалттай хуралдаанд өөрсдийн эрхлэх асуудлаар оролцох эрхтэй**. Бусад албан тушаалтнууд Жогорку Кенешийн дарга, түүний эзгүйд орлогч даргын урилгаар **хаалттай хуралдаанд оролцох эрхтэй**.

5.Жогорку Кенешийн **хаалттай хуралдааны** агуулгыг дэлгэх, тараахыг, мөн хуралдааны үед фото зураг авах, видео болон аудио бичлэг хийхийг, мэдээлэл боловсруулах хэрэгсэл, харилцаа холбоо болон радио холбоо ашиглахыг хориглоно.

<sup>174</sup> Закон Кыргызской Республики О Регламенте Жогорку Кенеша Кыргызской Республики (Принят Жогорку Кенешем Кыргызской Республики 14 октября 2011 года)  
kenesh.kg/ru/article/show/14/reglament-zhogorku-kenesha-kirgizskoy-respubliki



6.Жогорку Кенешийн хаалттай **хуралдааны** дуу, дүрс бичлэг, тэмдэглэл хөтлөх бэлтгэл ажлыг Ажлын албаны холбогдох нэгж нууцлалыг хангаж хэрэгжүүлнэ.

8.Жогорку Кенешийн **хаалттай хуралдаанаас** гаргасан шийдвэр, санал хураалтын дүнг Жогорку Кенешийн цахим хуудсанд байршуулна.

## 2.5.ОХУ

### ҮНДСЭН ХУУЛЬ

100.2.Холбооны зөвлөл болон Төрийн Думын **хуралдаан нээлттэй байна**. Танхимуудын Регламентад заасан тохиолдолд **хуралдааныг хаалттай хийж болно**.

### ТӨРИЙН ДУМЫН РЕГЛАМЕНТ<sup>175</sup>

*37 дугаар зүйл.*

1.Төрийн Думын **хуралдаан нээлттэй**, ил тод явагдах бөгөөд хэвлэл, мэдээлэлд хүртээмжтэй байна.

2.Танхимын зөвшөөрснөөр түүний хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбоотой төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөгчид, шинжээч бусад мэргэжилтнийг оролцуулж болно. Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад танхимын **хуралдаан нээлттэй байна**.

3.Төрийн Дум нь өмнөх хуралдаанд Төрийн Думын дарга, Төрийн Думын Зөвлөл, хороо, бүлэг, ОХУ-ын Ерөнхийлөгч санал оруулснаар **хаалттай хуралдаан** хийхээр шийдвэрлэж болно.

4.**Хаалттай хуралдаан** хийх тухай шийдвэрийг хуралдаанд оролцож байгаа депутатуудын олонхын саналаар гаргана.

5.**Хаалттай хуралдаан** хийх шийдвэрийг тухайн хуралдаан эхлэхээс нэгээс доошгүй цагийн өмнө гаргана.

6.Төрийн Думын **хаалттай хуралдаан** дээр фото зургийн болон фото, видео, кино зургийн аппарат ашиглах, цахилгаан холбооны болон радио холбооны техник, дуу бичлэгийн болон мэдээлэл боловсруулах техник ашиглахыг хориглоно.

7.**Хаалттай хуралдаанд** хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг оруулахгүй.

8.Төрийн Думын хуралдаанд дээр хэлэлцсэн төрийн болон бусад нууцад хамаарах асуудлыг нийтэд зарлахыг хориглоно.

9.**Хаалттай хуралдааныг** даргалагч нь хуралдаан эхлэхийн өмнө Төрийн Думын депутатууд, хаалттай хуралдаанд уригдсан зочдод **хаалттай хуралдааныг** хийх журам, тухайн хурлаар хэлэлцэх нууцад хамаарах асуудал, түүний нууцын зэрэглэлийн талаар тайлбарлаж, төрийн болон бусад нууцад хамаарах мэдээллийг задруулбал хүлээх хуулийн хариуцлагыг тайлбарлана.

10.Төрийн Думын **хаалттай хуралдааны** тэмдэглэл, хаалттай хэлэлцсэн

<sup>175</sup> Эх сурвалж: ОХУ-ын Төрийн Думын регламент (Гарын авлага), Мөнхийн үсэг ХХК. 2019 он.

асуудалд хамааралтай материал, цахим системийн санал хураалтын дүн, хаалттай хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийн мэдээг Төрийн Думын нууцын асуудал хариуцсан нэгжид хадгална. Эдгээр материалтай нууцын хэсэгт, гарын үсэг зурж танилцаж болно.

*38 дугаар зүйл.*

1.ОХУ-ын Ерөнхийлөгч, Төрийн Дум дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгч, Холбооны Зөвлөлийн дарга, Холбооны Зөвлөлийн гишүүн, Холбооны Засгийн газрын тэргүүн, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дарга, ОХУ-ын Дээд шүүхийн дарга, ОХУ-ын Арбитрын Дээд шүүхийн дарга, ОХУ-ын Тооллогын комиссийн дарга, түүний орлогчид, Тооллогын комиссын гишүүд, Хүний эрхийн асуудлын онц эрхт төлөөлөгч, ОХУ-ын Ерөнхий прокурор, ОХУ-ын Сонгуулийн төв байгууллагын дарга нь **нээлттэй, хаалттай бүх хуралд оролцох эрхтэй.**

1.1.Нийтийн танхимын Зөвлөлөөс эрх олгосон Нийтийн танхимын гишүүн Төрийн Думын **хаалттай хуралдаанд оролцох эрхтэй.**

*84 дүгээр зүйл.*

2.Энэ Регламентад өөрөөр заагаагүй бол дэгийн асуудлаар шийдвэрийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргана.

**з) хуралдааныг хаалттай хийх тухай;**

*179 дүгээр зүйл.*

1.ОХУ-ын Ерөнхийлөгчийг буруутгах санал болон комиссын дүгнэлтийг Төрийн Думын хуралдаанаар хэлэлцэнэ. Танхимын шийдвэрээр Төрийн Думын хуралдааныг **хаалттай** хийж болно. Танхим нь Төрийн Думын нийт депутатын олонхын саналаар тухайн хэлэлцүүлгийг олон нийтэд шууд дамжуулахаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандаж болно.

## **2.6.ӨМНӨД СОЛОНГОС**

### **ҮНДСЭН ХУУЛЬ**

50.1.Үндэсний Ассамблейн чуулган нь **нээлттэй хуралдана.** Гагцхүү хуралд оролцогч гишүүдийн олонхын саналаар болон Үндэсний Ассамблейн даргаас үндэсний аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзвэл **хаалттай хуралдаж болно.**

50.2.**Хаалттай хуралдааны** агуулга, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

### **ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ТУХАЙ ХУУЛЬ<sup>176</sup>**

*75 дугаар зүйл (Хуралдааныг нээлттэй хийх)*

1.Нэгдсэн хуралдааныг олон нийтэд **нээлттэй хийж болно.** Харин Үндэсний Ассамблейн спикерийн санал болгосноор, эсхүл 10 болон түүнээс дээш гишүүдийн гарын үсэг зурснаар спикер бүлэг тус бүрийг төлөөлж буй гишүүнтэй зөвшилцөж

<sup>176</sup> National Assambley Act. Эх сурвалж: Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль (Гарын авлага), Мөнхийн үсэг ХХК. 2019 он.

үндэсний аюулгүй байдлын үүднээс **хаалттай хуралдаж болно**.

2.Энэ зүйлийн 1-т заасныг үндэслэн санал болгох эсхүл зөвшөөрөл авахдаа хэлэлцүүлэг хийхгүйгээр санал хурааж шийдвэрлэнэ.

*158 дугаар зүйл (Ёс зүйн хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа)*

Хариуцлага тооцох тухай хуралдааныг олон нийтэд **нээлттэй хийхгүй**. Нэгдсэн чуулган, эсхүл хорооны тогтоол өөрөөр гарсан тохиолдолд дээрх заалт үйлчлэхгүй.

## 2.7.СЛОВАК УЛС

### ҮНДСЭН ХУУЛЬ

83.3.Словак Улсын Үндэсний Зөвлөлийн **хуралдаан олон нийтэд нээлттэй байна**.

83.4.**Олон нийтэд хаалттай хуралдааныг** гагцхүү хуульд заасан журам, эсхүл Словак Улсын Үндэсний Зөвлөлийн нийт гишүүдийн тавны гуравны шийдвэрээр хийж болно.

### СЛОВАК УЛСЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ<sup>177</sup>

18.1.Үндэсний Зөвлөлийн **хуралдаан нээлттэй байна**. Үндэсний Зөвлөлийн хуралдааны танхимд олон нийтэд зориулсан хязгаарлагдмал тооны суудалтай байна.

		<p>Гишүүн хаалттай хурлын тэмдэглэл болон түүнтэй холбоотой нууц материалыг авах хүсэлт гаргасан тохиолдолд хяналт шалгалтад харшлахгүй бол хорооны дарга нь зөвшөөрнө. Материалыг Ассамблейгаас гадагш гаргаж болохгүй.</p> <p><b>70 дугаар зүйл. Хорооны баримт бичгийг хэвлэх болон удирдах</b></p> <p>5.Хорооноос бий болсон, эсвэл хороонд хүргүүлсэн нууц бичгийг хадгалж хариуцахтай холбогдсон асуудлыг энэ хуулиар тогтоогүй бол Үндэсний Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвшөөрлөөр Үндэсний Ассамблейн спикер тогтооно.</p>
5.	Финланд	<p><b><u>Финландын Парламентын хуралдааны дэг</u></b></p> <p><b>Зүйл 43а. Хорооны баримт бичгийг нийтлэх</b></p> <p>Хорооны тэмдэглэлийг мэдээллийн сүлжээнд байршуулж нийтэд нээлттэй байлгана. Асуудлыг хэлэлцэх бэлтгэлтэй холбоотой баримт бичгийг тухайн асуудал хороогоор шийдвэрлэгдсэний дараа нийтэд нээлттэй болгоно. Хэрэв нууцын зэрэглэлтэй биш бол хороонд болон хорооны ажлын хэсэгт төлөөлөлгүй парламентын бүлэг шийдвэрлэгдэж буй асуудалтай холбоотой баримт бичгийн хуулбарыг авах эрхтэй.</p> <p>Хэрэв хорооны баримт бичиг Финландын олон улсын харилцаа, хөрөнгө санхүү, санхүүгийн зах зээлд ноцтой хохирол учруулахаар бол тухайн мэдээллийг нийтэд задлахгүй. Олон нийтийн ашиг сонирхол баримт бичгийг нийтэд ил болгохыг шаардсанаас бусад тохиолдолд хэрэв баримт бичиг нь худалдааны нууц, мэргэжлийн мэдээлэл, хувь хүний эрүүл мэндийн байдал болон санхүүгийн байдал зэргийг агуулж баримт бичгийг ил болгосноор тухайн этгээдүүдэд ноцтой хохирол учруулахаар бол баримт бичгийг нууцална. Хороо нь дээрхтэй адил шалтгаанаар баримт бичгийг нууц хэвээр байлгаж болно.</p> <p>Үндсэн хуулийн 50.3 дугаар зүйлд заасны дагуу хороо баримт бичгийг нууцын зэрэглэлтэй гэж зарласан бол баримт бичгийг нууцална. Засгийн газар Финландын гадаад харилцаа, эсхүл Европын Холбоонд хамаарах асуудлыг нууцын зэрэглэлд байлгах хүсэлт гаргасан тохиолдолд хороо хүсэлтийн талаар шийдвэр гарах хүртэл тухайн асуудлыг нууцална.</p> <p>Хэрэв хороо хугацааг богиносгох тухай шийдвэр гаргаагүй бол хорооны нууцын зэрэглэлд оруулсан баримт бичгийг нууцлах хугацаа Засгийн газрын үйл ажиллагаа ил тод байх тухай актын 31 дүгээр зүйлд (621/1999) заасантай адил байна.</p> <p>Спикерийн зөвлөл хорооны баримт бичгийг нийтэд ил болгохтой холбоотой нарийвчилсан удирдамж гаргаж болно.</p>

# МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ДҮРЭМ

(Мэдээлэл, лавлагаа)

*Р.Нургүл, Р.Өнөрсайхан*

Энэхүү судалгаанд гадаадын зарим орны Парламентын ажлын алба (Тамгын газар)-ны үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрмийг тоймлон судалсан болно. Судалгаанд авагдсан орноос ОХУ, Казахстан (Парламентын доод танхим) нь Парламентын ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлыг дүрмээр зохицуулсан бол Бангладеш Улс нь дээрх харилцааг “Парламентын ажлын албаны тухай хууль”-иар зохицуулсан байна. Лавлагаанд гадаадын зарим улс орнууд (БНСУ, Серб, Швед) Парламентын ажлын албатай холбоотой асуудлыг Парламентын хуульдаа хэрхэн тусгасныг Хүснэгт 2-т тоймлон харуулав.

Уг сэдвийн хүрээнд мэдээллийн хайлт хийхэд Молдова, Латви зэрэг орнуудын Парламентын ажлын албаны дүрэм олдсон боловч дэлхийд нийтлэг хэрэглэгддэг хоёрдогч хэлээр орчуулагдаагүй тул судлах боломжгүй байв.

Энэхүү лавлагаанд хамрагдсан авагдсан улсуудын Парламентын ажлын албаны дүрэм, хууль дараах онцлогтой байна: (Дэлгэрүүлгүйг Хүснэгт 1-ээс үзнэ үү.)

## 1. МОНГОЛ УЛС

Судалгаанд авагдсан улсын холбогдох дүрмүүдтэй харьцуулахад Монгол Улсын Тамгын газрын дүрэмд дараах онцлох заалтууд орсон байна.

*I бүлэг. Нийтлэг үндэслэл.*

- Тамгын газар үйл ажиллагаа явуулахад баримтлах зарчим;
- Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, ажлын жилийн төлөвлөгөөтэй байх;
- Тамгын газар өөрийн үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах талаар тус тус заасан байна.

*II бүлэг. Тамгын газрын үүрэг, эрх.*

- Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад нь зөвлөх үүрэг бүхий зөвлөл Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэд ажиллах талаар, мөн Зөвлөлтэй холбоотой асуудлуудыг тусгасан байна.
- Тамгын газарт ажиллаж байгаа албан хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан тушаалд тавигдах шаардлага хангасан, төрийн мэргэшсэн албан хаагч байх ба төрийн ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын дэг журмыг сахиж, гагцхүү хуулийн хүрээнд ажиллах зарчмыг баримтална.

**Мөн IV бүлэгт УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албатай харилцах талаар, VI бүлэгт УИХ-ын даргын ажлын хэсэгтэй харилцах талаар тус тус зохицуулсан байна.**

## 2. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын Төрийн Думын Ажлын албаны дүрэмд дараах онцлог зохицуулалт байна:

*I бүлэг. Нийтлэг үндэслэл.* Ажлын алба нь улс төрийн нам, шашны болон олон нийтийн холбоо байгуулж болохгүй талаар зохицуулсан.

ОХУ-ын Төрийн Думын ажлын алба нь дараах бүтцийн нэгжүүдтэй байна<sup>291</sup>.

- Төрийн Думын дарга, түүний 1-р орлогч, орлогч нарын ажлын алба;
- Төрийн Думын гишүүдийн бүлгийн ажлын алба;
- Төрийн Думын хороод болон комиссуудын ажлын алба;
- Төрийн Думын Ажлын албаны дарга, түүний орлогч нарын ажлын алба;
- Удирдлагын болон бүтцийн бусад нэгжүүд.

Ажлын албаны бүтцийн нэгж бүр өөрийн гэсэн дүрэмтэй, түүнийг холбогдох удирдлага нь батлах бөгөөд бүтцийн нэгж бүрийн чиг үүргийг уг дүрмээр тодорхойлдог онцлогтой байна<sup>292</sup>.

*V бүлэг. Ажлын албаны ажилтнууд.* Ажилтнуудад үзүүлэх санхүүгийн, материаллаг, нийгмийн дэмжлэг туслалцаа, түүнчлэн соёлын болон эрүүл мэндийн үйлчилгээ нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн Захиргаа болон Засгийн газрын ажлын албаны ажилтан, албан хаагчдын хангамжтай ижил түвшинд байх тухай заасан байна.

## 3. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Мажилисын Ажлын албаны дүрмийн *II бүлэгт Мажилисын Ажлын албаны үндсэн чиг үүргийг* тодорхойлсон байна<sup>293</sup>. Үүнд:

1. Мажилисын үйл ажиллагаа болон Парламентын танхимуудын хамтарсан хуралдааныг зохион байгуулах;
2. Мажилисын үйл ажиллагаа болон Парламентын танхимуудын хамтарсан хуралдааныг явуулахад хууль, эрх зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, Мажилисаар хэлэлцэж буй хуулийн төсөлтэй холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэх;
3. Мажилисын гишүүдэд хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мөн Мажилисын гишүүдийн ажилд хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх;
4. Мажилисын үйл ажиллагааг мэдээ мэдээлэл, дүн шинжилгээгээр хангах;
5. Мажилисын гадаад харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах;
6. Мажилисын үйл ажиллагааг мэдээлэл харилцаа холбоогоор хангах;

<sup>291</sup> “Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын ажлын албаны тухай дүрэм” (*Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации*), IV бүлэг. Бүтцийн нэгжүүд болон үндсэн чиг үүрэг, 1 дүгээр зүйл. <http://duma.gov.ru/duma/staff/status/>

<sup>292</sup> “Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын ажлын албаны тухай дүрэм” (*Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации*), IV бүлэг. Бүтцийн нэгжүүд болон үндсэн чиг үүрэг, 2, 3 дугаар зүйл. <http://duma.gov.ru/duma/staff/status/>

<sup>293</sup> “Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисын ажлын албаны тухай дүрэм” (*Положение об Аппарате Мажилиса Парламента Республики Казахстан*), <http://www.parlam.kz/ru/mazhilis/apparat/documents>

7. Мажилисын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг зохион байгуулах;
8. Мажилисын боловсон хүчинтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх;
9. Мажилисын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд материаллаг хангамж болон техник хэрэгслээр хангах зэрэг болно.

Түүнчлэн дээрх зүйл тус бүрийн хүрээнд хийгдэх ажил үүргийг нарийвчлан заасан байна. Ийнхүү зааснаар Мажилисын ажлын албаны үндсэн чиг үүргийг илүү цэгцтэй, ойлгомжтой байдлаар тодорхойлжээ.

*IV бүлэгт. Төрийн албан хаагчдын эрх, үүрэг, хариуцлага болон хөдөлмөрийн нөхцөл.* Парламент болон Мажилисын тухайн бүрэн эрхийн хугацаа дуусах, шинээр гишүүд сонгогдох тохиолдолд Ажлын албанд ажилладаг төрийн албан хаагчдын ажил үүрэг дуусгавар болохгүй, хэвийн үргэлжлэх талаар тусгажээ.

#### **4. БҮГД НАЙРАМДАХ БАНГЛАДЕШ АРД УЛС**

Бангладеш Улсын Парламентын Ажлын албаны тухай хуульд дараах онцлог зохицуулалтуудыг тусгасан байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд УИХ-ын Тамгын газар байгуулах, ажилтан алба хаагчдын сонгон шалгаруулалт, ажиллах нөхцөл, чиг үүрэг үйл ажиллагааг зохицуулсан бөгөөд Үндсэн хуулийн 79 дүгээр заалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж заасан байна.
- Парламентын даргатай зөвшилцөж чуулганыг зарлан хуралдуулах, хойшлуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.
- Парламентын дарга нь Ажлын албаны төсвийг захиран зарцуулдаг.
- Парламентын гишүүдийн орон сууцны асуудал, орон сууцны тохижилтыг шийдвэрлэдэг байна.



Доорх хүснэгтэд судалгаанд хамрагдсан улсуудын Парламентын ажлын албадын дүрмийн агуулгыг тоймлон харуулав.

Хүснэгт 1

МОНГОЛ УЛС	ОХУ	БНКаЗУ	БАНГЛАДЕШ УЛС
Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм <sup>294</sup>	Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын ажлын албаны тухай дүрэм (Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации) <sup>295</sup>	Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисын ажлын албаны тухай дүрэм (Положение об Аппарате Мажилиса Парламента Республики Казахстан) <sup>296</sup>	Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Парламентын Ажлын Албаны тухай хууль (Parliament Secretariat Act, 1994) <sup>297</sup>
<b>I. Нийтлэг үндэслэл.</b> 1. УИХ-ын ажлын алба нь Тамгын газар байх талаар; 2. Тамгын газрын үндсэн чиг үүрэг; 3. Тамгын газар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд баримтлах хууль тогтоомжууд; 4. Тамгын газар үйл ажиллагаа явуулахад баримтлах зарчим; 5. Тамгын газар Улсын Их Хурлаас баталсан төсөвт зардлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах; 6. Тамгын газар хуулийн этгээд мөн бөгөөд тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх; 7. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, ажлын жилийн төлөвлөгөөтэй байх; 8. Тамгын газар өөрийн үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын	<b>I бүлэг. Нийтлэг үндэслэл</b> 1. Ажлын албаны үндсэн үйл ажиллагаа; 2. Ажлын алба үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд баримтлах хууль тогтоомжууд; 3. Ажлын алба нь улс төрийн нам, шашны болон олон нийтийн холбоо байгуулж болохгүй талаар; 4. Ажлын албаны хамтарч ажиллах байгууллагууд; 5. Ажлын албаны бүтэц, боловсон хүчний хангамж, ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний хэмжээ, материаллаг болон техник үйлчилгээний хангамж, Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг тогтоох; 6. Төрийн Думын хороодын ажлын албаны боловсон хүчний тоо хэмжээг тогтоох; 7. Төрийн Думын гишүүдийн бүлгийн ажлын албаны боловсон хүчний тоо	<b>I бүлэг. Нийтлэг үндэслэл.</b> Мажилисын ажлын албаны үндсэн үйл ажиллагаа, Ажлын албанд хамааралтай хууль, эрх зүйн зохицуулалтууд, Ажлын алба нь нэр, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байх талаар заасан. Мөн Ажлын албаны бүтэц, боловсон хүчний тоог тодорхойлох ажлыг Мажилисын Зөвлөл (Бюро) хэрэгжүүлэх талаар тусгасан байна.	<b>I. Нийтлэг үндэслэл.</b> - Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу Парламентын Ажлын алба нь нарийн бичгийн даргатай байна; - Парламентын Ажлын алба нь хараат бус байна; - Парламентын Ажлын алба нь энэхүү хуулийн дагуу томилогдсон ажилтан, албан хаагчдаас бүрдэнэ.

<sup>294</sup> Монгол Улсын Их Хурлын Тамгын Газрын Дүрэм, <https://www.legalinfo.mn/annex/details/3216?lawid=6256>

<sup>295</sup> Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации, <http://duma.gov.ru/duma/staff/status/>

<sup>296</sup> Положение об Аппарате Мажилиса Парламента Республики Казахстан, <http://www.parlam.kz/ru/mazhilis/apparat/documents>

<sup>297</sup> Parliament Secretariat Act, 1994, [http://www.commonlii.org/bd/legis/num\\_act/psa1994228/](http://www.commonlii.org/bd/legis/num_act/psa1994228/)



<p>Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах талаар тус тус заасан байна.</p>	<p>хэмжээг тогтоох; 8. Ажлын албаны үйл ажиллагаанд Төрийн Думын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах хороо хяналт тавих талаар тус тус тусгасан байна.</p>		
<p><b>II. Тамгын газрын үүрэг, эрх.</b> Тамгын газрын хэрэгжүүлэх эрхийг тодорхойлохоос гадна үндсэн ажил үүргүүдийн талаар тодорхой заасан байна.</p>	<p><b>II бүлэг. Ажлын албаны удирдлага.</b> 1. Ажлын албаны даргыг томилох болон чөлөөлөх; 2. Ажлын албаны даргын бүрэн эрх; 3. Ажлын албаны дарга нь бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах талаар тус тус заасан байна.</p>	<p><b>II бүлэг. Ажлын албаны үндсэн чиг үүрэг.</b> Энэ бүлэгт дараах 9 зүйлийг зохицуулжээ. Үүнд: 1. Мажилисын үйл ажиллагаа болон Парламентын танхимуудын хамтарсан хуралдааныг зохион байгуулах; 2. Мажилисын үйл ажиллагаа болон Парламентын танхимуудын хамтарсан хуралдааныг явуулахад хууль, эрх зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, Мажилисаар хэлэлцэж буй хуулийн төсөлтэй холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэх; 3. Мажилисын гишүүдэд хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мөн Мажилисын гишүүдийн ажилд хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх; 4. Мажилисын үйл ажиллагааг мэдээ мэдээлэл, дүн шинжилгээгээр хангах; 5. Мажилисын гадаад харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах; 6. Мажилисын үйл ажиллагааг мэдээлэл харилцаа холбоогоор хангах; 7. Мажилисын үйл ажиллагаатай</p>	<p><b>II. Парламентын Ажлын Албаны үүрэг, зохион байгуулалт</b> - Парламентын даргатай зөвшилцөж чуулганыг зарлан хуралдуулах, хойшлуулахтай холбоотой асуудал; - Парламентын номын сангийн үйл ажиллагаа, түүний зохион байгуулалт; - Парламентын байнгын болон бусад бүх хороодын хуралдааныг зарлан хуралдуулах, туслалцаа үзүүлэх, хуралдааны тэмдэглэл бэлтгэх; - Парламентын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, хэвлэу нийтлэх; - Парламентын гишүүдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай туслалцаа үзүүлэх; - Парламентын гишүүдийн орон сууцны асуудал хариуцах; - Парламентын цайны газрын хяналтыг сайжруулах; - Дарга, дэд дарга, парламентын гишүүдийн цалин, тэтгэмж олгохтой холбогдсон асуудлыг хариуцах; - Парламентын гишүүдийн орон сууцны тохижилтийн /тавилга/ асуудлыг шийдвэрлэх; - Парламентуудын Холбоо (Interparliamentary Union),</p>

		<p>холбоотой бичиг баримтыг зохион байгуулах;</p> <p>8. Мажилисын боловсон хүчинтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх;</p> <p>9. Мажилисын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд материаллаг хангамж болон техник хэрэгслээр хангах зэрэг болно. Түүнчлэн эдгээр зүйл тус бүрийн хүрээнд хийгдэх ажил үүргийг нарийвчлан заасан байна.</p>	<p>Commonwealth Parliamentary Association (CPA) болон SAARC-т багтсан орнуудын парламенттай харилцаа холбоо тогтоох;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын парламентын конвенци болон хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд парламентын төлөөлөгчдийн харилцан айлчлалыг зохион байгуулахтай холбоотой бүх ажлыг хариуцах;</li> <li>- Парламентын Тамгын газрын ажилтан, албан хаагчдад орон сууцны тусалцаа дэмжлэг үзүүлэх, хуваарилах;</li> <li>- Парламентын Ажлын албаны дотоод аюулгүй байдлыг хангах;</li> <li>- Парламентын Ажлын албаны хөгжлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.</li> </ul>
<p><b>III. Тамгын газрын удирдлага, зохион байгуулалт.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах;</li> <li>2. Ерөнхий нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүрэг;</li> <li>3. Ерөнхий нарийн бичгийн дарга Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг УИХ-ын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж, УИХ-ын даргатай зөвшилцөж батлах;</li> <li>4. Тамгын газрын дотоод журмаар тогтоох асуудлууд;</li> <li>5. Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөл;</li> <li>6. Зөвлөлийн бүрэлдэхүүн;</li> <li>7. Зөвлөлийн бүрэлдэхүүн,</li> </ol>	<p><b>III бүлэг. Ажлын албаны даргын орлогчид.</b></p> <p>1-р орлогч болон бусад орлогч нарыг томилох, чөлөөлөх, мөн орлогч нар нь Ажлын албаны нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулж, хянах талаар заасан.</p>	<p><b>III бүлэг. Ажлын алба болон түүний нэгжүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах.</b></p> <p>Тус бүлэг нь Ажлын албаны дарга, түүний орлогч нарыг томилох, чөлөөлөх болон тэдний эрх, үүргийн талаар зохицуулсан. Мөн Ажлын албаны нэгжийн дарга нар нь нэгжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар заасан байна.</p>	<p><b>III. Ажлын Албаны захиргааны үүрэг.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1) Нарийн бичгийн дарга Ажлын албаны үйл ажиллагааг Парламентын даргын өмнө бүрэн хариуцна.</li> <li>2) Парламентийн Ажлын албаны бүх ажилтан албан хаагчид нарийн бичгийн даргын өмнө хариуцлага хүлээх бөгөөд Нарийн бичгийн даргын шууд удирдлаган дор албан үүргээ гүйцэтгэнэ.</li> </ol>

<p>ажиллах журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батлах;</p> <p>8. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлууд;</p> <p>9. Тамгын газарт ажиллаж байгаа албан хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим;</p> <p>10. Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг Ерөнхий нарийн бичгийн дарга батлах;</p> <p>11. Тамгын газар нь Байнгын хорооны ажлын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах талаар тус тус зохицуулсан байна.</p>			
--	--	--	--

<p><b>IV.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албатай харилцах</b></p> <p>1.Тодорхой асуудлын хүрээнд Тамгын газарт хүргүүлсэн УИХ дахь нам, эвслийн бүлгийн санал дүгнэлтийг олшруулах, тараах ажлыг хариуцах</p> <p>2.Тамгын газар болон нам, эвслийн бүлэг үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах</p> <p>3.Тамгын газар нь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар тус тус заасан байна.</p>	<p><b>IV бүлэг. Бүтцийн нэгжүүд болон үндсэн чиг үүрэг</b></p> <p>1. Ажлын албаны бүтцэд орох нэгжүүд. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн Думын дарга, түүний 1-р орлогч, орлогч нарын ажлын алба;</li> <li>• Төрийн Думын гишүүдийн бүлгийн ажлын алба;</li> <li>• Төрийн Думын хороод болон комиссуудын ажлын алба;</li> <li>• Төрийн Думын Ажлын албаны дарга, түүний орлогч нарын ажлын алба;</li> <li>• Удирдлагын болон бүтцийн бусад нэгжтэй байх.</li> </ul> <p>2. Ажлын албаны бүтцийн нэгж бүрийн дүрмийг холбогдох удирдлага нь батлах;</p> <p>3. Бүтцийн нэгж бүрийн чиг үүргийг холбогдох дүрмээр тодорхойлох;</p> <p>4. Бүтцийн нэгж бүрт холбогдох дүрмийн эх хувь Төрийн алба болон боловсон хүчний удирдах газарт хадгалагдах;</p> <p>5. Төрийн Думын гишүүдийн туслахуудын тухай тус тус зохицуулсан байна.</p>	<p><b>IV бүлэгт. Төрийн албан хаагчдын эрх, үүрэг, хариуцлага болон хөдөлмөрийн нөхцөл.</b> Энэ бүлэгт албан хаагчдад хамааралтай эдгээр асуудлыг зохицуулах хууль тогтоомжуудыг заасан байна. Мөн Парламент болон Мажилисын тухайн бүрэн эрхийн хугацаа дуусах, шинээр гишүүд сонгогдох тохиолдолд Ажлын албанд ажилладаг төрийн албан хаагчдын ажил үүрэг дуусгавар болохгүй, хэвийн үргэлжлэх талаар тусгажээ.</p>	<p><b>IV. Парламентын Ажлын Албаны ажиллах зохион байгуулалт</b></p> <p>1.Парламентын Ажлын алба нь аливаа яам, хэлтэс, архивын газар зэрэг Засгийн Газрын салбар болон бусад байгууллагуудтай шууд холбоо тогтоох эрхтэй.</p> <p>2.Парламентын дарга нь Ажлын албаны үүрэг, зохион байгуулалтын журам, тогтоолыг батлах эрхтэй.</p>
<p><b>V. 2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.</b></p>	<p><b>V бүлэг. Ажлын албаны ажилтнууд.</b> Энэ бүлэг нь Төрийн Думын Ажлын албаны ажилтнууд болон нэгжүүдийн удирдлагыг томилох, чөлөөлөх, түүнчлэн ажилтнуудын ажил үүргийн чиглэлийг тодорхойлж батлах талаар зохицуулсан. Мөн ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлыг зохицуулах хууль тогтоомжуудыг заажээ. Ажилтнуудад үзүүлэх санхүүгийн, материаллаг, нийгмийн дэмжлэг туслалцаа, түүнчлэн соёлын</p>		<p><b>V. Ажлын Албаны ажилтнуудын томилгоо, ажлын зохион байгуулалт</b></p> <p>1.Парламентын Ажлын албаны ажилтнуудын томилгоо нь холбогдох журам батлагдах хүртэл 1982 оны Парламентын Ажлын албаны албан хаагчдыг томилох тухай /Parliament Secretariat Officers and Employees Recruitment Rules/ дотоод журмаар зохицуулагдана.</p> <p>2.Парламентын дарга нь Ажлын</p>

	болон эрүүл мэндийн үйлчилгээ нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн Захиргаа болон Засгийн газрын ажлын албаны ажилтан, албан хаагчдын хангамжтай ижил түвшинд байх тухай заасан байна. Түүнээс гадна ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлагын талаар зохицуулах хууль тогтоомжуудыг тусгажээ.		албаны үйл ажиллагааг Парламентад танилцуулах үүрэгтэй. 3. Парламентын дарга нь Ажлын албаны төсвийн зохицуулалтыг бүрэн хариуцна.
<b>VI. Улсын Их Хурлын даргын ажлын хэсэгтэй харилцах</b> 1. Тамгын газар нь УИХ-ын даргын ажлын хэсэгтэй Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан харилцах 2. Тамгын газар нь Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх 3. Улсын Их Хурлын даргын зөвлөх, ажлын хэсгийн ажилтан Тамгын газарт харьяалагдах талаар тус тус тусгасан.			<b>VI. Парламентын Ажлын Албаны төсөв зохицуулалт:</b> 1. Төсвийн жил эхлэхээс 3 сарын өмнө Парламентын дарга нь Ажлын албаны тухайн жилийн нийт төсвийг урьдчилан танилцуулсан байна. 2. (1)-т заасан танилцуулах мэдэгдэл нь дарга, дэд дарга, парламентын гишүүдийн цалин, тэтгэмж болон Парламентын Ажлын албаны ажилтнуудын цалин, тэтгэмж, Ажлын албаны захиргааны зардал болон Парламентын гишүүдийн орон сууцны зэрэг нийт зардал хамаарна. 3. (2)-т заасан мэдэгдэл нь Сангийн яаманд хүргэгдэх ба Засгийн газрын тухайн жилийн төсөв хамт батлагдана. 4. Ажлын албаны жилийн төсөв батлагдсанаас хойш төсвийн зарцуулалтад Аудитын хяналт шалгалт, мөн Парламент хяналт тавих эрхтэй байна.



Дэлхийн улс орнууд Парламентын ажлын албатай холбоотой асуудлыг Парламентын хуульдаа хэрхэн тусгасныг Хүснэгт 2-тоймлон харуулав. Тухайлбал, Солонгос улсын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйлд Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай, Серби улсын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 16 дугаар бүлэгт Үндэсний Ассамблейн Ажлын албаны тухай, Шведийн улсын Риксдагийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт Риксдагийн удирдах газрын тухай тус тус зохицуулжээ.

Хүснэгт 2

Бүгд Найрамдах Солонгос Улс	Бүгд Найрамдах Серби Улс	Шведийн Хаант Улс
Үндэсний Ассамблейн тухай хууль 21 дүгээр зүйл. Үндэсний Ассамблейн Тамгын газар <sup>298</sup>	Үндэсний Ассамблейн тухай хууль 16 дугаар бүлэг. Үндэсний Ассамблейн Ажлын алба <sup>299</sup>	Риксдагийн тухай хууль 14 дүгээр бүлэг. Риксдагийн удирдах газар <sup>300</sup>
<ol style="list-style-type: none"> <li>1. Үндэсний Ассамблейн Тамгын газрын зорилго;</li> <li>2. Тамгын газар нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон бусад төрийн албан хаагчдаас бүрдэх;</li> <li>3. Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;</li> <li>4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний Ассамблейн даргын удирдлаган дор Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд хяналт тавих;</li> <li>5. Тамгын газар нь Үндэсний Ассамблейн гишүүн болон хороодоос хүсэлт гаргасны дагуу шаардлагатай материалаар хангах;</li> <li>6. Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл түүнээс үүрэг авсан ажилтан 5-д заасан тохиолдолд хорооны өмнө тайлан тавих, тайлбар хийх;</li> </ol>	<p><b>68 дугаар зүйл.</b> “Үндэсний Ассамблейн техникийн болон бусад бэлтгэл ажлуудыг Үндэсний Ассамблейн Ажлын алба хариуцан ажиллана. Тус албаны ерөнхий зохион байгуулалтыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана.”</p> <p><b>69 дүгээр зүйл.</b> Ерөнхий нарийн бичгийн дарга нь журам, тушаал, шийдвэр, захирамж гаргана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэ зүйлийн эхний хэсэгт зааснаас гадна хүний нөөцийн төлөвлөлт, ажлын албаны жилийн хөтөлбөр, хөгжлийн хэтийн төлөвлөгөөг батална.</p> <p><b>70 дугаар зүйл.</b> Төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, бусад холбогдох журам болон төрийн байгууллагуудын хөдөлмөрийн болон хамтын гэрээний тухай ерөнхий дүрмүүд нь Үндэсний Ассамблейн Ажлын Албаны ажилтан, албан хаагчдад мөн</p>	<p><b>2 дугаар зүйл.</b> “Парламентын Удирдах Газар нь Парламент (Riksdag)-ын дотоод болон Европын Холбооны асуудал эрхэлсэн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Парламент (Riksdag)-ын гишүүдэд зөвлөн туслах, салбар чиглэлээр байнгын хороодын үйл ажиллагаанд чиглэсэн бодит мэдээллээр хангах үүрэгтэй.</p> <p>Үүнээс гадна Парламентын Удирдах Газар нь дараах чиг үүргийн хүрээнд ажиллана:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын хэлэлцээ хийх, маргааны нөхцөлд Парламент (Riksdag)-ын харьяа эрх бүхий байгууллагыг төлөөлөх;</li> <li>2. Засгийн газрын нэгдсэн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх талаар санал авах, төлөвлөх (Үндэсний Аудитын Газарт хамаарахгүй);</li> <li>3. Парламент (Riksdag)-ын захиргаатай холбоотой</li> </ol>

<sup>298</sup> Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act), 21 дүгээр зүйл. Үндэсний Ассамблейн Тамгын газар, [http://korea.assembly.go.kr/res/low\\_06\\_list.jsp](http://korea.assembly.go.kr/res/low_06_list.jsp)

<sup>299</sup> Үндэсний Ассамблейн тухай хууль (The Law on The National Assembly), 16 дугаар бүлэг, 68-72 дугаар зүйл, <http://www.parlament.rs/upload/documents/The%20Law%20on%20the%20National%20Assembly.pdf>

<sup>300</sup> Риксдагийн тухай хууль (The Riksdag Act), 14 дүгээр бүлэг. Риксдагийн удирдах газар, <https://www.riksdagen.se/globalassets/07.-dokument-lagar/the-riksdag-act-2015.pdf>



<p>7. Энэ хуульд зааснаас бусад харилцааг өөр хуулиар тогтоох талаар тус тус заасан байна.</p>	<p>үйлчилнэ.  <b>71 дүгээр зүйл.</b> Төрийн Байгууллагын Нийтлэг Үйлчилгээний Алба нь Үндэсний Ассамблейд тээврийн хэрэгсэл, засвар үйлчилгээ, гарааш, нийтийн хоолны үйлчилгээ үзүүлнэ.  Мөн дотоод аюулгүй байдал, дэг журам сахиулах үйлчилгээг Дотоод хэргийн яамны аюулгүй байдлын албаны ажилтнууд Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.  <b>72 дугаар зүйл.</b> Ажлын албаны зохион байгуулалт, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад асуудлыг Ассамблейн дотоод журмын дагуу Үндэсний Ассамблейн тухай хууль болон Үндэсний Ассамблейн холбогдох эрх бүхий хорооны актаар зохицуулна.</p>	<p>болон парламентын дэргэдэх Риксбанкнаас бусад санхүүгийн байгууллагуудтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх;  4.1-3 дугаар хэсэгт заасан асуудлуудын талаарх холбогдох журам, зөвлөмжийг батлах.  <b>3 дугаар зүйл.</b> Парламентын Удирдах Газрын үндсэн чиглэлийг Парламент (Riksdag) хариуцна.  <b>4 дүгээр зүйл.</b> Парламентын ерөнхий нарийн бичгийн дарга нь Парламентын Удирдах Газрыг удирдан бөгөөд танхимын хуралдааны тэмдэглэлийг нягт хөтлөх, Парламентаас гаргасан шийдвэрийг нийтэд мэдээлэх, Парламентын даргын ажил үүрэгт туслалцаа үзүүлэх үүрэгтэй.</p>
--	---	---

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://duma.gov.ru/duma/staff/status/>
- <http://www.parlam.kz/ru/mazhilis/apparat/documents>
- <https://www.legalinfo.mn/annex/details/3216?lawid=6256>
- [http://www.commonlii.org/bd/legis/num\\_act/psa1994228/](http://www.commonlii.org/bd/legis/num_act/psa1994228/)
- <http://www.parlament.rs/upload/documents/The%20Law%20on%20the%20National%20Assembly.pdf>
- <https://www.riksdagen.se/globalassets/07.-dokument--lagar/the-riksdag-act-2015.pdf>
- [http://korea.assembly.go.kr/res/low\\_06\\_list.jsp](http://korea.assembly.go.kr/res/low_06_list.jsp)

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ЦАЛИНГИЙН  
СИСТЕМ, НИЙГМИЙН БАТАЛГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН  
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ,  
Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл,  
Р.Оргилмаа, Р.Өнөрсайхан, Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

**Нэг. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

- 1.1. Оршил хэсэг
- 1.2. Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр боловсруулахад анхаарах асуудал, бусад орнуудын туршлага
- 1.3. Зөвлөмж

**Хоёр. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

- 2.1. ОХУ
- 2.2. Австрали Улс
- 2.3. АНУ
- 2.4. Герман Улс
- 2.5. Ирланд Улс
- 2.6. Солонгос Улс
- 2.7. Эстони Улс
- 2.8. Энэтхэг Улс

**Гурав. ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ  
АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## Нэг. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### 1.1. ОРШИЛ ХЭСЭГ

Улсын Их Хурлын 2019 оны 12-р сарын 20-ны өдрийн 106-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө” (цаашид Стратеги төлөвлөгөө гэх)-г хэрэгжүүлэх хүрээнд Стратеги төлөвлөгөөний 6.1 “УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж чадавхыг бэхжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” зорилтын дагуу төлөвлөгдсөн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** Сайн туршлага бүхий дэлхийн бусад орнуудын парламентын ажлын албадын цалин хөлсний систем, хүний нөөцийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийн талаарх туршлагыг судалж харьцуулсан лавлагаа мэдээлэл бэлтгэх, улмаар УИХ-ын Тамгын газраас уг стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг тодохойлоход туршлага болохуйц мэдээллийг багцлан хүргэх, Тамгын газрын холбогдох хэлтэс, нэгжүүдэд мэдээллийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгааны явцад гадаадын бусад орнуудын парламентын ажлын албадын хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, албан тушаалд тавигдах шаардлага, цалин хөлс, урамшууллын систем, ажилтнуудын нийгмийн үйлчилгээ болон баталгааны талаарх мэдээллийг эрх зүйн зохицуулалт болон практик туршлагын хүрээнд судалж, мэдээллийн илэрц сайтай, жишиг болохуйц тогтолцоотой ОХУ, Австрали, АНУ, ХБНГУ, Ирланд, БНСУ, Энэтхэг, Эстони зэрэг 8 орны туршлагыг дэлгэрэнгүй байдлаар харьцуулан судлав.

Судалгааны явцад, ардчилсан парламентын засаглалыг хөгжүүлэх зарчим, бодлогын хүрээнд парламентын мэргэшсэн ажлын албыг бүрдүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэхэд олон улсын хэмжээнд баримталдаг бодлого, зарчмууд болон бусад орнуудын сайн туршлагад суурилсан гарын авлага, зөвлөмж бий эсэх талаар мэдээллийн хайлт хийж, дараах эх сурвалжуудыг хамтатган судалж, судалгааны хураангуй хэсгийг боловсруулахад ашиглав. Үүнд:

1. Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2030)-ын хүрээнд батлан гаргасан “Олон Улсын Парламентын холбоо (IPU)-ны 2017-2021 оны стратеги”;
2. ОУПХ (IPU)-ноос парламентын зарим мэргэшсэн ажлын албадын ажил үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулан гаргасан гарын авлага, зөвлөмжүүд;
3. Зарим орны парламентын ажлын албаны ажилтнуудад зориулсан гарын авлагууд;
4. Судалгаанд авагдсан орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт (Судалгааны хэсгээс үзнэ үү).

**Судалгааны үр дүн:** Дэлхий нийтийн чиг хандлагаас үзэхэд парламентын засаглал сонгодог утгаараа төлөвшсөн, өндөр хөгжилтэй зарим орнууд (тухайлбал

ИБУИНВУ, АНУ, Австрали, БНСУ гэх мэт)-ын хувьд парламентын үндсэн чиг үүргийг хариуцлагатай, чанартай хэрэгжүүлж хүчирхэг, ардчилсан парламентын засаглалыг төлөвшүүлэхэд парламентын ажлын албаны мэргэшсэн байдал, үзүүлж буй ажил үйлчилгээ, үүнд чиглэсэн хүний нөөцийн бодлого, зохицуулалт, удирдлага, менежментийн арга барил чухал болох нь харагдаж байна.

## **1.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

***Нэг. Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа юуны өмнө, тухайн байгууллага (парламентын ажлын алба)-д ажиллагсад нь тодорхой шаардлагад нийцэж, үр бүтээлтэй ажиллахаас гадна хувь хүнийхээ хувьд ирээдүйтэй, баталгаатай, ажил-амьдралын бүх асуудлыг зохицуулсан хүний нөөцийн бодлого бүхий үнэт зүйл, зарчимтай байгууллагад ажилладаг гэдэгт итгэлтэй байх ёстой болдог учраас байгууллагын үнэт зүйлс болон хүний нөөцийн бодлогын (ХНБ) хүрээнд баримтлах зарчмуудыг тодорхой болгосон байх шаардлагатай.***

Жишээ нь: ИБУИНВУ-ын Парламентын ажлын алба хүний нөөцийн үнэт зүйлсээ дараах байдлаар тодорхойлжээ\*:

Core value: тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн үр нөлөөтэй, бүтээмжтэй, мэдээлэл сайтай хүний нөөцийг бүрдүүлэх. Үүнд:

1. Шударга байдал (integrity)- Парламентын гишүүд, хороод болон олон нийтэд тэгш, шударга, алагчлалгүй, үнэнч шударгаар үйлчлэх;
2. Мэргэшсэн байдал (professionalism) - ажил үйлчилгээг дээд зэргээр, өндөр бүтээмжтэй, нягт нямбай, оновчтой арга хэлбэрээр хүргэх чадвартай байхаас гадна байнга урагш тэмүүлж, өөрчлөгдөж байгаа ажлын шаардлагад нийцэж ажиллах;
3. Багаар ажиллах (teamworking)- харилцан бие биенээ дэмжиж, итгэлцэл, хүндлэл дээр тулгуурласан хамтын ажиллагааг бий болгох;
4. Хүлээн зөвшөөрөгдөх (recognition)- хувь хүний хөгжлийг аль болохоор дээшлүүлж, хувь хүн бүрийн оролцоо болон ялгаатай байдлыг үнэлж, тэгш боломж олгохын төлөө байх;
5. Итгэл үнэмшил (commitment)- Парламентын ажлын алба бол ажил-амьдралын асуудлаа тэнцвэртэй зохицуулахын чухлыг хүлээн зөвшөөрсөн, одоо байгаагаасаа илүү их боломжийг олж болох, ажиллахад хамгийн тохиромжтой газар гэдэгт ажилтнууд итгэлтэй байх

\*(House of Commons, UK, <http://intranet.parliament.uk/people-offices/administration/business-planning/business-plans/corporate-business-plan-201112/>)

***Хоёр. Бусад орнуудын туршлагаас үзэхэд парламентын ажлын албаны хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд дараах асуудлуудыг нийтлэг авч үздэг бөгөөд холбогдох эрх зүйн актууд болон дүрэм, журмаар зохицуулан баталгаажуулсан байна. Судалгаанд авагдсан орнуудын туршлага, нийтлэг жишгийг харгалзан ХНБ-ын хүрээнд зохицуулах асуудлуудыг дараах байдлаар тоймлон танилцуулж байна. Үүнд:***

1. Эрх зүйн баталгаа (төрийн албаны хаагчийн болон хууль тогтоох байгууллагын ажлын албаны албан хаагчийн статус, эрх зүйн зохицуулалт, холбогдох дүрэм, журам);
2. Цалингийн сүлжээ (үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын систем);
3. Байгууллагын бүтэц, удирдлага, менежмент;
4. Ажлын байранд тавигдах шаардлага (ажилтанд тавигдах шаардлага, ажлын байрны тодорхойлолт, байгууллага болон ажилтны эрх, үүрэг гэх мэт);
5. Ажлын байрны нөхцөл, нийтлэг болон тусгай хэрэгцээтэй албан хаагчдын асуудлыг зохицуулах (ажлын байрны хэвийн нөхцөл бүрдүүлэх, ажлын цаг, илүү цаг, цайны завсарлага, ээлжийн амралт, баяр ёслолын амралт, чөлөө олгох, хүүхэд төрүүлэх, үрчлэх, ар гэрийн гачигдал, шөнийн ээлжийн ажил, давхар ажил, хагас цагаар, уян хатан цагаар, гэрээр ажиллах, яаралтай горимоор ажиллахтай холбоотой ажлын цагийн зохицуулалт, ахмад болон залуу ажилтны хөдөлмөрийн онцлог, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны асуудал гэх мэт);
6. Ажилтнуудад үзүүлэх сервис үйлчилгээ (ажлын байр, хоол, унаа, бялдаржуулах болон амралт чөлөөт цагаа өнгөрөөх, аялал зугаалга, банк, АТМ, машины зогсоол, харуул хамгаалалт, хүүхэд асрах үйлчилгээ, тамхины цэг гэх мэт);
7. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, аюулгүй байдал (эмнэлэг, эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ, ажлын байранд эрсдлээс хамгаалах, стресс бууруулах, эмнэлгийн чөлөө, өвчний акт, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа, ар гэрийн гачигдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн хяналт, гал команд гэх мэт);
8. Сурч боловсрох, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломж (урт-богино хугацаагаар сурах, мэргэших, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, карьер өгсөх, сэлгэн ажиллахад чиглэсэн байгууллагын менежмент, коучинг, ментор, дадлагажуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэх мэт);
9. Тэгш эрх, бие хүний ялгаатай байдлыг зохицуулах (удирдлага болон ажилнуудын эрх, үүрэг, ажлын байран дахь дарамт, ялгаварлан гадуурхалт, оролцох болон эс оролцох зарчим, зан төрхийн онцлогийг зохицуулах, сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх, санал гомдол барагдуулах, стрессийн хүчин зүйлийг бууруулах, парламентын гишүүд, удирдлага болон ажилтан хоорондын харилцаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлэх, ажлын байран дахь маргаан, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, үйл ажиллагааны доголдлыг засах, муу ажилтантай ажиллах гэх мэт);
10. Тайлагнал, хариуцлагын систем (тайлан, төлөвлөлт, үр дүнгийн үнэлгээ, хариуцлага, сахилга батыг хянах, сайжруулах гэх мэт);
11. Дижитал систем, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал;
12. Парламентын гишүүнтэй харилцах, ажил мэргэжлийн этик, ёс зүй;
13. Ажлаас гарах, чөлөөлөгдөх;
14. Тэтгэвэр тогтоолгох, өндөр настны халамж, дэмжлэг гэх мэт.

***Гурав. Судалгаанд авагдсан орнуудын парламентын ажлын албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалттай холбоотой туршлагыг дараах***

## **байдлаар тоймлон хүргэж байна. Тухайлбал:**

**1. Эрх зүйн зохицуулалтын хүрээг авч үзвэл:** Судалгаанд авагдсан орнуудын парламентын хүний нөөцийн асуудлыг Австрали, Ирланд, Солонгос улсууд Парламентын ажлын албаны тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журмаар, Америк, Орос, Эстони зэрэг улсууд Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулсан бол Герман, Энэтхэг улсууд ажлын албаны дотоод журмаараа зохицуулсан байна. Тухайлбал:

**ОХУ-ын хувьд** Төрийн Думын Аппаратын үйл ажиллагаа, албан хаагчдын эрх, үүрэг, хариуцлагыг ОХУ-ын төрийн албаны холбогдох хууль тогтоомж, ОХУ-ын Төрийн Думын регламент, Төрийн Думын Аппарат (Тамгын газар)-ын дүрмээр тодорхойлдог байна. Төрийн Думын регламент<sup>301</sup> буюу дэгийн 78.1-д “Төрийн Думын депутат, намын бүлэг, Хороо, Комисс болон Төрийн Думын дарга, түүний орлогчийн эрх зүй, зохион байгуулалт, баримт бичиг, **судалгаа, мэдээлэл**, санхүү, материал-техник, нийгэм-ахуйн хангамжийн асуудлыг Төрийн Думын Ажлын Аппарат хэрэгжүүлнэ”<sup>302</sup> гэж заасан. Аппаратын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Төрийн Думын Аппаратын дүрмээр нарийвчлан зохицуулсан байх ба Төрийн Думын дарга (спикер)-ын захирамжаар дүрмийг баталдаг. Тамгын газрын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, санхүү, нийгэм ахуй, эрүүл мэндийн хангамжийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын аппаратын ажилтнуудынхтай адил түвшинд тогтоосон. Төрийн Думын аппарат нь дэргэдээ Үйлдвэрчний зөвлөлтэй байж болдог.

**Австрали улсын хувьд** Парламентын ажлын албаны ажилтнуудад холбоотой асуудлыг Парламентын ажлын албаны тухай хууль (*Parliamentary Service Act 1999*) болон Парламентын ажлын албаны “Байгууллагын гэрээ 2017” (*Department of Parliamentary Services Enterprise Agreement 2017*)-р зохицуулдаг<sup>303</sup>. Мөн түүнчлэн холбооны улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа захиргаа удирдлага, хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал чиглэлийн бусад бүх хууль тогтоомжуудыг дагаж мөрдөнө. Австралийн парламентын ажлын албаны хүний нөөцийн харилцааг зохицуулсан хамгийн гол акт нь *Parliamentary Services Enterprise Agreement -2017* буюу “Парламентын үйлчилгээний гэрээ -2017” хэмээх бичиг баримт юм. Энэхүү гэрээ нь Австралийн үндэсний “Тодорхой хөдөлмөр эрхлэлтийн тухай” (*Fair Work Act 2009*) хуулийн 172 дугаар зүйлийн хүрээнд байгуулсан гэрээ бөгөөд парламентын ажлын албанд ажиллагсдын хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нийгмийн баталгааны бүхий л асуудлыг энэ гэрээгээр зохицуулдаг.

**АНУ-ын хувьд** Сенат болон Төлөөлөгчдийн танхим нь тус тусдаа ажлын албатай байна. АНУ-ын Хүний нөөцийн алба нь (US Office of Personnel Management)<sup>304</sup> холбогдох хууль тогтоомжийн дагуу холбооны засгийн газрын хэмжээнд мөрдөх хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, төрийн албан хаагчдын эрүүл мэнд,

<sup>301</sup> Регламент Государственной Думы. Принят постановлением Государственной Думы Федерального Собрания Российской Федерации от 22 января 1998 года № 2134-II ГД. Эх сурвалж: <http://old.duma.gov.ru/about/regulations/>

<sup>302</sup> Эх сурвалж: Оросын Холбооны Улсын Төрийн Думын регламент (Гарын авлага). Ц.Цолмон ба бусад. Мөнхийн үсэг, 2019 он. 53-54 дэх тал.

<sup>303</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Employment/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Employment\\_Condition](https://www.aph.gov.au/About_Parliament/Employment/Department_of_Parliamentary_Services/Employment_Condition)

<sup>304</sup> <https://www.opm.gov/about-us/>



нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, даатгалын хөтөлбөрүүдийг удирдан зохион байгуулж, төрийн албаны шатлан дэвших зарчмыг баримтлан ажилд томилох болон ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвших зэрэгт холбооны засгийн газрын харьяа агентлагуудад хяналт тавьж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажилладаг байна. Холбооны засгийн газрын харьяа агентлаг, албан газрууд нь холбогдох хууль тогтоомж болон АНУ-ын Хүний нөөцийн албанаас баталсан дүрэм журам, заавар зөвлөмжийн дагуу, түүнтэй уялдуулж үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.<sup>305</sup>

Холбооны засгийн газрын харьяа агентлагууд нь ажиллах хүчнээ хөгжүүлэх, чадавхжуулах, тэдэнд зориулсан сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулахдаа Нэгдсэн Улсын Код 5 дугаар зүйл, Бүлэг 41 Сургалт<sup>306</sup>, Холбооны журмын 410<sup>307</sup>, 412<sup>308</sup> дугаар зүйлүүд болон холбогдох бусад хууль, дүрэм, журмуудыг баримталдаг байна. Хууль тогтоох байгууллагын ажлын албаны ажилтнуудын цалин хөлс, урамшууллын асуудал нь холбооны засгийн газрын нийт ажилтан, албан хаагчдын дийлэнх олонход мөрдөж буй цалингийн ангилал, зэрэглэлд хамаарагдаж байна.

**ХБНГУ-ын хувьд** Бундестагийн Ерөнхийлөгч нь ард түмний төлөөллийг хэрэгжүүлэгч Элч бөгөөд Холбооны Улсын дээд эрх мэдлийн байгууллага болох Германы Бундестагийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготой байгуулсан Тамгын газрын толгойлогч дарга (захирагч) юм. Ерөнхийлөгч Тамгын газрын дүрмийг тодорхойлно.

**Ирланд улсын хувьд** төрийн алба нь түүхэн уламжлалаа хадгалсан нэлээд онцлог хэв шинжтэй, төрийн албан хаагчдын ангилал, зэрэг дэв, нэр томьёо харилцан адилгүй байдаг. Төрийн алба, тэр дундаа парламентын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд Парламентын албан хаагчийн тухай хууль, Яамдын болон парламентын албан байрны хууль, Төрийн албаны зохицуулалтын тухай хууль, Төрийн албаны комиссын тухай, Парламентын комиссын тухай хууль, Нийтийн албаны удирдлагын хууль, Тэтгэврийн насны тухай зэрэг өнө эртний хуулиуд мөрдөгдөж, холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд орсоор байна. 1959 оны Парламентын Тамгын газрын албан хаагчдын тухай хуульд тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, дэд дарга, аюулгүй байдал болон үйлчилгээний асуудал эрхэлсэн дарга нарыг томилохтой холбоотой асуудлыг тусад нь зохицуулсан. Мөн Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг өндөр албан тушаалтны цалинтай холбогдох асуудлыг тусгай хуулиар зохицуулна. 2015 оны тус хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга болон дэд дарга нарыг Парламентын комисс хэмээх бие даасан байгууллагаас парламентын дээд танхимын дарга нэр дэвшүүлснээр томилох болсон байна. Тус хуульд парламентын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэй албан хаагчид нь төрийн албан хаагчид хамаарна гэж заасан байна.

<sup>305</sup> <https://www.loc.gov/careers/working-at-the-library/benefits/>

<sup>306</sup> <https://www.law.cornell.edu/uscode/text/5/part-III/subpart-C/chapter-41>

<sup>307</sup> <https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?c=ecfr&sid=3098262948269d8650f63b050af2012e&rgn=div5&view=text&node=5:1.0.1.2.58&idno=5>

<sup>308</sup> <https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?c=ecfr&sid=3098262948269d8650f63b050af2012e&rgn=div5&view=text&node=5:1.0.1.2.58&idno=5>

**Эстони улсын хувьд** Парламент (Рийгикогу)-ийн ажлын алба (канцлер) нь Рийгикогуг Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Рийгикогугийн канцлер нь 1992 оны 10 дугаар сард байгуулагдсан ба чиг үүргийг нь Рийгикогугийн журмын тухай хууль<sup>309</sup> болон Рийгикогугийн канцлерийн дүрмээр<sup>310</sup> зохицуулдаг бөгөөд Рийгикогугийн Удирдах зөвлөлд ажлаа хариуцан тайлагнадаг. Рийгикогугийн Удирдах зөвлөлөөс Канцлерийн бүтэц, орон тоог батлах ба Рийгикогугийн журмын тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийг үндэслэн тэдгээрийн цалингийн удирдамж<sup>311</sup> - ийг мөн тогтоодог.

**Энэтхэг улсын хувьд** Парламент нь доод танхим буюу Ардын танхим (House of People/ Lok Sabha), дээд танхим буюу Муж улсуудын зөвлөл (Council of State/ Rajya Sabha) гэсэн хоёр танхимтай. Үндсэн хуулийн 98 дүгээр зүйлийн 1-д “Парламентын танхим тус бүр орон тооны Тамгын газартай байна”, Үндсэн хуулийн 98 дугаар зүйлийн 2-т, “...Парламентын танхим бүрийн Тамгын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үүрэг, хариуцлагын асуудал болон ажиллах нөхцөлийг Парламент хуулиар зохицуулна”, Үндсэн хуулийн 98 дугаар зүйлийн 3-т, “...Парламентын танхим тус бүрийн Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах ба Үндсэн хууль болон Парламентын дээд, доод танхимын даргаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд ажиллана” гэж тус тус заажээ. Энэ хүрээнд Парламентын доод танхим буюу Ардын танхимын дарга Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дараа Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга ажилтнуудыг сонгох, ажилд авах, тэдгээрийн ажил үйлчилгээний нөхцөл, ажлын байранд тавигдах шалгуур, сонгон шалгаруулалтыг Парламентын доод танхим (Lok Sabha)-ын ажлын албаны дотоод журам, 1955 (Lok Sabha Secretariat (Recruitment and Conditions of Service) Rules, 1955 болон “Ажилд авах нөхцөл, түүнд тавигдах шалгуур” ЕНБД-ын 2007 оны захирамж (Recruitment and conditions of service orders, 2007)-оор зохицуулсан. Парламентын доод танхимын Тамгын газар нь шаардлага хангахуйц боловсон хүчнээр хангах зорилгоор албан тушаалын орон тооны 50%-ийг нийтэд нээлттэй зарлан сонгон шалгаруулж, 50%-ийг ажлын албаны албан хаагчдаас шатлан дэвшүүлэх зарчмаар томилдог байна.<sup>312</sup>

**БНСУ-ын хувьд** Үндэсний Ассамблейн Судалгааны албаны туршлагыг тусгайлан судалсан бөгөөд тус албаны хүний нөөцийн асуудлыг Үндэсний Ассамблейн тухай хууль, Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хууль, Үндэсний Ассамблейн хүний нөөцийн журам, Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны цалин хөлсний журмууд болон холбогдох бусад хууль тогтоомжуудаар зохицуулагддаг. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, цалин хөлстэй холбоотой нарийвчилсан журмыг холбогдох байгууллагын саналыг үндэслэн Ерөнхийлөгчийн зарлигаар баталдаг. Төрийн албан хаагчийн цалин хөлс олгох журам, Төрийн албан хаагчийн нэмэгдэл хөлсний талаарх журам 2020 оны 1 дүгээр сард шинэчлэн батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

<sup>309</sup> <https://www.riigiteataja.ee/akt/12849986?leiaKehtiv>

<sup>310</sup> <https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2014/11/Riigikogu-Kantselei-p%C3%B5him%C3%A4%C3%A4rus-2.pdf>

<sup>311</sup> <https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2014/11/Palgajuhend-01.01.2020-terviktekst.pdf>

<sup>312</sup> <http://loksabhaph.nic.in/writereaddata/Secretariat/RulesApplicableToEmployees/RecruitmentRules.htm>

## **2. Цалин хөлс, урамшууллын системийг авч үзвэл:**

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо онолын хувьд дараах зарчмуудыг баримталдаг нь судалгаанаас харагдаж байна.<sup>313</sup> Үүнд:

- Төрийн албан хаагчийн ажиллах хүчний өнөөгийн болон дараа үеийн потенциалыг нөхөх, ажилтны хувийн болон гэр бүлийн амьжиргааны хэрэгцээг хангахуйц байх;
- Албан хаагчийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болохуйц байх;
- Төрийн албан хаагчдын орон тоо, зохион байгуулалтыг оновчтой тогтоох;
- Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн зах зээл дээрх нийгмийн статус, мэргэжлийн нэр хүндийг өсгөх;
- Нийгмийн янз бүрийн эрсдлээс хамгаалахуйц байх;
- Төрийн албаны тухайн албан тушаалд тохирохуйц мэдлэг, чадвар, хувийн сайн шинж чанарыг бүрдүүлсэн өндөр мэргэшсэн ажилтнуудыг татахуйц байх.

Судалгаанд хамрагдсан дийлэнх улсуудын парламентын ажлын албаны ажилтнуудын цалин хөлс, нийгмийн асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Парламентын ажлын албаны тухай хуулиар зохицуулж байгаа бол Эстони улсад Рийгикогугийн Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан "Рийгикогугийн канцлерийн цалингийн удирдамж", Энэтхэг улсад парламентын доод танхимын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар баталсан "Ажилд авах нөхцөл, түүнд тавигдах шалгуур", ОХУ-д Төрийн Думын Аппаратын ажилтнуудын цалин, нэмэгдлийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар тус тус тогтоож, зохицуулж байгаа нь онцлог байна.

**ОХУ-ын хувьд** Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг ОХУ-ын Засгийн газрын санал болгосноор "Холбооны төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийн тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн 763 дугаар зарлигаар тогтоосон. Энэ зарлигийн 2 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Тамгын газрын төрийн албан хаагчдын цалин, сарын мөнгөн урамшууллыг тогтоосон байна.

*ОХУ-ын Төрийн Думын Аппаратын цалин, түүний нэмэгдэл нь:*

- ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Дум (доод танхим)-ын Тамгын газрын төрийн албан хаагчдын цалин, сарын мөнгөн урамшуулал нь ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөл (дээд танхим)-ийн Тамгын газрынхтай ижил байна.
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн ажлын алба, Төрийн Думын ажлын алба болон ЗГ-ын яамдын ажлын албаны ажилтнуудын цалингийн нэмэгдлийн коэффициентийг харьцуулж үзвэл Ерөнхийлөгчийн алба-14,21, Төрийн Думын ажлын алба-11,29, ЗГ-ын яамдын ажлын алба-9,77 байна. Үүнээс үзэхэд Төрийн Думын ажлын албаны аппаратын цалингийн нэмэгдэл нь Ерөнхийлөгчийн албанаас бага, ЗГ-ын яамдынхаас өндөр байгаа нь харагдаж байна.

Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл нь төрийн албаны зэрэг дэвийн

<sup>313</sup> Гоман К.И. Сравнительный анализ зарубежных и российской систем материального стимулирования труда государственных служащих, 2014

нэмэгдэл, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл, онцгой албаны нэмэгдэл, төрийн нууцтай ажилласны нэмэгдэл, онц чухал даалгавар гүйцэтгэсний нэмэгдэл, сарын үр дүнгийн мөнгөн урамшуулал, ээлжийн амралт, материаллаг тусламж болон холбогдох бусад нэмэгдлүүдээс бүрдэж байна.

**Австрали улсын хувьд** Парламентын үйлчилгээний байгууллагын гэрээний 42-р зүйлд заасны дагуу гэрээ хэрэгжих хугацаанаас эхлэн ажилтнуудын цалинг 3 хувиар, 12 сарын дараа 2 хувиар, 18 сарын дараа 1 хувиар тус тус нэмэгдүүлэхээр заасан байна.

3	ХБНГУ	-Төрийн албан хаагчийн тухай хууль -Холбооны Улсын Цалингийн тухай хууль <a href="https://www.gesetze-im-internet.de/bbesg/">https://www.gesetze-im-internet.de/bbesg/</a> -Хөдөлмөрийн эрх зүй (Холбооны Улсын Амралтын тухай хууль, Хөлсийг үргэлжлүүлэн олгох тухай хууль г.м.)	-Албан хаагчийн (тогтмол цалин) хувьд: Холбооны Улсын Цалингийн тухай хуулийн Хавсралт-4.1. А-Албан хаагч ба цэрэг <a href="https://www.gesetze-im-internet.de/bbesg/anlage_iv.html">https://www.gesetze-im-internet.de/bbesg/anlage_iv.html</a> -Ажилтны (хөлсний ажилтан) хувьд: Ажил олгогч, ажилтан хоорондын харилцааг зохицуулсан хөдөлмөрийн эрх зүйн нэгдсэн нэг хууль байхгүй, олон хуулиас бүрдэнэ
4	Ирланд	-Парламентын комиссын тухай хууль <sup>390</sup>	Парламентаас баталсан

<sup>385</sup> <http://loksabhaph.nic.in/writereaddata/Secretariat/RulesApplicableToEmployees/RandCSrules1955.pdf>

<sup>386</sup> <http://164.100.47.194/loksabha/writereaddata/our%20parliament/Bureau%20of%20parliamentary%20studies.pdf>

<sup>387</sup> [https://www.aph.gov.au/About Parliament/Parliamentary Services/Department of Parliamentary Services/Conditions](https://www.aph.gov.au/About%20Parliament/Parliamentary%20Services/Department%20of%20Parliamentary%20Services/Department%20of%20Parliamentary%20Services/Conditions)

<sup>388</sup> <https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title2/chapter45&edition=prelim>

<sup>389</sup> <https://www.govinfo.gov/content/pkg/STATUTE-84/pdf/STATUTE-84-Pg1140.pdf#page=1>

<sup>390</sup> <http://www.irishstatutebook.ie/eli/2003/act/28/enacted/en/print.html>

	Улс	-Парламентын комиссоос баталсан журам	төсвийн хүрээнд Парламентын Комиссоос албан хаагчдын цалинг олгоно. Цалингийн мэдээллийг Парламентын албан ёсны цахим хуудсанд байршуулсан байна. <sup>391</sup>
5	ОХУ	-ОХУ-ын Төрийн албаны тухай хууль (2004) ( <a href="http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_42413/">www.consultant.ru/document/cons_doc_LAW_42413/</a> ) -"Холбооны төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийн тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2006 оны 763 дугаар зарлиг	Холбооны төрийн албан хаагчдын албан тушаалын цалин, нэмэгдэлтэй холбоотой суурь харилцааг зохицуулах ба зарим нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон.
		"Холбооны төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийн тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2006 оны 763 дугаар зарлиг ( <a href="http://kremlin.ru/acts/bank/24131">http://kremlin.ru/acts/bank/24131</a> )	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалин, цалингийн нэмэгдлийг тогтоосон.
6	БНСУ	-Төрийн албаны тухай хууль <sup>392</sup>	Төрийн албан хаагч нь ажиллаж буй албан тушаалдаа тохирсон цалин хөлс, урамшуулал авахыг зохицуулж, нарийвчилсан харилцааг Ерөнхийлөгчийн зарлигаар батлахаар хуульчилсан.
		-Төрийн албан хаагчийн цалин хөлсний журам <sup>393</sup>	Энэхүү журмаар албан тушаалын зэрэглэл тус бүр болон салбар тус бүрээр цалингийн шатлалыг нарийвчлан баталсан бөгөөд цалин хөлс тооцохтой холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгасан.
		-Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журам <sup>394</sup>	Энэхүү журмаар төрийн албан хаагчийн цалин хөлснөөс гадна авах нэмэгдэл болон урамшуулалын талаар нэг бүрчлэн заасан.
7	Эстони Улс	-Рийгикогугийн Удирдах зөвлөлийн 2013 оны 2-р сарын 19-ний 33 тоот тогтоолоор баталсан "Рийгикогугийн канцлерийн цалингийн удирдамж" <a href="https://www.riigiteataja.ee/akt/12849986?leiaKehtiv">https://www.riigiteataja.ee/akt/12849986?leiaKehtiv</a>	Удирдамжид Рийгикогугийн канцлерийн албан тушаалтнууд болон ажилтнуудын цалин хөлс, урамшуулал, баяр амралтын нэмэгдэл болон бусад цалингийн нөхцөл, журмыг зохицуулна.
8	БНЭУ	-Ажилд авах нөхцөл, түүнд тавигдах шалгуур, ЕНБД-ын 2007 оны захирамж <sup>395</sup>	Парламентын доод танхимын ажилтан, албан хаагчдын цалингийн сүлжээ, ажилд авах нөхцөл шалгуурыг тодорхойлсон.

<sup>391</sup> <https://www.oireachtas.ie/en/foi/pay-and-grading/>

<sup>392</sup> <http://www.law.go.kr/LSW/lsLinkProc.do?&lsNm=%EA%B5%AD%EA%B0%80%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EB%B2%95&chrClsCd=010202&mode=20&ancYnChk=0#>

<sup>393</sup> <http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EB%B3%B4%EC%88%98%EA%B7%9C%EC%A0%95>

<sup>394</sup> (<http://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?lsptninfSeq=106597&chrClsCd=010202&ancYnChk=0>)

<sup>395</sup> <http://loksabhaph.nic.in/writereaddata/Secretariat/RulesApplicableToEmployees/RecruitmentRules.htm>

**Хавсралт 3.3. Парламентын ажлын албаны ажилтнуудын нийгмийн баталгааны талаарх лавлагаа**

	Улсын нэр	Холбогдох баримт бичиг	Тайлбар
1	Австрали Улс	-Парламентын ажлын албаны “Байгууллагын гэрээ 2017” ( <i>Department of Parliamentary Services Enterprise Agreement 2017</i> ) <sup>396</sup>	<b>Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа:</b> – эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал (гэрээний 1 дүгээр хэсэг, гэрээний 10 дугаар зүйл) – ажлын цаг, ажил эрхлэлтийн байдал (гэрээний 2-р хэсэг) – илүү цагаар ажиллах (гэрээний 2 дугаар хэсэг, 19-р зүйл) – ажилтнуудыг сургах, хөгжүүлэх (гэрээний 5 дугаар хэсэг, 61-р зүйл) ажлын гүйцэтгэл хангалтгүй байх (гэрээний 5 дугаар хэсэг, 62-р зүйл)
2	ХБНГУ	-Төрийн албан хаагчийн тухай хууль <a href="https://www.gesetze-im-internet.de/bbg_2009/">https://www.gesetze-im-internet.de/bbg_2009/</a> -Хөдөлмөрийн эрх зүй (Холбооны Улсын Амралтын тухай хууль, Хөлсийг үргэлжлүүлэн олгох тухай г.м.)	-Албан хаагчийн (тогтмол цалин) хувьд: Хуулийн 6-р хэсэг-Албан хаагчийн үндсэн эрх, үүрэг -Ажилтны (хөлсний ажилтан) хувьд: Ажил олгогч, ажилтан хоорондын харилцааг зохицуулсан хөдөлмөрийн эрх зүйн нэгдсэн нэг хууль байхгүй, олон хуулиас бүрдэнэ
3	Ирланд Улс	-Төрийн албаны тухай холбогдох хуулиуд <sup>397</sup> -Парламентын комиссын тухай хууль -Парламентын комиссоос баталсан журам	Парламентын комиссын тухай хууль болон төрийн албан хаагчийн нийгмийн халамжтай холбогдох бусад хуулийн зохицуулалт хэрэглэгдэнэ. <sup>398</sup>
4	ОХУ	ОХУ-ын Төрийн албаны тухай хууль (2004) ( <a href="http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_42413/">www.consultant.ru/document/cons_doc_LAW_42413/</a> )	Холбогдох асуудлаар суурь харилцааг зохицуулна. Тусгайлан тамгын газарт хэрэгжүүлэх хөтөлбөр хайлтын үр дүнд олдоогүй болно.
5	БНСУ	-YA Тамгын газрын тухай хууль <sup>399</sup>	Тус хуулиар Тамгын газрын ажилтнуудын албан тушаалын зэрэглэлийг зааж өгсөн нь суурь зохицуулалт юм.
		-YA Судалгааны албаны тухай хууль <sup>400</sup>	Тус хуулиар Судалгааны албаны бүтэц, ажилтнуудын албан тушаалын ангилалыг заасан.
		-Төрийн албаны тухай хууль <sup>401</sup>	Төрийн албан хаагч нь ажиллаж буй албан тушаалдаа

<sup>396</sup> [https://www.aph.gov.au/About Parliament/Employment/Department of Parliamentary Services/Employment Conditions](https://www.aph.gov.au/About_Parliament/Employment/Department_of_Parliamentary_Services/Employment_Conditions)

<sup>397</sup> <https://www.oireachtas.ie/en/search/?q=public+service+act>

<sup>398</sup> <http://www.irishstatutebook.ie/eli/2003/act/28/enacted/en/print.html>

<sup>399</sup> <http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%82%AC%EB%AC%B4%EC%B2%98%EB%B2%95>

<sup>400</sup> [http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9E%85%EB%B2%95%EC%A1%B0%EC%82%AC%EC%B2%98%EB%B2%95/\(16327\)](http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9E%85%EB%B2%95%EC%A1%B0%EC%82%AC%EC%B2%98%EB%B2%95/(16327))

<sup>401</sup> <http://www.law.go.kr/LSW/lsLinkProc.do?&lsNm=%EA%B5%AD%EA%B0%80%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EB%B2%95&chrClsCd=010202&mode=20&ancYnChk=0#>

			тохирсон цалин хөлс, урамшуулал авахыг зохицуулж, нарийвчилсан харилцааг Ерөнхийлөгчийн зарлигаар батлахаар хуульчилсан.
		-Төрийн албан хаагчийн цалин хөлсний журам <sup>402</sup>	Энэхүү журмаар албан тушаалын зэрэглэл тус бүр болон салбар тус бүрээр цалин хөлс тооцохтой холбоотой асуудал болон урамшуулалтай холбоотой асуудлыг тусгасан.
		-Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журам <sup>403</sup>	Энэхүү журмаар төрийн албан хаагчийн цалин хөлснөөс гадна авах нэмэгдэл болон урамшуулалын талаар нэг бүрчлэн заасан.
6	Эстони Улс	-Төрийн албаны тухай хууль, 2-р бүлэг <a href="https://www.riigiteataja.ee/akt/106102016002?leiaKehtiv">https://www.riigiteataja.ee/akt/106102016002?leiaKehtiv</a>	- Төрийн албаны тухай хуулийн 2-р бүлэгт хүний нөөцийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан.
		-Хөдөлмөрийн гэрээний тухай хууль <a href="https://www.riigiteataja.ee/akt/122122012030">https://www.riigiteataja.ee/akt/122122012030</a>	-Хөдөлмөрийн гэрээний тухай хуулиар ажилтны хөдөлмөр эрхлэлт, ажиллах нөхцөл, ажил амралтын цаг зэргийг зохицуулсан.

UIH.MN  
СҮДАЛГААНЫ САН

<sup>402</sup> <http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EB%B3%B4%EC%88%98%EA%B7%9C%EC%A0%95>

<sup>403</sup> (<http://www.law.go.kr/LSW//lumLsLinkPop.do?lspttninfSeq=106597&chrClsCd=010202&ancYnChk=0>)



# КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА, ХУРАЛДААНЫГ ЗАЙНААС ЯВУУЛЖ САНАЛ ХУРААХ ТАЛААРХ ТУРШЛАГА

(2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Алтан-Оч (Ph.D), Р.Нургүл, Д.Халиун  
Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Г.Билгээ

Дэлхийн улс орнуудын парламентын ажиллагаанд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор дараах өөрчлөлтүүд орж байна. Үүнд:

- Нэгдсэн болон байнгын хороодын хуралдааныг тодорхой, эсхүл тодорхой бус хугацаагаар хойшлуулах, зогсоох;
- Нэгдсэн болон байнгын хороодын хуралдааны тоог цөөлөх, богиносгох;
- Зөвхөн онц шуурхай асуудлаар хуралдах;
- Хуралдаан явуулах байршлыг эрсдэл бага газар луу шилжүүлэх;
- Хуралдаанд оролцох гишүүдийн дээд хязгаарыг тогтоох;
- Гишүүд хоорондын зохистой зай (1м, 1,5м, 2м) тогтоох;
- Олон нийтийг хамарсан арга хэмжээг хойшлуулах, цуцлах;
- Парламентын ордонд нэвтрэх хязгаарлалт тогтоох;
- Алсын зайнаас ажиллах.

(Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс үзнэ үү.)

COVID-19 вирусийн цар тахал дэгдсэнтэй холбогдуулан дэлхийн улсуудын парламентын байнгын ажиллагаа тасалдахад хүрч байна. Үүнтэй холбоотой улс орнуудад шаардлагатай яаралтай асуудлыг парламентаар хэлэлцүүлж батлуулах процессыг хэрхэн явуулах санал санаачилгыг парламентын гишүүд болон олон нийтээс гаргаж байна.

Хэдийгээр одоо байгаа online-conference эсхүл, video-conference системийг ашиглан зайнаас цахим хэлбэрээр парламентын хуралдааныг тогтмол явуулах талаар санал гаргаж байгаа боловч одоогийн байдлаар нэгдсэн шийдвэрт хүрээгүй байна.

Харин яаралтай хууль тогтоомжийг алсын зайнаас санал хураах замаар батлахаар шийдэж буй цөөн хэдэн тохиолдол байна. Гэхдээ энэ тохиолдолд парламентын хуралдааны дэг, гишүүдийн асуулт, хариулт хэрхэн явагдах, саналын нууцлалын асуудлыг хэрхэн шийдэх нь нарийн зохицуулагдаагүй байна.

## Remote participation болон Teleworking

Европын Парламентын хувьд 2020.03.19-нд Ерөнхий нарийн бичгийн дарга Парламентын ажлын албанд гишүүдийг хуралдаанд алсын зайнаас оролцох боломжоор хангаж, бэлтгэл ажил хийхийг үүрэг болгосон. Европын Парламентын Ерөнхий нарийн бичгийн даргын гарын үсэг зурсан баримтад: **“remote**



**participation**” буюу алсын зайнаас оролцох гэдэг нь “being able to view and listen to proceedings, ask for the floor and intervene in the meeting” буюу “хуралдааныг үзэж, сонсох, асуулт асууж, үг хэлж хуралд оролцох”-ыг ойлгоно гэжээ.

Мөн “гишүүд өөрсдийн iPad, эсхүл iPhone-г ашиглан платформд алсаас холбогдох боломжтой” гэж баримт бичигт дурджээ. Дээрх платформ нь нийт 1000 оролцогчдын оролцоог хангаж, “remote polling” буюу алсын зайн санал хураалт явуулах боломжтой юм. Европын Парламентын Ерөнхийлөгчийн мэдээлснээр 2020.03.26-ны ээлжит бус чуулганы хуралдаанд алсын зайнаас санал хураалт явуулах (гишүүн өөрийн парламентын цахим шуудангаар саналын хуудсыг хүлээн авч бөглөөд, буцааж илгээх бөгөөд гишүүдийн илгээсэн саналыг хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ) бөгөөд 2020.07.31-ийг хүртэл санал хураалтыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн.<sup>404</sup>

Эстони Улсын хувьд Хороодын хуралдааныг **teleworking**<sup>405</sup> хэлбэрээр явуулах боломж бүрдүүлэх тал дээр ажиллаж байна. 2020.03.16-ны өдөр Парламентын Үндсэн хуулийн хороо онцгой байдлын үед хороодын хуралдаануудыг цахимаар буюу алсын зайнаас зохион байгуулах асуудлыг хэлэлцсэн байна. Хорооноос Парламентын дэг, дотоод журмын тухай хуулийн дагуу Парламентын хороодын цахим буюу алсын зайнаас явуулах боломжтой гэж дүгнэсэн байна.

"Хуралдаанд оролцоход шаардлагатай нөхцөл болох үг хэлэх, асуулт асуух, санал өгөх зэргийг хангасан тохиолдолд хуралдааныг алсын зайнаас явуулж болно гэж одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг тайлбарлаж болохоор байна" гэж Үндсэн хуулийн хорооны дарга мэдэгдсэн. Мөн онцгой нөхцөл байдлыг харгалзан хороодын үйл ажиллагааг тасалдуулахгүй, алсын зайнаас үргэлжлүүлэн ажиллах нь чухал болохыг онцолсон. Одоогийн байдлаар Парламентын дэгийг өөрчлөхийг яаравчлахгүй, харин онцгой байдал дуусахад холбогдох асуудлыг судалж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, хууль эрх зүйн орчныг илүү тодорхой болгоно гэж мэдэгдсэн.

Үндсэн хуулийн хорооноос Парламент дахь бүлгүүдэд захидал илгээж, Парламентын дэг, дотоод журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлэхийг хүссэн байна. Хорооноос ирц, оролцооны асуудлыг эргэн харж, хууль эрх зүйн орчныг тодорхой болгохын тулд хорооны хуралдаанд алсын зайн оролцоог ямар нөхцөлд хангуулах вэ гэдгийг тодорхой болгох ёстой гэж холбогдох Хорооны дарга тус тус мэдэгдсэн байна.<sup>406</sup>

<sup>404</sup> <https://www.euractiv.com/section/digital/news/european-parliament-to-roll-out-distance-voting-technology-for-meps/>

<sup>405</sup> “Telework” нэр томъёоны талаар

Монголчилбол	— телеажил, зайнаас ажиллах
Ижил утгатай үгс	— telecommuting, telework, teleworking, working from home (WFH), mobile work, remote work, flexible workplace)
Кембрижийн тайлбар толь <sup>405</sup>	— албан байгууллагатайгаа утас, цахим шуудангаар холбогдож, эсвэл интернетээр ашиглаж ажлаа гэртээ гүйцэтгэх
АНУ-ын Хүний нөөцийн алба <sup>405</sup>	— “telework” буюу “teleworking” гэсэн нэр томъёог 2010 онд батлагдсан Телеажлыг зохицуулах тухай хуульд <sup>405</sup> “ажилтан үүрэг, хариуцлагаа, мөн ажлын байрны тодорхойлолтод заасан бусад үйл ажиллагаагаа ажил олгогчийн тогтоосон ажлын байрнаас бусад байршилд гүйцэтгэх ажлын уян хатан нөхцөлийг ойлгоно” гэсэн байна.

Энэ нь ажилтанд ажлын цагийн аль ч үед ажлаа тогтоосон газар (тухайлбал, гэртээ, телеажлын төвд) хийх боломжийг олгодог ажлын зохион байгуулалт юм. Үүнд албан ёсны томилолт, “mobile work” хамаарахгүй.

<sup>406</sup> <https://www.riigikogu.ee/en/press-releases/constitutional-committee-en/constitutional-committee-rules-procedure-allow-holding-committee-sittings-teleworking-format/>

## ПАРЛАМЕНТЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫГ АЛСЫН ЗАЙНААС ЯВУУЛЖ САНАЛ ХУРААХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Үүсэж буй одоогийн нөхцөлд зарим орны парламентаас хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй зайнаас хуралдаж, санал хураалт явуулах туршлагаудын талаарх мэдээллийг оруулсан болно. Үүнд:

1. Австралийн Парламент COVID-19-ийн нөхцөл байдалтай холбогдуулан парламентын чуулганыг 8 дугаар сарын 11 хүртэл хойшлуулсан бөгөөд 5 дугаар сард баталдаг төсвийг 10 дугаар сарын 6-нд батлахаар болоод байна. Харин Хороодын үйл ажиллагаа алсын зайнаас явагдана.
2. АНУ-ын Пенсильвани мужийн Төлөөлөгчдийн танхим нь COVID-19 вирусийн дэгдэлттэй холбоотой онц байдлын үед хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн танхимын түр журмыг 2020 оны 3-р сарын 16-нд баталсан байна.
3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс. Нэгдсэн фракци нь 2020 оны 03-р сарын 23-нд төлөвлөөд байгаа фракцийн хурлаа “фракцийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх” үүднээс тэргүүлэх депутатууд, Засгийн газрын төлөөлөгчдийг хамруулан зайн хурал (теле-конференци) зохион байгуулахаар шийдвэрлэв.
4. Шинэ Зеланд. Бизнесийн хороо нь Танхимын санал хураалтад оролцох хүмүүсийн тоог багасгах зорилгоор зарим тооны үйл ажиллагааг (хорооны хуралдаан, асуулт асуух, санал өгөх) цахим хэлбэрээр явуулахыг дэмжиж журмын төсөл боловсруулсан байна.
5. Евро Парламентын хуралдааныг 2020 оны 3-р сарын 26-ны өдөр зайнаас явуулж, цахим шуудангаар санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн байна.
6. Бүгд Найрамдах Польш Улсад Кабинетын зарим гишүүд коронавирусийн халдвар авсны улмаас Засгийн газар үйл ажиллагаагаа алсын зайнаас цахимаар (видео хурал-teleconference) зохион байгуулж байна.

**1. Австралийн Парламентын** хувьд Парламентын чуулганы хуралдааныг хойшлуулсан, харин үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор холбогдох хууль, дүрмийн хүрээнд Хороодын үйл ажиллагааг зайнаас явуулах боломжтой юм. Тухайлбал, Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгийн 235 (b)-д:

*“Хорооны үйл ажиллагааг хорооны гишүүд, эсхүл гэрч нартай дуу-дүрсний (audio visual), эсхүл аудио холболт (audio links)-ыг ашиглан явуулж болно. Дуу-дүрс, эсхүл аудио холболтыг ашиглаж буй тохиолдолд хорооны гишүүд, гэрчүүд хаана байхаас үл хамааран бие биетэйгээ нэгэн зэрэг ярих, сонсох боломжтой байх ёстой.”* гэж заасан.

Сенатын хуралдааны дэгийн 30-д Сенатын хороодын хуралдааныг цахим/электрон хэлбэрээр явуулахыг зөвшөөрсөн бөгөөд оролцогчид нь нэг дор байрлах шаардлагагүй юм.

Харин хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуульд (1901 он) Парламентын хууль тогтоох ажиллагаанд "шуудан, телеграф, телефон утас болон бусад адил төстэй үйлчилгээ"-г ашиглаж болохыг заасан бөгөөд үүнд радио, телевиз, интернет зэрэг технологийн дэвшилтэд бусад арга хэрэгслүүд багтаж болно гэж тайлбарлаж байгаа юм. Үндсэн хуульд Парламентын хуралдаан явагдах газар (байршил –

Австралийн нийслэлийн нутаг дэвсгэр), гишүүдийн ирц (гуравны нэгээс доошгүй) зэргийг заасан учир алсын зайнаас ажиллахад хүндрэл үүсэх юм. Үүнтэй холбоотойгоор 2020.03.23-нд Ерөнхий Атторней Кристиан Портер хоёр санал оруулсан бөгөөд энэ нь спикер болон томоохон намууд зөвшөөрсөн тохиолдолд гишүүд зайнаас оролцох, мөн хоёр том нам зөвшөөрсөн тохиолдолд хуралдааны дэгд өөрчлөлт оруулахад дийлэнх олонхын саналыг шаардахгүй зэрэг боломжуудыг нээж өгөх юм.<sup>407</sup>

## 2. АНУ-ын Пенсильвани муж

АНУ-ын Пенсильвани мужийн Төлөөлөгчдийн танхим нь COVID-19 вирусийн дэгдэлттэй холбоотой онц байдлын үед хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн танхимын түр журам баталсан байна. Журамд тусгасан асуудлыг тоймловол:<sup>408</sup>

- Төлөөлөгчдийн танхимын гишүүд нь заавал хуралдааны танхимд байхгүйгээр зайнаас санал өгч болно. Үүний тулд гишүүн нь тухайн хэлэлцэж буй асуудлаар ямар саналтай байгаагаа бүлгийнхээ зохицуулагчид (whip) урьдчилан мэдэгдэнэ. Бүлгийн зохицуулагч нь гишүүний хэлсний дагуу хуралдааны танхимд гишүүний өмнөөс санал өгнө. Хуралдааны танхимд зөвхөн Хурлын дарга, бүлгийн ахлагчид, бүлгийн зохицуулагчид эсхүл, итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн заавал оролцох шаардлагатай төлөөлөгчид байна.
- Хороодын хуралд зайнаас санал өгөх процесс Төлөөлөгчдийн танхимын хуралдаантай адил зарчмаар явагдах бөгөөд ялгаа нь гишүүний саналыг хорооны дарга эсхүл, хорооны цөөнхийг ахлагч тухайн гишүүний өмнөөс өгнө.
- Онц байдлын үед батлагдсан хууль тогтоомжийг хэлэлцэх болон хэрэгжүүлэх хугацааг ердийн үеэс богиносгосон байна. Өөрөөр хэлбэл, Төлөөлөгчдийн танхимаас гаргасан аливаа хууль тогтоомжийг түргэвчилсэн байдлаар хэлэлцэн баталж хэрэгжүүлнэ. Тухайлбал, хууль тогтоомжийн төслийг олон нийтэд танилцуулснаас хойш 24 цагийн хугацаанд хүлээн авч шийдвэрлэнэ гэснийг 3 цаг, хэлэлцэх асуудлууд, хороодын тайланг Төлөөлөгчдөд 12 цагийн өмнө хүргэнэ гэснийг 3 цаг, батлахад бэлэн болсон хууль, тогтоомжийг олон нийтэд танилцуулснаас 6 цагийн дараа эцсийн санал хураалт явагдана гэснийг 3 цаг болгож багасгасан байна.
- Хуульд заасан зарим тохиолдолд хууль тогтоомжийг цахим шуудангаар илгээж болохгүй гэсэн хязгаарлалт нь COVID-19-тэй холбоотой асуудлуудад хамаарахгүй байхаар заажээ.
- Энэ түр журам нь Төлөөлөгчдийн танхим хүчингүй болгох хүртэл эсхүл, онц байдал цуцлагдах хүртэл хүчинтэй байна.

## 3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Германы Бундестаг (үгчилбэл, “Холбооны Их хурал”) болон Бундесрат (үгчилбэл,

<sup>407</sup> <https://theconversation.com/a-virtual-australian-parliament-is-possible-and-may-be-needed-during-the-coronavirus-pandemic-134540?fbclid=IwAR26ORiohuCu9zQl1C2YwtyDWiKSOI5B5z7brWPqacY6xVXIbCGJzyq0n4>

<sup>408</sup> Regular Session 2019-2020 House Resolution 834  
<https://www.legis.state.pa.us/cfdocs/billinfo/billinfo.cfm?sYear=2019&sInd=0&body=H&type=R&bn=834>

“Холбооны Зөвлөл”) одоогоор хэвийн ажиллаж байна. Энэ 7 хоногт хуралдаж, корона хямралын эсрэг Онцгой байдал, хамгаалалтын талаар багц хуулийг “хурдавчилсан” горимоор баталж, ирэх долоо хоногоос эхлэн Улаан өндөгний баярыг тохиолдуулан 3 долоо хоног завсарлаж амарна.

Нэгдсэн фракци 2020 оны 03-р сарын 24-нд төлөвлөөд байсан хурлаа хийхгүй аж. Харин SPD фракц гишүүдээ сайн дураар ирж хуралдаа оролцохыг зөвшөөрсөн аж. Бундестагийн 2020 оны 03-р сарын 25-нд төлөвлөгдөөд буй чуулганы ажиллагаа онцгой (тусгай) журмаар явагдана.[1]

Төсвийн алдагдал үүсэхээс сэргийлэхийн тулд хямралын эсрэг авах багц арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор төсвийн зарлагыг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг “үнэмлэхүй” буюу Бундестагийн нийт гишүүдийн олонхоор (доод тал нь 355 депутат байх) батлах шаардлагатай тул SPD фракцийн тэргүүн бүх гишүүдийг 25-ны өдөр Берлинд хүрэлцэн ирж, Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцохыг уриалсан аж.[1]

Нэгдсэн фракци 2020 оны 03-р сарын 23-нд төлөвлөөд байгаа фракцийн хурлаа “фракцийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх” үүднээс тэргүүлэх депутатууд, Засгийн газрын төлөөлөгчдийг хамруулан зайн хурал (теле-конференц) зохион байгуулахаар шийдвэрлэв. Иймээс фракцийн гишүүд санал хүсэлт, асуултаа холбогдох ажлын хэсгийн ахлагчид урьдчилж өгсөн байх шаардлагатай.[1]

SPD фракцийн тэргүүний мэдэгдсэнээр, фракцийн хурал ч тэр чуулганы хуралдааны танхимд депутатуудын хоорондын зайг аюулгүй хэмжээнд байлгах шаардлагатай. Мөн нийтийн тээвэр хэрэглэхийг хүсэхгүй байгаа депутат өөрийн авто машинтайгаа ирээд Бундестагийн далд гараашийн зогсоолд тавих боломжтой.[1]

Мөн түүний мэдэгдсэнээр, төсвийн алдагдлыг зогсоох тухай хуулийн шийдвэрийн талаарх үнэмлэхүй олонхын санал хураалтад нэрийн дагуу зөвхөн өөрийн биеэр оролцох (сүүлийн чуулганы хуралдааныг чуулганы танхимаас гадуур хийсэн) тул цагийг сунгаж, депутат хоорондын зайг барих шаардлагатай.[1] (Чуулганы танхимд хуруугаа уншуулж ирцээ бүртгүүлээд гарч, хуралдаанаа өөр танхимд хийгээд, ээлж дараатай буцаж чуулганы танхимд ирж хуруугаа уншуулан саналаа өгөх боломжтой [ГА])

Онцгой байдалтай холбоотой багц хуулийг холбогдох байнгын хороод хэлэлцэнэ. Ингэхдээ “тэд урьдчилан тохиролцоод цөөн тоотойгоор хуралдах боломжтой” хэмээн SPD фракцийн тэргүүн мөн мэдэгдэв. 2020/03/27-ний өдөр Бундесрат багц хуулийг эцэслэн батална.[1]

Бундестагийн шийдвэр өнөөг хүртэл “гишүүдийн талаас илүү хувь нь хуралдааны танхимд хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно” хэмээн Бундестагийн Дүрэм (дотоод журам)-д тусгагдсан байдаг. Тэгвэл корона хямралын үед дор хаяхад дөрөвний нэг нь ирснээр Бундестагийн шийдвэр гарах төслийг одоогийн байдлаар AfD намаас бусад фракциуд зөвшилцөөд бүгд дэмжсэн байна. AfD одоогоор хариугаа өгөөгүй боловч тэдэнгүйгээр эцсийн шийдвэр гарах боломжтой байгаа аж. Энэ нь байнгын хорооны хуралдаанд ч мөн адил хамаарна. Ингэхдээ Дүрмийн 216

дугаар зүйлийн “а” хэсэгт “Тусгай зохицуулалт” гэсэн гарчигтайгаар нэмэлт оруулах ажээ. Энэхүү зохицуулалт нь хамгийн оройтлоо гэхэд 2020 оны 9-р сарын 30 хүртэл хүчинтэй байх юм. Зүүний фракцийн тэргүүний мэдэгдсэнээр, түүнээс өмнө ч цуцлах боломжтой аж.[2]

Германы Үндсэн хуульд зөвхөн дайн байлдааны үед Бундестаг (цуглаж) хуралдаж чадахгүйд хүрвэл түүний үүргийг Бундестаг (гуравны хоёр нь), Бундесрат (гуравны нэг нь)-аас нэгдэж бүрдсэн 48 гишүүнтэй хамтарсан хороо буюу Онцгой парламент гүйцэтгэж болохоор тусгасан байдаг аж.[2] Зарим улс төрчид үүнтэй төстэй хямралын үеийн “Онцгой Бундестаг” байгуулах талаар Үндсэн хуульд нэмэлт оруулах санал гаргаж байгаа боловч Бундестагийн гүйцэтгэх захирал (манай Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргатай адил [ГА]) нь ийм шийдвэрийг маш нухацтай судалсны үндсэн дээр яаралгүй гаргах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна.[3]

Тэгээд ч Үндсэн хуульд өөрчлөлт оруулахын тулд гуравны хоёрын санал хэрэгтэй. Корона хямралын үед олон депутат, нэн ялангуяа муж улсуудын төлөөлөгчдийг халдвараас сэргийлэн нэг дор цуглуулах боломж хүндрэлтэй харагдаж байна.[3]

#### **4. Шинэ Зеланд<sup>409</sup>**

Бизнесийн хороо нь Танхимын санал хураалтад оролцох хүмүүсийн тоог багасгах зорилгоор зарим тооны үйл ажиллагааг (хорооны хуралдаан, асуулт асуух, санал өгөх) цахим хэлбэрээр явуулахыг дэмжиж журмын төсөл боловсруулсан байна.

Тус төсөлд зааснаар Танхимд парламентын гишүүд аль болох хоорондоо зайтай сууна. Нийтийн танхимууд зочдод үйлчлэхгүй. Парламентын болон хороодын хуралдаанд оролцох нийгмийн гишүүд, ажиглагчид, гэрч, нотолгоо баримтыг оруулахгүй. Тэд тухайн хорооны фэйсбоок, цахим хуудас болон теле хурлаар баримт нотолгоо гарган ирүүлж болно.

Харин хорооны гишүүд хурлын үеэр нэг нь нэгнээсээ 2 метрийн зайтай сууна. Энэ нөхцөлийг хангахын тулд хорооны хуралд видео, цахим хэлбэрээр оролцохыг зөвшөөрнө. Үүнийг хуралд оролцсонд тооцно.

Парламентын танилцах аяллыг түр зогсоосон. Мөн танхимд санал өгөгчдийн тоог зохицуулах, хязгаарлах зорилгоор санал хураалтад цахимаар оролцохыг зөвшөөрсөн. Хурлын дарга зарим нэг хороодын хурлыг зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах, алсаас цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг онцгой зохицуулалтыг санал болгох эрхтэй. Харин Парламент нь ажлаа хэрхэн алсаас явуулах, цахим хэлбэрээр шийдвэр гаргах вэ гэдгийг Бизнесийн хороо шийдвэрлэнэ. Спикер болон дэд спикер эзгүй тохиолдолд түүний туслах спикер орлох боломжтой байхаар тусгажээ.

#### **5. Европын парламент**

Европын парламентын байршлыг өөрчилж Францын Страсбург хотоос Бельгийн нийслэл Брюссель рүү шилжүүлсэн.

<sup>409</sup> [https://www.parliament.nz/en/pb/hansard-debates/rhr/combined/HansDeb\\_20200319\\_20200319\\_16](https://www.parliament.nz/en/pb/hansard-debates/rhr/combined/HansDeb_20200319_20200319_16)  
<https://www.stuff.co.nz/national/health/coronavirus/120402590/coronavirus-parliament-changing-rules-to-run-on-skeleton-numbers-if-needed>



2020 оны 03-р сарын 11-нээс Европын парламентын ажлын албаны дийлэнх ажилтнууд зайнаас буюу teleworking ажлын горимд шилжсэнтэй холбоотой парламентын гишүүд нийтээрээ зайнаас ажиллах шийдвэрт хүрсэн байна.

Европын парламентын ерөнхийлөгч болон улс төрийн бүлгийн тэргүүлэгчид зөвлөлдөөд Европын парламентын ерөнхийлөгчийн саналыг дэмжин 2020 оны 03-р сарын 26-нд ээлжит бус чуулганыг товлон хуралдуулж яаралтай арга хэмжээ авах шийдэлд хүрсэн байна.

2020 оны 03-р сарын 26-нд Covid-19 халдварын улмаас гишүүн орнуудад туслах яаралтай арга хэмжээний талаар цахимаар<sup>410</sup> (видео хурал) явагдах ээлжит бус чуулганы санал хураалтыг хэрхэн явуулах тухай нэлээд хэлэлцсэний эцэст Европын парламентын ажлын албанаас Сонгуулийн тухай болон Гишүүний тухай хуульд заасны дагуу гишүүний санал найдвартай, аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлж, парламентын гишүүдийн парламентын цахим хаягийг ашиглан саналыг хүлээж авахаар шийдэлд хүрсэн байна. Гишүүн өөрийн парламентын цахим шуудангаар саналын хуудсыг хүлээн авч бөглөөд, буцааж илгээнэ. Гишүүдийн илгээсэн саналыг хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ. Ийнхүү 2020 оны 07-р сарын 31 хүртэл санал хураалтыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна.<sup>411</sup> Хороодын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан хэвээр байна.<sup>412</sup>

## **6.Бүгд Найрамдах Польш Улс**

2020.03.02-ны өдрөөс албан хаагчид зайнаас, цахимаар ажиллаж эхэлсэн байна.

2020.03.08-ны өдөр Хямралын тухай хууль (Crisis act) батлагдсан байна.

Парламентын нэгдсэн хуралдаан болон хороодын хуралдаан хойшлогдсон бөгөөд парламентын ажлын албаны ихэнх ажилтнууд цахимаар гэрээсээ ажиллаж байна.

Парламентын доод танхим ирэх Баасан гаригт буюу 2020.03.27-ны өдөр хуралдаж коронавирусийн улмаас эдийн засагт учирч болох хохирлоос сэргийлэх тухай засгийн газраас өргөн барьсан яаралтай хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэх, Сенатаас санал болгосон төсвийн тодотгол болон онц байдал тогтоосон одоогийн нөхцөл байдалд парламент хэрхэн ажиллах талаар парламентын дэгийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт зэрэг асуудлаар хуралдахаар зэхэж байна. Одоогийн мөрдөж буй ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийг баримтлан хуралдааныг хэдийд, хэрхэн зохион байгуулах талаар эцсийн шийдвэрийг Мягмар гаригт шийдвэрлэнэ гэсэн байна.<sup>413</sup>

Кабинетын зарим гишүүд коронавирусийн халдвар авсны улмаас Засгийн газар үйл ажиллагаагаа алсын зайнаас цахимаар (видео хурал-teleconference) зохион байгуулж явуулж байна.<sup>414</sup>

2020.03.24-ний<sup>415</sup> хэвлэлийн бага хурал дээр Сеймын маршалл (Парламентын доод танхимын спикер) хатагтай Эльжбета Витек Сеймын Тэргүүлэгчдийн

<sup>410</sup> [https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session\\_20200326-0900-PLenary\\_vd](https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session_20200326-0900-PLenary_vd)

<sup>411</sup> <https://techcrunch.com/2020/03/23/eu-parliament-moves-to-email-voting-during-covid-19/>

<sup>412</sup> <https://www.europarl.europa.eu/committees/en/home>

<sup>413</sup> <https://polandin.com/47227651/parliament-mobilising-for-a-sitting-on-friday>

<sup>414</sup> <https://polandin.com/47189504/empty-corridors-of-power-coronavirus-affects-parliament-and-government>

<sup>415</sup> <http://www.sejm.gov.pl/Sejm9.nsf/komunikat.xsp?documentId=7743E94797CE0333C125853500520DB8>

гаргасан шийдвэрийг танилцуулав. Сейм Танхимын хуралдааны дэгд өөрчлөлт оруулах саналыг дэмжсэн бөгөөд ийнхүү танхимд байх гишүүдийн тоог хязгаарласан байна. Хуралдаанд намын бүлгийн төлөөлөгч нар оролцох бол бусад гишүүд алсын зайнаас оролцох юм. Мөн тэрээр хурлын онцгой нөхцөл байдал зөвхөн эпидеми, эпидемийн аюул, түүнчлэн Үндсэн хуульд тусгагдсан онц байдал, байлдааны байдал, байгалийн гамшиг зэрэг гурван нөхцөл байдалд хамаарна гэдгийг онцоллоо. Тэргүүлэгчдийн 5 гишүүн уг саналыг дэмжиж, 1 гишүүн түдгэлзсэн бол дэмжээгүй санал гараагүй байна.

Шинэ горимоор ажиллах асуудлаар гишүүдэд IT-ийн мэргэжилтнүүд болон хуульчид заавар, зөвлөгөө өгч, богино хэмжээний видео зааварчилгаа өгөх юм. Системийн ерөнхий туршилтыг Пүрэв гарагт буюу 2020.03.26-нд явуулна. Шинэ горимоор Парламент 2020.03.27-нд хуралдана. Парламентын IT төвөөс гишүүдэд тусгай холбоос link явуулж тухайн гишүүнийг мөн болохыг баталгаажуулахаас гадна гишүүний бүртгэлтэй гар утасны дугаараас SMS-ээр мөн тухайн гишүүн мөн болохыг нотолж, оролцоог нь бүртгэх юм. Танхимд байрлах хоёр том дэлгэцээр гишүүдийг харж, сонсож болох юм.





## КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА

/2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/

Хүснэгтэд 2020.03.18-наас хойш улс орнуудын парламентын үйл ажиллагаанд орсон өөрчлөлтийн талаар нэмж оруулав. Иран, Канад, Өмнөд Африк, Кени, Итали, Солонос, Их Британи, Нидерланд, Норвеги, Австрали, Япон зэрэг улсын хувьд одоогоор шинэ өөрчлөлтүүд ороогүй байна.

**Хүснэгт 1**

Улс	Нөхцөл байдал <sup>416</sup> /2020.03.25 10:00/	Парламентын ажиллагаа	Тайлбар
1. Европын парламент <sup>417</sup>		Байршлыг шилжүүлсэн	ЕП-ын чуулганы чуулганы нэгдсэн хуралдааныг 4 өдрөөс 1.5 өдөр (2020.03.30-04.02-ноос 2020.04.01-04.02) болгон богиносгож, “эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй” гэх үндэслэлээр Бельгийн нийслэл Брюсселиэс Францын Страсбург хотноо шилжүүлсэн.
		Үргэлжлэх хугацааг богиносгосон	2020.03.16-наас эхлэх 7 хоногт товлосон <b>Хороодын хуралдааныг хойшлуулах</b> шийдвэр гаргасан. <sup>418</sup>  2020.03.11-ний байдлаар ЕП-ын дийлэнх ажилтнууд зайнаас буюу teleworking ажлын горимд шилжээд байна. Одоогоор 7 хоногийн 70 хувьд нь зайнаас ажиллаж, 1.5 өдөр ажил дээрээ ажиллах бол цаашид нөхцөл байдлаас хамааран 100 хувьд хүргэх юм. <sup>419</sup>  Гаднаас хүн оролцох арга хэмжээнүүдийг цуцалсан.  2020.03.26-нд Covid-19 өвчний улмаас гишүүн орнуудад туслах яаралтай арга хэмжээний талаар цахимаар <sup>420</sup> (видео хурал) явагдах ээлжит бус чуулганы санал хураалтыг цахимаар явуулахаар болсон.

<sup>416</sup> <https://www.worldometers.info/coronavirus/> 2020.03.25-ны 10 цагийн байдлаар

<sup>417</sup> <https://www.euractiv.com/section/health-consumers/news/parliament-president-under-pressure-to-suspend-plenary/>

<sup>418</sup> <https://www.europarl.europa.eu/news/en/press-room/20200310IPR74511/ep-calendar-revised-to-ensure-parliament-can-exercise-its-core-functions>

<sup>419</sup> <https://techcrunch.com/2020/03/11/european-parliament-moves-to-majority-teleworking-in-response-to-covid-19/>

<sup>420</sup> [https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session\\_20200326-0900-PLenary\\_vd](https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session_20200326-0900-PLenary_vd)

			2020-07-31 хүртэл санал хураалтыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна. <sup>421</sup> Хороодын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан хэвээр байна. <sup>422</sup>
2. БНХАУ <sup>423</sup>	Бүртгэгдсэн -81218 Нас барсан - 3281	Хойшлуулсан	2020.02.24-нд БХАТИХ-ын 3 дугаар хуралдааныг хойшлуулах шийдвэрийг БХАТИХ-ын Байнгын хорооноос гаргасан.  2020.03.24-ний байдлаар хуралдаан хойшлогдсон хэвээр байна. <sup>424</sup>
3. Иран	Бүртгэгдсэн -24811 Нас барсан - 1934	Түр завсарласан	Коронавирусийн тархалт Ираны Үндэсний ассамблей, Сенат, парламентын хороодын ээлжит хуралдааны үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлж байна. Парламентын 2 танхимын хороодын үйл ажиллагааг Коронавирусийн тархалттай холбоотой Ассамблейн дарга болон Сенатын тэргүүний шийдвэрээр цуцалжээ. Царт тахлын улмаас парламентын үйл ажиллагаа түр завсарлаж, парламентын гишүүд гадаадад болон дотоодод явахгүй хэсэг хугацаанд “амрах”-д хүрээд байна. Үндэсний ассамблей 2020 оны 3 сард 12 ажлын өдөр хуралдахаар төлөвлөсөн боловч 5 ажлын өдөр хуралдаад баасан гаригт түр хугацаагаар завсарласан.  Түүнчлэн, 2020.03.16-27-ны хооронд товлогдсон Төрийн ордон дахь байгууллагуудын болон Үндэсний ассамблейн дэд панелүүдийн 24 хуралдаан мөн цуцлагдсан байна. Мөн хугацаанд товлогдсон Сенатын хороодын 18 хуралдааныг цуцалжээ.  Ираны парламентын 24 гишүүн буюу 10 орчим хувь нь вирусийн шинжилгээнд эерэг гэсэн хариу авч, үүний улмаас саяхан Тегераныг төлөөлж сонгогдсон консерватив улс төрч Фатемех Рахбар болон Мохаммед Али Рамезани нар нас баржээ. Үүний дараа Ираны нийслэл Тегеранд засгийн газрын албан тушаалтнуудыг аялахыг хориглосон бөгөөд парламент тодорхойгүй хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоогоод байна.
4. Испани <sup>425</sup>	Бүртгэгдсэн -42058	2020.03.25-ны өдөр хүртэл (15 хоног) түр	2020.03.10-ны өдөр Парламентын доод танхимыг үйл ажиллагааг 15 хоногоор түр зогсоох шийдвэр гаргасан.

<sup>421</sup> <https://techcrunch.com/2020/03/23/eu-parliament-moves-to-email-voting-during-covid-19/>

<sup>422</sup> <https://www.europarl.europa.eu/committees/en/home>

<sup>423</sup> <http://www.npc.gov.cn/englishnpc/c2763/202002/3be9ebfa9cbf4fe9b087a947951ce0e1.shtml>

<sup>424</sup> <http://www.npc.gov.cn/englishnpc/c2763/202002/3be9ebfa9cbf4fe9b087a947951ce0e1.shtml>

<sup>425</sup> <https://www.theguardian.com/world/2020/mar/13/european-countries-take-radical-steps-to-combat-coronavirus>

	Нас барсан - 2991	зогсоосон	<p>2020.03.14-ны өдрөөс Улс орон даяар 15 хоногийн хугацаатай онц байдал зарласан.</p> <p>2020-03-18-ны өдрийн парламентын хуралдаан дээр Ерөнхий сайд Педро Санчез улс орон даяар 15 хоногийн хугацаатай зарласан онц байдлыг нөхцөл байдал дордсоны улмаас 2020-04-11-ний өдөр хүртэл дахин сунгах шаардлагатай байгааг мэдэгдсэн байна. Парламентын танхим дахь хуралдаанд 28 гишүүн, 5 сайд оролцсон байна.</p>
<b>5. Франц</b>	Бүртгэгдсэн -22304 Нас барсан - 1100	2020.03.22 хүртэл түр зогсоосон	<p>Францын Үндэсний ассамблейн 9 гишүүний коронавирусийн шинжилгээ эерэг гарсан. Үүнтэй холбоотой парламентын доод танхимын үйл ажиллагааг 2020.03.22 хүртэл түр хугацаагаар зогсоосон байна.</p> <p>Түүнчлэн Францын Соёлын сайд Franck Riester-ийн шинжилгээний хариу эерэг буюу халдвартай гарсан тул гэрээсээ ажлаа хийж байна.</p> <p>Сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газраас хурал, уулзалтыг аль болох бага хийх, ширээнүүдийг өдөрт 2 удаа ариутгаж арчих, хурал, уулзалтыг аль болох зайнаас зохион байгуулах /видео хурал/, чухал бус уулзалтыг цуцлах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Түүнчлэн, өвчний тархалт нэмэгдэж байгаагаар холбоотой 2020 оны 3-р сарын 16-ны даваа гарагаас эхлэн бүх цэцэрлэг, сургууль, их дээд сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргажээ.</p> <p>2020-03-22-ны Ням гаригт үүрээр Үндэсний Ассамблей тусгай хорооны-цөөн тооны гишүүдтэйгээр хуралдан коронавирусийн тархалттай тэмцэхэд Засгийн газарт тусгай эрх олгох хуулийг яаралтай батлав. Тус хуулиар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Улс даяар онц байдал зарлаж, хөл хорио тогтоов.</li> <li>• 2 сарын хугацаанд засгийн газраас шаардлагатай бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг коронавирусийн эсрэг тэмцэхэд ашиглаж болох зөвшөөрлийг олгов. Тухайлбал, эмнэлгийн ажилтнуудыг таксигаар үнэгүй тээвэрлэх эрхийг олгов.</li> <li>• Орон нутгийн сонгуулийн 2 дахь шатны санал хураалтыг хойшлуулав.</li> <li>• Эдийн засагт үзүүлэх тодорхой дэмжлэгийг батлав.</li> <li>• Хууль зөрчсөн этгээдэд 135 еврогийн мөнгөн торгууль ногдуулахаас</li> </ul>

<p>эхлээд 6 сар хүртэл хорих шийтгэлийг баталсан байна.</p> <p>Ирэх Ням гаригт буюу 2020.03.29-нд Үндэсний Ассамблей мөн цөөн гишүүний бүрэлдэхүүнтэй дахин хуралдахаар шийдвэрлэсэн байна.</p>			
6. Канад <sup>426</sup>	Бүртгэгдсэн -2792 Нас барсан - 26	2020.04.20-ын өдрийг хүртэл түр зогсоосон (5 долоо хоног)	2020.03.13-ны өдөр Парламент дахь бүх намууд Нийтийн танхим болон Сенатын үйл ажиллагааг 5 долоо хоногоор (Нийтийн танхим 2020.04.20, Сенат 2020.04.21-ний өдрийг хүртэл) түр зогсоохоор санал гарган, шийдвэрлэсэн. Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно. Мөн шийдвэрээр 2020.03.30-нд Холбооны төсвийг хэлэлцэх байсныг хойшлуулсан. Шинэ тов одоогоор гараагүй байна.
7. Эстони <sup>427</sup>	Бүртгэгдсэн -369	Хуралдааны тоог цөөлсөн	<p>2020.03.12-нд 2020.05.01 хүртэл Онц байдал зарласан. 2020.03.13-нд Эстонийн парламент зөвхөн цаг үеийн чухал асуудлыг шийдвэрлэхээр тогтсон. Мөн нэгдсэн хуралдааныг Даваа-Пүрэв гарагт явуулдаг байсныг зөвхөн Даваа гарагт, Асуулгыг Лхагва гарагт явуулахаар тус тус шийдвэрлэсэн байна.</p> <p>Хороодын хуралдааныг Даваа гарагт зөвхөн шаардлагатай тохиолдолд явуулна.</p> <p>Ахмадын зөвлөлөөс Парламентын Үндсэн хуулийн хороонд онц нөхцөл байдалд Хороодын хуралдааныг <b>алсын зайнаас явуулах</b> боломж олгох тогтоол боловсруулахыг үүрэг болгов.</p> <p><u>2020.03.16-нд</u> Үндсэн хуулийн хороо хуралдаж Онцгой байдлын үед хорооны хурлыг цахим (teleworking) зохион байгуулах талаар ярилцаж, Рийгикогугийн тухай хууль болон Дотоод журмын тухай хуулиар хороодын хуралдаанд оролцох шаардлагатай бүх нөхцөл (тайлбар хийх, асуулт асуух, санал өгөх) хангагдаж байгаа тохиолдолд хуралдааныг цахим хэлбэрээр явуулах боломжтой гэдэг дээр санал нэгдэв. Хорооны дарга онцгой нөхцөл байдлыг харгалзан хороодын хурал ажил тасалдахгүй байх нь чухал бөгөөд энэ нь цахим хэлбэрээр үргэлжилж болох юм. Мөн процедурын журмыг яаран өөрчлөх шаардлагагүй, дараа нь нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний</p>

<sup>426</sup> <https://www.cbc.ca/news/politics/parliament-suspended-1.5496469>

<sup>427</sup> <https://www.riigikogu.ee/en/press-releases/others/riigikogu-will-reorganise-work-prevent-spread-coronavirus/>

			<p>үндсэн дээр өөрчлөлт оруулж болох юм гэж хорооны байр суурийг илэрхийллээ.<sup>428</sup></p> <p>20.03.2020 Европын Холбооны асуудал эрхэлсэн хорооны (ЭЛАК) дарга Аннели Отт Комиссын нэрийн өмнөөс Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лейенд захидал илгээж, Европын Комиссоос зохион байгуулалтад тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг хүсч, энэ ажилд хамтран ажиллахаа мэдэгдсэн.</p> <p>2020.03.23-ны Даваа гаригийн нэгдсэн хуралдаанаар 03.25-ны Лхагва гаригт Рийгигогугийн Удирдах зөвлөлийн сонгуулийг хийхээр шийдвэрлэсэн.</p>
8. Пакистан <sup>429</sup>	Бүртгэгдсэн -972	2020.04.05 хүртэл түр зогсоосон	<p>Пакистаны түүхэнд анх удаа Үндэсний Ассамблейн үйл ажиллагааг, үүнд Дээд ба Доод танхимуудын Байнгын хороодын хуралдааныг түр зогсоосон байна. Парламентын ээлжит чуулган 2020.03.19-ны өдөр дуусах байсан боловч коронавирусийн халдварын дэгдэлттэй холбоотойгоор 2020.03.14-нд дээрх шийдвэрийг гаргасан байна. Сенатын үйл ажиллагааг 2020.04.05 хүртэл түр зогсоосон байна.</p> <p>2020.03.25-нд Үндэсний Ассамблейн спикер Асад Кайзерын санаачилгаар Сенат ба Үндэсний Ассамблейн парламентын удирдагчдын хамтарсан уулзалт 3-р сарын 25-ны өдөр Исламабад дахь Парламентын ордонд болно. Энэхүү уулзалтаар Үндэсний Ассамблейн дарга гаргаж авсан бөгөөд коронавирусаас үүдэлтэй нөхцөл байдал ба түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэлэлцэж, коронавирусийн эсрэг ажиллах парламентын хороог байгуулах асуудлыг хэлэлцэх юм.<sup>430</sup></p>
9. Филиппин <sup>431</sup>	Бүртгэгдсэн -552 Нас барсан - 35	2020.04.12 хүртэл түр зогсоосон	<p>2020.03.13-ны өдөр Парламентын доод танхимаас Танхимын үйл ажиллагааг 2020.03.16-04.12-ны дуустал түр зогсоохоор шийдвэрлэсэн. Холбогдох хэлтэс, хороодыг ээлжээр ажиллуулах бол ээлжээр ажиллаагүй ажилтнуудыг зайнаас ажиллуулна. COVID-19-ын халдвартай тэмцэх, үр нөлөөг бууруулах асуудлаарх Холбогдох хорооны хурал, сонсгол, хэлэлцүүлгийг Парламентын комплекст зохион байгуулж болно.</p>

<sup>428</sup> <https://www.riigikogu.ee/en/press-releases/constitutional-committee-en/constitutional-committee-rules-procedure-allow-holding-committee-sittings-teleworking-format/>

<sup>429</sup> <https://www.pakistantoday.com.pk/2020/03/14/first-pakistans-parliamentary-business-suspended-due-covid-19-scare/>

<sup>430</sup> [www.thenews.com.pk/print/633780-pm-not-to-attend-parliamentary-group-leaders-meeting-tomorrow](http://www.thenews.com.pk/print/633780-pm-not-to-attend-parliamentary-group-leaders-meeting-tomorrow)

<sup>431</sup> <https://news.abs-cbn.com/news/03/13/20/congress-house-of-representatives-batasan-suspends-work-march-16-to-april-12>

			2020.03.24-нд онцгой хуралдааныг зарлан хуралдуулж Ерөнхийлөгчид коронавирусийн дэгдэлтийн эсрэг авах арга хэмжээний онцгой эрхийг олгох хуулийн төслийг баталсан.
<b>10. Өмнөд Африк</b> <sup>432</sup>	Бүртгэгдсэн -554	Түр зогсоосон	2020.03.17-ноос эхлэн Парламентын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэрийг Парламентын тэргүүлэгч нар, парламентын дахь намын бүлгийн дэг сахиулагч нар болон намын бусад төлөөлөгч нарын шуурхай хурлаар шийдвэрлэсэн байна. Тус шийдвэрийг Засгийн газраас коронавирусийн халдварын тархалтыг зогсоох үүднээс 100-аас дээш хүн оролцох уулзалт, цуглааныг хориглосныг үндэслэн гаргажээ.
<b>11. Кени</b> <sup>433</sup>	Бүртгэгдсэн - 25	2020.04.14 хүртэл түр зогсоосон	2020.03.17-ноос 2020.04.14 хүртэл коронавирусийн халдварын тархалттай холбоотойгоор Парламентын дээд, доод танхимуудын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан гэж Үндэсний Ассамблейн спикер мэдээлсэн.
<b>12. Итали</b>	Бүртгэгдсэн - 69176 Нас барсан - 6820	Байнгын хороодын хуралдаанууд цуцлагдсан. Видеоконференц форматад шилжсэн. Хуралдааны тоог хязгаарласан.	Байнгын хороодын хуралдаанууд цуцлагдсан. Онц шуурхай асуудлаар Парламентын танхимууд видеоконференц явуулах бөгөөд санал хураалт (нэгдсэн хуралдаан)-ыг долоо хоногийн зөвхөн 1 өдөр буюу Лхагва гарагт явуулахаар шийдвэрлэсэн. Парламентын гишүүдийг танхимд нэвтрэхэд биеийн халууныг хэмжин оруулж, гишүүд хоорондоо хамгийн багадаа 1 метрийн зайтай суух юм.
<b>13. Австрали</b>	Бүртгэгдсэн - 2317 Нас барсан - 8	Нэгдсэн хуралдааныг 2020 оны 8 дугаар сар хүртэл зогсоосон <sup>434</sup>  Хороодын үйл ажиллагаа алсын зайнаас явагдана	2020.03.16-наас эхлэн Парламентын ордонд нэвтрэх нөхцөлийг хязгаарлаж, Парламентад оронд хийх томоохон арга хэмжээг хойшлуулах, эсхүл цуцалсан.  2020.03.23-наас эхлэх Хороодын сонсголд олон нийтийг оруулахгүй бөгөөд зөвхөн онц шаардлагатай тохиолдолд гэрчийг оролцуулах юм. Хороодод сонсгол зохион байгуулах тохиолдолд видео, телеконференцийн горимд шилжихийг зөвлөсөн. Хороодын үйл ажиллагааг Парламентын цахим хуудсаар дамжуулна.

<sup>432</sup> <https://www.timeslive.co.za/politics/2020-03-17-parliament-to-shut-down-until-further-notice-because-of-covid-19/>

<sup>433</sup> <https://www.pulselive.co.ke/news/parliament-suspends-sitting-over-coronavirus/9k5tmfd>

<sup>434</sup> <https://www.aph.gov.au>

<b>14. Непал</b> <sup>435</sup>	Бүртгэгдсэн - 2	2020.03.20 хүртэл түр зогсоосон  Тодорхойгүй хугацаагаар түр зогсоосон	2020.03.13-наас 2020.03.20 хүртэл коронавирусийн халдварын тархалттай холбоотойгоор Парламентын дээд, доод танхимуудын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан.  2020.03.20-нд Парламентын дээд танхимын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар дахин хойшлуулав. Мөн Засгийн газрын зааварчилгааг үндэслэн (нэг дор 25-аас дээш хүн цугларч болохгүй) төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааг цаашид мэдэгдэл гаргах хүртэл түр зогсоосон.  2020.03.24-нөөс 7 хоногийн хугацаатай бүх орон даяар хөл хорио тогтоох шийдвэрийг Засгийн газраас гаргажээ.
Хэвийн ажиллагаатай			
<b>15. БНСУ</b>	Бүртгэгдсэн - 9037 Нас барсан - 120	Хэвийн	Парламентын сонгууль 2020.04.15-нд явагдана.
<b>16. Их Британи</b> <sup>436</sup>	Бүртгэгдсэн - 8077 Нас барсан - 422	Хэвийн <sup>437</sup>	2020.03.16-наас эхлэн Парламентын ордонд нэвтрэх нөхцөлийг хязгаарлаж, Парламентад хүлээн авалт хийх зэргийг зогсоосон.  ДЭМБ-аас шинэ коронавирусийн халдварыг цар тахлын хэмжээнд хүрсэн гэж дүгнэсэнтэй холбоотойгоор тодорхой улс, бүс нутагт аялахгүй байхыг зөвлөхийн сацуу Парламентын гишүүд, парламентын бүлгэм, хамтрагч байгууллагуудад парламентын айлчлал хийхгүй байх, төлөөлөгчид нь эрсдэлт бүлэгт хамарч буй эсэх асуудалд онцгой анхаарахыг хатуу зөвлөсөн байна.
<b>17. Нидерланд</b>	Бүртгэгдсэн - 5560 Нас барсан - 276	Хэвийн <sup>438</sup>	2020.03.31-нийг хүртэл Парламентын ордонд зөвшөөрөл бүхий сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас бусад иргэдийг нэвтрүүлэхгүй. Хуралдаан, хэлэлцүүлгүүдийг цахим хуудас үзэх боломжтой.
<b>18. Норвеги</b>	Бүртгэгдсэн - 2866	Хэвийн <sup>439</sup>	2020.03.07-ноос Парламентын ордонтой танилцах арга хэмжээг зогсоосон.

<sup>435</sup> <https://myrepublica.nagariknetwork.com/news/parliament-put-off-for-eight-days-over-coronavirus-fears/>

<sup>436</sup> <https://www.parliament.uk/business/news/2020/march/uk-parliament-coronavirus-update/>

<sup>437</sup> Following a joint meeting today, the Commissions of the House of Lords and House of Commons have issued the following statement:

"The Commissions of both Houses met today to discuss Parliament's response to Coronavirus. There are no plans to suspend Parliament.

